



Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал ба аялагчдын удирдлага, зохион байгуулалт

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДАМЖ

Дугаарыг хянан тохиолдуулсан Юу-Фай Люнг, Анна Спэнсели, Глен Хвеннгаард, Ралф Бакли
Цувралыг хянан тохиолдуулсан Грезйг Грөвес



Манай гаригийн ТХГН-уудын хөгжлийн төлөө

ТХГН-уудын Шилдэг Туршлагауд Цуврал Дугаар 27



Convention on
Biological Diversity



TAPAS GROUP
Tourism and Protected Areas Specialist Group



IUCN-ийн ТХГН-уудын шилдэг туршлагауд цуврал

Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн (ТХГН) Шилдэг Туршлагын Удирдамж нь IUCN-ийн ТХГН-уудын Олон улсын комисс (WCPA)-оос ТХГН-уудын менежерүүдэд зориулж гаргасан, олон улсын хамгийн том, чухал эх сурвалж болно. Практик үйл ажиллагааг сайжруулахын төлөө нэгдсэн мэргэшсэн мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааны дүнд боловсруулсан энэхүү гарын авлагад IUCN-ийн бүхий л талбараас ирсэн сургамж, зөвлөмжүүдийг багтаасан болно. Энэхүү гарын авлагыг ТХГН-ийг үр дүнтэй, тэгш хүртээмжтэй, тогтвортойгоор удирдаж, бодит амьдралд бий болдог төрөл бүрийн асуудлуудыг шийдэхэд ашиглаж болно. Улмаар төрийн болон төрийн бус байгууллагууд (ТББ), ТХГН-ийн хамгаалалтын захиргаад, нөхөрлөлүүд, нутгийн иргэд, хувийн хэвшлийнхэн болон түншүүдэд зорилго, зорилтуудаа үр дүнтэй биелүүлэх, түүний дотор Биологийн олон янз байдлын конвенцид тусгасан ТХГН-ийн талаарх заалтуудыг хэрэгжүүлэхэд туслах болно.

Удирдамжуудын цуврал багцыг дараах хаягаас авна уу: www.iucn.org/pa_guidelines

Нэмэлт үнэ төлбөргүй дагалдах мэдээллийг дараах хаягаас авна уу: www.cbd.int/protected/tools/

"Хамгаалагдсан Гариг" хөтөлбөрт хувь нэмрээ оруулахыг хүсвэл дараах хаягаар хандана уу: www.protectedplanet.net/

IUCN-ийн ТХГН-ийн ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ ТҮҮНИЙ МЕНЕЖМЕНТ БОЛОН ЗАСАГЛАЛЫН ХЭЛБЭРҮҮД

IUCN-нд тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

"Байгаль орчныг урт удаан хугацаанд экосистемийнх нь үр ашиг, оршин буй соёлын үнэт зүйлсийнх нь хамт эрх зүй, бусад үр дүнтэй арга хэрэгсэл хэрэглэн хамгаалж, ашиглаж байгаа, хүлээн зөвшөөрөгдсөн газар зүйн орон зай"-г тусгай хамгаалалттай газар нутаг хэмээн.

ТХГН-ийг менежментийн хувьд үндсэн зургаан ангилалаар (нэгдүгээрх нь дэд хэсэгтэй) тодорхойлдог;

Ia Дархан цаазат газар: Хуурай болон далайн бүсэд орших онцлог экосистем болон геологи/геоморфологи, биологийн олон янз байдал бүхий, аливаа ашиглалт нөлөөлөл нь хязгаарлагдсан, тусгай хамгаалалттай газар нутаг.

Ib Зэрлэг онгон газар: Биологийн олон янз байдал, түүний амьдрах орчин нь хүний үйл ажиллагааны нөлөөнд автаагүй, байгалийн унаган төрхийг нь хадгалах зорилготой бүс нутаг

II Байгалийн цогцолборт газар: Өөрийн гэсэн амьтан, ургамлын төрөл зүйл, экосистемийн онцлогтой, байгаль, соёлын өвийг хамгаалах хэмжээнд оюун санаа, шинжлэх ухаан, боловсролыг дэмжсэн үйл ажиллагаа, амралт зугаалга, аялал хийх боломжтой, экосистемийн баялаг процессийг хадгалж үлдсэн хөндөгдөөгүй, эсвэл бага хэмжээгээр хөндөгдсөн томоохон газар нутаг.

III Байгалийн дурсгалт газар: Хуурай газрын тогтоц, тэнгисийн эрэг, далайн цүнхээл, агуй, балар эртний амьд ой гэх мэт. геологийн тогтцуудыг хадгалах зорилгоор хамгаалсан газар нутаг.

IV Амьдрах орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн бүс нутаг: Биологийн олон янз байдлын тодорхой зүйлийн амьтан ургамал, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах зорилгоор хамгаалалтанд авсан газар нутаг. Хэдийгээр горимд нь тийм шаардлага үгүй ч олон тохиолдолд хөндлөнгөөс нь хүний интервенц хийж, тодорхой амьтан, ургамлыг хамгаалж байх шаардлагатай газар нутаг.

V Хуурай газар болон далай тэнгисийг хамгаалсан ТХГН: Хуурай газар, далай тэнгис, эрэг орчмын нутгийг хамрах бөгөөд хүн байгалийн харилцан шүтэлцээнээс экологи, соёл, гоо зүйн чухал ач холбогдол бүрэлдсэн газар. Энэхүү харилцан шүтэлцээ нь тус газрын хадгалалт, тогтвортой байдал, байгаль хамгаалалтанд чухал ач холбогдолтой болсон учир хамгаалалтанд авсан газар нутаг.

VI Байгалийн нөөцийг тогтвортой ашиглах ТХГН: Экосистемийг уламжлалт ахуй соёл, байгалийн нөөц ашиглалтын уламжлалт менежменттэй нь цуг хадгалж, хамгаалдаг газар нутаг. Ихэвчлэн том хэмжээтэй, онгон байгалиа авч хоцорсон энэ газар нутгийн нөөцийг тогтвортой менежментээр дамжуулж ашигладаг бөгөөд байгаль хамгаалалд ноцтой хохирол учруулалгүйгээр, аж үйлдвэрийн бус хэлбэрээр нөөц ашиглалтыг зөвшөөрдөг газар нутаг.

Эдгээр категоруудыг менежментийн үндсэн зорилго, зорилтуудад тулгуурлан тодорхойлдог бөгөөд газар нутгийн дор хаяж 3/1 буюу 75%-д нь хамрагдсан байх ёстой байдаг.

Удирдлага, зохион байгуулалт буюу менежментийн хэлбэрүүд нь тухайн ТХГН-ийн засаглалын шинж байдлаас буюу эрх мэдэл хаана төвлөрч, ТХГН-ийг хэн удирдахаас хамаарч ялгаатай байдаг. IUCN-с Засаглалын дөрвөн төрлийг тодорхойлсон байдаг. Үүнд:

A Төрөл. Төрийн төвлөрсөн засаглал: Холбооны эсвэл улсын яам/агентлаг; Орон нутгийн шинжтэй яам эсвэл агентлаг (бүсийн, аймгийн, хотын түвшний удирдлага гэх мэт); Засгийн газрын эрхийг төлөөлөн хэрэгжүүлэгч (жишээ нь ТББ-д гэх мэт)

Б Төрөл. Эрх мэдлээ хамтран хэрэгжүүлдэг засаглал: Хил дамнасан засаглал (2 ба түүнээс дээш улс орнууд хоорондоо албан болон албан бус харилцаагаар зохицуулдаг); Хамтын ажиллагаан дээр суурилсан засаглал (олон талын этгээд, байгууллагууд төрөл бүрийн байдлаар хамтран ажилладаг хэлбэр); Хамтарсан засаглал (олон талын бүрэлдэхүүн, эсвэл олон гишүүнтэй засаглал)

В Төрөл. Хувийн засаглал: Газрын эзэн хувийн газраа ТХГН-т хамруулж, хамгаалалтын үйл ажиллагааг нь өөрөө удирддаг; ашгийн төлөө бус байгууллагууд (ТББ, их, дээд сургуулиуд гэх мэт), эсвэл ашгийн төлөө байгууллагууд (газар эзэмшдэг корпорацууд гэх мэт).

Г.Төрөл. Уугуул болон нутгийн иргэдийн засаглал: Уугуул оршин суугчдын хамгаалсан, өөрсдөө удирддаг газар нутаг; Нутгийн иргэдэд суурилсан хамгаалалттай газар нутгууд.

IUCN-ийн тодорхойлолтууд болон ангилалын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Доодли (2008) *ТХГН-ийн менежментийн ангилал тогтоох удирдамж* -с авч болох бөгөөд дараах хаягаас татаж авах боломжтой:

www.iucn.org/pa_categories.

Засаглалын хэлбэрүүдийн тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг Боррини-Ферабэнд нар. (2013) *ТХГН-ийн Засаглал: ойлгож, хэрэгжүүлэх нь* гэсэн бүтээлээс авч болох бөгөөд дараах хаягаас татаж авах боломжтой:

<https://portals.iucn.org/library/node/29138>.

Тусгай хамаалалттай газар нутгийн аялал жуулчлал ба аялагчдын удирдлага зохион байгуулалт

Тогтвортой хөгжлийн удирдамж

Дугаарыг хянан тохиолдуулсан Юу-Фай Люнг, Анна Спэнсели, Глен Хвеннгаард, Ралф Бакли

Цувралыг хянан тохиолдуулсан Греэйг Гревес

Энэхүү номонд тодорхой газар зүйн байршил бүхий байгууллага, мэдээллүүдийг оноож, танилцуулсан нь IUCN, Биологийн төрөл зүйлийн конвенци (CBD), Франц улсын Гадаад хэрэг, олон улсын хөгжлийн яам, ХБНГУ-ын улсын Эдийн засгийн харилцаа, хөгжлийн яам (BMZ), IUCN-ийн ТХГН-уудын Олон улсын комисс (WCPA), Аялал жуулчлал ба ТХГН-ийн Мэргэжилтнүүдийн Бүлэг (TAPAS), болон АНУ-ын Хойд Каролина мужийн Улсын их сургууль зэрэг байгууллагуудын зүгээс холбогдох улс орнуудын хууль эрх зүй, газар, нутаг, төр захиргаа тэдгээрийн хил хязгаартай холбоотой байр суурийг ямар нэг байдлаар, огтхон ч илэрхийлээгүй хэрэг болно.

Энэхүү бүтээлд илэрхийлсэн үзэл санаа нь IUCN, Биологийн олон янз байдлын тухай конвенци, Франц улсын Гадаад Хэрэг, Олон Улсын Хөгжлийн Яам, ХБНГУ-ын улсын Эдийн Засгийн Харилцаа, Хөгжлийн Яам (BMZ), IUCN-ны ТХГН-ийн WCPA Аялал жуулчлал ба ТХГН-ийн Мэргэжилтнүүдийн Бүлэг (TAPAS) болон АНУ-ын Хойд Каролина мужийн Улсын их сургууль зэрэг байгууллагуудын албан ёсны байр суурь биш болно. Энэхүү бүтээлийг дээрх нэр бүхий байгууллагуудаас олгосон мөнгөн болон мөнгөн бус тусламж дэмжлэгийн ачаар хэвлүүлсэн болно.

IUCN болон бусад оролцогч байгууллагууд энэхүү баримт бичгийн анхны хувилбар болох англи хэлнээс монгол хэл рүү хөрвүүлэхэд гарсан алдаа, дутагдлын төлөө хариуцлага хүлээхгүй. Хэрэв зөрүү гарсан тохиолдолд анхны хувилбарыг үзнэ үү. Анхны хэвлэлийн нэр: *Tourism and visitor management in protected areas: Guidelines for sustainability. Best Practice Protected Area Guidelines Series No. 27 (2018)*. Нийтэлсэн: IUCN, Гланд, Швейцар. DOI: <https://doi.org/10.2305/IUCN.CH.2018.PAG.27.en>

Энэхүү хэвлэлийн Монгол хувилбар нь Азийн бүсийн ТХГН-уудын Түншлэл (APAP) байгууллагын удирдлага дор БНСУ-ын ТХГН-уудын Удирдлага (KNPS)-ын санхүүжилтээр бүтээгдэв.

Хэвлүүлсэн: IUCN, Гланд, Швейцарь.

Зохиогчийн эрх: © 2018 Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN)
2020 IUCN Монгол орчуулга

Зохиогчийн эрхийн зүгээс энэхүү гарын авлагыг боловсрол болон бусад ашгийн бус зорилгоор хэвлэхийг хүсвэл ямар нэгэн албан ёсны бичгийн зөвшөөрөлгүйгээр дахин хэвлэхийг зөвшөөрч байгаа болно. Албан ёсны бичгийн зөвшөөрөлгүйгээр худалдах болон бусад шалтгаанаар ашиг олох зорилгоор дахин хэвлэх, ашиглахыг зохиогчийн эрхийн зүгээс хориглоно.

Ишлэл: Юу-Фай Лjung, Анна Спенсели, Глен Хвеннгаард, болон Ралф Бакли (хян.) (2020). *Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал ба аялагчдын менежмент: Тогтвортой аялал жуулчлалын удирдамж. Тусгай Хамгаалалттай Газар Нутгуудын Шилдэг Туршлагаудын Удирдамж цуврал № 27*, Гланд, Швейцарь : IUCN. xii + 120 хуудас.

ISBN: 978-2-8317-2056-2

DOI: <https://doi.org/10.2305/IUCN.CH.2018.PAG.27.mn>

Нүүр зураг: Бразил улсын Игуачу Хүрхрээ БЦГ-т аялж яваа жуулчид. © Юу-Фай Лjung

Арын зураг : Жуулчид Исландийн Катла дахь Солхемажокулийн Мөсөн голыг үзэж байгаа нь. UNESCO-гийн Дэлхийн геопаркууд. © Юу-Фай Лjung

Хэвлэлийн эх: Таад Мерер

Эрхлэн гаргасан газар: IUCN (Олон Улсын Байгаль хамгаалах холбоо)

Азийн бүсийн оффис
63 Sukhumvit Soi 39
Klongton – Nua, Wattana
10110 Bangkok, Thailand
Tel +66 2 662 4029
Fax +66 2 662 4387 wcpa@iucn.org, www.iucn.org/resources/publications



Олон улсын байгаль хамгаалах холбоо нь (IUCN) байгаль орчин болон хөгжлийн сорилтуудад бодит шийдэл олоход олон улсад тусалдаг байгууллага юм. IUCN нь байгаль түүний үнэ цэнийг хамгаалах, ашиглахад ижил тэнцүү үр ашигтай засаглалыг бий болгох, улмаар уур амьсгалын өөрчлөлт, хүнс тэжээлийн болон хөгжлийн асуудлуудад хандахдаа байгальд суурилсан шийдвэр гаргахад гол анхаарлаа хандуулдаг. IUCN нь НҮБ болон хувийн хэвшил, төрийн болон ТББ-уудтай хамтран бодлого, хууль, эрхзүй, шилдэг туршлагуудыг боловсруулж байгаагаас гадна судалгаа шинжилгээ, дэлхий даяар хэрэгжиж буй олон төслүүдийг дэмжин ажилладаг. 1948 онд байгуулагдсан IUCN нь эгнээндээ 1,300 гаруй төрийн болон төрийн бус байгууллагууд, 13,000 гаруй сайн дурын шинжээч, мэргэжилтнүүдийг нэгтгэсэн, байгаль орчны олон асуудлыг хамруулсан дэлхийн хамгийн том сүлжээ юм. IUCN нь дэлхийн 50 гаруй байгууллагын 1,000 гаруй ажилчид, ТББ, хувийн хэвшлийн зуу зуун түншүүдийн дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

www.iucn.org



Франц улс - IUCN хоорондын түншлэлийн зорилго нь Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын гэрээ болон Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал юм. Үүгээрээ дэлхийн хэмжээнд болон Европын газар нутгийг хамарсан, ялангуяа Франц улсын эрх ашиг, сонирхолыг татсан төслүүдийг дэмжинэ гэж ойлгох нь зүйтэй. Энэ түншлэл нь Францын холбогдох байгууллага, мэргэжилтнүүдээр хангах, эсвэл IUCN-ийн ахлах албан тушаалтнуудад техникийн туслалцаа үзүүлдэг. Түншлэлд Европ болон гадаад хэрэг, байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн яамдууд, хилийн чанад дахь газар нутаг болон Францын хөгжлийн агентлаг (AFD) зэрэг байгууллагуудаас бүрддэг. Түншлэл нь 2005 онд байгуулагдсан цагаас хойш үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа бөгөөд 2017-2020 оны хооронд ойролцоогоор 9 сая орчим евро зарцуулаад байна.

www.iucn.org/fr/partenariat-france-iucn



IUCN-ийн ТХГН-уудын Олон улсын комисс (WCPA)

Дэлхийн ТХГН-уудын мэргэжилтнүүдийн анхны нэгдсэн сүлжээ юм. Энэ комиссийг IUCN-ийн Тусгай хамгаалалттай газруудын хөтөлбөрөөс дэмждэг бөгөөд эгнээндээ 140 гаруй орны 14,000 гаруй гишүүдийг нэгтгээд байна. IUCN-ийн WCPA нь засгийн газар болон бусад этгээдүүдэд ТХГН-ийг төлөвлөж, улс орны бусад салбаруудтай уялдуудах, төлөвлөгөө гаргагчдад стратегийн зөвлөгөө өгөх, ТХГН-уудын чадавхи, хөрөнгө оруулалтыг бэхжүүлэх, учирч буй асуудлуудыг шийдэхэд оролцогч болон хамтрагч талуудад ойлгуулж, тэдний оролцоог нэмэгдүүлэх зэргээр дэмжлэг үзүүлэн ажилладаг. IUCN болон WCPA нь ТХГН-уудын хөгжил дэвшлийн төлөө 50 гаруй жил ажиллаж байна.

www.iucn.org/wcpa



Герман улс нь цөлжилттэй тэмцэх, даяаршлыг ижил тэнцүү байлгах, энх тайвныг сахих, эрх чөлөө, ардчилал, хүний эрхийг дээдлэх болон байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалах чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгтэй идэвхтэй хамтран ажилладаг. **ХБНГУ-ын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (BMZ)** нь Германы хөгжлийн бодлогын үзэл санаа, холбогдох журмууд болон олон төрлийн тоглогчидтой ажиллах хамтын ажиллагааны урт хугацааны бодлого, хэрэгжүүлэх арга зам, зааврыг боловсруулдаг. Германы засгийн газрын зарчим бол улс орнуудтай хамтран ажиллахдаа хоёр талын хамтын ажиллагааг эрхэмлэдэг явдал юм. BMZ нь Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн түнш орнуудтайгаа хамтран ажиллах бодлого, үзэл санааг хамтарсан төсөл хөтөлбөрүүд хэлбэрээр боловсруулж, хэрэгжүүлэгч байгууллага нь төсөлд тусгасан бодлого, арга хэмжээг ёсчлон гүйцэтгэдэг. Нэмж хэлэхэд BMZ нь иргэний нийгэмлэг, сүм хийд, янз бүрийн сангууд, хувийн хэвшил зэрэг маш олон төрлийн байгууллагуудтай харьцаж ажилладаг байна.

www.bmz.de



Convention on
Biological Diversity

Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD) нь олон улсын хэмжээнд биологийн олон янз байдлыг хамгаалах, амьтан ургамлын төрөл зүйлийн бүрэлдэхүүн, генетик нөөцийг тогтвортой ашиглах, үр ашгийг ижил тэнцүү хуваарилах үүднээс 1993 оны 12 дугаар сард хүчин төгөлдөр болж, хэрэгжиж эхэлсэн. Дэлхийн 193 орон гэрээлэгч талууд болж энэ конвенцид нэгдэн орсон бөгөөд биологийн төрөл зүйлүүдийн эмзэг байдал, экосистемийн үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэх, үр ашгийг нь нутгийн уугуул иргэд, нөхөрлөлүүд хүртээх, залуучууд, эмэгтэйчүүд, ТББ болон хувийн хэвшлийнхний оролцоотойгоор шилдэг технологи, сайн туршлагыг нэвтрүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг. 2010 онд хуралдсан CBD-ийн талуудын арав дахь удаагийн уулзалтаар стратегийн таван зорилт, Аичигийн Биологийн олон янз байдлын 20 зорилтыг багтаасан 2011-2020 оны биологийн олон янз байдлын стратеги төлөвлөгөөг шинэчлэн баталсан. Уг төлөвлөгөө нь зөвхөн биологийн олон янз байдалтай холбоотой конвенцид төдийгүй НҮБ-ын системд чиглэсэн биологийн олон янз байдлыг хамарсан ерөнхий хүрээ юм.

www.cbd.int



TAPAS GROUP

Tourism and Protected Areas Specialist Group

IUCN WCPA-ийн Аялал жуулчлал, ба ТХГН-ийн Мэргэжилтнүүдийн Бүлэг (TAPAS) нь 500 гаруй сайн дурынхныг нэгтгэсэн сүлжээ юм. Энэ бүлгийн зорилго нь ТХГН-ийн ажилтнууд болон энэ салбарт ажилладаг бусад мэргэжлийн шинжээчдийн хамтын ажиллагаа, туршлага, мэдлэгийг солилцох, манлайллыг хөгжүүлэх, ухаалаг шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх замаар ТХГН-т тогтвортой аялал жуулчлал хөгжих үндсэн суурийг бий болгоход оршино.

www.iucn.org/theme/protected-areas/wcpa/what-we-do/tourism-tapas

**NC STATE
UNIVERSITY**

ТХГН-ийн хэлтэс амралт, аялал жуулчлалын менежмент (PRTM) нь Хойд Каролина муж улсын Байгалийн нөөцийн коллежийн гурван хэлтсийн нэг нь юм. Үндсэн чиг үүрэг нь ард иргэдийн оролцоог дэмжих, сургах, нийгмийн судалгааны ажлыг төгөлдөршүүлэх замаар байгаль, соёлын нөөцийг амралт зугаалга, спортын арга хэмжээнд зохистой ашиглах, сурталчилах менежментийг бий болгоход оршино. Энэ чиглэлээр оюутнуудыг сургах, тэдний манлайллыг хөгжүүлэх, судлаачдыг бэлтгэдгээс гадна амралт, аялал жуулчлал, спортын арга хэмжээ нь эргээд байгаль орчин, нийгэм эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж байхыг тунхагладаг.

cnr.ncsu.edu/prtm

АГУУЛГА

Өмнөх үг	ix
Талархал	xi
Хураангуй	xv

1.ТХГН дахь аялал жуулчлал ба зочдын нөөц ашиглалтын менежмент 1

1.1. ТХГН-т тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нь	2
1.2. Тогтвортой хөгжлийг хангасан ТХГН болох боломж	3
1.3. ТХГН дахь аялал жуулчлалын олон улсын ойлголтууд	4
1.4. ТХГН-ийн аялал жуулчлалын шилдэг туршлага: онцлог шинж чанарууд	9
1.5. Энэ удирдамж яагаад шинээр гарах болсон бэ?	9
1.6. Удирдамжийн бүтэц, зохион байгуулалт	10

2.ТХГН дахь аялал жуулчлалын нөлөөлөл 11

2.1. Эерэг болон сөрөг үр нөлөөллийг дэнслэх нь	12
2.2. Байгаль хамгааллын шууд үр ашиг	14
2.3. Байгаль хамгааллыг шууд бус дэмждэг эдийн засгийн үр ашигууд	18
2.4. Байгаль хамгаалалд дам дэмжлэг үзүүлдэг нийгэм, олон нийтийн шинжтэй үр ашигууд	20
2.5. Олон нийт, хувь хүний сайн сайхан оршихуйд тустай аялал жуулчлалын үр ашигууд	22
2.6. Аялал жуулчлалын сөрөг нөлөөлөл	25
2.7. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүд	26
2.8. Нийгэм, соёлын сөрөг нөлөөллүүд	27
2.9. Шилдэг туршлагууд	30

3. Менежментийн зорилтуудыг аялал жуулчлалын нөлөөтэй уялдуулах нь 31

3.1. Аялал жуулчлалын менежмент нь урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх үйл хэрэг	32
3.2. Нэгдүгээр зарчим: Менежментийн арга барилыг ТХГН-ийн зорилго, үнэт зүйлс тодорхойлно.....	32
3.3. Хоёрдугаар зарчим: Аялал жуулчлал болон аялагчдын удирдлага, зохион байгуулалтыг (менежмент) урьдчилан төлөвлөх нь үр дүнг сайжруулна.....	36
3.4. Гуравдугаар зарчим: Аялагчдын үйл ажиллагаа буюу ашиглалтын нөхцлийг өөрчлөх нь зайлшгүй бөгөөд эерэг үр дүнд хүргэх магадлалтай.....	40
3.5. Дөрөвдүгээр зарчим: Хүний үйл ажиллагаанаас болж байгалийн нөөц баялаг болон нийгмийн орчин нөхцлүүд өөрчлөгдөх нь зайлшгүй.....	41
3.6. Тавдугаар зарчим: Менежмент нь хүний зан төлөвт нөлөөлж, аялал жуулчлалаас үүдэлтэй нөлөөллийг боломжит доод төвшинд хүргэхэд чиглэнэ	42
3.7. Зургаадугаар зарчим: Нөлөөлөл нь олон хүчин зүйлсээс шалтгаалдаг учир үйл ажиллагааг хязгаарлах нь менежментийн олон сонголтуудыг нэг юм.....	45
3.8. Шилдэг туршлагууд.....	46

4. Тогтвортой аялал жуулчлалын дасан зохицох менежмент..... 47

4.1. Долоодугаар зарчим: Мониторинг үнэлгээ бол менежментийн салшгүй хэсэг мөн.....	48
4.2. Наймдугаар зарчим: Шийдвэр гаргахдаа техникийн шинж чанар болон үнэт зүйлсийн шинж чанартайг ялгаж салгадаг байх	60
4.3. Есдүгээр зарчим: Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэгдсэн байр суурь ба түншлэл шаардлагатай учир хамааралтай талуудын оролцоог хангах	62
4.4. Аравдугаар зарчим: Тогтвортой хөгжлийн талаархи мэдээлэл түгээж, дэмжлэг авахад харилцаа холбоо туйлын чухал.....	62
4.5. Гэрчилгээг үзүүлэх.....	64
4.6. Аялал жуулчлалын менежментийн гурван талт тогтолцооны хүрээ.....	68
4.7. Шилдэг туршлагууд.....	70

5. Тогтвортой аялал жуулчлалын менежментийн чадавхийг бэхжүүлэх нь 71

5.1. Чадавхийг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсгүүд	72
5.2. Менежерүүдийн чадавхийг бэхжүүлэх нь	74
5.3. Нутгийн иргэдийн чадавхийг бэхжүүлэх нь	75
5.4. Түншлэлийн замаар менежментийн чадавхийг бэхжүүлэх нь	78
5.5. Шилдэг туршлагууд.....	79

6. Аялал жуулчлалын орлого, зарлагыг удирдан зохицуулах замаар байгаль хамгааллыг үр дүнд хүргэх нь 81

6.1. Биологийн олон янз байдлыг хамгаалахад учирдаг санхүүгийн хомсдол	82
6.2. Аялал жуулчлалын төлбөрөөс орлого бүрдүүлэх нь	82
6.3. Концессоос олох аялал жуулчлалын орлого	92
6.4. Аялал жуулчлалын орлогыг хандив, тусламжаас бүрдүүлэх нь.....	93
6.5. Зардлыг хэмнэх, үр ашигтай байх санаачилгууд.....	94
6.6. Эдийн засгийн үр өгөөж, холбоосыг өргөн цар хүрээгээр байгаль хамгаалах үйлстэй холбох нь.....	95
6.7. Шилдэг туршлагууд.....	97

7.ТХГН дахь аялал жуулчлалын хэтийн төлөв..... 99

7.1. Байгаль хамгааллын үндсэн зорилтондоо хүрэхэд аялал жуулчлал дэмжлэг болох боломжтой	100
7.2. Тогтвортой аялал жуулчлалын эрин үе	100
7.3. Хэтийн хандлагууд.....	101
7.4. Дүгнэлт.....	106
Үгийн тайлбар.....	107
Зохиогчдын оролцоо	114
Ашигласан хэвлэл	116

ШИГТГЭЭ

Шигтгээ 1.1	Гол нэр томьёоны тодорхойлолт	2
Шигтгээ 2.1	Руанда улсын Галт уулын Байгалийн цогцолборт газар дахь уулын горилла үзэх аялалын олон талын үр ашгууд.....	13
Шигтгээ 2.2	Хувийн эзэмшилд байгаа хамгаалалттай бүсүүд: аялал жуулчлал, байгаль хамгааллын түншүүд.....	16
Шигтгээ 2.3	ТББ-ын удирдлагатай бүхий тусгай хамгаалалттай газар нутгууд: Эзэн Хааны Байгаль Хамгаалах Нийгэмлэг (Иордан улс)	16
Шигтгээ 2.4	Биологийн олон янз байдлыг иргэдийн амьжиргаатай холбох нь: ТХГН дахь нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой түншлэл	17
Шигтгээ 2.5	Түншлэлээр дамжуулан бизнесийн ур чадварыг бүрдүүлэх нь.....	18
Шигтгээ 2.6	Дэлхийн геопарк ба тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал (Хонг Конг ТУБ, Хятад, Бразил улсууд).....	19
Шигтгээ 2.7	ТХГН-ийн аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг бодлогоор дэмжих нь: улсын туршлага.....	21
Шигтгээ 2.8	Байгалийн дурсгалт зүйлс, орон нутгийн сууринг тогтвортой аялал жуулчлалаар хамгаалах нь.....	22
Шигтгээ 2.9	Эрүүл мэндийн түншлэл: Австралийн Медибанк, Викториа Хүрээлэн болон Зүрх Хамгаалах Үндэсний Сангийн хамтын ажиллагаа.....	23
Шигтгээ 2.10	Мачу Пичу (Перу) дахь аялал жуулчлалын үр нөлөө.....	24
Шигтгээ 2.11	Дэд бүтэцтэй холбоотой нөлөөнүүд	26
Шигтгээ 3.1	ТХГН-т арилжааны аялал жуулчлал хөгжүүлэх гарын авлагад оруулбал зохих сэдвүүд	35
Шигтгээ 3.2	Биологийн олон янз байдлыг харгалзан Зочид буудал, амралтын баазуудын байршил, загварыг сонгоход баримтлах зарчмууд.....	35
Шигтгээ 3.3	Аялагчдад өгч буй сэтгэл ханамжаар дамжуулан байгалийг хайрлан хамгаалах сэтгэл зүйг бий болгох нь: Вади Ел-Хитан Халим загасны хөндий Дэлхийн соёлын өв газар (Египет).....	37
Шигтгээ 3.4	Даацийн талаархи товч түүх	39
Шигтгээ 3.5	Гранд Каньон Үндэсний Парк (АНУ)-н төлөвлөлт ба бүсчлэл	41
Шигтгээ 4.1	Сайн дурынхан ТХГН-т судлаач-иргэн, хянагчаар ажиллах нь	49
Шигтгээ 4.2	Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн мониторинг, Намиби улсын жишээ: Эвент Захиалах Систем	50
Шигтгээ 4.3	Аялагчдын стандартчилсан хяналт: Нордикийн болон Балтийн орнууд хоорондын уялдаа холбоотой хүчин чармайлт	51
Шигтгээ 4.4	Есөметигийн Үндэсний Байгалийн Цогцолборт Газар (АНУ) дахь аялагчдын ашиглалт, нөлөөллийг хянах нь.....	52
Шигтгээ 4.5	Аялагчдын мониторингд ашигладаг олон аргууд: Вилморийн Байгалийн Цогцолборт газар (Канад улс) ..	54
Шигтгээ 4.6	Прухоник Байгалийн Цогцолборт Газар дахь аялагчдын төрөл дээр хийсэн мониторинг (Чех улс).....	55
Шигтгээ 4.7	Төлөвлөлтийн явцын жишээ: Фонг На Ха Хи Банг БЦГ (Вьетнам улс).....	57
Шигтгээ 4.8	Казакстан дахь нутгийн иргэдийн дунд ТХГН-ийн тухай ойлголтыг өөрчлөхөд Алматы БНГ-ын гүйцэтгэж буй үүрэг.....	58
Шигтгээ 4.9	БНХАУ-ын Жиужайгоу Цогцолборт Газрын мэдээллийн технологийн ашиглалт.....	59
Шигтгээ 4.10	Аялагчдад Дэлхийн өвийг сурталчилан таниулах нь: Гунунг Үндэсний Байгалийн Цогцолборт Газар: Малайз улс.....	60
Шигтгээ 4.11	Перу улсын ТХГН-ийн Үндэсний Сүлжээн дэхь мэдээлэн тайлбарлах төвүүд	61
Шигтгээ 4.12	Оролцооны аргаар түүхийг мэдэж суралцах нь: Аялагчдын мэдлэг болон ур чадварт суурилсан танин мэдүүлэх аргаар жуулчидтай харилцах нь (Канад улс).....	64
Шигтгээ 4.13	Канадын ТХГН-ийн Хамгаалалтын Захиргааны зах зээлийн судалгаа ашиглалт ба үр өгөөжийн сурталчилгаа	65
Шигтгээ 4.14	Европын Тогтвортой Аялал Жуулчлалын Дүрмийн хүрээнд түншлэлийг хөгжүүлэх нь.....	66
Шигтгээ 4.15	Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын Зөвлөлийн шалгуур үзүүлэлтүүд	67
Шигтгээ 5.1	ТХГН-ийн Байгаль Хамгаалах Хөтөлбөрийн Нутгийн Иргэдийн Менежмент (COMPACT).....	74
Шигтгээ 5.2	Орчны бүсийн нутгийн иргэдийн чадавхийг бэхжүүлэх нь	76
Шигтгээ 5.3	Тенбанг Бапу-гийн Нутгийн Итгэдэд Түшиглэсэн Хамгаалалтай Газрын аялал жуулчлал ба байгаль хамгаалал (Энэтхэг улс)	77
Шигтгээ 5.4	Нийнлийн ЖикийнТХГН-ийн (загас агнуурын салбар) хамтын төлөвлөлт ба менежмент (Юкон, Канад Улс).....	78
Шигтгээ 5.5	Түншлэлээр дамжуулж чадавхи бий болгосон “Африкийн Нөөц” (Africa’s Recourse)-ийн туршлага	79

Шигтгээ 5.6	Аялал жуулчлалын менежментийн түншлэл: АНУ-ын Ойн Алба (USFS)-ны жишээ	80
Шигтгээ 6.1	Аялал жуулчлалын зарлагыг байгаль хамгааллын үр дүнтэй холбох нь	83
Шигтгээ 6.2	Хил дамнасан ТХГН-ийг дэмжих зорилгоор зохион байгуулсан амралт зугаалгын "Цөлийн Хаад (Намиби)" эвент үйл ажиллагаа	84
Шигтгээ 6.3	Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үйл ажиллагааг дэмжихэд аялал жуулчлалыг ашиглах нь: Хустай Байгалийн Цогцолборт Газар (Монгол)	85
Шигтгээ 6.4	Танзани улсын ялгаатай тогтоосон нэвтрэх хураамжийн тухай	87
Шигтгээ 6.5	Галт уулын БЦГ-т горилла харах үйл ажиллагааны хураамж (Руанда)	88
Шигтгээ 6.6	Өмнөд Африкийн ТХГН-ийн Захиргааны концессийн гэрээнүүд	90
Шигтгээ 6.7	Аялал жуулчлалын үйл ажиллагааг гэрээгээр амжилттайгаар гүйцэтгүүлэх: Тамботагийн Судалгааны Төв болон Байгалийн Нөөц Газар (Перу)	96
Шигтгээ 6.8	Эдийн засгийн үр өгөөжийг орон нутгийн иргэд хүртэх нь: Дамараланд Бааз болон Торрагийн нутгийн иргэдэд түшилэсэн байгаль хамгаалах газар (Намиби)	97
Шигтгээ 6.9	Корбеттийн Байгалийн Цогцолборт газрын аялал жуулчлалын менежментийг санхүүжүүлэх нь (Энэтхэг)	98
Шигтгээ 7.1	Перу улсын ТХГН дахь аялал жуулчлал ба уур амьсгалын өөрчлөлт: нөлөөллийн үнэлгээ, түүнд дасан зохицох зөвлөмжүүд	102

ХҮСНЭГТ

Хүснэгт 1.1	IUCN ТХГН-ийн ангилал болон аялагчдийн үйл ажиллагаа, ашиглалт, аялал жуулчлалын менежментийн хандлага	6
Хүснэгт 1.2	ТХГН-ууд дахь аялал жуулчлалын менежментийн боломж ба бэрхшээлүүд	7
Хүснэгт 2.1	ТХГН дахь аялал жуулчлалаас гарч болох үр ашгууд	12
Хүснэгт 2.2	ТХГН дахь аялал жуулчлалын зарцуулалтаас олох боломжит орлогын эх үүсвэрүүд	20
Хүснэгт 2.3	Аялал жуулчлалын хүрээлэн буй орчин болон экологид үзүүлж болзошгүй сөрөг үр дагаварууд	28
Хүснэгт 2.4	ТХГН-ийн орон нутгийн иргэдийн нөлөө: Нийгэм, соёлын болон Эдийн засгийн нөлөө	29
Хүснэгт 3.1	ТХГН-ийн аялал жуулчлал ба аялагчдад хандсан менежментийн 10 зарчим	33
Хүснэгт 3.2	Квот тогтоох төрлүүд	44
Хүснэгт 3.3	Менежментийн шууд ба шууд бус аргуудын жишээ	45
Хүснэгт 4.1	Аялагчдын нөлөөллийн мониторингд ашигладаг зарим нийтлэг аргууд	52
Хүснэгт 4.2	ТХГН-ийн Аялал жуулчлалын менежмент дэхь нутгийн иргэдийн оролцооны хэлбэрүүд	58
Хүснэгт 5.1	Чадамжийг хөгжүүлэхэд олон нийтийн оролцоог үнэлэх шалгуурууд	75
Хүснэгт 6.1	Хамгаалалттай газар нутгуудыг санхүүжүүлэх арга хэлбэрүүд	83
Хүснэгт 6.2	Сан Парк Байгалийн Цогцолборт Газрын (Өмнөд Африк) аялал жуулчлалын төрөл бүрийн хураамж, үнийн дүнгийн хамт	84
Хүснэгт 6.3	ТХГН-ийн нэвтрэх хураамжуудын харьцуулсан үзүүлэлт	86
Хүснэгт 6.4	Шинэ Зеландад концессийг хэрхэн ангилж, түүнийг хэрхэн хэрэгжүүлж буй жишээ	89
Хүснэгт 6.5	Концессийн үйл ажиллагааны цар, хэмжээг 5 улсын жишээгээр	91
Хүснэгт 6.6	ӨАБНУ-ын Байгалийн Цогцолборт Газруудын паркын орлогын эх үүсвэр, 2016	98
Хүснэгт 7.1	Энэхүү гарын авлагад багтсан шилдэг туршлагууд	104

ГРАФИК

График 3.1	Амралт зугаалгын боломжийн хамрах хүрээний хялбаршуулсан жишээ	38
График 3.2	Аялагчид, аялал жуулчлалыг зохицуулах стратегиуд	40
График 4.1	Төслийн менежментийн тойрог	48
График 4.2	IUCN-ийн веб хуудас дээрхи Дэлхийн өвийн газрууд программын хэрэглэгчийн хэсэг	56
График 6.1	Хамгааллын санхүүжилтийн дутууг нөхөх	82
График 6.2	Шийдвэр гаргахад хэрэглэдэг гадны болон дотоодын 3 гол асуулт	93

Өмнөх үг

ТХГН-ийг удирдаж, зохион байгуулах нь ТХГН-ийн ажилтнуудаас ажлын их ур чадвар, мэдлэг, туршлагыг шаарддаг үйл хэрэг юм. IUCN-с гаргасан ТХГН-уудын Шилдэг Туршлагауудын Цуврал нь чухам энэ үйл хэрэгт туслах зорилготой бөгөөд дэлхийн өнцөг булан бүрт байгаа тэргүүний арга, туршлагауудыг гаргаж үзүүлдэг билээ. Олон ТХГН-ууд нь аялал жуулчлалыг менежментийн зорилгодоо хүрэх нэгэн арга болгож ашигладаг ба үүнд нь хувийн хэвшлийнхэн зэрэг олон тооны сонирхогч талууд оролцдог. ТХГН-т аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх замаар менежментийн зорилгуудыг гүйцэлдүүлэх шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байгаа учир байгальд ээлтэй, тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх шинэ удирдамж бий болгох хэрэгцээ шаардлагыг үүсгэж иржээ. ТХГН дахь аялал жуулчлалыг тойрсон улс төр, хууль эрх зүй, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал нь улс орон бүрт харилцан адилгүй байдаг атлаа тэр дундаас авч хэрэглэх нийтлэг, баялаг ажлын арга, туршлагауд маш олноор оршсоор ирсэн байна.

IUCN-ийн WCPA нь олон жилийн турш Аялал жуулчлал ба ТХГН-ийн мэргэжилтнүүдийн бүлгээр (TAPAS) дамжуулан шилдэг арга ажиллагааг хөгжүүлэхэд чармайж иржээ. IUCN-ийн WCPA-ийн Пол Ийглс, Стефен Мккүүл, Кристофер Хайнз (Paul Eagles, Stephen McCool and Christopher Haynes) нарын 2002 онд эрхлэн гаргасан 8 дугаар цуврал болох ТХГН-уудын Шилдэг Туршлагын Зөвлөмжүүд нь чухал ач холбогдолтой мэдээллүүдээр хангаж ирсэн юм. Гэвч өнгөрсөн 15 гаруй жилийн хугацаанд олон өөрчлөлтүүд гарсан тул шинээр гарын авлага гаргах шаардлага үүсэв. Тэр зорилтыг энэхүү удирдамжаар хангахыг зорьсон юм. Энэ удирдамжинд дэлхийн 50 гаруй улс орны мэргэжилтнүүд зөвлөж, туршлагаасаа хуваалцсан бөгөөд өргөн олноор хэлэлцүүлж, мэргэжил нэгтнүүдээр сайтар шүүлгүүлэв. Анхны эхийг 2014 онд Сиднейд зохион байгуулагдсан IUCN-ийн ТХГН-уудын Дэлхийн ТХГН-ийн дээд хэмжээний уулзалт дээр нээснээс хойш цахим сүлжээнд байрлуулснаар салбарын мэргэжилтнүүд, IUCN-ийн шинжээчдийн олон удаагаар шүүлтүүр, хэлэлцүүлгээр орсон болно.

Байгаль хамгааллын үүднээс харах юм бол аялал жуулчлал, аялагчдыг удирдан зохион байгуулах нь түвэгтэй асуудал, сорилтуудыг араасаа дагуулж байдаг билээ. Дэлхийн улс орнуудын ТХГН-ийн хамгаалалтын захиргаадуг газар нутгийнхаа ихэнх хэсгийг аялал жуулчлалд ашиглуулах хэрэгтэйн зэрэгцээ, хамгаалах хэрэгтэй болдог. Гэтэл ТХГН-уудын зүгээс аялал жуулчлалыг хэр хэмжээнд дэмжих, хязгаарлах, зохицуулах, үнэ хөлс тогтоох, дэд бүтцийн ямар үйлчилгээг зөвшөөрөх, хамгаалалтын алба өөрөө гүйцэтгэх үү эсвэл нутгийн иргэд, сайн дурынхан, эсвэл бүр хувийн хэвшлийнхнээр гүйцэтгүүлэх гэх мэт олон асуудлуудыг шийдэх хэрэгтэй болдог. Үүнд хууль эрхзүй, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал мөн тухайн ТХГН-ийн экологийн онцлог гэх мэт олон хүчин зүйлс нөлөөлдөг.

Аялал жуулчлалын бүхий л төрлүүд нь байгаль орчинд ямар нэг нөлөө заавал үзүүлж байдаг бөгөөд хэмжээгээрээ өөр хоорондоо харилцан адилгүй. Жигнүүрийн нэг захад зэрлэг, онгон байгальд хамгийн бага нөлөө үзүүлдэг, явган ба усан аялал ордог. Аялалын энэ төрлийг дэлхийн олон ТХГН-уудад зөвшөөрдөг бөгөөд энэ тал дээр байгаль хамгаалах үйл ажиллагаанд саад бололгүйгээр аялагчдад үр өгөөж өгсөн аялал жуулчлалын шалгарсан, зөв менежментүүдийн талаар энэ удирдамжид багагүй үгүүлэх болно.

Жигнүүрийн нөгөө талд овор, хэмжээ томтой дэд бүтэц, байршуулах хэрэгсэл, хоолны газрууд байх бөгөөд зарим нь нэг өдөрт зуун мянган зочдод үйлчилж гаргах хэмжээний байна. Жуулчид олноороо очдог ТХГН-уудад ийм хэмжээний барилга, байгууламжууд хэрэгтэй байдаг боловч тэдгээрийг хэрхэн зөв, зүйтэй ашиглаж, ажиллуулах талаар асуудлууд гарч ирдэг. Аялал жуулчлалын энтерпренёрууд, аялал жуулчлалын холбоод, төрийн аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийн хувьд томоохон хэмжээний үл хөдлөх хөрөнгүүдийг орлогын эх үүсвэр гэж хардаг. Гэвч нийтийн эзэмшлийн ТХГН-ууд дахь аялал жуулчлалын хувийн хөрөнгө оруулалттай төсөл бүхэн амжилттай байсан түүх үгүй бөгөөд зарим тохиолдолд тэр бүү хэл экологи, нийгэм, санхүү болон хуулийн томоохон асуудал, бэрхшээлүүдийг бий болгосон байдаг. Жуулчид олноороо очдог ТХГН дахь дэд бүтцийн талаархи төсөөлөл, дизайн шийдэл ямар байх, үйл ажиллагааг зөв зүйтэйгээр удирдаж, зохион байгуулах зэрэг нь ТХГН-ийн хамгаалалтын албадуудад техник, улс төрийн томоохон асуудлууд үүсгэж байдаг.

Аялал жуулчлал нь нөгөө талаар ТХГН болон нутгийн иргэдэд эдийн засгийн үр өгөөж өгч, байгаль хамгаалах ажилд томоохон дэмжлэг үзүүлж болдог. Хөгжингүй олон улс оронд ТХГН болон түүний орчин дахь аялал жуулчлалын хөгжил нь ТХГН-т төрөөс бодлогын болон санхүүжилтийн дэмжлэг авах үндэслэл болдог. Аялал жуулчлал, зочлох үйлчилгээ нь нийгэм эдийн засаг, халамж үйлчилгээний ашиг тус бий болгож, хамгаалалтын захиргаадууд төлбөрөөр дамжуулан орлого бүрдүүлж чаддаг учир байгаль хамгаалах байгууллага, хувь хүмүүсийн хувьд лобби хийх нэг арга хэрэгсэл болж чаддаг. Саяханаас аялал жуулчлалын ач холбогдлын тоонд хүн байгальтай ойр байснаар сэтгэцийн болон биеийн эрүүл мэндэд ач тустай болох нь батлагдаж, үр өгөөж нь нэмэгдсээр байна.

Хөгжиж буй олон улс оронд арилжааны аялал жуулчлал эрхлэгчид гадаад орноос аялагчид, үйлчлүүлэгчид авчирах замаар гадаад валют олж ирдэг нь нийтийн эзэмшлийн, дундын болон хувийн ТХГН-уудад санхүүгийн шууд дэмжлэг болж байдаг. Ийм хэлбэрийн аялал жуулчлалыг амжилттай хэрэгжүүлэх нь менежментийн мэргэжлийн ур чадвартай, орон нутгийн зан заншил, соёлыг гярхай тусгасан, олон улсын зах зээлийн нөхцөл байдалд нийцсэн байхыг шаарддаг. Үүний зэрэгцээгээр боломж л гарвал байгальд амарч зугаалах сонирхолтой дотоодын аялал жуулчлалын зах зээлийг хөгжүүлэхийг хичээх хэрэгтэй. Арилжааны аялал жуулчлал нь донорууд, тусламжийн сангууд, ТББ-ууд болон нутгийн иргэдтэй түншлэх замаар ТХГН-т хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж, тодорхой төрөл зүйлийн амьтныг хамгаалахад тус нэмрээ өгч чаддаг. Аялал жуулчлалын ийм олон төрлийн үйл ажиллагаа, гадаад валютын өсөлт, бууралт дунд байгаль хамгаалах төсөл, хөтөлбөрөө хэрэгжүүлэх нь ихээхэн хэмжээний ур чадвар шаарддаг зүйл юм.

Дэлхий дахинаа Биологийн олон янз байдлын тухай Аичигийн Зорилтуудыг аль болох олон ТХГН-уудад хэрэгжүүлэхээр хичээж буй энэ цаг үед байгаль хамгааллын менежерүүдийн хувьд бусад салбартай үр дүнтэй ажиллах хэрэгцээ шаардлага гарч байна. Аялал жуулчлал, зочлох үйлчилгээ нь энэ хамтын ажиллагааг өргөжүүлэхэд гол түлхүүр арга хэрэгсэл болж чадах ч холбогдох газар нутгийн экологи, байгаль хамгааллын үнэ цэнийг хадгалж удирдан, зохион байгуулах тал дээр мэргэжлийн ур чадвар, арга туршлага шаардаж байгаа юм. Дэлхийн өнцөг булан бүрт орших ТХГН-уудын захиргаад, менежерүүдэд чухам эдгээр арга, ур чадваруудын талаар мэдүүлж, танилцуулахыг энэхүү удирдамжаар зорив.

Kathy MacKinnon

Dr Kathy MacKinnon
Дарга, IUCN-ны ТХГН-ийн WCPA

Trevor Sandwith

Trevor Sandwith
Захирал, IUCN-ны Дэлхийн ТХГН-ийн Хөтөлбөр

Талархал

Энэхүү гарын авлагыг IUCN-ийн ТХГН-уудын Олон улсын комисс (WCPA), ХБНГУ-ын Эдийн засаг, Хөгжлийн Яамны (BMZ)-ны нэрийн өмнөөс Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ) болон Францийн Гадаад Харилцаа, Олон Улсын Хөгжлийн Яамны дэмжлэгтэйгээр хэвлэв. Тэдний харамгүй дэмжлэгийн үр дүнд энэхүү гарын авлагын эхийг англи хэлээр бүтээж Франц, Герман болон Испани хэл рүү хөрвүүлсэн болно.

Энэ ажил нь IUCN-ийн WCPA Аялал жуулчлал ба ТХГН-ийн Мэргэжилтнүүдийн Бүлгийн (TAPAS) санаачилга байв. IUCN-ийн WCPA дор нэгдсэн хэд, хэдэн сайн дурын бүлгүүдийн нэг болох ТХГН-ийн Мэргэжилтнүүдийн Бүлэг нь 500 гаруй сайн дурынхнаас бүрдсэн байдаг. Тэдний зорилго нь ТХГН-т тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, байгаль, экосистем болон түүний соёлын үнэт зүйлийг хамтад нь урт хугацааны турш хамгаалах нэг хэрэгсэл болгох явдал юм. TAPAS бүлэг мөн ТХГН дахь аялал жуулчлалын талаархи мэдлэг, жишиг үйл ажиллагаанууд болон шилдэг туршлагаудыг түгээн дэлгэрүүлэх ажил хийдэг.

Энэхүү удирдамж нь IUCN ТХГН-уудын Олон улсын комисс (WCPA) эрхлэн гаргасан Шилдэг Туршлагын Зөвлөмжүүд 1992 он (McNeely, et al., 1992), 2002 (Eagles, et al., 2002) онуудад тус, тус хэвлэгдсэний дараа гарч буй 3 дахь удаагийн нэмэлт хэвлэл юм. Редакцийн зүгээс эдгээр анхдугаар удирдамжуудын зохиогчид болох Жефри МкНийли, Жеймс Торшел, Хектор Себаллос Ласкурин, Пол Ийглс, Стефан МкКүүл болон Кристофес Хэйнс нарт талархалаа илэрхийлье.

Бид энэхүү удирдамжинд өргөн олон нийтийн санаа бодол, мэдлэг, туршлагыг аль болох тусгах гэсэн үүднээс салбарын олон тооны зүтгэлтнүүд болон эрдэмтэн судлаачдыг оролцуулахыг зорив. Энэ зорилгодоо хүрэхийн тулд TAPAS-ийн олон нийтийн болон бусад мэргэжилтнүүдийн сүлжээ ашиглан удирдамж бүтээхэд орж ажиллах заруудыг тавьсан болно. 2012 онд БНС-ын Жежү арал дээр зохиогдсон IUCN-ийн Дэлхийн Байгаль Хамгаалах Их Хурал болон 2013 онд АНУ-ын Колорадо мужийн Денвер хотод болсон Жеорж Врайтийн Нийгэмлэгийн Бага Хурлын үеэр семинарууд зохиож, удирдамжийн бүтэц зохион байгуулалт, агуулга болон оруулж хавсаргах туршлагаудын талаар хэлэлцсэн байдаг. Энэхүү хоёр арга хэмжээнд 16 орны нийт 32 мэргэжилтэн оролцсон байдаг. Ийнхүү бид TAPAS-ийн гишүүдээс гадна, техникийн мэргэжилтэн, ТХГН болон аялал жуулчлалын мэргэшсэн шинжээчдээс бүрдсэн олон улсын 58 нэр бүхий гишүүдийг сонгон ажиллуулсан бөгөөд тэд хуваагдан бүлэг, хэсгүүд, харуулах жишээ зэргийг хуваан бичсэн болно. Удаах хуудсанд хүн тус бүрийг ажилласан бүлгүүдээр хуваан үзүүлэв.

Удирдамжийн төгсгөл хэсэгт хувь нэмрээ оруулсан зохиогчдын нэрсийг цагаан толгойн үсгийн дарааллын дагуу оруулсан болно.

2014 оны зун энэ удирдамжийн анхны ноорог бүрэн эхээрээ бэлэн болж, улмаар заавал биелүүлэх журам ёсоор IUCN-аар хянан шүүгдсэн болно. 2014 онд Австрали улсын Сидней хотод хуралдсан IUCN-ийн Олон Улсын Байгаль Хамгаалах Их Хурлын үеэр нэмэлт хэлэлцүүлгийг хийж, санал хүсэлтийг цуглуулсан байдаг. Энэхүү гарын авлага нь дараах мэргэжил нэгт эрхэмүүдийн өгсөн санал, хүсэлтийн ачаар өндөр түвшинд хүрсэн болно. Үүнд: Ражив Бартари, Адониа Бинтоора, Пол Ийглс, Жанет Маккей, Марсело Нотариани, Стефен МкКүүл, Сибил Рейдмиллэр, Ейк вон Русчковский, Диего Сберна, Жон Сениор болон Алесаандро Ванзелло нар болно. Дагалдах нэмэлт редакцийн ажлыг IUCN болон IUCN-ийн WCPA-ийн удирдлага дор Грейг Гревес (IUCN-ийн Шилдэг Туршлагын Удирдамжуудын редактор), Тревор Санвит (IUCN-ийн WCPA-ийн ТХГН-уудын Хөтөлбөрийн захирал), Кейти МакКиннон (IUCN ТХГН-уудын Олон улсын комисс (WCPA)) нар гүйцэтгэсэн болно. ТХГН-ийн WCPA-с нэмж томилсон 2 хянан тохиолдуулагч болох Пенелоп Фиггис, Роббин Бушел нар нэмэлт редакцийг хийсэн болно. Эдгээр хүмүүс нь хувиараа болон хамтдаа удирдамжийн сүүлчийн хувилбарууд дээр санаа оноогоо харамгүй өгч, дотор нь үгүүлж буй утга агуулгыг улам төгөлдөржүүлэхэд редакцийн хувьд үнэтэй хувьд нэмэр оруулсан болно.

Бид энэхүү гарын авлагыг хянан тохиолдуулах, ялангуяа гар бичвэрүүдийг энэхүү эцсийн форматанд оруулах хэцүү, нарийн чимхлүүр ажлыг Давид Хармонд туйлын ихээр талархаж буйгаа илэрхийлж байна. Түүний цуцашгүй их эрч хүч, хянан тохиолдуулах гайхамшигтай авьяас чадвар нь удирдамжийг боловсруулж дуусгах, батлуулах сүүлчийн ажлуудад тун чухал хэрэгтэй байсан эрч хүчийг өгсөн билээ. Мөн мэргэжлийн дизайнерийн хувьд тэвчээр, ур чадвар гаргаж удирдамжийн өнгө төрхийг бүрэлдүүлсэн Тад Мермерт талархъя.

Энэхүү нөр их хөдөлмөр шаардсан гарын авлагыг бүтээхэд төрөл бүрээр дэмжиж, тусалсан доктор Чесли Валден-Шрейнер, Анна Миллер нарт, мөн Хойд Каролина мужийн Их Сургуулийн (NCSU)-ийн докторантурт суралцаж байсан оюутнууд, төслийн дэмжигч нарт ахлах хянан тохиолдуулагчдын зүгээс онцгойлон талархахыг хүсч байна. Хойд Каролина мужийн Их Сургуулийн докторантуурт суралцаж байсан оюутнууд болон доктор Шиангю Шү, Вей-люн Цай, Жинжер Дийсон болон Пей-Инг-Лий, Реда Невеу, Жессика Дитмер зэрэг бусад мөр зэрэгцэн хамтран суралцагчид нь хэрэгцээт материалуудыг эх хэлнээс орчуулах, хэвлэлтэнд өрхөд туслах, цахим эх сурвалж олж өгөх гэх мэт сайн дурын ажлыг хийж гүйцэтгэн, тусалж дэмжсэн билээ.

Шилдэг туршлагуудын хамтын нийгэмлэг

Энэхүү удирдамж нь ТХГН-ийн менежерүүдэд үнэ цэнтэй мэдээлэл өгч, шинэ санаа төрүүлж, урам зоригоор тэтгэнэ хэмээн бид найдаж байна. Энэ удирдамжийг ашигласнаар ТХГН-ууд дахь аялал жуулчлалын шилдэг туршлагуудын хамтын нийгэмлэг бий болж, улмаар дэлхий нийтээрээ төрөл бүрийн харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан шилдэг туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх болов уу гэж найдна. Энэхүү хамтын нийгэмлэгийн дотор мэдлэг солилцох үйл ажиллагааг тэтгэх үүднээс Цахим Мэдээллийн Сан <http://go.ncsu.edu/iucn-sustainabletourism-bpg> дээр байршуулсан болно. Одоогоор түр сервер ашиглаж байгаа боловч яваандаа IUCN-ийн мэдлийн сервертэй болох юм. Энэхүү цахим сангийн зорилго нь дараах юм. Үүнд: (1) цахим хэлбэрээр унших болон дэлгэрэнгүй мэдээллээр хангах, мөн (2) Заавар, удирдамж, зөвлөмж, шинэ санаанууд бүртгэсэн мэдээллүүд зэргийг бусдад хуваалцах зорилгоор байрлуулах.

Бид энэхүү Удирдамж хийгээд Цахим Мэдээллийн Санг ТХГН-ийн менежерүүдэд тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэхэд нь зориулан ажилдаа бодитойгоор ашиглаж, тохируулан хэрэглэж байгаасай хэмээн хүсэмжилж, гаргав.

Юу-Фай Люнг, Анна Спэнсели, Глен Хвеннгаард, Ралф Бакли нар.

Монгол хувилбар

“Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал ба аялагчдын удирдлага, зохион байгуулалт” удирдамжийн монгол хувилбар нь Азийн бүсийн ТХГН-уудын түншлэл (АРАР) байгууллагын удирдлага дор БНСУ-ын ТХГН-уудын Удирдлага (KNPS)-ын санхүүжилтээр бүтээгдэв. АРАР нь Бүс нутгийн хэмжээнд ТХГН-ийн үр ашигтай удирдлага зохион байгуулалтыг улам сайжруулах зорилгоор төр болон сонирхогч талууд, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилгоор байгуулагдсан байгууллага юм.

Энэхүү удирдамжийг Монгол хэлнээ орчуулан бэлтгэхэд дараахи хүмүүсийн хүчин зүтгэл голлох үүргийг гүйцэтгэсэн болно.

Орчуулгын баг: Байгаль зэрлэг амьтдын хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын ажилтнууд болох Н.Одончимэг, С.Болорцэцэг, А.Отгонсүрэн, Б.Түвшинтунгалаг, О.Мэндбаатар, Л.Очирхуяг, Л.Чанцалхам, Б. Бүүвэйбаатар

Удирдсан: Көрк Олсон

Хянан тохиолдуулсан: Дашдооровын Гэрэлтөв, Пүрэвжавын Сувд, Базарсадын Чимэд-Очир, Ёндонгийн Бадрал.

Ерөнхий редактор: Дашдооровын Гэрэлтөв

MONGOLIA QUEST

Your Journey into Pure Adventure

Бүлэг тус бүрийн зохиогчид

Бүлэг 1- Зохиогчид: Yu-Fai Leung, Anna Spenceley, Stephen McCool and Paul F. J. Eagles. Case Box Оролцогч: B1.1 (Anna Spenceley). Бүлгийн зохицуулагч: Yu-Fai Leung.

Бүлэг 2-Зохиогчид: Anna Spenceley, Glen Hvenegaard, Robyn Bushell, Yu-Fai Leung, Stephen McCool and Paul F. J. Eagles. Шигтгээ жишээнүүд оруулахад тусалсан хүмүүс: B2.1 (Anna Spenceley), B2.2 (Mohammad Rafiq, Sibylle Riedmiller and Delphine M. King), B2.3 (Donald Hawkins), B2.4 (Chih-Liang Chao, Dau-Jye Lu and Mei-Hui Chen), B2.5 (Giulia Carbone and Maria Ana Borges), B2.6 (David Newsome, Young Ng and Jasmine Cardozo Moreira), B2.7 (Chelsey Walden-Schreiner), B2.8 (Ivana Damnjanović), B2.9 (Robyn Bushell), B2.10 (Lincoln Larson), B2.11 (Ralf Buckley). Бүлгийн зохицуулагчид: Anna Spenceley and Glen Hvenegaard.

Бүлэг 3 - Зохиогчид: Elizabeth Halpenny, Therese Salenieks, Robert Manning, Yu-Fai Leung and Anna Spenceley. Шигтгээ жишээнүүд оруулахад тусалсан хүмүүс: B3.1 (Anna Spenceley), B3.2 (Giulia Carbone), B3.3 (Dan Paleczny), B3.4 (Robert Manning and Anna Spenceley), B3.5 (Robert Manning). Бүлгийн зохицуулагчид: Elizabeth Halpenny, Therese Salenieks and Yu-Fai Leung.

Бүлэг 4 - Зохиогчид: Yu-Fai Leung, Elizabeth Halpenny, Therese Salenieks, Robert Manning, Ian Bride, Chelsey Walden-Schreiner Шигтгээ жишээнүүд оруулахад тусалсан хүмүүс: B4.1 (Therese Salenieks), B4.2 (Anna Miller), B4.3 (Chelsey

Walden-Schreiner), B4.4 (Chelsey Walden-Schreiner, Anna Miller and Yu-Fai Leung), B4.5 (Debbie Mucha), B4.6 (Luis Monteiro), B4.7 (Anna Hübner and Chelsey Walden-Schreiner), B4.8 (Dilya Woodward and Alexandra Vishnevskaya), B4.9 (Chengzhao

Wu, Xiaoping Zhang ба Jianghua Ran), B4.10 (Lisa King), B4.11 (Jorge Chávez), B4.12 (Jake Paleczny), B4.13 (Elizabeth Halpenny), B4.14 (Yu-Fai Leung, Anna Spenceley, Glen Hvenegaard and Ralf Buckley), B4.15 (Kelly Bricker, Chelsey Walden-Schreiner and Anna Spenceley). Бүлгийн зохицуулагчид: Yu-Fai Leung, Elizabeth Halpenny and Therese Salenieks.

Бүлэг 5 - Зохиогчид: Anna Spenceley, Susan Snyman, Sandra de Urioste-Stone and Stephen McCool. Жишээ шигтгээ оруулахад тусалсан: B5.1 (Chelsey Walden-Schreiner), B5.2 (Megan Epler Wood and Mark Milstein), B5.3 (Kamal Medhi and Rajiv Bhartari), B5.4 (Dan Paleczny and Erik Val), B5.5 (Susan Snyman and Dani Ndebele), B5.6 (Erin Seekamp and Lee Cervený). Бүлгийн зохицуулагчид: Anna Spenceley.

Бүлэг 6 - Зохиогчид: Andrew Rylance, Anna Spenceley, Marcello Notarianni, Andy Thompson, Midori Paxton, James Barborak, Peter J. Massyn, Paul F. J. Eagles, Ralf Buckley, Susan Snyman and Chelsey Walden-Schreiner. Жишээ шигтгээ оруулахад тусалсан: B6.1 (Andrew Rylance), B6.2 (Anna Spenceley), B6.3 (Chelsey Walden-Schreiner and Dashpurev Tserendeleg), B6.4 (Anna Spenceley), B6.5 (Anna Spenceley), B6.6 (Anna Spenceley), B6.7 (Jorge Chávez ба Kurt Holle), B6.8 (Susan Snyman and Dani Ndebele), B6.9 (Rajiv Bhartari). Бүлгийн зохицуулагчид: Anna Spenceley.

Бүлэг 7 - Зохиогчид: Glen Hvenegaard, Ralf Buckley, Anna Spenceley and Yu-Fai Leung. Жишээ шигтгээ оруулахад тусалсан: B7.1 (Chelsey Walden-Schreiner). Бүлгийн зохицуулагч: Glen Hvenegaard.



Гавайн арал дахь Биологийн олон янз байдлаар баян Галт Уулын Байгалийн Цогцолборт Газрын жим. АНУ. © Yu-Fai Leung



Гроноцкий дархан цаазат газрын Грейсэрс хөндий дахь харах цэг. ОХУ © Elena Nikolaeva

Хураангуй

Тусгай хамгаалалттай газруудыг аялал жуулчлалаар дэмжих нь

Тусгай хамгаалалттай газар нутгууд нь дэлхий нийтийн байгаль хамгаалах стратегид гол байр суурь эзэлдэг билээ. Аялал жуулчлал нь аялагчдыг тусгай хамгаалалттай газрын үнэ цэнтэй өвөрмөц байдалтай холбож өгснөөрөө байгаль хамгаалах эерэг хүч болж хувирдаг. Аялагчдын ТХГН-аас олж авсан үр өгөөж нь хувь хүний хөгжилд нөлөөлөхийн зэрэгцээ хамгаалалттай газрын үнэ цэнийг илүү мэдэрч, хамгаалах, дэмжих мэдрэмжийг төрүүлж байдаг.

Тусгай хамгаалалттай газрын эдийн засгийн үр ашиг нь үзэсгэлэнт онгон дагшин байгаль, зэрлэг ан амьтад болон нутгийн өвөрмөц соёлоос хамаарахаас гадна эдгээр хүчин зүйлс нь хамгаалалтад авах нэгэн том шалтгаан болдог. Дэлхийн аялал жуулчлалын салбарын нэг том урсгал бол тусгай хамгаалалттай газрын аялал жуулчлал бөгөөд үзүүлэх нөлөө болон хэмжээ нь асар том юм. Жуулчдын томоохон урсгалаас үүдэн суурь дэд бүтэц болон үйлчилгээний ажиллах нөөц шаардагдаж эхэлдэг ба улмаар эдийн засаг, нийгэм, соёлын салбар болон хүрээлэн буй орчинд нөлөөлж эхэлдэг.

Тогтвортой аялал жуулчлалыг бий болгосноор Биологийн олон янз байдлын конвенц (CBD)-ийг хэрэгжүүлэх Стратеги төлөвлөгөө 2011-2020, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн Зорилго, болон Аялал жуулчлал ба Соёлын тухай Мускатын тунхаглал (UNWTO and UNESCO, 2017)-ын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэсэн үг юм. Гэсэн хэдий ч буруу төлөвлөгдсөн аялал жуулчлал нь эсрэгээрээ хамгаалалттай бүс нутгийн биологийн олон төрөл зүйл болон байгалийн тогтцод сөрөгөөр нөлөөлөх талтай байдаг.

Энэхүү удирдамж нь голчлон тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж буй аялал жуулчлалын мэргэжилтнүүд, засаг захиргааныхан, менежерүүд, төлөвлөгчид, засгийн газрын төлөөлөгч нар, төрийн бус байгууллагууд, нутгийн иргэдийн нөхөрлөлүүд, газар эзэмшигчид болон уугуул иргэдэд зориулагдсан юм. IUCN-ийн WCPA-с гаргасан сайн туршлагаудын талаар өмнө нь гарсан 2 цуврал дээр суурилсан энэ удирдамжинд тусгай хамгаалалттай газрын аялал жуулчлалыг удирдлагын төвшинд оновчтой, сайн удирдаж, байгаль хамгаалах зорилгоо хэрэгжүүлэхэд туслах зорилготой болно.

Энэхүү удирдамжинд тусгай хамгаалалттай газар нутаг дахь аялал жуулчлалын болоод аялагчдын менежментийн чухал ойлголтуудыг тусгасан болно. Доорх элементүүд нь энэхүү баримт бичигт тусгагдсан хамгийн чухал хэсгүүд юм. Үүнд:

1. Аялал жуулчлал, аялагчдын менежментэд баримтлах 10 зарчмын хэлэлцүүлэг;
2. Тогтвортой аялал жуулчлал хөгжсөнөөр ямар ч нөхцөлд бодит байдал дээр хэрхэн хэрэгжиж болдогийг танилцуулсан "Шигтгээ" хаягтай жишээнүүд;
3. Жишээ тус бүрээс авч, ашиглаж болох гол санаа, мэдлэгүүдийг тусгасан "Шилдэг Туршлагаудын Гол Санаа"-нууд;
4. Бүлэг бүрийн төгсгөлд Шилдэг Туршлагын Гол Санаануудыг жагсаасан жагсаалтууд зэрэг болно.

Ерөнхий тойм, шилдэг туршлагууд

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежерүүдийн хувьд экологийн бүрэн бүтэн байдал, үнэт зүйлсийг алдагдуулахгүйгээр аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялагчдад боловсролын ач холбогдолтой, утга төгөлдөр үр өгөөж өгөх, хамгаалалтын менежментийн орлогыг нэмэгдүүлэх ачаа нь улам бүр нэмэгдсээр байна. Тусгай хамгаалалттай бүс нутагт аялал жуулчлалыг удирдан зохион байгуулах нь өндөр хэмжээний ур чадвар, цогц мэдлэгийг шаарддаг. Тус удирдамж нь дэлхийн өнцөг булан бүрийн шилдэг туршлагуудыг цуглуулж, тэдгээрийг хэрэглэж болох газруудад сурталчилан таниулахад чиглэсэн юм. Бидний гол зорилго бол байгаль орчныг хамгаалах үйл явцыг урт удаан хугацаанд, орон нутгийн болон бүс нутгийн хэмжээнд дэмжсэн тогтвортой аялал жуулчлалын хэлбэрийг сурталчилахад оршино.

Нэгдүгээр бүлэгт ТХГН-ийн аялал жуулчлалын ерөнхий ойлголтууд, дэлхий нийтийн байгаль хамгааллын үйлсэд оруулах боломжтой хувь нэмэр, менежменттэй холбоотой сорил, бэрхшээлүүдийн талаар танилцуулна. ТХГН дахь аялал жуулчлалын шилдэг туршлагуудаас гол шинж чанаруудыг нь гаргаж тавьсан болно.

Тусгай хамгаалалттай газрын аялал жуулчлал нь хүрээлэн буй орчин, эдийн засаг, нутгийн ард иргэд болон жуулчдад олон нөлөө үзүүлдэг. Хоёрдугаар бүлэгт өөр өөр үнэ цэнтэй оролцогч талууд аялал жуулчлалаас гардаг эерэг ба сөрөг нөлөөг хэрхэн хүлээн авч болдог талаар хураангуйлсан байгаа. Шилдэг туршлагууд нь дараах шинж чанарыг үзүүлсэн байдаг:

- Байгаль хамгаалахад хувь нэмэр оруулдаг үндэсний аялал жуулчлалын бодлогыг дэмжиж, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа болон орон нутгийн иргэдэд эдийн засгийн үр өгөөжийг бий болгодог.
- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг зах зээлтэй нь холбон дэмждэг.
- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээг хүргэх чиглэлээр бизнесийг хөгжүүлэх, менежментийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулдаг.
- ТХГН дахь амралт, зугаалгын үйл ажиллагааг нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцүүлж, олон нийтийг хамарсан том зорилтуудыг хангахын төлөө шинээр төлөвлөдөг.

Судалгаа шинжилгээ болон практик туршлагаас суралцсан зүйлс дээр үндэслэн аялал жуулчлалыг амжилттай хөгжүүлэхэд олон нийт болон нутгийн иргэдийн дэмжлэгийг нэмэгдүүлэх 10 зарчмыг тодорхойлсон байна. Гуравдугаар бүлэгт 1-6 хүртэлх зарчмуудыг хэлэлцэхдээ ТХГН-ийн менежментийн зорилтуудыг аялал жуулчлалын эерэг ба сөрөг нөлөөллүүдтэй хэрхэн уялдуулах талаар тусгасан байна. Энэ бүлэгт аялал жуулчлалын дэд бүтэц, арилжааны аялал жуулчлал болон аялагчдын ашиглалтын менежментийг зөв зүйтэй төлөвлөх нь ямар ач тустай байдгийг үзүүлжээ. Энэ хэсэгт дурдсан шилдэг туршлагууд нь дараах зүйлсийг агуулна:

- Тухайн байршил дахь бүтээн байгуулалтын дизайн болон барилгын ажлыг төлөвлөхдөө байгаль орчинд үзүүлэх нөлөө нь хамгийн бага, урт удаан хугацаанд ашиглагдах, дахин боловсруулах боломжтой, хүртээмжтэй, тогтвортой материалууд сонгох.
- ТХГН-ийн баримталдаг үнэ цэнэ, зорилго зорилтууд, холбогдох шалгуур үзүүлэлтүүд, стандартад суурилсан менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх.

- Харилцан бие биенээ нөхөж, дэмжиж байдаг менежментийн арга, техникүүдийг нэгтгэн ашиглах.

Дөрөвдүгээр бүлэгт тогтвортой аялал жуулчлалын дасан зохицох менежменттэй холбоотой 7-оос 10-р зарчмуудыг оруулжээ. Эдгээр зарчмууд нь аялагчдын хэрэгцээ шаардлага, туршлага, нөлөөлөл, иргэдийн оролцоо, түншлэл, боловсрол, харилцаа холбоо, мэдээллийн технологи ба маркетингийг хянах шинэлэг аргууд дээр илүү төвлөрнө. Дасан зохицох менежментийн шилдэг жишээнүүдэд дараах орно:

- Судлаач иргэн болон бусад хөтөлбөрөөр дамжуулан сайн дурын ажилтнуудын ур чадвар, урам зоригийг менежментийн үйл ажиллагаанд ашиглах.
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн мониторингийг шаардлагатай техник технологи, санхүүгийн хангалттай үүсвэртэй уялдуулан холбох.
- Ямар үнэ цэнийг хамгаалж буйгаа ойлгосны үндсэн дээр үйл ажиллагаагаа тодорхойлж, менежментийн тохирох арга зам, практик туршлагуудыг хэрэглэдэг байх.
- Байгаль орчны боловсрол олгох, мэдээлэн тайлбарлах хөтөлбөрүүдэд ТХГН-ийн аль үнэт зүйлсийг сонгохоо стратегийн төвшинд төлөвлөх.
- Байгаль орчны боловсрол олгох, мэдээлэн таниулах хөтөлбөрүүдэд ТХГН-ийн аль үнэт зүйлсийг сонгохдоо стратегийн түвшинд төлөвлөх.
- Аялагчдад дэлхий дахинд болж буй ижил төстэй асуудал бэрхшээлүүдийг ойлгуулан тайлбарлах замаар асуудлын өргөн цар хүрээг ойлгуулж байх.
- Маркетинг, сурталчилгааны стратеги гаргахаасаа өмнө судалгаа, анализаар дамжуулан оршин суугчдын талаар гүнзгий ойлголттой болох.
- Аялал жуулчлал, түүний нөлөөллийн бодлого, төлөвлөлт, менежментийн, мониторингийн хүрээг багтаасан аялал жуулчлал, биологийн төрөл зүйлийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн удирдамжуудыг дагах.

Тавдугаар бүлэгт жуулчид, түншлэл, аялал жуулчлалын орлогыг удирдан зохион байгуулах ТХГН-ийн менежер, нутгийн иргэд болон сонирхолын бүлгүүдийн чадавхийг дээшлүүлэхтэй холбоотой асуудлуудыг хөндсөн болно.

Чадавхи бэхжүүлэх оролдлого хэр үр ашигтай байх нь ур чадвар, мэдлэгийн нарийвчилсан үнэлгээ хэр сайн хийгдсэн, сургалтын тодорхой зорилтууд, оролцогч талуудын хүлээлт, бүтээлч түншлэл, шаардлагатай техник технологийн ашиглалт хэр байгаа зэргээс хамаардаг.

Чадавхи бэхжүүлэхтэй холбоотой шилдэг жишээнүүдэд дараах орно:

- Аялал жуулчлалыг газар дээр нь төлөвлөхдөө үзэл баримтлалын загвар, суурь үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дасан зохицох менежмент хийх боломж олгосон системд суурилсан үйл ажиллагааг дагаж мөрдөх.
- Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг оролцогч талуудтай хамтран боловсруулах.
- Орон нутгийн иргэдийн аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх чадавхийг үнэлж цэгнэх.
- Түншлэлээр гүйцэтгэсэн бүх ажил үйлсийг бүртгэж, хүлээн зөвшөөрсөн байх.

Зургаадугаар бүлэгт аялал жуулчлалаар дамжуулан санхүүгийн тогтвортой эх үүсвэртэй болж чадсан дэлхийн ТХГН-уудын жишээг оруулсан бөгөөд тухайн тэргүүн туршлага нь хэрхэн амжилтанд хүрснийг дэлгэрүүлэн тусгасан болно. Эдгээрийн түгээмэл шинж байдал нь санхүүгийн сахилга бат, хураамжийн цогц бодлого, концесс болон бүх төрлийн тусгай зөвшөөрлүүд, орлого хуваарьлах шударга бөгөөд шилэн аргачилалтай байгаа зэргийг агуулж байна. Энэ талын шилдэг туршлагуудад дараах орно:

- ТХГН-ийн (эсвэл нийт системийнх нь) нэвтрэх хураамжийн хэмжээг тогтоохын өмнө бүрэн хэмжээний санхүүгийн үнэлгээг хийх.
- Жуулчин болон тур операторуудаас хураамжийн хэмжээний талаар санал асуулга авах. Ижил төстэй орон нутгийн болон бүс нутгийн ТХГН-ийн хураамжийн хэмжээтэй уялдуулах.
- Жуулчны үйл ажиллагаа эрхлэгчидтэй байгуулах гэрээнд хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалал, тогтвортой үйл ажиллагааг дэмжих нөхцөл боломжийн талаар оруулж өгөх.
- Концессийн гэрээнд нийт ажилчдын тодорхой хувийг орон нутгаас бүрдүүлэх, боломжтой тохиолдолд орлогыг орон нутагт зарцуулах, үйлчилгээний гэрээг орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай тусгах.

Долоодугаар бүлэгт дэлхийн хүн амын өсөлт, уур амьсгалын өөрчлөлт зэрэг нь аялал жуулчлалын эрэлт, аялалын төрөл, ТХГН-ийн ашиглалтын хэв байдлыг хэрхэн өөрчилж байгаа, тэдгээрийн эсрэг ТХГН-ийн менежментийг хэрхэн тохируулан өөрчилж, хор хөнөөлийг нь бууруулсан арга хэмжээ, харилцааны зөв стратеги авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар тус, тус өгүүлнэ.



Далайн Игуана гүрвэл (*Amblyrhynchus cristatus*) ба жуулчид далайн эрэг дээр хамтдаа. Galápagos арал, Эквадор улс © Yu-Fai Leung



Намрын алхалт. Үндэсний Ойн БЦГ, Итали улс © Yu-Fai Leung

ТХГН ДАХЬ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА ЗОЧДЫН НӨӨЦ АШИГЛАЛТЫН МЕНЕЖМЕНТ

Тогтвортой хөгжлийн удирдамж

1



© Chelsey Walden-Schreiner

1.1 ТХГН-т тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нь

Байгаль хамгаалах үйлсэд томоохон байр суурь эзэлдэг, яригдах ёстой сэдэв бол аялал жуулчлал юм. Дэлхийн хүн ам нэмэгдэж, алс зайд хурдан тээвэрлэх боломжууд бүрдсэнээр аялал жуулчлал нь байгаль болон соёлын өв хадгалж үлдсэн газар нутаг, далайн эргийн үзэсгэлэнт газруудад төвлөрөх болжээ. Ийм газрууд нь ихэвчлэн тусгай хамгаалалттай газар нутгууд байдаг. Байгалийн үр шимээс хамаардаг аж үйлдвэрийн салбаруудаас ялгаатай нь аялал жуулчлалд байгалийн үзэсгэлэнт газрууд, зэрлэг амьтад, онгон дагшин газар нутаг болон уугуул соёл заншил хэрэгтэй байна. Иймд үндэсний орлого нэмэгдүүлж, ажлын байр бий болгох аялал жуулчлалын чадамж нь байгалийн нөөцийг бараа, бүтээгдэхүүний түүхий эд болгон ашиглахаас илүү унаган байгалийг нь хадгалах, зохистойгоор ашиглах чухал хүчин зүйл болж чаддаг байна.

Энэхүү удирдамж нь төлөвлөгөө, бодлого боловсруулагчид, ТХГН-ийн менежерүүд болон байгаль хамгаалах чиглэлээр ажилдаг бусад мэргэжилтнүүдэд ТХГН-т аялал жуулчлалыг зохистойгоор удирдан зохион байгуулж, хамгаалах зорилгуудаа хэрэгжүүлэхэд нь туслах зорилготой юм.

Аялал жуулчлалын зохих төрлүүдийг сонгож хөгжүүлэхэд тодорхой бодлого баримталж, юунд анхаарч, зайлсхийх талаар урьдчилан тооцоолсон байх учиртай.

Дэлхийн өнцөг булан бүрт ТХГН-ийн менежерүүд өдий төдий тооны, заримдаа өөр хоорондоо зөрчилдсөн зорилтууд хангахын төлөө ажиллаж байна.

Тэд ТХГН-таа үр өгөөжтэй, боловсрол танин мэдэхүйд түшиглэсэн үйл ажиллагаа явуулж, байгаль хамгаалах үйл ажиллагааг дэмжсэн орлого төвлөрүүлж, иргэдийн оролцоо, үр өгөөжийг хангах үүрэгтэй ажилладаг атлаа хажуугаар нь хэт төвлөрөл, хэт хөгжүүлэлт, хог хаягдал зэрэг аялал жуулчлалын сөрөг үр дагаваруудаас сэргийлж ажиллах шаардлагатай байдаг. Иймд энэхүү удирдамж нь төлөвлөгөө зохиогчид хийгээд хамгаалалтын захиргааны менежерүүдэд эрх, үүргээ тэнцвэртэйгээр биелүүлэхэд нь хэрэг болох тэргүүний арга туршлагуудаар хангах зорилготой болно.

Менежерүүдэд тулгардаг гол бэрхшээл бол тогтвортой хөгжлийг хангах явдал гэж ойлгож болох юм. ТХГН-уудад бидний хэрэгжүүлэхээр зорьж буй аялал жуулчлал нь ердийн нэг аялал жуулчлал биш харин “тогтвортой” буюу “тулхтай” аялал жуулчлал болно.

Тогтвортой буюу тулхтай аялал жуулчлалыг дараах байдлаар тодорхойлдог:

“Эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчинд тухайн цаг үе хийгээд ирээдүйд гарах үр дүнг бүрэн тооцсоны үндсэн дээр аялагчид, салбар, байгаль орчин болон нутгийн иргэдийн хэрэгцээг хангасан аялал жуулчлалыг хэлнэ” (UNWTO & UNEP, 2005: 11–12) гэжээ.

Аялал жуулчлалын боломжит ашиг тус, сөрөг нөлөөллийн өргөн цар хүрээг нь нягт нямбай тооцохдоо дараах суурь зарчимуудад үндэслэх ёстой. Тухайлбал:

ТХГН-ууд дахь аялал жуулчлал нь тогтвортой байхын тулд нэн түрүүнд зөвхөн богино эсвэл ойрын хугацаанд бус урт удаан хугацаанд байгаль орчныг хамгаалах үйл явцад хувь нэмэр оруулсан, мөн байгаль хамгаалах үйл ажиллагаа нь

Шигтгээ 1.1

Гол нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү удирдамжид ашигласан хамгийн чухал гэсэн ач холбогдолтой нэр томъёоны тодорхойлолтыг оруулав. Тодорхойлолтуудыг нь тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) үзэл санаад нийцүүлсэн бөгөөд үндсэн тодорхойлолтууд ба нэр томъёоны бусад тайлбарыг гарын авлагын төгсгөлд, үгийн тайлбар хэсэгт тусгасан болно.

Нутгийн (угтан авагч) иргэд: ТХГН-ийн ойролцоо амьдрах тодорхой гишүүдээс бүрдсэн нийгмийн хэсэг бүлэг хүмүүс. Иргэдийн энэ бүлэг нь төрийн нэгдсэн захиргаатай байх бөгөөд түүх, соёлын нийтлэг өвтэй байж болно.

Зочин буюу аялагч: ТХГН-т аялагч гэдэг нь тухайн газарт зөвшөөрсөн бүсэд газар, усаар зорчиж буй хүн юм. ТХГН-ны захиргаанд орон тооны хамааралгүй, дотор нь оршин суудаггүй иргэнийг аялагч гэнэ. Аялахыг зөвшөөрсөн бүсүүд нь ихэвчилэн амралт зугаалга, боловсрол, эсвэл соёлын арга хэмжээний зориулалттай аялахыг зөвшөөрсөн газрууд байдаг.

Жуулчин: Аялалынхаа үеэр ТХГН дотор хоноглож буй аялагчийг жуулчин гэнэ

Аялагчдын ашиглалт: Тусгай хамгаалалттай газарт аялах аялагчдад хамааралтай ашиглалт, үйлчилгээг хэлнэ.

Аялал жуулчлал: Өөрийн амьдарч буй орчноос (энэ тохиолдолд ТХГН) нэг жилээс илүүгүй хугацаагаар гадагш аялж, оршин суух иргэний үйл ажиллагааг хэлнэ.

Тогтвортой аялал жуулчлал: Өнөөгийн болон ирээдүйн эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг бүрэн тооцож, аялагчид, үйлдвэр, байгаль орчин болон орон нутгийн (эзэн) иргэдийн эрэлт хэрэгцээг хангасан ТХГН дахь аялал жуулчлалыг хэлнэ.

Эх сурвалж: Hornback and Eagles, 1999; UNWTO & UNEP, 2005; Spenceley, et al., 2017b; UNWTO, 2018

аялагчдын зохисгүй үйлдэл хийгээд удирдлага, зохион байгуулалтын алдаанаас болж доголдохгүй байхаар нөхцлүүдийг бүрдүүлсэн байх шаардлагатай. Эдгээр нь Олон Улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) тусгай хамгаалалттай газар нутгийн үндсэн тодорхойлолттой нягт уялдсан ойлголтууд юм. Тухайлбал:

“Байгаль орчныг урт удаан хугацаанд экосистемийнх нь үр ашиг, оршин буй соёлын үнэт зүйлсийнх нь хамт эрх зүй, бусад үр ашигтай арга хэрэгсэл хэрэглэн хамгаалж, ашиглаж байгаа, хүлээн зөвшөөрөгдсөн газар зүйн орон зай” (-г тусгай хамгаалалттай газар нутаг хэмээнэ) гэжээ. (Dudley, 2008: 7; нэмэлт нэр томъёоны тодорхойлолтыг 1.1-р шигтгээ мэдээллээс үзнэ үү)

Энэхүү үндсэн зарчмыг харгалзан бид тусгай хамгаалалттай газар нутагт тогтвортой буюу тулхтай аялал жуулчлалыг бодлого, төлөвлөлтөөс нь менежмент хүртэлх бүхий л үе шатанд тусгаж өгөх ёстой. Тухайлбал:

- Экологийн үйл явцууд, хүмүүст гоо сайхан, сэтгэлийн сайхан мэдрэмж төрүүлдэг чанарууд, мөн биологийн олон янз байдлыг алдагдуулахгүйгээр жуулчдыг татдаг байгаль, соёлын үнэт зүйлсийг хадгалж, хамгаалах;
- Уугуул болон нутгийн иргэдийн эрх, тэдний нийгэм, соёлын мөн чанарыг хүндэтгэж, өв соёл, уламжлалт үнэт зүйлсийг нь хадгалан хамгаалж, өөр соёл, удамжлалтай хүмүүсийн хоорондын харилцаа, хүлцэл тэвчээрийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах;
- Аялал жуулчлалтай холбогдсон бүх зөвшөөрөл эзэмшигчид болон оролцогч талууд нутгийн эзэн иргэдэд тогтвортой ажлын байр, орлого олох боломж, нийгмийн үйлчилгээ үзүүлсэн, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулсан үйл ажиллагааг явуулдаг байх.
- Аялагч, зочдод байгаль орчин, тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдлыг ойлгуулсан, өндөр чанартай аялал жуулчлал хөгжүүлэх боломжуудаар хангах (UNWTO & UNEP, 2005-д оруулсан). ТХГН-т аялал жуулчлалыг хөгжүүлэх, удирдан зохион байгуулах ажилд оролцдог бүх хүмүүс эдгээр үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхийг зорих ёстой. Эдгээр зорилгод нийцэхгүй, тогтвортой биш аялал жуулчлалыг ТХГН-т нэвтрүүлэх ёсгүй.

ТХГН-т ямар аялал жуулчлалыг тогтвортой, тулхтайд тооцохыг шийдэхэд амаргүй. Учир нь дараах асуултуудад хариулах шаардлагатай болдог. Үүнд:

- ТХГН болон түүний ойролцоох нутагт ирэх аялагчдын хөл хөдөлгөөнийг тогтвортойгоор зохицуулсан төлөвлөлтийн хууль тогтоомж, дүрэм журам, дэд бүтэц байна уу?
- Аялагч, жуулчдын хөл хөдөлгөөнийг зохицуулж, мониторинг хийхэд тухайн газрын үнэт зүйлсийн судалгааг хийж, баримтжуулсан эсэх?
- Аялал жуулчлалын хөгжил, хэрэгцээг хангахад ТХГН-ийн эрхэм зорилго, зорилтууд зөрчилдөж байна уу?
- Дэд бүтцийн хамрах хүрээ, төрөл юу байх вэ? Тэдгээрийг хаана байрлуулах вэ? (хоноглох байр г.м.)

- ТХГН-ийн эрхэм зорилго, зорилтуудыг харгалзан үзсэний үндсэн дээр биофизикийн нөлөөллийг ямар түвшинд хязгаарлах вэ?
- Зар сурталчилгааны үйл ажиллагааг жуулчдын зах зээлийн аль сегментэд чиглүүлэх ёстой вэ?
- Менежментийн зүгээс аялал жуулчлалын ямар хэлбэрийг хөгжүүлж, ямар төрлүүдээс зайлсхийх вэ?
- Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч этгээд нь хэн бэ? Аж ахуйн нэгжүүд үү төрийн бус байгууллага уу? Эсвэл хамгаалалтын захиргааны ажилтнууд уу?
- ТХГН-ийн эрхэм зорилго, зорилтыг харгалзан үзсэний үндсэн дээр биологийн олон янз байдал, байгальд үзүүлэх нөлөөллийг ямар түвшинд байхыг зөвшөөрөх вэ?
- Нутгийн иргэд ямар төрлийн үйлчилгээ үзүүлж, ямар цар хүрээнд оролцох вэ?
- ТХГН-т эсвэл орчны бүсэд буй нутгийн иргэд аялал жуулчлал хөгжүүлэхэд хэрхэн идэвхтэй ажиллаж, үр шимээс нь хүртэх вэ?
- Аялал жуулчлал, аялагчдаас олсон орлогыг менежмент, байгаль хамгаалах үйлс, нутгийн иргэдэд хэрхэн хүртээх вэ?
- Дээрхи асуудлуудыг шийдвэрлэхийн тулд байгаль хамгааллын төлөвлөлт болон аялал жуулчлалын бодлогод хэрхэн нөлөөлж болох вэ?
- Нэг талдаа аялал жуулчлалаас гарах үр нөлөө, нөгөө талдаа жуулчдад өгөх үр өгөөжийн зохистой хэмжээг менежментийн зүгээс хэрхэн тогтоож, төлөвлөх вэ?
- Менежментийн үйл ажиллагаа, түүний ажлын үр дүнд мониторинг хэрхэн хийх вэ?

ТХГН-т аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нэн түрүүнд дээрхи асуултуудыг авч хэлэлцэх ёстой бөгөөд шийдлүүд нь хамгаалалттай газрын зорилго, зорилтуудтай уялдсан байх ёстой. Хүснэгт 1.1-д IUCN-ийн ТХГН-ийн зургаан ангилалыг харуулсан бөгөөд тус бүрийн менежмент нь аялал жуулчлалтай хэрхэн холбогдож, ангилал тус бүрд байж болохуйц аялагчдын төрлийг үзүүлжээ. Энэхүү удирдамж нь төлөвлөгөө зохиогчид болон холбогдох менежерүүдэд ТХГН-ийн зорилго, зорилтуудтай нийцсэн аялал жуулчлалыг хэрхэн зохиож, зохион байгуулахад нь туслах зорилготой билээ.

1.2 Тогтвортой хөгжлийг хангасан ТХГН болох боломж

Бодит байдал дээр менежерүүдийн хувьд санасандаа хүрч ажиллах нь тун бага байдаг. ТХГН-ийн үйл ажиллагаа нь улс төр, нийгэм, эдийн засгийн өргөн цар хүрээнд дор явагддаг. Менежерүүдэд санхүүгийн хангалттай нөөц, ажилтан болон бусад эх үүсвэр байдаггүйгээс гадна оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллээр дутагддаг. ТХГН-т тогтвортой аялал жуулчлалыг бий болгоход аялал жуулчлалаас орж ирэх ашгийг хамгийн өндөрт байлгахын зэрэгцээ сөрөг үр нөлөөг багасгаж, аливаа өөрчлөлтүүдэд дасан зохицох шаардлага үүсдэг.

ТХГН дахь аялал жуулчлалын өөрийн өвөрмөц шинж чанар нь байгаль хамгаалах үйлсэд эерэг нөлөөлөл болж байдаг. Аялал жуулчлал, амралт зугаалга, аялагчдын хэрэглээ нь тусгай хамгаалалттай олон газруудын хувьд чухал бүрэлдэхүүн хэсэг нь болсоор иржээ. Аялагчид нь байгаль, соёлын өвийг танин мэдэж, ач холбогдолыг нь ойлгож авдаг. Ийм харилцаа нь хувь хүний өсөлт, сайн сайхан байдалд нөлөөлж, орон нутгийн түвшинд тэдний хариуцлага, өмчлөлийн мэдрэмжийг нэмэгдүүлдэг (Walker & Chapman, 2003).

Аялал жуулчлал нь үр дүнтэй байхын тулд эдийн засгийн олон салбарын дэмжлэгийг шаарддаг бөгөөд орон нутгийн болон үндэсний эдийн засгийг дэмжин, орлого бүрдүүлж чаддаг. Товчхондоо, ТХГН-ийн аялал жуулчлал нь боломж, бэрхшээлийн аль алиныг нь бий болгож байдаг (Хүснэгт 1.2).

Хүн амын тоо өсөж, байгалийн баялгийн эрэлт нэмэгдэж байгаа өнөө үед хамгаалалттай газар нутаг дахь байгалийн аялал жуулчлалаас гарах эдийн засгийн үр өгөөж нь байгаль хамгааллыг дэмжих томоохон хөшүүрэг болж чадна.

ТХГН-ийг түшиглэсэн аялал жуулчлал нь дэлхийн аялал жуулчлалын салбарын томоохон хэсэг бөгөөд цар хүрээ, нөлөө нь ч асар их байдаг. НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас (UNWTO) мэдээлснээр 2017 онд олон улсын жуулчдаас орох орлого 1.33 тэрбум давсан бөгөөд олон улсад аялал жуулчлалаас орох орлого нь 1.34 их наяд ам.доллараар нэмэгдсэн нь дэлхийн ДНБ-ий 10 хувийг эзэлж байна (UNWTO, 2018). Олон улсын аялал жуулчлал нь 2030 он хүртэл жилийн 3.3 хувийн өсөлттэй үргэлжлэх бөгөөд дотоодын аялал жуулчлал үүнээс хамаагүй давна гэж таамаглаж байна. Аялагчдын ийм өндөр тоо нь суурь дэд бүтэц, хөдөлмөр эрхлэлт, үйлчилгээний эрэлт хэрэгцээг бий болгож байдаг нь эргээд эдийн засаг, нийгэм, соёл, хүрээлэн буй орчинд нөлөөлөх хүчин зүйлс болдог билээ. ТХГН-т дээрхи бүх хүчин зүйлс нөлөөлж байдаг.

Хэрэв аялал жуулчлалыг тогтвортой, тулхтайгаар зохион байгуулж чадвал дэлхийн хэмжээнд ТХГН-уудын тоо, төрөл болон зөв удирдлага, зохион байгуулалттай менежментийн эгнээг нэмэгдүүлэх сайн талтай байдаг. Аялал жуулчлал нь Биологийн олон янз байдлын конвенцийн (CBD) 2011-2020 оны Биологийн Олон Янз Байдлын Стратегийн Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шууд хувь нэмэр оруулж, байгаль хамгаалал, олон нийтийн хөгжил, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд ихээхэн дэмжлэг үзүүлж чадна (McCool & Moisey, 2008; UNWTO, 2010; Buckley, 2012a; Hvenegaard et al., 2012; CBD, 2015; UNEP-WCMC & IUCN, 2016).

2004 онд CBD-ийн батламж доор Биологийн олон янз байдал, аялал жуулчлалыг хөгжүүлэх удирдамжийг (CBD, 2004) баталж, шилдэг туршлага, тэдгээрийн хэрэглээний талаарх жишээ бүхий гарын авлагыг 2015 онд хэвлэн сурталчилжээ (CBD, 2015). Мөн түүнчилэн 2030 он хүртэл ядуурлыг арилгах, эх дэлхийгээ хамгаалах хөгжлийн шат ахихад чиглэсэн нийт 17 зорилго бүхий НҮБ-ын "Тогтвортой Хөгжлийн Зорилго"-уудыг (SDGs) хэрэгжүүлэхэд аялал жуулчлал нь хувь нэмрээ оруулах боломжтой юм. Тогтвортой хөгжлийн зорилгууд нь НҮБ-ын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн гол цөм болж, үүнд аялал жуулчлал нь 8-р зорилго (эдийн засгийн тогтвортой өсөлт), 12-р зорилго (тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл),

14-р зорилго (далай, тэнгис, далайн нөөцийг хадгалах, тогтвортой ашиглах) болон 15-р зорилго (хуурай газрын экосистемийг хамгаалж, сэргээж, тогтвортой ашиглахыг дэмжих, ойг тогтвортой ашиглаж, цөлжилттэй тэмцэж, газрын доройтлыг зогсоон сэргээж, биологийн олон янз байдлын мөхлийг зогсоох) зэрэгт тус тус тусгагдсан байдаг (<http://www.un.org/sustainabledevelopment>).

ТХГН бүрт аялагчид, нутгийн уугуул иргэд, сонирхогч талууд болон ард иргэдэд ойлгуулж мэдүүлэх өвөрмөц үнэт зүйлс байдаг. НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага (ЮНЕСКО)-ын Шим Мандлын Нөөц Газар, ЮНЕСКО-гийн Дэлхийн Өв, ЮНЕСКО-гийн Дэлхийн Геопарк болон Рамсарын ус намгархаг газар зэрэг олон улсын статустай болсон ТХГН-уудын хувьд байгаль, соёлын өвийн хувьд дэлхийд хосгүй гэдгээ нэмж харуулах шаардлага үүсдэг. Энэхүү чухал ажлыг гүйцэтгэх хамгийн гол арга хэрэгслийн нэг бол тогтвортой аялал жуулчлал билээ.

1.3 ТХГН дахь аялал жуулчлалын олон улсын ойлголтууд

Аялал жуулчлалыг амжилттай зохион байгуулахад менежер, ажилтнууд нь асуудлынхаа олон улсын илүү том хүрээний ойлголт, агуулгыг мэдсэн байх шаардлагатай болдог. Сүүлийн үед дэлхий дахинд болж буй том үзэгдэл бол ТХГН-ийг хамгаалах чиглэлээр олон улсын хамтын ажиллагаа, зохицуулалт эрчимжиж байгаа явдал юм. Эдгээр хандлага нь 1970-аад оноос хойш гарч ирсэн олон улсын чанартай ТХГН-ийн тодорхойлолтууд, санал санаачилгуудаас харагддаг. Эдгээр санаачилгад Дэлхийн өв, Рамсарын конвенц, Биологийн олон янз байдлын конвенц (CBD) зэрэг заавал биелүүлэх гэрээ, ЮНЕСКО-гийн Хүн ба Биосферийн хөтөлбөр, түүний биосферийн олон улсын сүлжээ, нөөц гэх мэт сайн дурын хүчин чармайлтууд болон мөн саяхан бий болсон Биологийн олон янз байдлын түншлэл (IUCN, 2017c) зэрэг багтана. Эдгээр нь бүгд байгаль хамгааллын стандартууд болон, холбогдох хяналт мониторинг, нөхөн сэргээлт хийх нөхцөл, шаардлагуудыг тогтоож өгсөн байдаг. Дээр дурдагдсан олон улсын чанартай тодорхойлолт авахын тулд ТХГН - ууд нь дурдсан стандартуудыг хангахаас гадна бүх түвшинд холбогдох хууль тогтоомжинд нийцсэн байх хэрэгтэй болдог.

Эдгээр бүх санаачилгууд нь аялал жуулчлалд хамааралтай болно.

Дэлхийн өв

Дэлхийн өвийн конвенц нь байгаль, соёл болон холимог өвийн дурсгалыг хүлээн зөвшөөрч, хамгаалах дэлхийн хамгийн чухал арга хэрэгсэл юм. Нийт 193 улс нэгдэн орсон энэхүү конвенцын гэрээг ЮНЕСКО-гийн дэргэдэх нарийн бичгийн дарга нарын газар хариуцаж, Дэлхийн Өвийн Хорооноос удирддаг. Байгалийн өвд бүртгэх эсэхийг шийддэг Дэлхийн өвийн конвенцийн зөвлөлдөх гурван комиссийн нэгт IUCN багтдаг. ТХГН-ийн хувьд өндөр ач холбогдлын зэргийг илтгэдэг Дэлхийн өвийн жагсаалтанд "хүн төрөлхтний хувьд хосгүй үнэ цэнэтэй"-д тооцогдох онцгой газар нутгийг багтаадаг. Дэлхийн улс орнуудын хувьд Дэлхийн өвийн жагсаалтад багтсан газар нутгаа аялал жуулчлалын онцгой чиглэл болгон сурталчлах нь элбэг. Энэ нь аялал жуулчлалыг ямар

хэмжээнд, ямар чиглэлээр хөгжүүлэх нь зүйтэй вэ гэдэг асдлууд дэвшүүлэх болжээ. Нэг талаараа аялал жуулчлал нь Дэлхийн өвийн жагсаалтад багтсан дурсгалт газрын хосгүй үнэ цэнийг аялагчдад таниулах нэг боломж юм (Шигтгээ 4.10, хууд.54). ЮНЕСКО нь Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн дурсгалт газруудын менежерүүдэд зориулан тогтвортой аялал жуулчлалын цахим зааварчилгааг бий болгосон бөгөөд түүнийг өөр бусад ТХГН-уудад ч ашиглаж болдог. Энэхүү зааварчилгаа нь ТХГН-ийн менежерүүдэд үндсэн ойлголтуудаас (стратегийн, засаглал) эхлэн харилцаа холбоо, дэд бүтэц болон бусад чиглэлүүдээр нарийн мэдээлэл бүрээр алхам алхмаар чиглэл өгдөг байна.

(http://whc.unesco.org/sustainable_tourism_toolkit/how-use-guide).

Шим мандлын нөөц газар

Шим Мандлын Нөөц Газрууд нь Дэлхийн Өвийн Жагсаалтад орсон газруудын адил ЮНЕСКО-оод харьялагддаг, олон улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын сүлжээний нэг юм. Нөөц газар тус бүр биологийн олон янз байдлыг тогтвортой ашиглалттай уялдуулах шийдлүүдийг дэмжинэ. Мөн нийгэм, экологийн тогтолцооны өөрчлөлтийг ойлгож удирдан зохион байгуулах, мөн түүнчлэн зөрчлөөс сэргийлж, биологийн олон янз байдлыг удирдан зохион байгуулах зэрэгт салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажиллахад ач холбогдол өгдөг. Тогтвортой аялал жуулчлал нь Шим Мандлын Нөөц Газрын үйл ажиллагааны зорилгыг хангахад чухал үүрэгтэй бөгөөд тодорхой тооны шим мандлын нөөц газруудын менежментийн түвшинд сайжруулалт хийж ажиллаж байна.

(<http://www.unesco.org/new/en/natural-sciences/environment/ecological-sciences/biosphere-reserves/>).

Дэлхийн геопаркууд

Дэлхийн Геопаркууд нь ЮНЕСКО-оод харьяалагддаг, олон улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын сүлжээний нэг юм (<http://www.unesco.org/new/en/natural-sciences/environment/ecological-sciences/biosphere-reserves/>).

Дэлхийн геопарк нь “Олон улсын геологийн ач холбогдол бүхий тогтоц, ландшафтыг нь нэгдсэн байдлаар хамгаалж, боловсрол олгож, тогтвортой хөгжүүлэх менежментээр зохицуулдаг газарзүйн нэгдмэл бүс нутаг” юм

(<http://www.unesco.org/new/en/natural-sciences/environment/earth-sciences/unesco-global-geoparks/>).

2017 оны байдлаар ЮНЕСКО-ийн (GGN) 38 гишүүн орны 140 геопарк бүртгэгдсэн байна (GGN, 2018). Дэлхийн геопаркууд нь “геологийн аялал жуулчлал”-ын томоохон төвүүд болж өгдөг бөгөөд үзэсгэлэнт тогтоцууд, чулуужсан олдворууд, эрдэс чулуулгуудаас авахуулаад хуучны уурхай, усан үзмийн талбай гэх мэт өөр хоорондоо эрс ялгаатай сонирхол татам газруудаас бүрддэг (Шигтгээ 2.6, хууд.16).

Рамсарын ус намгархаг газрууд

Олон улсын ус намгархаг газар ялангуяа усны шувууд олноор цуглардаг орчныг хамгаалах тухай Рамсарын конвенцийн тогтоосон ач бүхий ус намгархаг газруудыг Рамсарын ус намгархаг газрууд гэж нэрлэдэг. Рамсарт орсон олон газрыг “жуулчдыг татах ус, намгархаг газрууд” гэж үздэг бөгөөд конвенцийн зорилго, үйл ажиллагааны хүрээнд UNWTO-ийн тодорхойлсон тогтвортой аялал жуулчлалын үзэл санаатай уялдуулан холбоход анхаардаг. Ус, намгархаг газар нь жуулчдын, ялангуяа шувуу ажиглагчид болон зэрлэг амьтад сонирхогчдыг ихээр татдаг. Энэхүү конвенцийн хүрээнд олон янзын төрөл зүйл, тэдний амьдрах орчныг хамгаалахтай холбогдуулан баримтлах аялал жуулчлалын удирдамж, бодлогууд гаргажээ (Рамсарын конвенц and UNWTO, 2012).



Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь ТХГН-т олон хэлбэрээр явагддаг. АНУ-ын Вашингтон хотын ойролцоох Потомак голын дагуу Чесапик, Огайо каналын үндэсний паркт явган аялал хийж буй байдал (Зүүн) © Yu-Fai Leung. Кени улсын Масай Мара улсын ДЦГ-ын зэрлэг амьтдыг харж байна (Баруун). © Anna Spenceley.

Хүснэгт 1.1. IUCN ТХГН-ийн ангилал болон аялагчийн ашиглалт, аялал жуулчлалын менежментийн хандлага

IUCN Тусгай хамгаалалт-тай газар нутгийн ангилал *	Үндсэн зорилго, хамгааллын үнэ цэнэ	Аялал жуулчлал, аялагчдын ашиглалтын зөвшөөрөх хэм хэмжээ	Аялагчдын төрөл					
			Хувь хүн	Судлаачид	Арилжааны хэрэглэгчид	Жуулчид ба амрагчид	Шашин, соёлын жуулчид	Давтан аялагчид
Ia) Дархан цаазат газар	Биологийн олон янз байдал, гео-өв соёлыг хамгаалах (экологийн болон шинжлэх ухааны үнэ цэнэ агуулсан)	<ul style="list-style-type: none"> Зөвхөн зохион байгуулалттай эрдэм шинжилгээ, иргэдийн шинжлэх ухаан эсвэл сайн дурын үйлчилгээний хөтөлбөрөөр дамжуулан нэвтэрч болно 	✓	✓			✓	
Ib) Онгон зэрлэг газар	Хөндөгдөөгүй эсвэл маш бага хөндөгдсөн байгалийн онцлог бүхий газрын хамгаалал (онгон газар болон экологийн үнэ цэнэ бүхий)	<ul style="list-style-type: none"> Цөөн тооны, үйлчилгээ шаардахгүй, бие даасан аялагчдыг нэвтрүүлэх нь менежментийн зорилго байна. Үйл ажиллагааны цар хүрээ, аялагчдын тоо, хамрах талбайг хязгаарлана. Аялал жуулчлалын үйл ажиллагааг хязгаарлаж, өндөр хараа хяналт дор явуулна. (жишээлбэл ашиглалтын тусгай зөвшөөрөл өгөх г.м.) 	✓	✓				
II) Байгалийн цогцолборт газар	Экосистем, түүний экологийн үйл явцын хамгаалал (экологи, амралт зугаалга, нутгийн иргэдийн үнэ цэнэ)	<ul style="list-style-type: none"> Аялагчдын хэрэгцээ, үр өгөөжтэй аялах явдлыг хангах нь менежментийн зорилго байна. Дотор нь бүсчилсэн хувааж, тохирох дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлэх замаар аялагчдын амрах, зугаалах боломжийг бүрдүүлдэг (ТХГН дотор жуулчдын байршуулах хэрэгслийг шийдэх тал дээр өөр, өөрийн онцлогийг гаргасан байдаг). 	✓	✓	✓	✓	✓	✓
III) Байгалийн дурсгалт газар	Байгалийн өвөрмөц төрхийг хамгаалах (экологи, амралт зугаалга, нутгийн иргэдийн үнэ цэнэ)	<ul style="list-style-type: none"> Аялагчдын хэрэгцээ, үр өгөөжтэй аялах явдлыг хангах нь менежментийн зорилго байна. Аялагчдыг амрах зугаалах боломжийг хангасан байдал нь байгаль хамгаалал, олон нийтийн ойлголцол дээр түшиглэсэн байна. 	✓	✓	✓	✓	✓	✓
IV) Амьдрах орчин / зүйлүүдийг хамгаалах менежмент бүхий бүс нутаг	Менежментийн арга хэрэгсэл ашиглан байгаль хамгаалах үйл ажиллагаа (экологи, нутгийн иргэд, амралт зугаалгын үнэ цэнэ)	<ul style="list-style-type: none"> Амралт, зугаалгын болон арилжааны аялал жуулчлал хөгжүүлэх нь менежментийн зорилтуудын нэг байна. Холбогдох байр сав, дэд бүтэц, үйлчилгээг зүүлэх замаар төрөл бүрийн амралт зугаалгын нөхцлөөр хангана. Зэрлэг амьтад ажиглах аялал жуулчлалыг хөгжүүлсэн байна. 	✓	✓	✓	✓	✓	✓

V) Эх газар/ Далайн эргийн Хамгаалагдсан газрууд	Ландшафт/ далайн эргийн хамгаалал (нутгийн иргэд, экологи, амралт зугаалгын үнэ цэнэ)	<ul style="list-style-type: none">• Менежментийн үндсэн зорилго нь аялал жуулчлал байна.• Холбогдох байр сав, дэд бүтэц, үйлчилгээгээр хангах замаар төрөл бүрийн амралт зугаалгын нөхцлийг бүрдүүлнэ.• Арилжааны аялал жуулчлал нийтлэг түгсэн байна.	✓	✓	✓	✓	✓	✓
VI) Байгалийн нөөц газар	Байгалийн экосистемийг тогтвортой ашиглах (нутгийн иргэд, амралт зугаалга, экологийн үнэ цэнэ)	<ul style="list-style-type: none">• Амралт, зугаалгын болон арилжааны аялал жуулчлал хөгжүүлэх нь менежментийн үндсэн зорилтууд байж болно.• Холбогдох байр сав, дэд бүтэц, үйлчилгээгээр хангах замаар төрөл бүрийн амралт зугаалгын нөхцлийг бүрдүүлнэ.• Арилжааны аялал жуулчлал нийтлэг түгсэн байна.	✓	✓	✓	✓	✓	✓

* Иш татав. Dudley (2008), Dudley, et al. (2013), and Spenceley, et al. (2015).
** ТХГН дахь соёлын ач холбогдолтой дурсгалт газруудыг эргэн зорих гэх мэт ТХГН-руу давтан аялагчид (Spenceley, et al. 2015: 720).

Хүснэгт 1.2. ТХГН-ууд дахь аялал жуулчлалын менежментийн боломж ба бэрхшээлүүд

Боломжууд	Бэрхшээлүүд
Өндөр чанартай, мэдээлэн тайлбарлах аргаар ТХГН-н үнэ цэнийг иргэдэд ойлгуулах замаар байгаль, соёлын өв хамгаалах үйлсийг талархан дэмждэг иргэдийн тоог нэмэх.	ТХГН-д ашиг хонжоо хайсан байдлаар хандаж, аялалын шинэ бүтээгдэхүүн, ашиг хонжоо олох төдий хэрэгсэл болгосноор байгаль хамгаалах үйл хэргийг нь орхигдуулах.
Идэвхтэй аялагчдыг зохион байгуулалтын ажилд гар бие оролцуулж, тэднээс санхүүгийн шууд дэмжлэг авах замаар (хураамж, концессын төлбөр г.м.) байгаль хамгаалах үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах.	Аялал жуулчлалын ашиг сонирхол нь хэт давамгайлснаар ТХГН дахь байгаль, соёлын өвийг хадгалж хамгаалах зорилготой сайн менежментийн үйл хэргийг хэрэгжүүлхэд саад болох.
ТХГН-ийн аялал жуулчлал нь орон нутгийн болон бүс нутгийн эдийн засагт чухал гэдгийг хүлээн зөвшөөрснөөр улс төрийн дэмжлэг, менежментийн санхүүжилтийг нэмэгдүүлэх үндэслэл болно.	ТХГН-ийн аялал жуулчлалын ач холбогдол нь ТХГН болон түүний орчныг хэт их хөгжүүлэх, улс төрийн шийдвэр гаргахад хүргэх.
Дэд бүтцийн эмзэг асуудлыг төлөвлөх, учруулсан хохирлыг арилгах, аялагчдийн нөлөөллийг бууруулах, (гаргасан зам, жимийг нягташруулах гэх мэт) аялал жуулчлалын үр нөлөөг эерэг байлгах.	Бохирдол (хог хаягдал, нүүрстөрөгчийн ялгаралт гэх мэт), нөөцийг тогтворгүй ашиглах (ус гэх мэт), эмзэг газрыг гэмтээх (муу хөгжсөн эсвэл дэд бүтэцийг оновчгүй газар барих байдлаар гэх мэт) зэрэг нь хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлнэ.
Орон нутгийн соёлыг (дэлгүүр, гар урлал, дуу хөгжим, хоол хүнс зэргээр дамжуулан) танилцуулж, тайлбарлан ойлгуулах, боловсрол танин мэдэхүйн үйл ажиллагаануудаар соёлын өвийн үнэт зүйлсийг сурталчилж, хамгаалах замаар ТХГН-ууд дахь нийгэм, соёлын хүн хүрэх үр өгөөжийг нэмэгдүүлэх.	Нутгийн иргэдэд сөрөг үр дагаварууд авчирна. Жишээ нь соёлыг бараа бүтээгдэхүүний хэв загварт оруулах, уламжлалт аж ахуйг эвдэх, гэмт хэрэг гарах, хэт их бөөгнөрөл үүсгэх, аялал жуулчлалын бүтээн байгуулалтын зорилгоор иргэдийг нүүлгэн шилжүүлэх, уламжилалт нөөцөд нэвтрэх эрхийг нь алдуулах, онгон, шүтээн газрыг гэмтээх, гутаан доромжлох, жуулчдын хөл, хөдөлгөөнд даруулах гэх мэт. Аялал жуулчлал нь амжиргааны өртгийг нэмэгдүүлж, инфляц хөөрөгддөг.

ТХГН болон түүний орчны бүсэд байгаа иргэдэд нийгэм, эдийн засгийн үр өгөөж бий болгосноор нутгийн иргэдийн зүгээс зэрлэг амьтдын хоолоо олж идэх, амьдрах орчноо хадгалах зорилготой үйлдлүүдийг тэвчдэг, хамгаалдаг болно.	Үр өгөөжөөс хүртэж чаддаггүй амьжиргааны түвшин доогуур иргэд өөрсдийгөө болон эд хөрөнгөө хамгаалах эсвэл ашиг олох зорилгоор зэрлэг амьтдыг устгаж хөнөөнө.
Аялал жуулчлалын орон нутгийн эзэмшилтэй капитал, аялал жуулчлалын бизнесийн үйл ажиллагаа, ажил эрхлэлт, амьжиргааны нэмэлт эх сурвалж болон аялал жуулчлалын хангамжийн сүлжээн дэхь бизнес эрхлэлт (хөтөч тайлбарлагч хийх, гар урлал, хоол хүнс, тээвэр гэх мэт) зэргийн хооронд уялдаа холбоог сайжруулсанаар орон нутагт төвлөрсөн эдийн засгийн холбоосыг дэмжих.	Мэдээллийн дутмаг байдал, санхүүгийн хүртээмжгүй байдал, бодлого зохицуулалт, залгамж чанар хангалтгүй зэргээс болж эдийн засгийн эерэг холбоосууд үр дүнгээ өгч чадахгүй алдагддаг.

Тусгай хамгаалалттай бүс нутгуудын сүлжээ

Дэлхий дээр бүс нутгийн хэмжээнд тусгай хамгаалалтад авсан газрууд олон бий. Эдгээр тусгай хамгаалалттай газрууд нь газарзүйн онцлог байдлаараа хөрш зэргэлдээ улсуудтайгаа холбогддог. Үүний нэг жишээ нь Европын Холбооны Natura 2000 систем болон Зүүн Өмнөд Азийн орнуудын нийгэмлэгийн (АСЕАН) Өв Соёлын Паркуудын сүлжээ юм. Бүс нутгийн түвшинд тогтвортой аялал жуулчлалтай холбоотой удирдамж, баримтлах зарчим зэргийг хэд хэдэн улс орнууд нэгдэн боловсруулж гаргадаг. Жишээлбэл: ТХГН-ууд дахь Тогтвортой аялал жуулчлалын европын тунхаг бичиг (EUROPARC, 2010) болон Зүүн Азийн тусгай хамгаалалттай газар ба хүрээлэнд хэрэгжүүлэх Аялал жуулчлалын зөвлөмж зэргийг нэрлэж болно (Eagles, et al., 2001). Энэтхэг, Непалын арав гаруй тусгай хамгаалалттай газар нутгийг хамрах, Терай Арын Ландшафт нь уудам орон зайг хамарсан, хил дамнасан байгаль хамгаалах үйл ажиллагаа юм. Энэ нь үндэстэн дамнасан бүс нутгийн сүлжээний нэг хэлбэр бөгөөд аялал жуулчлал эрчимтэй хөгжүүлж буй. Амьтдын амьдрах орчин хийгээд биологийн төрөл зүйл нь хоорондоо холбогдсон, том хэмжээг хамарсан тусгай хамгаалалттай газар нутгуудын сүлжээнд илүү амжилттай хамгаалагдаж чаддагийг хил дамнасан байгаль хамгаалах үйл ажиллагаа харуулж байна.

(<https://www.protectedplanet.net/c/connectivity-conservation>).

Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD)

Олон улсын өөр нэг гэрээ бол Биологийн олон янз байдлын тухай конвенц (CBD) юм. Хэдийгээр тусгай хамгаалалттай газар нутгийг шууд тогтоон тодорхойлдоггүй боловч дэлхийд орон нутаг-төвтэй байгаль хамгаалах үйлс дэлгэрүүлэхэд өөрийн "иж бүрэн, сайн менежменттэй, тогтвортой санхүүжилттэй, үндэсний болон бүс нутгийн, дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрсөн тусгай хамгаалалттай газар нугийн тогтолцоо" бий болгох Тусгай Хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагааны хөтөлбөрөөрөө дамжуулан чухал үр нөлөө үзүүлдэг. (<https://www.cbd.int/protected/>).

CBD Конвенцын аялал жуулчлалын удирдамжийг (CBD, 2004) олон улс орнууд нэгдэн боловсруулсан бөгөөд биологийн олон янз байдалд аялал жуулчлалаас үзүүлэх нөлөөллийг шийдвэрлэхэд үзүүлэх гол тулгуур баганы нэг хэвээр байна.

Зэрлэг Амьтдын Нүүдлийн Зүйлүүдийг Хамгаалах тухай Конвенц (CMS)

Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенц (CMS) нь нүүдлийн амьтад, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, тогтвортой ашиглахад чиглэсэн нь дэлхийн хамтын ажиллагааны индэр юм (CMS, 2018). Аялагчид нүүдлийн амьтдыг ихээхэн сонирхдогийг анзаарсны дүнд CMS нь НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөртэй хамтран аялал жуулчлалын ашиг тус, түүний эрсдэлийн талаар томоохон судалгааг хийсэн байдаг (UNEP & CMS, 2006).

Дэлхийн аялал жуулчлалын байгууллага

Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага (UNWTO) нь НҮБ-ын тогтвортой, нийтийг хамарсан аялал жуулчлалыг сурталчлах үүрэгтэй байгууллага юм. UNWTO нь аялал жуулчлалыг НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг (SDGs) хангах нэг хэрэгсэл хэмээн тооцдог бөгөөд тогтвортой аялал жуулчлалын санал, санаачилгуудыг санхүүжүүлж ажилладаг. Үүний нэг нь улс орон болон хамгаалалтын захиргаанд зориулсан тогтвортой аялал жуулчлалын стандартууд боловсруулдаг. Дэлхийн тогтвортой аялал жуулчлалын зөвлөл болно. Зах зээлд өөрсдийгээ тогтвортой аялал жуулчлал эрхэлдэгээ батлахыг зорьсон улс орон, ТХГН-ууд дээрхи стандартуудыг дагаж, мөрдсөн байх шаардлагатай байдаг (Шигтгээ 4.15, хууд.59). Нөгөө нь Тогтвортой хөгжлийн зорилтуудын 12-р зорилтод багтсан хариуцлагатай хэрэглээ болон үйлдвэрлэлийг хангахад хувь нэмэр оруулдаг Тогтвортой Аялал Жуулчлалын 10 жилийн хөтөлбөр (10YFP) юм.

(<http://sdt.unwto.org/about-10yfp-stp>).

1.4 ТХГН-ийн аялал жуулчлалын шилдэг туршлага: онцлог шинж чанарууд

Тусгай хамгаалалттай газрын менежерүүд болон бусад шийдвэр гаргагчдад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нь туслах зорилгоор энэхүү Удирдамжинд хэд хэдэн шилдэг туршлагуудаас санал болгож байна. Тэдгээрийг тогтвортой аялал жуулчлалд хүрэх зам харгуйн гэрэлтүүлэгч шонгууд хэмээж ч болох юм. Гэрэлтэй шон олон байх тусам нэгнээс нөгөөрүү дамжсаар зорьсон газартаа амархан хүрдэгийн адил.

Юуг, яагаад сайн туршлага хэмээж буйг ойлгохын тулд тэдгээрийн дунд орших нийтлэг шинж чанаруудыг мэдэх нь чухал юм. ТХГН-ууд дахь аялал жуулчлалын шилдэг туршлагууд нь дараах мөн чанаруудыг агуулдаг аж. Үүнд:

- “Гурвалсан суурь зарчим”-уудийг дагаж мөрддөх. Энэ нь нэр томьёоны хувьд бусад салбарт ч өргөн хэрэглэдэг бөгөөд гаргасан амжилтыг дан ганц эдийн засгийн үр өгөөжөөс гадна байгаль орчин, нийгмийн салбарт гаргаж байгаа үнэ цэнээр нь хэмжихийг хэлнэ. Дараах гурвалсан суурь зарчимаар ТХГН дахь тогтвортой аялал жуулчлалыг хэмжинэ. Үүнд: (1) байгаль хамгаалахад (хүрээлэн буй орчны үнэ цэнэ) хувь нэмэр оруулах; (2) ТХГН-ийн менежментийн зардалд дэмжлэг үзүүлэх, нутгийн иргэдийн тогтвортой амьжиргаанд нэмэр болох байдлаар эдийн засгийн үр ашгийг бий болгох (эдийн засгийн үнэ цэнэ); (3) нийгэм, соёлыг дэлгэрүүлэхэд хувь нэмэр оруулах (нийгмийн үнэ цэнэ).
- Тусгай хамгаалалттай газрын мөн чанартай нийцсэн байх. Аялал жуулчлалын шилдэг туршлага нь тухайн ТХГН-ийн өвөрмөц нөхцөл байдал бүрт тохирсон шинжтэй байдаг. Нэг газрын шилдэг туршлага өөр газарт яг таг таарах албагүй. Сонгох олон аргуудын зөвхөн нэг нь байж болдог. Өөрөөр хэлбэл энэхүү удирдамжинд санал болгосон шилдэг туршлагууд нь уян хатан шинж чанартай. Тухайн менежер хүн зохих үнэлгээ шинжилгээг хийж, өөрийн нөхцөл байдалдаа тохируулан ашиглах нь зөв юм.
- Аялагчдад дээд зэрэглэлийн сэтгэл ханамж өгөх нь чухал юм. Аялал жуулчлалыг байгаль орчныг хамгаалах, нутгийн иргэдийг хөгжүүлэх үр дүнтэй арга хэрэгсэл болгоё гэвэл аялагчдад өгөх үр өгөөжийн чанарыг хадгалахад анхаарах хэрэгтэй болно (McCool, 2006). Аялагчдын авах үр өгөөжийг “хувь хүний дотоод ертөнц хийгээд түүний хийж буй үйл хөдлөл, оршин байгаа нийгэм, байгаль орчинтойгоо холбоотойгоор авч буй сэтгэл ханамж нь нарийн нийлэмж” гэж тодорхойлжээ (Borrie & Roggenbuck, 1998:115). Аялагч хүн өндөр үр өгөөжийг бие бялдар сорьсон, сурч мэдсэн, олон нийтийн харилцаанд орсон зэрэг төрөл бүрийн амралт, зугаалгаас олж авна.
- Байгаль хамгаалах ёс зүйг бий болгох. Хамгаалалтын захиргааны менежер, ажилтнууд, аялал жуулчлалын тур операторуудын ТХГН-уудад эрхэлдэг үйл ажиллагаа нь өөр газарт хийдэг үйл ажиллагаанаас чанарын хувьд огт ялгаатай байх

ёстой. ТХГН-ийн аялал жуулчлалын үндсэн зорилго бол үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, цаашлаад аялагчдад байгаль хамгаалах ёс зүйг сурталчлах явдал юм. Тусгай хамгаалалт бүхий газрыг хамгаалах шаардлагыг ойлгосон аялагч цаашид урт удаан хугацааны дэмжигч болж ч хувирах магадлалтай. Зарим тохиолдолд жуулчдыг буяны сан эсвэл бусад аргаар дамжуулан аялж байгаа газрынхаа байгаль хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулах саналыг эелдэгээр илэрхийлж болдог.

- Сөрөг нөлөөлөөл болон үр ашгийн аль алийг тооцох. ТХГН дахь менежментийн бүхий л арга хэмжээ, хичнээн сайн жишээн дээр суурилсан байлаа ч заавал алдаа, дутагдал гаргаж л байдаг. Сайн туршлага байхын мөн чанар нь үүнийг хүлээн зөвшөөрөхөөс эхлэх бөгөөд үр ашиг, сөрөг нөлөөллийг эрт илрүүлэхээс эхэлнэ. Нийгэм ба хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, дүн шинжилгээ, мониторинг хийх шаардлагатай байдаг.
- Орон нутгийн иргэдийн онцгой хэрэгцээнд хүндэтгэлтэй байх. ТХГН-ийн аялал жуулчлалын үр ашгийг ханган нийлүүлэгчид хүртэхийн зэрэгцээ нутгийн иргэд ч хүртэж байх ёстой. Үүний нэгэн адил хэрэв аялал жуулчлалаас орон нутагт сөрөг үр нөлөө гарвал гол хохирогчид нь нутгийн иргэд байх ёсгүй.

1.5 Энэ удирдамж яагаад шинээр гарах болсон бэ?

Энэ удирдамж нь практик үйл ажиллагаа эрхлэгчид, шинжээчид, онолын судлаачдын олон жилийн туршид хуримтлуулсан баялаг мэдлэг дээр үндэслэснийг номын төгсгөлийн хэсэгт байгаа ашигласан эх сурвалжуудын жагсаалтаас харж болно. Онцлон тэмдэглэхэд ТХГН дахь аялал жуулчлалын талаар өмнө нь гарсан хоёр удирдамжийн шинэчилэн найруулсан ажил болно. Эдгээр нь (1) НҮБ-ын UNWTO болон НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөрийн хамтран гаргасан Үндэсний парк ба ТХГН дахь Аялал Жуулчлалын Хөгжил (McNeely, et al., 1992). (2) ТХГН дахь Тогтвортой аялал жуулчлал: Төлөвлөлт ба Менежментийн Удирдамж (Eagles, et al., 2002) тус тус билээ. Сүүлийнх нь IUCN-ийн ТХГН дахь Тэргүүний Арга Туршлагын Удирдамж цувралын нэг хэсэг болж байжээ. Энэ хоёул одоо ч гэсэн ач холбогдлоо алдаагүй бөгөөд мэдээллийн үнэтэй эх сурвалжууд байсаар байна. Гэвч ТХГН дахь менежментийн бүх талбарт өөрчлөлт, хувьслууд асар хурдан явагддагаас өнгөрсөн 15 жилийн дотор шинэ асуудлууд урган гарч, тэдгээрийг шийдвэрлэх шинэ санаанууд ч зэрэгцэн гарсаар иржээ. Үүнд хоёр чухал бүтээл байгаагийн нэг нь дээр дурдсан CBD-ийн биологийн олон янз байдал аялал жуулчлалын хөгжлийн талаар хийгдсэн гарын авлага (CBD, 2015), нөгөө нь IUCN-наас гаргасан ТХГН-ийн Засаглал ба Удирдлага, Зохион байгуулалтын гарын авлага тус тус болно (Worboys, et al., 2015).

Энэхүү удирдамж нь ТХГН дахь тогтвортой аялал жуулчлалын чиглэлээр гарсан менежментийн хамгийн сүүлийн үеийн ололт амжилт, сэтгэлгээг тусгасан бөгөөд шинэ санаа шийдлийг хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар дэвшүүлэв.

1.6 Удирдамжийн бүтэц, зохион байгуулалт

Удирдамжийн зорилтот бүлэгт ТХГН-т аялал жуулчлалын чиглэлээр ажилладаг мэргэжлийн хүмүүс болон бусад сонирхогч талууд (эрх эзэмшигчид мөн орно) багтана. Үүнд: гүйцэтгэх баг, менежерүүд, төлөвлөгөө зохиогчид, төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд (ТББ), орон нутгийн эвсэл, бүлэглэлүүд, хувийн газар өмчлөгчид болон бусад этгээдүүд хамрагдана. Нэр томъёоны хувьд хялбар байх үүднээс энэ бүх хүмүүсийг бид нэгтгээд “тусгай хамгаалалттай газар нутгийн менежерүүд” хэмээн нэрийдэв. Дэлхийн өнцөг булан бүрээс олон жишээ татан судалж, уг удирдамж нь хичнээн ядмаг, эсвэл хичнээн сайн нөөц, эх сурвалжтай ажиллаж байгаагаас нь үл хамааран бүхий л нөхцөл дунд ажиллаж байгаа менежерүүдэд адилхан хамааралтай байлгахыг зорив.

Удирдамжийн удаах хэсгүүдэд ТХГН дахь тогтвортой аялал жуулчлалын ойлголтын өргөн цар хүрээ хийгээд тодорхой процесс дараалал, арга хэрэгсэл, техник ажиллагаануудын талаар авч үзэв. Тухайлбал:

- 2-р Бүлэг. “ТХГН дахь аялал жуулчлалын нөлөөлөл” бүлэг нь тусгай хамгаалалттай газар дахь аялал жуулчлалын эерэг болон сөрөг үр дагаваруудыг тодорхойлно. Аялал жуулчлал дахь байгаль хамгаалал, эдийн засаг болон нийгмийн ашиг тус, сул тал зэрэг нь хэрхэн хоорондоо уялдаа холбоотойг харуулна.
- 3-р Бүлэг. “Менежментийн зорилтуудыг аялал жуулчлалын нөлөөтэй уялдуулах нь” бүлэгт аялагч болон аялал жуулчлалын менежментийн арван зарчмыг танилцуулах бөгөөд үүнээс эхний зургаад нь тусгай хамгаалалттай газрын зорилго, үнэт зүйлийг тодорхойлох менежмент болон төлөвлөлтийн арга хэрэгсэл, технологийг хэлэлцэж, тэдгээрийг аялал жуулчлалын болзошгүй сөрөг үр дагаварын эсрэг хэрхэн ашиглаж болох тухай дурдна.
- 4-р Бүлэг. “Тогтвортой аялал жуулчлалын дасан зохицох менежмент” нь аялал жуулчлалын нэгдсэн менежментийн хөтөлбөрийн үндсэн элементүүдийг багтаасан сүүлийн дөрвөн зарчим юм. Үүнд: нөөцийн мониторинг, дотоод хяналт, олон нийтийн оролцоо, мэдээлэл харилцаа холбоо ба сурталчилгаа орно.

Бүлгийн төгсгөлд гэрчилгээжүүлэлтийн талаар хэлэлцэж, ТХГН дахь аялал жуулчлалын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн нийцүүлсэн менежментийн гол, гол асуудлыг нэгтгэдэг аялал жуулчлал, аялагчдын менежментийн гурвалсан хүрээг хөндөнө.

- 5-р Бүлэг. “Тогтвортой аялал жуулчлалын менежментийн чадавхийг бэхжүүлэх” бүлэгт тусгай хамгаалалттай газрын менежерүүд, тэдгээрийн байгууллага, орон нутгийн иргэдийн зүгээс аялал жуулчлалын тогтвортой менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, хүний нөөцийн болон нийгмийн нөөцийг олж авах арга замыг тайлбарласан болно.

- 6-р Бүлэг. “Аялал жуулчлалын орлого, зарлагыг удирдан зохицуулах замаар байгаль хамгаалын үр дүнд хүрэх нь” бүлэгт аялал жуулчлалын үйл ажиллагаанаас авах төлбөр, тусгай хамгаалалттай газарт нэвтэрсэний төлбөр, концессийн төлбөр зэрэг нь тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагаа, байгаль хамгаалах үйлсийг санхүүжүүлэхэд хэрхэн тус нэмэр болж болох талаар гарна. Концесс эзэмшигчтэй гэрээ байгуулах, аялал жуулчлалын сайн санааны тусламж дэмжлэгийн талаар сүүлийн үед гарч ирж буй боломжуудын талаар мөн тусгасан.
- 7-р Бүлэг. “ТХГН-ийн аялал жуулчлалын хэтийн төлөв” бүлэгт дэлхийн орчин үеийн хэрэг явдалд тогтвортой аялал жуулчлал ямар байр суурь эзэлж байгаа талаар авч үзнэ. ТХГН-ийн менежерүүд ирээдүйд тохиолдож болох ямар ямар асуудлуудад анхаарах ёстой, мөн энэхүү Удирдамжид дурдаж буй тэргүүний туршлагуудыг хэрхэн өөрийн хөрсөн дээр буулгаж, хэрэгжүүлж болох талаар дурдна.

Бүлэг тус бүрт тусгай хамгаалалттай газрууд болон хамгаалалтын захиргаадын хэрэгжүүлж буй сайн жишээнүүдээс суутган оруулав. Дотор нь гол ач холбогдол бүхий зөвлөмжүүдийг “Шилдэг туршлагын гол санаа” хэмээн онцлон үзүүлэв. Эд бүгдийг нэгтгэж, 7-р бүлэгт оруулсан болно. Эдгээр “Шилдэг туршлагууд” нь бүх сайн жишээг мэдээж бүрэн хамарч чадахгүй ч өнөө цаг үед ТХГН дахь аялал жуулчлалын менежментэд гарч байгаа хамгийн тэргүүний туршлагуудын дээжис гэж ойлговол зохилтой. Ижил төстэй удирдамжуудад орсон дэлхийн чанартай шилдэг туршлагуудын нэг хэсэг хэмээн ойлговол зохилтой (CBD, 2015).

Удирдамжийн эцэст уншигчдад бусад тэргүүний туршлагуудаас мэдээлж, санал сэтгэгдлээ хуваалцах боломж олгох зорилгоор Цахим Нөөцийн Сан (<http://go.ncsu.edu/iucn-ustainabletourism-bpg>) сайтыг байрлуулсан болно. Ингэснээр энэхүү удирдамж нь “амьд” харилцаа бий болгож, мэдээллийн санг арвижуулж, баяжуулахад уншигчдад оролцох боломж олгож буй хэрэг юм. Тэргүүний, сайн арга туршлагын нэмэлт жишээнүүдэд дүн шинжилгээ хийж, мэдээлж, таниулах зорилгоор IUCN болон Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (GIZ) хоорондын түншлэлээр ПАНОРАМА: Эрүүл Гаригийн Төлөөх Шийдэл төслийг хэрэгжүүлж байна (www.panorama.solutions).

Удирдамж дахь бүлгүүд, жишээнүүд дээр хэлэлцүүлж байгаа мэдээллүүд нь тусгай хамгаалалттай газар нутаг дахь байгаль хамгаалах зорилго, үйлсэд саад учруулахгүйгээр хэрэгжиж байгаа аялал жуулчлалын шилдэг туршлагууд болно. Шилдэг туршлагууд нь эцсийн дүндээ аялал жуулчлалыг ТХГН-ийн байгаль хамгааллын зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг болгохын төлөө чиглэсэн технологийн ноу-хау болон менежерүүд, аялал жуулчлалын байгууллагууд, нутгийн иргэд болон аялагчдын зан хандлага, хүчин чармайлт, зүтгэлүүдээс бүрдсэн нийлбэр юм.

ТХГН дахь аялал жуулчлалын нөлөөлөл

2



2.1 Эерэг болон сөрөг үр нөлөөллийг дэнслэх нь

ТХГН дахь аялал жуулчлал нь олон төрлийн эерэг ба сөрөг үр нөлөөг дагуулж болдог. Нөлөөллийн хүрээ нь ТХГН-ийн байгалийн нөөц баялаг, орон нутгийн эдийн засаг, нутгийн иргэд болон жуулчдийг ч бас нь хамарна. Энэ удирдамжид аялал жуулчлалын эерэг нөлөөг аль болох ихэсгэж, сөрөг нөлөөг бууруулах зорилгоор тэргүүн туршлагуудаас хуваалцах болно.

Тэнцвэрийг бий болгох нь зарим тохиолдолд хүндрэлтэй байдаг. Өсөн нэмэгдэх жуулчдын хэрэгцээг хангах зорилгоор зарим ТХГН-уудад олон тооны дэд бүтцийг байгуулсан боловч түүгээр үйлчлүүлэх жуулчид хийгээд дэд бүтцийн өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөнүүд гарах болов. Жишээ нь АНУ-ын Елевстөүн Байгалийн Цогцолборт Газрын Хүрэн баавгайн (*Ursus arctos*) амьдрах чухал орчинд аялагчдын сонирхлыг татах зорилгоор олон тооны дэд бүтэц байгуулсан нь баавгай болон аялагчдын хөл хөдөлгөөний хооронд зөрчилдөөн гарахад хүргэжээ. Энэ бол цогцолборт газрын менежерүүдийн хувьд тохиолддог нийтлэг толгойн өвчин

юм. Эерэг нөлөө (аялагчдын авдаг үр өгөөж), сөрөг нөлөөлөл (амьдрах орчинд саад болдог, зэрлэг амьтдын оршин буй газар хүмүүс зорчдог) хоёрыг ийм, тийм байна гэдгийг хэрхэн дэнслэх вэ? Үүнтэй агаар нэг адил өдгөө улс орнуудын хэмжээнд ТХГН дахь байгаль хамгаалах хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж, иргэдийн аялах, үзэж, баясах дур сонирхолыг зохицуулж, аялагчдаас орж ирэх орлогын боломжийг ашиглаж, гадаад валютын эх үүсвэр олох вэ гэгчилэн олон асуудлууд хөвөрсөөр байна.

Нийтлэг тохиолддог нэгэн дүр зургийг авч үзье. Тухайн нэг тусгай хамгаалалттай газрыг аялагчид “нээх”, эсвэл сурталчилгааны нөлөөгөөр олны анхааралд өртөж аялагчдын хөл хөдөлгөөнд дарагдаж эхэлнэ. Ингэснээр нутгийн иргэд ашиг орлого нэмэгдэхийг хүлээнэ. Харамсалтай нь зөв төлөвлөлт, зохицуулалт байхгүйн улмаас тохиромжгүй газарт барилга, байгууламжууд баригдаж, унаган төрх алдагдаж, зэрлэг амьтдын амьдрах орчныг сүйтгэдэг. Мөн шингэн хатуу бохирын зохицуулалт, хог хаягдлын менежмент маш хангалтгүй хэрэгждэг. ТХГН-ийн гол үнэт зүйлсийг агуулсан газрууд хэт их хүний хөлөнд өртөж, байгаль орчин талхлагдаж аялагчдын хүртэх үр өгөөж буурч орхидог.

Хүснэгт 2.1. ТХГН дахь аялал жуулчлалаас гарч болох үр ашгууд

Үр ашгийн төрөл	ТХГН-т аялал жуулчлалаас үзүүлж чадах боломжит үр ашгууд
Байгаль орчны хувьд	<ul style="list-style-type: none">Иргэдэд байгаль хамгаалал түүний, хэрэгцээ шаардлагын талаар мэдлэг олгохТуршилт, боловсрол, тайлбарлан таниулах замаар байгалийн үнэ цэн, нөөцийн талаархи ойлголт, ухаарлыг түгээхОршин суугчдынх нь хувьд үнэ цэн багатай буюу үр ашиг гэхээсээ зардал, чирэгдэл гэж тооцогддог байгалийн нөөцийн үнэ цэн, хамгаалалын ач холбогдлын талаар сурталчлан таниулахАялал жуулчлалын бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөх үүднээс байгаль орчны талаарх сайн туршлага, менежментийн тогтолцоо, мөн зорих газар дахь аялагчдын биеэ авч явах байдлын талаархи судалгаа, хөгжлийг дэмжихИргэн-судлаач бүхий сайн дурынханыг ашиглан байгаль орчны болон төрөл зүйлийн хяналт мониторингийг дэмжих
Эдийн засгийн хувьд	<ul style="list-style-type: none">Нийт улс орон, бүс нутаг болон орон нутагт ирэх эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар байгаль орчин, зэрлэг амьтдыг хамгаалах ухамсарыг нэмэгдүүлэхОрон нутгийн иргэдийн ажил, орлогыг нэмэгдүүлэхАялал жуулчлалын шинэ төрлүүдийг гарган ирж орон нутгийн эдийн засгийг солонгоруулахОрон нутгийн барилга байгууламж, тээвэр болон харилцаа холбоог илүү тогтвортой байхаар сайжруулахОрон нутгийн үйлдвэрлэгч, худалдаалагч болон ажил үйлчилгээ үзүүлдэг иргэдийг дэмжихШинэ зах зээл, шинэ гадаад валютын эх сурвалж нээхОрон нутагт татварын орлогыг бүрдүүлэхАжилчдыг шинэ ур чадварт суралцах боломж нээхАялал жуулчлалаас татвар, хураамж авах замаар ТХГН-д санхүүгийн дэмжлэг бий болгох
Нийгмийн/ олон нийтийн хувьд	<ul style="list-style-type: none">Орон нутгийн иргэдийн амьжиргааны чанарыг дээшлүүлэхИргэдийг тухайн нутаг орныхоо соёл, ТХГН-гийн талаар бахархах сэтгэлийг өдөөхАялагчид болон орон нутгийн иргэдийн байгаль орчны боловсролыг дэмжих, соёлын өвийн болон байгалийн нөөцийн үнэ цэнийн талаар илүү их ойлголттой болгохАялагчдад төдийгүй оршин суугчдад ч гэсэн сонирхолтой байх орчныг бүрдүүлэх. Ингэснээр ашигтай шинэ үйл ажиллагаануудыг ч гарган ирж болох юм (тухайлбал, үйлчилгээ юм уу эсвэл бүтээгдэхүүнд суурилсан үйлдвэрлэл гэх мэт)Иргэд хоорондын харилцааг хөгжүүлэх замаар ахуй соёлын хоорондын ойлголтыг сайжруулахСоёл, гар урлал, болон урлагийг хөгжүүлэх, хамгаалах үйлсийг дэмжихХүмүүсийг өөр бусдын хэл, соёлоос суралцахыг явдлыг дэмжих

- Хүний сайн сайхан оршихуйг дэмжсэн гоо сайхан, итгэл бишрэл, эрүүл мэнд гэх мэт бусад үнэт зүйлсийг дэмжих
- Идэвхтэй амралтын хэлбэрүүдийг (явган алхах, дугуй унах зэрэг) ашиглан бие физиологи, эрүүл мэндийг сайжруулах
- Стресс, ядаргааг бууруулах замаар сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулахад хувь нэмэр оруулах
- Байгаль хамгааллын нэр хүндийг орон нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд нэмэгдүүлэх
- Аялагчдад үнэт зүйлс, байгаль хамгаалал болон менежментийн зовлон, жаргалын талаар таниулан ойлгуулах.

Эх үүсвэр: Eagles, et al., 2002; CBD, 2004; Maller, et al., 2009, IUCN, 2010; Spenceley, et al., 2015

Шигтгээ 2.1

Руанда улсын Галт уулын Байгалийн Цогцолборт газар дахь уулын горилла үзэх аяллын олон талын үр ашгууд

Руанда улсын Галт уулын Байгалийн цогцолборт газрын (VNP) 160 кв.км талбайд тархан амьдардаг, ховор төрлийн уулын горилла нь (*Gorilla beringei beringei*) жуулчдыг татах гол үзвэр болдог. Руандад байгалийн үзэсгэлэнд тулгуурласан аялал жуулчлалыг засгийн газар, байгаль хамгаалах хөдөлгөөний зүгээс дэмждэг бөгөөд уулын гориллаг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэвч, зарим хэсэгтээ 1 кв.км талбайд 820 хүн оногддог, хүн амын нягтшилаар Африк тивдээ хамгийн өндөрт тооцогддог Руанда улсын VNP-ын орчмын оршин суугчид нь нэн ядуу фермерүүд ажээ. Үүний улмаас уулын горилл нь хөдөө аж ахуйн хөгжил, нөөцийн хууль бус ашиглалт (жишээлбэл: хавхаар агнах) зэргээс шалтгаалан тоо толгой хорогдох нөхцөл аюулд өртдөг байна. Иймд орон нутгийн иргэдэд бодит ашиг хүртээх нь гориллагийн оршин тогтнолыг хангахад ихээхэн чухал үүрэг гүйцэтгэлэг байна.

Уулын гориллаг үзэх аялал жуулчлалын зарим эерэг нөлөөллөөс дурьдвал:

- **Байгаль орчны хувьд:** Уулын гориллын тоо толгойд нөлөөлөх олон хүчин зүйл байдаг боловч Fawcett (2009)-ийн дүгнэснээр жуулчид ирэх болсноор хулгайн ан гарахаас сэргийлэх болжээ.
- **Эдийн засгийн хувьд:** Орон нутгийн иргэдэд (зарим нь хууль бус ангаар амьдардаг байсан) хөтөч, мөр хөөгч, хулгайн ангийн эсрэг манаач зэрэг ажлын байрууд бий болжээ.
- **Нийгмийн хувьд:** 2005-2010 оны хооронд ойролцоогоор 428,000 ам.долларын хөрөнгө оруулалтыг Руандагийн нийгмийн төслүүд, үүний дотор сургууль барих, байгаль орчны хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх (жишээлбэл: мод суулгах, хөрсний элэгдлийг хянах), 1,250 гаруй хүнд үйлчлэх 30 тооны усны савыг байршуулах, хүнсний аюулгүй байдлын санаачлага зэрэгт зарцуулсан байна. Төслүүдийг орлого хуваах зарчмаар санхүүжүүлж, цогцолборт газар руу нэвтрэх төлбөр, аялал жуулчлалаас олсон орлогын 5 хувийг цогцолбор газрын орчинд нийгмийн төсөл хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

6-р бүлгийн Шигтгээ 6.5-д энэ цогцолбор газарт нэвтрэх зочны зөвшөөрөл, гориллаг харах үйлчилгээний төлбөрийн тухай нэмэлт мэдээллийг дурьдсан болно. IUCN-ийн амьтны төрөл зүйлийг хамгаалах комиссоос (Macfie & Williamson, 2010) том биет сармагчны төрлийг дагасан аялал жуулчлал, түүний менежментийн гарын авлага, зардал, боломжит ашиг зэргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл гаргасан байдаг.

Эх сурвалж: Plumptre, et al., 2004; Bush, et al., 2008; Fawcett, 2009; Uwingeli, 2009; Macfie & Williamson, 2010; Nielsen & Spenceley, 2011



Галт уулын цогцолборт газарт хөтөчтэй аялал. © Anna Spenceley.



Жуулчдын олж харсан уулын Горилла-н сүрэг © Mei Yei Yan

ТХГН дахь аялал жуулчлалын үзүүлэх нөлөө нь байгаль орчин, эдийн засаг, нийгэм гэсэн, ихэвчлэн өөр хоорондоо давхцдаг гурван өргөн ухагдахуунд хуваагдана ("Байгаль орчин" гэсэн утга нь биофизикийн нөлөөллийг агуулдаг бол "нийгэм" нь соёл, нутгийн иргэд гэх мэт өв соёлтой холбоотой нөлөөллийн утга санааг агуулдаг). Энэ бүлэгт эдгээр гурван төрлийн нөлөөг авч үзэхдээ жишээн дээр тайлбарлаж, ТХГН-ийн менежерүүдэд эерэг нөлөөг аль болох нэмэгдүүлж, сөрөг нөлөөг нь багасгахад туслах зорилгоор тэргүүн туршлагаудаас танилцуулна. Дараах бүлэгт нь тодорхой арга замууд, технологийн асуудлуудыг авч үзнэ. Мөн хэлэлцүүлгийн явцад урьдчилан тооцоолж чадаагүй нөлөөллийн эсрэг авах хариу арга хэмжээнд зориулсан дасан зохицох (тохируулах) менежмент, хяналтын үнэлгээг хэрхэн ашиглах талаар тусгасан болно.

Эерэг үү, сөрөг үү - Хэн шийдэх вэ? Ашиг тусыг нь хэн хүртэх вэ?

"Нөлөөлөл" гэдэг үг нь үндсэн утгынхаа хувьд аль нэг талыг барьсан санаа илэрхийлэхгүй. Зарим хүний эерэг гэж үзэж байгаа нөлөөг өөр зарим хүмүүс сөрөг гэж үзэх талтай. Энэ удирдамжийг ашиглаж байх явцдаа "Нөлөөллийг эерэг, сөрөг эсэхийг хэн тодорхойлох вэ?" гэдгийг байнга эргэцүүлж бодох нь маш чухал ач холбогдолтой гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Жуулчид тус ТХГН-т нэвтрэх хураамж, байршуулах хэрэгсэл, аяллын төлбөр (хөтөчтэй машин ба явган аялал гэх мэт), хоол хүнс, гар урлалын бүтээгдэхүүн худалдан авах гэх зэргээр ТХГН болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанд чамгүй хэмжээний төлбөр төлж байдаг. Энэ төлбөрөөс засгийн газар, ТХГН-ийн захиргаанууд, аялал жуулчлалын агентууд, тур операторууд, байршуулах хэрэгслийн газрууд, жижиглэн худалдаачид, үйлчилгээ эрхлэгчид болон нутгийн иргэд хувь хүртэх боломжтой. Тэгвэл энэ үр ашгийн хуваарьлалтыг хэрхэн хийх вэ? Энэ асуултын хариулт нь тухайн ТХГН дахь аялал жуулчлал нь тогтвортой байна уу үгүй юу гэдгийг харуулах урт удаан замнал, утга агуулгыг илтгэх хариулт болох билээ.

ТХГН дахь аялал жуулчлал нь байгаль хамгаалал болон түүнтэй холбоотой соёлын үнэт зүйлийг хадгалж, хамгаалахад заавал хувь нэмэр оруулдаг байх ёстой гэж үзвэл ТХГН дахь тогтвортой аялал жуулчлалын байгаль хамгааллын үр ашиг нь эдийн засаг, нийгмийн ашиг тустай уялдсан байдгийг харж болно. Хүснэгт 2.1-д аялал жуулчлалаас хүртэж болох гол үр ашгийг харуулав. Хүснэгтийн дээд талд бичигдсэн байгаль орчинд өгөх ашиг тус нь эдийн засаг, нийгмийн ашиг тусыг хэрхэн илэрхийлж буйг анхаараарай. Нийгэм, эдийн засгийн ашиг тус нь ч үүнтэй мөн адил байна. Эдгээр гурван ашиг тусууд хоорондоо уялдаа холбоотой байдаг. Ихэнх тохиолдолд тухайн нэг аялал жуулчлалын зорин очих газарт гурван ашиг тус гурвуул илэрсэн харагддаг (Шигтгээ 2.1).

Тогтвортой аялал жуулчлал хэрэгжиж байгаа ТХГН-д дээрхи гурван ашиг тус зэрэг илэрч байдаг (Borrini-Feyerabend, et al., 2005). Иймд дараагийн хэсэгт ТХГН дахь аялал жуулчлалын байгаль хамгаалал, эдийн засгийн болон нийгмийн үр ашгуудын талаар авч үзье.

2.2 Байгаль хамгааллын шууд ашиг ашиг

ТХГН дахь аялал жуулчлал нь байгаль хамгаалахад маш чухал нөлөө үзүүлж байдаг (Buckley, 2010a). Нөхцөл байдлаас шалтгаалан ТХГН дахь аялал жуулчлал нь байгаль хамгаалалд том, жижиг үүрэг гүйцэтгэж байдаг (Pegas & Stronza, 2008; Steven, et al., 2013). Зарим тохиолдолд аялал жуулчлал эрхлэгчид, тэр дундаа хувийн эзэмшилд байгаа тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд (Шигтгээ 2.2) зэрлэг амьтдын амьдрах орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд шууд дэмжлэг үзүүлж байдаг. Австралийн Филлип арлуудад Оцон шувууг (*Eudiptula minor*) олон нийтэд харуулахад (хархад) төлсөн төлбөрийг амьтны төрөл зүйлийн амьдрах орчинг таатай байдлаар бүрдүүлэхэд зарцуулдаг байна (Харрис, 2002).

Өөр бусад тохиолдолд аялал жуулчлалаас олсон орлогыг ховор амьтны төрөл зүйлийг хулгайн ангаас хамгаалах, зэрлэг амьтдын мониторинг, шинжлэх ухааны мэдээ, мэдээллийг цуглуулахад зарцуулж байна. Олон иргэд ТХГН болон ойр орчимд шинжлэх ухааны мэдээлэл цуглуулж, байгаль хамгаалах үйлсэд гар бие оролцох зорилгоор "сайн дурын" хөтөлбөрт хамрагддаг. Жишээлбэл, Глобал Вишн Интернэйшнл хэмээх төрийн бус байгууллага Сэйшелийн арлуудад далайн парк болон бусад байгаль хамгаалах чиглэлээр "байгаль хамгаалах судалгааны нэгжүүдийг ажиллуулдаг. Сайн дурынхан Байе Тернайын БЦГ болон Кюриусын үндэсний цэцэрлэгт хүрээлэнд биологийн судалгаа, шүрэн аралын үйл ажиллагаанд мониторинг хийхэд дэмжлэг үзүүлж, судалгааны ажлын тайлан мэдээгээ жилд хоёр удаа Сэйшелийн Үндэсний цогцолборт газрын удирдлагад илгээдэг байна (Spencely, 2016). Зарим тохиолдолд жуулчид ТХГН-т нэвтэрч харагдахад л хор хөнөөлтэй, хууль бус үйл ажиллагаа гарахаас сэргийлэгч болдог аж. Африкийн Бүгд Найрамдах улс дахь Дканга-Сангха Төслийн менежерүүд нь гориллаг хулгайгаар агнахаас урьдчилан сэргийлэх зорилгоор горилла үзэх аяллыг (*Gorilla spp.*) дэмждэг (Greer & Cipolletta, 2006). Руандагийн Вирунга Галт Уулсад гориллагийн аялал жуулчлал, судалгаа явагддаг газар дахь хулгайн анчдын тавьдаг урхи, ул мөр зэрэг нь аялал жуулчлал, судалгаа хийгддэггүй газрынхаас 25–50 хувиар багассан байжээ (McNeillage, 1996).

Үндэсний түвшинд авч үзвэл ТХГН дахь аялал жуулчлалын орлого нь гадаад валютын орлого, төлбөрийн тэнцэлд хувь нэмэр оруулах боломжтой (Mathieson & Wall, 1982) байдаг нь байгаль хамгаалах үйлсэд зориулах зардлыг хамгаалж, батлахад ихээхэн ач холбогдолтой юм. Түүнчилэн аялал жуулчлал нь ТХГН-ийн удирдлагуудын байгаль хамгаалах үйлсэд нь шууд орлогын эх үүсвэр бүрдүүлэн өгч, орон нутгийн иргэдэд байгалийн нөөцийг хайрлан хамгаалах сэдэл төрүүлж, хувийн хэвшлийнхэнд биологийн олон янз байдлыг хамгаалах урам зориг өгдөг (Bushell & McCool, 2007; Buckley, 2010a; Hvenegaard, 2011). Уг гурван ач холбогдлын талаар доор тайлбарлая:

ТХГН-ийн менежментэд орох орлого

Төрийн мэдлийн ТХГН-уудын аялал жуулчлалаас олсон орлогыг (ихэнх тохиолдолд) улсын санд төвлөрүүлдэг. Хэрэв тиймгүй бол аялал жуулчлалаас олох орлого нь ТХГН-ийн менежментэд шууд хувь нэмрээ оруулж байх билээ. Орлого олох механизмын дундаас хамгийн түгээмэл нь ТХГН-т нэвтрэх буюу жуулчны хураамж байдаг. Ийм хураамж нь аялагчдын тоог зохицуулах, танин мэдэх боломжийг олгох, тэр байтугай ТХГН-уудын сүлжээнд буй бусад газруудад татаас өгөх боломж ч олгох явдал байдаг (Lindberg, 1998). Аялал жуулчлалаас олох орлогоор мөн түүнчилэн тухайн хамгаалалттай газар нутаг болон нутгийн иргэдэд нь хүртээмжтэй, тогтвортой дэд бүтцийг хөгжүүлж, санхүүжүүлэх боломжтой билээ (нарны эрчим хүчний хураагуур гэх мэт).

Аялал жуулчлалаас олсон орлогыг ТХГН-ийн захиргаанд төвлөрүүлсний ач холбогдлыг Африкийн дараах жишээнүүд харуулж байна. Үүнд:

- Өмнөд Африкийн үндэсний паркууд 2002-2012 онд дэлгүүр, рестораны түрээс болон орон байр, канон завь, гэр бүлийн усан онгоцны концессийн гэрээнээс 58 сая ам.долларын орлого олжээ (SANParks, 2012).
- Мозамбек улсын Ниасса байгалийн нөөц газрын менежментэд хамгаалалтын бүс дэхь 12 талбайг концессийн гэрээгээр эзэмшүүлснээс жилийн 65,000 ам.долларын орлогыг олжээ (Rodrigues, 2012).
- Намиби улсын ТХГН-уудад аялал жуулчлалын 45 концессийн гэрээнээс 1.7 сая ам.долларын орлого олжээ (Thompson, 2014).

Эдгээр орлогыг хэрхэн зөв зүйтэй зарцуулах нь байгаль хамгаалах үйл ажиллагааны үр дүнд ихээхэн чухлаар нөлөөлнө. Жишээлбэл, зарим газарт орсон орлого нь томоохон хэмжээний төвлөрсөн менежменттэй хамгаалалтын захиргааных нь урсгал зардалд шингээд алга болох тохиолдол байна (Aylward, 2004). Канад улсад Засгийн газраас үзүүлэх татаасын хэмжээ багассан учир Онтарио Парк нь байгууллагын бүтэц зохион байгуулалт, шийдвэр гаргах явц, хууль эрх зүйн байдлаа сайжруулж дэмжлэг тусламж хүлээж авах тусгай санхүүжилтийн данснууд нээж ажилласны үр дүнд аялал жуулчлалаас олох орлогын хэмжээгээ 15 жилийн хугацаанд 14.7 сая ам.доллараас 52.8 сая ам.доллар болтол буюу 257 хувиар өсгөж чаджээ. Голчлон төлбөр, хураамжийг өсгөж, аялал жуулчлалын нэмэлт бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, тэдгээрийн чанарыг ахиулах замаар орлогын хэмжээгээ нэмэгдүүлж чадсан байна (Eagles, 2014).

Гэсэн хэдий ч аялал жуулчлалаас олох орлого нь харилцан адилгүй байдаг тул тухайн ТХГН-ийн сүлжээний түвшинд ажилладаг менежер, төлөвлөгөө гаргагчид өөрийн хамгаалалттай газар нутагтаа дүн шинжилгээ хийж, орлогын урсгал нь системийн хувьд санхүүжилтийн найдвартай эх үүсвэр эсэхийг тодорхойлох шаардлагатай болно. Аялал жуулчлалаас дорвитой хэмжээний орлого олдоггүй (цаашид ч олох төлөвгүй) хамгаалалттай газар нутгуудаас бүрдсэн ТХГН-ийн системүүд олон байдаг. Өөр зарим нь аялал жуулчлалаас олох орлогынхоо ихэнхийг эсвэл бүгдийг илүү олонд алдартай хамгаалалттай газар нутгийн захиргаанд татаас болгон алдах явдлууд ч байдаг. Энэ байдал нь нийт тогтолцооны хүрээнд ашиг орлогын хуваарьлалтыг хэрхэн хийх вэ гэсэн шийдэхэд амаргүй асуудлууд дээр авч ирдэг байна.

ТХГН болон түүний орчны бүс нутгийн иргэдэд эдийн засгийн үр ашиг өгсөнөөр байгаль хамгаалах сэтгэлтэй болгох нь

Аялал жуулчлал нутгийн иргэдэд ашиг тусаа өгөх нь тусгай хамгаалалттай газрын хараа хамгаалалтыг сайжруулж, нутгийн иргэдийн дэмжлэгийг бэхжүүлдэг (Pegas & Stronza, 2008; Biggs, et al., 2011). Жишээ татахад Төв Африкийн паркуудад горилла сармагчинг үзэх аялал өссөнөөр оршин суугчдын ТХГН болон гориллаг хамгаалах үйлсэд хандах хандлага нь ихэд эерэг болж иржээ (Weber, 1987; Blom, 2000; Lepp, 2002) (Шигтгээ 2.1-г харна уу). ТХГН-ийг төрийн бүс байгууллага удирдаж, аялал жуулчлалаар дамжуулан эдийн засгийн үр өгөөж авчирж буй Жордан улсын жишээг Шигтгээ 2.3-т харуулав. Энэхүү харилцаа холбооны талаар сүүлийн үед хийсэн судалгаагаар нутгийн иргэдийн дэмжлэгийг хангахад олон талын хүчин зүйл нөлөөлдөг нь харагджээ (de Vasconcellos Pegas, et al., 2013; Hayes, et al., 2015). Ерөнхийд нь авч үзэхүл нутгийн иргэдийг байгаль хамгаалах үйлсэд татан оролцуулах ажил олон жилийн хүчин чармайлт шаарддаг (14 хуудас, Хүснэгт 2.4).

ТХГН болон түүний орчны бүс дэх байгаль орчинг хамгаалахад хувийн хэвшлийн үзүүлэх шууд дэмжлэг

Зарим тур оператор компаниуд байгаль хамгаалах үйл ажиллагаанд шууд хандив тусламж өгөх (үйл ажиллагааны зардал, байгаль хамгаалагчдын цалин хөлс, тоног төхөөрөмж зэрэг), төлбөргүй үйлчилгээнүүд (үнэ төлбөргүй аялал, тээвэрлэлт болон байршуулах хэрэгсэл зэрэг), мөн байгаль хамгаалах чиглэлээр лобби хийх зэргээр дэмжлэг үзүүлдэг байна (Buckley, 2010a; Bottema & Bush, 2012). Аялал жуулчлалын салбарт хийгдсэн сайн санааны дэмжлэгийн судалгаанд (Goodwin, et al. 2009) нэр бүхий 29 аялал жуулчлалын компанийн санал, санаачлагаар 159.4 сая фунт стерлинг босгосон байжээ. Зэрлэг амьтан хамгаалах болон ТХГН-ийн санал санаачилгыг дэмжих зорилгоор Беуонд компани 2007 онд £451,000, Консервэйшн Френдс 2007–2008 онд £158,152, Робин Попе Сафарис жил бүр £63,000, Тайгерс тур оператор жил бүр £15,000 фунт стерлингийг тус тус хандивлажээ. Линдблад Экспедишн нь өөрийн Галапагост хийдэг аяллын жуулчдаас Чарльс Дарвин Санд өглөг, хандив авах харилцаа холбооны стратеги боловсруулж ажиллажээ. Линдбладын энэхүү хүчин чармайлт, санаачлагын үрээр Галапагост хийдэг аялал тус бүрээс дунджаар 1,800-аас 6,700 ам.долларын хандив босгох болсон нь өмнөхөөсөө дөрөв дахин нэмэгджээ. Нийт 10 жилийн хугацаанд US\$ 4.5 сая ам. доллар босгож, Чарльс Дарвины Судалгааны Станц болон Галапагосийн Үндэсний Паркын байгаль хамгаалах үйлсэд зориулжээ (Ham, 2011).

Сайн дурынхны аяллыг зохион байгуулдаг Earthwatch бусад нь зэрэг компаниуд оролцогч бүрийн төлбөрөөс тодорхой хувийг байгаль хамгаалах үйлсэд зарцуулдаг. Бусад тур оператор аяллын компаниудын хувьд ч жуулчиддаа байгаль хамгаалах үйлсэд, эсвэл хүний нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулах хөтөлбөрт хандив өгөхийг уриалж болох билээ.

Шигтгээ 2.2

Хувийн эзэмшилд байгаа хамгаалалттай бүсүүд: аялал жуулчлал, байгаль хамгааллын түншүүд

Хувийн эзэмшилд байгаа хамгаалалттай бүсүүд нь байгаль хамгаалах хөдөлгөөний хэсэг болсоор удаж байна. Үүнээс гадна хувийн газар эзэмшигчид, итгэмжлэх сан, сангууд болон олон ТББ-ууд, үүний дотор Консервэйшн Интернэйшнл (CI), Дэ Нэйчер Консерванси (TNC) болон Африк дахь Байгаль Хамгаалах Манлайллын Сүлжээ зэрэг байгууллагууд байгаль хамгаалах, судалгаа хийх зорилгоор газар нутаг өмчилж, эзэмшиж байна.

Хувийн байгууллага, газар эзэмшигчид, сан, фондууд, төрийн бус байгууллагууд болон олон нийтийн байгууллагуудад байгаль орчныг бүхлээр нь эсвэл хэсэгчлэн хамгаалах зорилгоор газар эзэмшиж, удирдан зохион байгуулах загварууд бий. Эдгээр загварууд нь тухайн улс бүрийн газар эзэмшлийн түүх, газар ашиглах систем, хууль эрх зүй болон соёлоос шалтгаалаад өөр өөр байдаг.

Нийтийнх байна уу хувийнх байна уу гэдгээс үл шалтгаалан (нутгийн иргэдийн удирддаг газар, орон нутаг ч хамаарна) хамгаалалттай газар орны төрөл зүйл, хэлхээ холбоо их байх тусам байгаль хамгаалах үйлсэд тустай байдаг. Бизнес сэтгэлгээ, ур чадвар, сайн менежмент, инновац, эрсдэл хүлээх чадвар, мөн хүсэл эрмэлзэл, хичээл зүтгэл, тууштай байдал зэрэг олон хүчин зүйлсийг хазаарлаж чадах аваас байгаль хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулж чадахыг Танзани болон Кени улсууд дахь иргэдийн санаачилгатай байгаль хамгаалах хөдөлгөөний жишээнүүдээс харж болно. Аялал жуулчлалаас олсон орлогоор хирс (*Diceros bicornis*; *Ceratotherium simum*), Африкийн зэрлэг нохой (*Lycaon pictus*), улаан ирвэс (*Acinonyx jubatus*) болон Сейшелийн цагаан нүдэн шувуу (*Zosterops modestus*) зэрэг зэрлэг амьдтыг хамгаалахад туслах үүрэг гүйцэтгэж болохыг хувийн эзэмшилд байдаг газар нутгийн байгаль хамгаалах арга үзүүлж байгаа юм.

Дүгнэж хэлэхэд, хувийн салбар нь төрийн мэдлийн тусгай хамгаалалттай газар нутагт байгаль хамгаалах чиглэлд дорвитой хувь нэмэр оруулах хүчтэй боловч дангаараа шийдэх арга зам нь биш юм. Эдгээр хүчин чармайлтын гол агуулга нь тэдгээрээс байгаль хамгаалах үйлсэд оруулах хувь нэмрийг нь илүү бодитой, илүү тодорхой болгохдоо орших юм. IUCN-ийн WCPA-с гаргасан хамгийн сүүлийн хэвлэл болох Хувийн Эзэмшилд Орших Тусхай Хамгаалалттай Газар Нутгийн Хэтийн Төлөв бүтээлд хувийн эзэмшилд орших хамгаалалттай газар нутгуудын тэргүүн туршлага, практик зааврууд болон ерөнхий хамрах хүрээг тайлбарласан байна.

Эх сурвалж: Spenceley, 2008; Buckley, 2010a, Buckley, 2010b; Sheail, 2010; Buckley, 2012a; TNC, 2013; Buckley, 2014; Leménager, et al., 2014; Stolton, et al., 2014; Mitchell, et al., 2018

Шигтгээ 2.3

ТББ-ын удирдлага бүхий тусгай хамгаалалттай газар нутгууд: Эзэн Хааны Байгаль Хамгаалах Нийгэмлэг (Иордан улс)

1966 онд Эзэн хаан Хуссейний ивээл дор байгуулагдсан Эзэн Хааны Байгаль Хамгаалах Нийгэмлэг (RSCN) ТББ нь Иордан улсын байгалийн нөөцийг хадгалан хамгаалах зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ нь Ойрх Дорнод дахь төрийн эзэмшлийн буюу олон нийтийн газрыг удирдан, зохион байгуулах эрх олгогдсон цөөхөн байгууллагын нэг юм.

RSCN нь 1994 оноос археологийн дурсгалт газар Петрагийн ойролцоо орших Данагийн Шим Мандлын Нөөц Газрийн менежментэд хүн-төвтэй шинэлэг хандлагыг хэрэгжүүлсэн байдаг. Орон нутгийн тосгод болон Бедоун нүүдэлчин иргэдтэй шууд хамтран ажилласнаар нөөц газрын байгалийн үзэсгэлэнт байдал, зэрлэг амьдтыг түшиглэсэн орлого олох төслүүд хэрэгжүүлж, ажлын байр болгожээ. Жишээ нь гар урлалын жижиг үйлдвэрүүд болон отоглох цэг, гэр буудлууд, эко лоожууд зэрэг аялал жуулчлалын бүтээн байгуулалтууд байгуулжээ. Ийм санаачилгууд нь Данагийн иргэдэд байгаль хамгаалах үйлсийн чухлыг харуулж, орон нутгийн зүгээс Нөөц газрыг дэмжих дэмжлэгийг тасралтгүй үргэлжлэх нөхцлийг бүрдүүлдэг байна. Хамгийн сүүлд RSCN-ийн зүгээс хэрэгжүүлсэн шинэлэг арга хэмжээний нэг нь 26 өрөө бүхий Фенаны Эко-лоожийг концессийн нөхцөлтэйгөөр Данагийн Шим Мандалын Нөөц Газрын баруун захад байгуулах зөвшөөрөл олгосон ажил болсон байна. Данагийн бүс нутаг нь төрөл бүрийн зэрлэг амьтан ургамал, геологийн бүтэц, үзэсгэлэнт газрууд болон шөнийн од ажиглах гайхамшигт боломжоос бүрдсэн газар юм. 2009 оны 9 дүгээр сард Эко Хотелс хэмээх арилжааны байгууллагад дээрхи лоожийг ажиллуулах концессийн эрхийг олгосноор аялагчдад байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөө үзүүлэх байдлаар Иорданы онгон байгальтай танилцаж, хүн ардын амьдрал, түүний эртний түүхтэй танилцах боломжийг бүрдүүлжээ.

RSCN-ийн салбар болох нийгэм эдийг засаг, экотуризмийг хөгжүүлэх Wild Jordan хэлтэс нь RSCN-ийн ТХГН-ийн дотор болон ойр орчимд байгальд түшиглэсэн үр ашигтай бизнесийг хөгжүүлж, нутгийн иргэдэд эдийн засаг, нийгмийн бодитой үр ашгийг авч ирж, Иорданы Хаант Улс даяар санхүү, улс төр, олон нийтийн дэмжлэгийг бий болгож байгаль хамгаалах үйлсэд зориулах зорилготой юм. RSCN ба Уайлд Иордан нь дотроо байршуулах хэрэгслүүд бүхий хэд хэдэн нөөц газрыг удирдан ажиллуулж байна.

Эх сурвалж: Feyna Ecolodge, 2017; RSCN, 2017



Жуулчид Иорданы Уади Рамийн тусгай хамгаалалттай газарт цөлийн тогтоцтой танилцаж байгаа нь. © Mei Yei Tan

Шигтгээ 2.4

Биологийн төрөл зүйлийг иргэдийн амьжиргаатай холбох нь: ТХГН дахь нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой түншлэл

Кентинг Үндэсний Парк (KNP) нь 1982 онд Хятад улс, Тайван дахь хамгийн анхны үндэсний парк болж байгуулагдсан. Энэ бүс нь Тайваны хамгийн алдартай ТХГН-ийн нэг бөгөөд далайн эрэг, шүрэн тогтоц, намгархаг газар, тэдний биологийн олон янз байдлыг ажиглахаар олон сая жуулчид хүрэлцэн ирдэг. Эргийн аялал жуулчлалын байгууламжуудаас хамааран KNP заналхийлэлд өртөөд байна. Байгалийн үнэт нөөцийг хамгаалахын зэрэгцээ, орон нутгийн иргэдэд дэмжлэг үзүүлэхээр KNP-ийн Захиргаанаас олон нийтэд суурилсан ногоон аялал жуулчлалыг сурталчлан дэмжихээр эко-аялал жуулчлалын хөтөлбөрийг Ширдингийн орон нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлж байна. Эко аялал жуулчлалын гол хамтрагч нь Ширдингийн Соёлын Хөгжлийн Нийгэмлэг (SCDA) - олон нийтийн байгууллага бөгөөд орон нутгийн сайн дурынхны оролцоотойгоор эко-аялал жуулчлалын хөтөлбөрийг зохион байгуулжээ.

Ширдингийн суурин нь газарзүйн хувьд KNP-ийн төвд байрлах бөгөөд Тайваны уугуул иргэдийн оршин суудаг бүс юм. Ширдинг сууринд ойролцоогоор 60 орчим өрхийн 400 гаруй иргэд амьдардаг. Өмнө нь эдгээр иргэд амьжиргаагаа ан агнуур, загасчлал болон (slash-and-burn) тарьж, газар тариалан эрхэлдэг байжээ. Яваандаа суурингийн иргэд бэлэг дурсгалын зүйлс борлуулах, зочдод хоол цайгаар үйлчлэх болжээ. Одоогоор суурингийн иргэдийн 70 гаруй хувь нь улирлын чанартай хөдөө аж ахуйн, эсвэл аялал жуулчлалын жижиглэн худалдааны салбарт ажиллаж байна. Зарим уламжлалт үйл ажиллагаа нь KNP болон суурингийн иргэдийн хооронд хурцадмал байдал үүсгэсэн байна.

2009 оноос хойш KNP-ийн захиргаа нь Ширдингийн амьжиргааны загварыг парк даяар өргөжүүлэн сурталчилж, эко-аялал жуулчлалын сүлжээг байгуулж байна. 2010 онд Ширдингийн эко-аялал жуулчлалын үйл ажиллагаанд 4000 гаран жуулчид ирж оролцон, 2011 онд 7000, 2012 онд 10,000 гаран жуулчин ирсэн байна. Төслийн энэхүү амжилтад үзүүлсэн нөлөөлөл нь:

- SCDA-ээс орон нутгийн иргэдийн оролцоотой эко аялал жуулчлалыг хөгжүүлэх ажил зохион байгуулсан
- KNP Захиргааны удирдлагын дэмжлэгтэйгээр орон нутгийн иргэдийг оролцуулан харилцан итгэлцлийг бүрдүүлсэн
- Экоуризмыг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн иргэдийн зөвшилцөл, урт хугацааны оролцоог бүрдүүлсэн
- Эко-аялал жуулчлалыг байгаль хамгаалах ажиллагаатай холбох, үүнд экологийн хяналтын өгөгдөл болон хулгайн антай тэмцэхэд ашиглах
- Орон нутгийн оршин суугчдын чадавхыг бүрдүүлэх, үүнд судалгаа, эргүүл, хяналт, хөрвүүлэлт, зохион байгуулах, харилцаа болон маркетингийн чадавх зэрэг болно.

Дээрх ахиц дэвшлээс үл хамааран төсөлд асуудал учирсаар байгаа бөгөөд тогтвортой хөгжилд хүрэхийн тулд өөрийн дүгнэлт, шүүмжлэлт сэтгэлгээг үргэлжлүүлэн хадгалах шаардлагатай.

Эх сурвалж: Huang, 2011; Shih, 2011; Liu, 2013



Кентинг БЦГ-ын захиргаа Ширдингт ой хамгаалах, экотуризм хөгжүүлэх зорилгоор нутгийн иргэдтэй хамтран ажиллаж байна.



Ширдингт сургалтанд хамрагдаж хүлээн зөвшөөрөгдсөн орон нутгийн сайн дурын ажилчид тусгай дүрэмт хувцас өмсөж экотуризмын хөтөч хийж байна. © Dau-Jye Lu and Chih-Liang Chao

ТЭРГҮҮН ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Зах зээлийн эрэлтэнд суурилсан аялал жуулчлалын үйлчилгээг нутгийн иргэдээр дамжуулан хөгжүүлэх. Бизнесийн амжилтыг нэмэгдүүлэх үүднээс орон нутгийн санал санаачилга, хувийн хэвшлийнхний хооронд түншлэл бий болгох.

2.3 Байгаль хамгааллыг шууд бус дэмждэг эдийн засгийн үр ашгууд

Аялал жуулчлал нь орон нутгийн эдийн засагт оруулж буй эерэг нөлөөллөөр дамжуулан ТХГН-ийн байгаль хамгаалах үйлсэд шууд бус хэлбэрээр нилээдгүй ач тус өгч байдаг. Жуулчдын зарцуулсан мөнгө зуучлагч байгууллагууд болон нутгийн иргэдэд олон талаар ач тусаа өгнө. Ажил эрхлэлт болон бизнесийн үйл ажиллагааг аялал жуулчлалын ажлын байр бий болгох шууд хэлбэрээр, туслах болон дагалдах бизнесүүдэд ажлын байрууд бий болгох шууд бус байдлаар дэмжиж байдаг юм. Үүнд жишээ нь байршуулах хэрэгсэл, аялал, бүтээгдэхүүн зарах төлбөртэй үйлчилгээ хийх зорилготой аялал жуулчлалын агентлагууд, цахим захиалгын

сайтууд; гар урлалын бүтээгдэхүүн зардаг орон нутгийн жижиглэн худалдаачид, жуулчдад зориулсан хоол хүнсээр хангагчид, аялал жуулчлалын компаниудийн үйл ажиллагааг дэмжсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ ханган нийлүүлэгчид, жижиглэнгийн худалдаачид болон жуулчид өөрсдөө багтна. Хөдөлмөр эрхлэлтийн ийм өсөлт нь орон нутгийн эдийн засагт нөлөөлж, бараа, ажил үйлчилгээний худалдын авалт, татварын орлогыг нэмэгдүүлдэг. Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь ажилчиддаа бусад салбарт ч ашиглаж болох шинэ үр чадварыг эзэмших боломжийг олгодог (Шигтгээ 2.5). Эдгээр үр өгөөж бий болсоноороо ТХГН дахь байгаль хамгаалах үйлс болон ард иргэдийн дунд дэмжлэгт сэтгэлийн тус дэм өгч байгааг Бразил, Хятадын Хонконг дахь геопаркийн хоёр жишээ харуулдаг байна (Шигтгээ 2.6). Олон нийтийн дэмжлэг нь эргээд улс төрийн тус дэмжлэг болж хувирдаг байна.

Шигтгээ 2.5

Түншлэлээр дамжуулан бизнесийн үр чадварыг бүрдүүлэх нь

Байгаль орчныг хамгаалах үйлсийг хэргийг орон нутгийн иргэдийн эдийн засгийн хөгжилтэй холбох хамгийн боломжтой салбар бол аялал жуулчлал хэмээн байгаль хамгаалах чиглэлийн олон байгууллагууд үздэг. Гэвч, орон нутгийн ихэнх иргэд бизнесийн туршлага багатай байдаг тул тэдний бий болгосон аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зах зээлийн хэрэгцээг хангахгүй, улмаар байгаль хамгаалах үйлсэд сөрөг үр дагавар учруулах нь бий. Нөгөө талаар аялал жуулчлалын салбарт оршиж буй асар их өргөн мэдлэг, туршлага нь байгаль орчныг хамгаалах байгууллагуудад эдийн засгийн хувьд ашигтай эко-аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгоход дэмжлэг үзүүлэх боломжтой. Аялал жуулчлалын бизнесийн үр чадварыг дамжуулж ашиглах зорилготой хэд, хэдэн түншлэлийг аялал жуулчлал болон байгаль орчны байгууллагууд байгуулжээ.



Аялал жуулчлалын бизнесийн үр чадварт жуулчдыг аюулгүй тээвэрлэх явдал орно. © Giulia Carbone

IUCN-ийн Бизнес болон Биологийн Төрөл Зүйлийн Хөтөлбөр, IUCN-ийн Голландын Хороо хамтран 2008 онд Барселон хотод зохион байгуулсан IUCN-ийн Байгаль Хамгаалах Дэлхийн Конгресс сургалтууд хийсэн нь цааш дөрвөн бүсийн сургалт болон өргөжиж, Камбож (2010), Кени (2011), Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Улс (2012) болон Бүгд Найрамдах Солонгос Улсуудад (2012) тус тус зохион байгуулагджээ.

Эдгээр сургалтын зорилтот бүлгүүд нь байгаль хамгаалах болон олон нийтийн байгууллагууд, ТХГН-ийн менежерүүд байв. Сургалтууд нь оролцогчдод өөрийн бизнесийг амжилттай явуулах, бизнесийн шаардлагатай үр чадварыг олгох, ТХГН дахь аялал жуулчлал болон амралтын газруудыг эдийн засгийн үр ашигтай байдлаар хөгжүүлэн, удирдахад чиглэсэн байна. Сургалтын хөтөлбөр нь бизнесийг хөгжүүлэх, менежментийн гол чиглэлүүд болох зах зээлийн нөхцөл, бизнесийн төлөвлөлт, эрүүл мэнд, аюулгүй байдал, тогтвортой ажиллагаа, маркетинг, борлуулалт, хэрэглэгчийн үйлчилгээний үр чадварыг хөгжүүлэхэд төвлөрсөн байна.

2011 оноос эхлэн, IUCN-ийн Бизнес ба Биологийн олон янз байдлын Хөтөлбөр нь Европын тэргүүлэгч тур оператор болох Куонитой хамтраад эдгээр сургалтыг зохион байгуулсан байна. Куони нь сургалтын төлөвлөгөөг гаргахад тусалсанаас гадна хамгийн гол нь зохион байгуулахад шаардагдах техникийн нөөцөөр дэмжлэг үзүүлжээ. Куонигийн эрүүл мэнд, аюулгүй байдал, маркетинг, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн экспертүүд нь өөрсдийн мэргэжлийн үр чадвар, туршлагыг оролцогчидтой хуваалцахын зэрэгцээ, сургалтын явцад бодит жишээн дээр мэргэжлийн тусламж үзүүлсэн байна. Сургалтыг бодит үр дүнд хүргэхийн тулд Куонигийн орон нутгийн ханган нийлүүлэгч компаниуд олцогч нарт өөрийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг албан ёсоор санал болгож, Куонигийн ирээдүйн багц аялалуудад оролцуулах боломжийг олгожээ. Энэ сургалтын талаарх тойм мэдээллийг <http://www.iucn.org/ecotourism> хаягаас үзэж болно.

ТЭРГҮҮН ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Бизнес хөгжил ба менежментийн үр чадварын сургалтыг нутгийн иргэдэд суурилсан аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхэд чиглүүлж, сургалтандаа нутгийн иргэд, ТББ-ын төлөөлөгчид болон ТХГН-ийн менежерүүдийг оролцуулах.

Шигтгээ 2.6

Дэлхийн геопарк ба тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал (Хонг Конг ТУБ, Хятад, Бразил улсууд)



Хонг Конгийн ЮНЕСКО Глобал Геопарк дахь базальт бус аварга том зургаан талт баганууд.
© David Newsome.



Бразилийн Арипе Геопаркийн орон нутгийн иргэдийн гар урлалын геобүтээгдэхүүнүүд © Jasmine C. Moreira.

Хэдийгээр зарим ачаалал ихтэй паркуудад аялагчдын менежменттэй холбоотой асуудлууд гарч ирсэн ч ЮНЕСКО-гийн Дэлхийн геопарк загварт аялал жуулчлалын байгаль хамгаалал болон эдийн засагт оруулах үр ашгийг хүлээн зөвшөөрч, хэд хэдэн бүс нутагт амжилттай хэрэгжүүлсэн байдаг. Хонг Конгийн ЮНЕСКО-гийн Дэлхийн геопарк (Хонг Конг ТУБ, Хятад) болон Арарипегийн ЮНЕСКО-гий Дэлхийн геопарк (Бразил) нь тогтвортой аялал жуулчлалыг геологийн өвийн байгаль хамгаалал болон эдийн засгийн ашигтайгаар хэрэгжүүлэх боломжийг харуулсан шилдэг жишээнүүд болой.

Хонг Конгийн ЮНЕСКО-ийн Дэлхийн геопарк нь 2009 онд анх үндэсний геопарк болж, 2011 онд ЮНЕСКО-ийн Дэлхийн геопарк статусыг авжээ. Дэлхийн геопаркын зорилго нь геологийн өвийг хадгалах, боловсрол, тайлбарлан мэдээлэх замаар (interpretation) дамжуулан геологийг сурталчлах, аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг дэмжихэд оршино. Энэ парк нь аялал жуулчлалыг хөгжүүлж, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэснээрээ эх газрын Хятадын паркуудаас ялгаатай. Хонг Конгийн ЮНЕСКО Дэлхийн геопаркийг Эх газар ба Далайн Паркийн Удирдлагын газраас удирдан, хамгаалдаг. Биологийн, газарзүйн, соёлын өвд гэмтэл, хохирол учруулах үйл ажиллагааг хориглодог. Хонг Конгийн ЮНЕСКО Дэлхийн геопаркийг бий болгосноор жилийн аялагчдын тоо жил бүр 5 хувиар тогтмол өсөж, одоогоор жилд 1 сая орчим аялагчдад хүрээд байна. Орон нутгийн дэлгүүр, зоогийн газар болон такси үйлчилгээнүүд аялал жуулчлалын нөлөөгөөр өргөжин тэлснээр, орон нутгийн бизнес эрхлэгчид нь Хонг Конгийн газар нутгийн газарзүйн өв соёлыг хамгаалах хүчтэй дэмжигчид болсон байна.

2006 онд үүсгэн байгуулагдсан Арарипегийн ЮНЕСКО Дэлхийн геопарк нь дэлхийн өмнөд хагаст байгуулагдсан, ЮНЕСКО-оос хүлээн зөвшөөрсөн хамгийн анхны геопарк бөгөөд Бразилдаа энэ төрлийн цорын ганц цогцолборт газар юм. Үндсэн дэд бүтэц нь жилд Жуазэйро до Норте хотод хүрэлцэн ирсэн 2.5 сая жуулчдыг хүлээн авах хүчин чадалтай. Геопаркт аялал жуулчлалын нийтлэг үйл ажиллагаа нь явган аялал, модонд авирах, дугуй унах, олсоор буух зэрэг багтана.

Арарипегийн ЮНЕСКО Дэлхийн геопарк нь шинжлэх ухаан, боловсрол, аялал жуулчлалын үнэ цэнэ бүхий 59 газарзүйн байршилтай. Нова Олинда хот нь Бразилийн хамгийн алдартай геологийн зорих газар бөгөөд нутгийн иргэдэд аялал жуулчлалын бизнес эрхлэх боломжийг бий болгож өгдөг. Каса Грандэ Сан нь Нова Олинда хотод үүссэн төрийн бус байгууллага бөгөөд орон нутгийн залуучуудыг соёлын өвийн менежментээр суралцахыг дэмждэг. 2006 онд төв оффис нь хотын хүн амаас гурав дахин их буюу 28,000 зочин хүлээн авч байжээ.

Арарипегийн Дэлхийн геопарк нь Сеара мужийн өмнөд бүсийн тогтвортой хөгжилд хүрэх чухал хэрэгсэл болдог. 2007 онд Соёлын яамнаас нь Арарипег Бразилийн соёлын салбарын хамгийн хүндтэй Родриго Мелло Франк Де Андраде-ийн шагналаар шагнажээ.

Эх сурвалж: Araripe Geopark, 2005; Cabral & Mota, 2010; McKeever, 2010; Moreira, 2011; Ng, 2011; Newsome, et al., 2013; AFCD, 2017

Аялал жуулчлалын шууд ба дам зардлын хувьсах хэмжээ, цар хүрээ

Хүснэгт 2.2 нь аялал жуулчлалаас олох шууд ба шууд бус орлогын боломжит эх үүсвэрүүдийг харуулсан байна. Ерөнхийд нь авч үзвэл орон нутгийн иргэдэд орлогыг

хамгийн их хэмжээнд байлгах нь шилдэг, тэргүүний арга ажиллагаа болох юм.

Аялал жуулчлалын эдийн засгийн үр дагаварын хэмжээ ямар байх нь олон хүчин зүйлээс хамаардаг. Үүнд:

- ТХГН-ийн шинж чанар, байгууламж, хүртээмж, жуулчдын сонирхолыг татах чанар;

Хүснэгт 2.2. ТХГН дахь аялал жуулчлалын зарцуулалтаас олох боломжит орлогын эх үүсвэрүүд

Жуулчдын шууд зарцуулалт	Оператор болон ТХГН-ийн удирдлагаас гарах шууд бус зарцуулалт
Байр сууц болон аяллын хөтөлбөрийн захиалга хийсний төлбөр	Дүрэмт хувцасны үйлдвэрлэл
Тээвэр (автобус, машин, онгоц, завь, зогсоол г.м)	Хангамжийн бараа, барилгын материалууд
Нэвтрэх хураамж	Тавилга үйлдвэрлэл
Байр сууц (ТХГН-ийн захиргаа эсвэл хувийн хэвшлийн ажиллуулдаг)	Зочид буудлын өрөөнүүдийн дотоод засалд зориулсан нутгийн иргэдийн гар урлал
Хөтөч, тайлбарлагчийн үйлчилгээ ба танин мэдэхүйн аяллын төлбөр	Хог хаягдлын зайлуулалт (дахин боловсруулалт)
Хоол, хүнс, ундаа (Зоогийн газар болон дэлгүүр)	Зочдод зориулсан үйлчилгээний хураамжинд төлсөн хувийн хэвшлийн концессийн төлбөр
Мэдээлэл (хөтөч ном, дүрс, ном, дүрс бичлэг)	Бренд бүтээгдэхүүний худалдааны патентын коммис(татвар)
Амралт зугаа үзүүлэх үйлчилгээ, тусгай эвент болон тусгай үйлчилгээнүүд	Татварууд
Төхөөрөмж хэрэгслэлийн түрээс	
Бараа худалдаа (төхөөрөмж хэрэгслэл, хувцас, бэлэг дурсгалын зүйлс, гар урлал, орон нутгийн иргэдээс гаралтай байгалийн гаралтай болон соёлын бүтээгдэхүүн	
Түлш (Мод, модны нүүрс)	
Сайн дурын өглөг хандив, нүүрстөрөгчийн хэмжээг буцаан бууруулах дүйцүүлсэн төлбөрүүд	


Эх үүсвэр: DFID, 1998; van Sickle & Eagles, 1998; Drumm, 2007; Eagles, 2014

- Тухайн зорих газарт жуулчны зарцуулах зардлын хэмжээ, хурд;
- ТХГН дахь эдийн засгийн хөгжлийн хэмжээ ба суурь түвшин;
- Тухайн зорих газар дахь аялал жуулчлалын зардлын дахин эргэлдэж буй хэмжээ (Mathieson & Wall, 1982).

2.4 Байгаль хамгаалалд дам дэмжлэг үзүүлдэг нийгэм, олон нийтийн шинжтэй ашиг тусууд

Аялал жуулчлалын нийгэм, олон нийтэд үзүүлдэг эерэг нөлөөнүүд нь байгаль хамгаалах үйл хэрэгт дам байдлаар тус дэм болж байдаг. Жуулчид болон орон нутгийн иргэдэд ТХГН, түүний орчмын нутаг дахь байгаль хамгаалах ашиг тусыг сурталчилан таниулах нь эргээд байгаль хамгаалах үйлсэд тус дэмжлэг үзүүлэхэд нь нөлөөлдөг байна (Beaumont, 2001; Zeppel & Muloin, 2008). Жуулчид болон орон нутгийн иргэд аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцсоноор орон нутагт тулгарч буй аюул заналхийлэл, байгаль хамгааллын асуудлууд болон менежментийн талаар илүү ойлголттой болж, санаа тавьдаг болдог (Hill, et al., 2010). Аялал жуулчлалын оператор болон хөтчүүд нь жуулчдын мэдлэгийг нэмэгдүүлж, байгаль хамгааллын эерэг үйл бүтээж, байгальд ээлтэй зан төлөв, буяны ажлыг дэмжсэнээр (Powell & Ham, 2008; Weaver, 2013) байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг (Powell, et al., 2009; Curtin, 2010).

Аялал жуулчлалын нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг хослуулах нь ТХГН-ийн хил хязгаарыг тэлэх үүрэг гүйцэтгэж, одоо байгаа газрын менежментийг өргөжүүлэх, сайжруулах сайн талуудтай юм (Dabrowski, 1994). Кени (Sindiyo & Pertet, 1984). Канад (Sewell, et al., 1989), Австрали (Harris, 2002) зэрэг улсуудад яг ийм үр нөлөөг хувийн эзэмшилд байдаг хамгаалалттай газруудад гаргажээ (Moore, 1991).



Канадын Бивер Хиллс Шим мандлын нөөц газар болох Микелон нуур нь Шувуудад чухал бус нутаг учир байгальтай холбогдох боломжийг олгодог. © Glen Hvenegaard

Шигтгээ 2.7

ТХГН-ийн аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг бодлогоор дэмжих нь: Ботсвана улсын туршлага

Ботсвана улсын аялал жуулчлал нь ерөнхийдөө Кгалагадийн цөл, өвст тал, саванна, Окаванго Делта зэрэг олон төрлийн зэрлэг ан амьтан, байгалийн үзэсгэлэнт дүр төрхөд татагдсан жуулчдын байгалийн аялал жуулчлалд суурилжээ. Аялал жуулчлал нь тус улсын эдийн засгийн хоёр дахь том салбар юм. 1970 оноос хойш зэрлэг амьтдын улирлын нүүдлийг хамгаалах, экологийн уян хатан чанарыг хадгалах, олон нийтийн оролцоотой тогтвортой аялал жуулчлалыг зах зээлд сурталчлах, нутгийн оршин суугчдад хүртэх ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Ботсвана улс томоохон хэмжээний газар нутгийг бодлогоор дархлан хамгаалсан байна.



Ботсваны дархан цаазат бүс дэх Африк бизон (*Syncerus caffer*) © Ralf Buckley

1990 онд баталсан Ботсванагийн аялал жуулчлалын бодлого нь нутгийн иргэдэд онгон байгальд суурилсан аялал жуулчлалаас ашиг хүртээх, орон нутагт ажил эрхлэх болон аялал жуулчлалын үйлчилгээг концессоор үзүүлэх боломжийг бий болгоход чиглэжээ. Жуулчдаас байгалийн нөөцөд, ялангуяа зэрлэг байгальд үзүүлэх нөлөөллийг харгалзан үзэж 1992 онд Аялал жуулчлалын тухай хууль, 1996 онд Аялал жуулчлалын дүрмийг батлан гаргасан бөгөөд эдгээр хууль нь цөөн тоотой, өндөр үнэтэй аялал жуулчлалын бизнесийг дэмжих чиглэлтэй. Эдгээр бодлого нь дэд бүтцийн чанар нэмэгдсэнтэй холбоотойгоор томоохон бүлгээр аяладаг гэрэл зургийн аялал жуулчлалд онцгой нөлөө үзүүлдэг. Энэ бодлогын дагуу аялал жуулчлалын аж ахуйн нэгжүүдийг 1992 оны Зэрлэг ан амьтан хамгаалах тухай болон ТХГН-ийн тухай хуульд тусгагдсан чанарын стандарт, протоколын дагуу ангилж, тусгай зөвшөөрөлтэй, зэрэглэлтэй болгосон. Энэ арга хэмжээ нь ялангуяа "тусгаарлагдсан" аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлдэг гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын зүгээс эсэргүүцэл тулгарсан боловч, биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалахад чухал дэмжлэг болсон юм.

Концессийнн гэрээг дунджаар 15 жилийн хугацаатай олгох бөгөөд байгаль орчин (жишээлбэл: дэд бүтцийн хөгжил, хог хаягдлын менежмент) болон нийгмийн (жишээлбэл: чадавхыг бэхжүүлэх, нутгийн иргэдийн ажил эрхлэлт, орон нутгийн орлого хуваарьлалт) нөлөөллийн асуудлыг шийдвэрлэхийг шаарддаг. Зарим ТХГН болон зэрлэг амьтдын нөөц газрын нийтийн хоноглох газрын менежментийг авч явах тендерт оролцогчоос байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг явцын дунд гаргаж, гэрээг зурах үедээ гүйцэтгэлийн баталгааг мөнгөн хэлбэрээр байршуулсан байхыг шаарддаг байна.

Олон нийтийн оролцоог хангах, нутгийн оршин суугчдын эрх ашгийг хамгаалах явдлыг 2002 оны Үндэсний Эко-жуулчлалын Стратеги (NES), Нутгийн иргэдэд түшиглэсэн Байгалийн Нөөцийн Менежмент (CBNRM)-ийн 2005 оны бодлогоор үргэлжлүүлэн дэмжсэн байна. NES нь экологи, эдийн засгийн тогтвортой байдалд төвлөрч, байгаль хамгаалалд томоохон хувь нэмэр оруулсан аялал жуулчлалын бизнесүүдэд шагнал олгодог. CBNRM нь байгаль хамгаалал, орон нутгийн хөгжлийн зорилтуудыг нэгтгэсэн менежментийн эрх мэдлийг талбай түрээслэх, хувийн байгууллагатай гэрээ байгуулах, орон нутагт зориулсан тэтгэлгийг дэмжих үүрэг бүхий хэд хэдэн олон нийтийн сангуудад шилжүүлсэн байна. Судалгаагаар CBNRM нь орон нутгийн иргэдийн санаачлагын орлого, нийгмийн хөрөнгийг нэмэгдүүлэх, ТХГН-ийг амжилттайгаар хамтран удирдахад хувь нэмэр оруулж буйг тогтоосон байна.

CBNRM-тэй холбоотой шаардлага нь байгаль хамгаалалд суурилсан байгууллагуудын хувийн (ихэвчлэн гадаадын өмчит) арилжааны аж ахуйн нэгжүүдтэй өрсөлдөх, тодорхой бүлгүүдийн давуу байдал, тухайн нийгэмд олж буй орлогын хэмжээ зэрэг орно.

Зэрлэг амьтдын тоо толгойг хамгаалах ажлын үр дүнд 2014 онд Засгийн газраас арилжааны ан агнуурт хориг тавьж, ан агнуурын бүсүүдийг гэрэл зургийн аяллын бүс болгосон байна. Окаванго Делта орчмын олон нийтийн концессийн үр дүнд ан агнуураас олдог байсан орлогыг нөхөх зорилгоор гэрэл зургийн аялал жуулчлалын үнэ тарифыг нэмжээ. Цөөн тооны зэрлэг амьтад зарим орон нутгийн хувьд дан гэрэл зурагт чиглэсэн аялал жуулчлалаас олох ашиг орлого нь бага байх магадлалтай тул засгийн газрын зүгээс зах зээлийг нь солонгоруулах стратеги хэрэгжүүлэх үүднээс (К. Бруукстэй хийсэн ярилцлагаас) Ботсваны Эко-жуулчлалын Баталгаажуулалтын Системийг Ботсваны Аялал Жуулчлалын Байгууллагын удирдлага дор хөгжүүлэн ажиллаж байна.

Эх сурвалж: IUCN Botswana, 2002; Hachileka, 2003; Mbaiwa, 2005; Thakadu, 2005; Blaikie, 2006; Magole & Magole, 2011; Mbaiwa & Stronza, 2011; Wyman, et al., 2011; TIES, 2013.

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Аялал жуулчлалын үйл ажиллагаагаар дамжуулан байгаль хамгаалалд шууд хувь нэмэр оруулдаг, хамгаалалтын захиргаа, нутгийн иргэдэд эдийн засгийн үр өгөөж өгдөг, олон түмэн, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн "гурвалсан суурь зарчим" бүхий үндэсний бодлого хэрэгжүүлэх.

2.5 Олон нийт, хувь хүний сайн сайхан оршихуйд тустай аялал жуулчлалын ашиг тусууд

Нийгэм олон нийт, эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөнүүд нь байгаль хамгаалал, ТХГН-ыг хүчирхэгжүүлээд зогсохгүй жуулчид, орон нутгийн иргэдэд ач тусаа өгж байдаг. Энэ хэсэгт нутгийн иргэдэд ирэх ашиг тус, эрүүл мэндийн ашиг тус гэсэн хоёр үндсэн сэдвийг хөндөх болно.

Нутгийн иргэдэд ирэх ашиг тусууд

Нутгийн иргэдийн хөгжлийг олон янзын хэлбэрээр, түүний дотор аялал жуулчлалаар дамжуулан хангаж болно. Ботсвана (Шигтгээ 2.7), Серб (Шигтгээ 2.8) зэрэг улсын жишээн дээр харахад ТХГН-н аялал жуулчлал нь нутгийн иргэдийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг байна (Eagles, et al., 2002; Telfer & Sharpley, 2008; Mitchell & Ashley, 2010; Snyman, 2013). Аялал жуулчлалын үйл ажиллагааг зөв төлөвлөж, удирдаж чадвал үр нөлөө ихтэй байдаг. Хамгаалалттай газар нутагт тогтвортой аялал жуулчлал

хөгжиж байгаа тохиолдолд дараах ашиг тусыг авч ирэх боломжтой. Үүнд:

- Нутгийн иргэдийн амьжиргааны түвшинг дэмжиж, сайжруулах. Жишээ нь дэд бүтэц, харилцаа холбоо, боловсрол, сургалт, сайжруулах санал санаачилга гаргаж ажиллах.
- Соёл, урлаг, үзэсгэлэнт газрууд, зэрлэг байгаль, ан амьтад зэрэгт түшиглэсэн орон нутгийн тогтвортой өсөлтийг хангах. Эдгээр нь тухайн орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх гол тулгуур, хүчин зүйл болдог.
- Иргэдийн хувийн ур чадварыг хөгжүүлж, засаглалыг сайжруулах замаар орон нутгийн хөгжлийг дэмжиж, бэхжүүлэх;
- Алслагдмал орон нутагт байгаа иргэдэд эрүүл мэндийн суурь үйлчилгээ, нийгмийн дэд бүтэц болон бусад бүтээн байгуулалтыг авч ирэх арга хэрэгсэл нь болох.

Нутгийн иргэдийн хувьд дээрхи нийгэм-эдийн засгийн үр өгөөжийг бодитой болгохын тулд аялал жуулчлалынхаа (аялагчдын) зорих газрыг хүрч очих боломжтой, мөн аялагчдын эрэлтийг хангаж, нутгийн иргэдийн өсөлттэй уялдсан дэд бүтцийг барьж байгуулсан байх шаардлагатай

Шигтгээ 2.8

Байгалийн дурсгалт зүйлс, орон нутгийн сууринг тогтвортой аялал жуулчлалаар хамгаалах нь

Сербийн хойд нутгийн Жадовник уулын энгэрт байршдаг, үзэсгэлэнт Сопотника хүрхрээ нь урт удаан хугацааны туршид "хараа, хамгаалалт"-нд байсны ачаар ариун дагшин, онцгон зэрлэг байдлаа хадгалан үлдэж чаджээ. Үүний зэрэгцээ, хөдөө аж ахуйгаас хамааралтай Сопотника тосгонд ажилгүйдлийн түвшин өндөр байсан тул оршин суугчдын зарим хэсэг нь цагаачлан гарсан байна. 2005 онд түүний байгаль, боловсрол, соёл, аялал жуулчлал, амралт зугаалгын үнэ цэнийг хадгалан хамгаалах зорилгоор байгалийн дурсгалт газар (IUCN-ийн III ангилал) ангилалд оруулж, менежментийг нь Камена Гора Уулчдын Клуб хэмээх ТББ-д хариуцуулжээ. Жуулчид хүрхрээ үзэхээс гадна Лим Голоор рафтинг завиар аялаж, явган аялж агуй, худаг, хавцал, модод, булаг шанд зэрэг байгалийн дурсгалт газруудтай танилцан, XIII зууны Милесева хийдэд зочилдог байна.

Өдгөө орон нутгийн лицензтэй уулын авирагчид тосгондоо амьдрангаа ажил эрхэлж, дурсгалт газрыг тогтвортой ашиглах, жуулчдын менежментийн хийх ажилд хувь нэмрээ оруулж байна. Жуулчид шошго бүхий эко-уутанд хогоо цуглуулаад буцаагаад авч явдаг тул хог цуглуулах цэг, сав байрлуулдаггүй. Байгальд аялагчдын хэсэг, эрдэмтэд хэрэв хүсвэл хуучин сургууль байгаад уулчдын лоож болсон байранд байрлаж болдог. Орон нутгийн суурин ч аялал жуулчлалын нөлөөгөөр сэргэж, олон иргэд төрлөх тосгондоо эргэн ирж, хэд хэдэн өрх айлууд байршуулах хэрэгсэл, нутгийн эрүүл хоол хүнсээр аялагчдад үйлчилдэг болсон. Сопотника тосгоны хамгаалагдсан байгаль, соёлын өв нь орон нутгийн тогтвортой хөгжлийн стратегийн чухал хэсэг болсон бөгөөд энэ нь олон төрлийн оролцогч талуудын хамтын ажиллагааны ач тус ажээ.

Эх сурвалж: Miljkovic & Zivkovic, 2012; Filipović, et al., 2017



Сербийн Сопотника хүрхрээ, түүний эргэн тойрны үзэсгэлэнт нутаг. © Ivana Damjanović.



Бразилын Тиюка БЦГ-ын Мэдээллийн төвд байрлуулсан жуулчдын авсан гэрэл зургийг үзэж буй жуулчин. © Yu-Fai Leung

болдог (Spenceley, 2008). Зам тавьж сайжруулах, тээврийн хэрэгслийг тогтвортой болгох, суурин холбоо, гар утас, интернет зэрэг харилцаа холбооны шийдлүүдийг бий болгохын зэрэгцээ цэвэр усны хангамж, бохирын шийдэл болон хог хаягдлын менежментийг бий болгох нь чухал ач холбогдолтой бөгөөд ингэснээр жуулчид, нутгийн иргэд, ТХГН-ийн болон гадаад ертөнцийг холбосон биет ба дижитал холбоос үүсэх боломжийг бий болгоно.

Аялал жуулчлалын бизнесүүд нь цэвэр усны хангамжийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн үйл ажиллагааг сайжруулах, олон нийтийн барилга байгууламжийг барих, орон нутгийн сургууль, айл өрх, хүүхэд багачуудад үндсэн хэрэглээний зүйлсийн хандив цуглуулах зэрэг орон нутагт чиглэсэн төсөл хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлж, санхүүжилт босгох зорилго бүхий ашгийн төлөө бус байгууллагуудтай хамтран ажилладаг (Wilderness Holdings, 2013). Эдгээр үйлчилгээ, нөөцөөр хангах нь аялал жуулчлалын олон нийтийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх шууд арга зам юм. Заримдаа аялал жуулчлалын компаниуд нь ажилчиддаа хэл, бичиг үсэг, математикийн ерөнхий сургалт явуулдаг нь нутгийн иргэдийн боловсролын түвшинг нэмэгдүүлдэг. Орон нутгийн иргэдэд эдгээр ур чадвар, мэдлэгийг өгсөнөөр ирээдүйн ажил эрхлэлтэндээ ашиглах боломжтой болно (Snyman, 2013).

Шигтгээ 2.9

Эрүүл мэндийн түншлэл: Австралийн Медибанк, Викториагийн ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаа, Зүрх Хамгаалах Үндэсний Сангуудын хамтын ажиллагаа

Австрали улсын хувьд биеийн дасгал, хөдөлгөөний дутагдал тулгамдсан асуудал болж, насанд хүрсэн хүн амын талаас илүү хувь нь таргалалт, эрүүл мэндээ хэвийн хадгалахад шаардлагатай идэвхтэй хөдөлгөөний дутагдал орсон байна. Таргалалт, таргалалтаас шалтгаалсан өвчлөлд зарцуулсан шууд болон шууд бус зардал 2008 - 2009 онд 37.7 тэрбум Австрали долларт хүрчээ. Судалгаагаар жил бүр 7,200 Австраличууд таргалалт, таргалалтаас шалтгаалсан өвчлөлөөр амь насдаа алдаж байна.

Энэ асуудлыг шийдвэрлэхэд чиглэн, Викториагийн хамгаалалтын захиргаа Эрүүл Хүрээлэн, Эрүүл Хүмүүс (НРНР) хөтөлбөрөөр хүмүүсийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор мужийн БЦГ болон ТХГН-уудад зочлохыг уриалах болсон байна. НРНР хөтөлбөрийн хамрах хүрээг нэмэгдүүлэх зорилгоор Викториагийн хамгаалалтын захиргаанаас Австралийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх сүлжээний томоохон төлөөлөл болсон Медибанк Австрали болон Зүрх хамгаалах Үндэсний Сантай хамтран ажиллах болжээ.

БЦГ-ууд нь иргэд болон олон нийтийн хувьд эрүүл мэндээ хадгалж, сайжруулах чухал газар болдог тул энэхүү түншлэл нь Медибанк болон Зүрх хамгаалах Үндэсний Сангийн хувьд олзуурхууштай зүйл байв. БЦГ-ууд нь дасгал, хөдөлгөөн хийх талбай олгож, иргэдийн физик болон сэтгэцийн эрүүл мэндэд сайнаар нөлөөлдөг. Ногоон орчин нь өөрөө эрүүл мэндэд сайнаар нөлөөлж, байгаль нь стресс, сэтгэцийн өвчлөл үүсэхээс сэргийлэхэд тустай нь батлагдсан байдаг билээ. НРНР хөтөлбөрийн доктор Роб Гренфелийн тэмдэглэснээр Медибанкийн дэмжлэгтэйгээр Викториа Хүрээлэн нь илүү олон хүнийг гэрээсээ гарч, Австралийн ТХГН-уудын нээлттэй зай талбайд дасгал хөдөлгөөн хийхэд сайнаар нөлөөлөх болсон гэжээ. Зүрх хамгаалах Үндэсний Сангийн гүйцэтгэх захирал Др. Лин Робертсын хэлснээр өдөрт 30 минут алхах нь зүрх судасны өвчлөл, цус харвах эрсдэлийг тал хувиар бууруулдаг байна.

Хамтын ажиллагааны хүрээнд Медибанк Олон Нийтийн Сангаас НРНР-тай хамтран өөр нэгэн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлжээ. Энэ хүрээнд эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ТХГН-уудад дасгал хөдөлгөөн хийх явдлыг эмчин заавраар олгодог болгоход дэмжлэг үзүүлж, нөөц боломжоор хангахаар ажиллаж байна.

Эх сурвалж: НРНР, 2017

ТЭРГҮҮН ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

ТХГН дахь амралт зугаалгын үйл ажиллагааг нутгийн иргэд, олон нийтийн хэрэгцээг хангах чиглэлээр дахин харж, хүний эрүүл мэнд, сайн сайхан оршихуй гэх мэт нийгмийн илүү том хэрэгцээг хангахад чиглүүлэх.

Иргэдийн эрүүл мэндийн ашиг тусууд

ТХГН-т тулгуурласан аялал жуулчлал нь иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд эерэг үр дагавар гаргадаг нь тогтоогдоод удаж буй. Хүний эрүүл мэнд нь цэвэр агаар, цэвэр ус зэрэг экосистемийн зөв тогтолцооноос хамааралтай байдаг билээ. Байгаль нь бидний бие махбодь, сэтгэлзүй, гоо сайхны болон оюун санааны хэрэгцээ шаардлагыг ханган дэмжиж байдаг (ТХГН-т ирж буй жуулчид нь баяр хөөр, адал явдал, амралт, урам

зориг, бүтээлч сэтгэлгээ зэргийг олж авах олон сэдэл зорилгоор аялдаг). Энэ бүхэн нь хүний эрүүл мэнд, сайн сайхан байдалд чухал нөлөөтэй (SHSD, Австрали, 2008). Хүний эрүүл мэндэд сайнаар нөлөөлдөг эдгээр хүчин зүйлс нь, сэтгэл гутрал, шилжин суурьшсан иргэд, дүрвэгсдийн сэтгэл засал, эрсдэлтэй орчинд буй хүүхдүүд ба давтан гэмт хэрэг үйлдэгч нарт зориулсан нийгмийн хөтөлбөрүүдийг санаачилан хэрэгжүүлэх боломж бий болгодог.

Шигтгээ 2.10

Мачу Пичу (Перу) дахь аялал жуулчлалын үр нөлөө



Зураг: Мачу Пичу нь ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн жагсаалтад бүртгэгдсэн Перу улсын аялал жуулчлалын гол бүс нутаг. © Brendali Carrillo Barrera

Эртний алдарт Инкүүдийн хот болох Перу улсын Мачу Пичу нь Үндэсний түүхийн нөөц газар бөгөөд ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэгдсэн газар юм. Хэдийгээр аялал жуулчлалын салбар нь цэцэглэн хөгжсөн боловч өсөн нэмэгдсээр буй жуулчдын тоо, хөгжил, бүтээн байгуулалт нь тухайн газрын экологийн бүрэн бүтэн байдал хийгээд нутгийн соёлын өвөрмөц шинжийг алдагдуулхад хүргээд байна. Байгаль орчинд дараах нөлөөг үзүүлэх болжээ. Үүнд:

- Биологийн олон янз байдалд үзүүлэх үр нөлөө: Ойрын үед болон цаашид хөгжүүлэхээр төлөвлөсөн аялал жуулчлал нь Өмнөд Америкт Андын өндөр уулсад үлдээд буй хамгийн сүүлийн ойн бүсэд аюул учруулж буй. Инкагийн түүхэн жимээр аялах (дурсгалт газарт хүрч очих гол зам нь) аялагчдын тоо нэмэгдсэнээр хүний гаргасан хог хаягдлыг нэмэгдүүлж, өндөр бүсийн эмзэг парамо өвслөг хөрсийг гэмтээж эхэлжээ. Онгон байгальд үзүүлж буй олон сөрөг нөлөөний нэг болох дуу чимээ нь Андын тас (*Vultur gryphus*) шувууг алга болход хүргэж, аялал жуулчлал дагасан дэд бүтцийн хөгжил нь ууланд амьдардаг нэн ховордсон Андын баавгайн (*Tremarctos ornatus*) нүүдлийн замыг алдагдуулжээ.
- Топографийн нөлөө: Мачу Пичугийн топографийн өвөрмөц бүтэц, газарзүйн эмзэг байдал нь аялал жуулчлалаас үүсч буй ачаалалд тун мэдрэг тул эртний хотынх нь зарим хэсэг доош хэвгийн гулсаж эхэлжээ. Мөн уулын оройд жуулчдад зориулж барьсан нэмэлт байгууламжууд нь Урумба голын хөндий дагуу хөрсний гулгалт өгж болзошгүй болгожээ.
- Археологийн тууринд үзүүлэх нөлөө: Инкачуудын үед Мачу Пичуд 500 хүрэхгүй хүн амьдардаг байсан бол өдгөө өдөртөө 2,000 гаруй жуулчин ирж байгаа нь МЭ 1470-аад оны үед баригдсан энэ хот өнөөгийн хэрэглээний ачааллыг даахгүйд хүргэж байна. Хэдийгээр зохицуулалт хийж, хөтөч тайлбарлагчтай аялал зохиож байгаа ч олон түүхэн байгууламжийн хэсгүүд эмтэрч, гэмтэж сүйджээ.
- Дэд бүтэц, зочдын үйлчилгээ: Мачу Пичугийн хувьд байгалийн онцлогоос нь шалтгаалан дэд бүтэц хөгжүүлэхэд тохиромжгүй, жуулчдын тоо өсөн нэмэгдэж буй, хэт бөөгнөрөл, түгжрэл үүсдэг зэрэг нь сэтгэл зовоосон томоохон асуудлууд болжээ. Сөрөг нөлөөг багасгаж, жуулчдын сэтгэл ханамжийг хадгалахын тулд удирдах байгууллагуудаас хүчин чадлыг зохицуулах арга сэдэж, мөрдүүлэхийг зорьж байна. Зөвшөөрөл, хязгаарлалтын арга хэмжээг зэргэлдээх Инка Трэйл зэрэг цэгүүд дээр хэрэгжүүлж эхэлсэн байна. Эрэлт хэрэгцээ их байдаг тул явган аялах хүсэлтэй жуулчид зургаан сар хүртэл хугацаанд хүлээлгэнд ордог болжээ.

Дээрхи товч мэдээлэл нь Мачу Пичугийн урт удаан хугацаанд ашиглагдах чадамж, оршин тогтнолд аялал жуулчлалаас учруулж буй аюулыг илтгэж байна. Мачу Пичугийн нөөц хамгаалалт болон аялал жуулчлалыг дэмжих хоорондын тэнцвэрийг зөв тогтоох нь дурсгалт газрын байгаль орчин, соёлын үнэ цэнийг хадгалахад чухал нөлөөтэй юм.

Эх сурвалж: LaFranchi, 2001; INC, 2005; Sassa, et al., 2005; Collyns, 2007; Larson & Poudyal, 2012



Эквадорын Галапагосын БЦГ-ын Бартоломе арлын хөтөчтэй явган аялал. © Yu-Fai Leung

Шинжлэх ухааны олон салбарт (экологи, биологи, байгаль орчны судлал, газар төлөвлөлт, сэтгэц эмгэг судлал, анагаах ухаан г.м.) байгаль нь хүний эрүүл мэндэд чухал ач тустай болохыг баталж нотолсон байдаг (Maller, et al., 2009). Эрүүл мэндийн зарим ач тус нь амьдралын хэв маягтай хэд, хэдэн байдлаар холбогддог. Хүн байгальд ойр байснаараа таргалалт, зүрх судасны болон уушгины өвчин, чихрийн шижин, цус харвалт, хорт хавдар, яс булчингийн өвчин, сэтгэл гутрал, ясны сийрэгжилт, ядаргаа, нойргүйдэл, зан төлөвийн өөрчлөлт зэрэг эрсдэлүүд нь багасдаг (Sparkes & Woods, 2009; Lemieux, et al., 2012; Romagosa, et al., 2015). Байгальд тогтмол аялах нь эрүүл мэндээ өвчнөөс урьдчилсан сэргийлэхэд тооцогдох болжээ. Олон улсын “Эрүүл хүрээлэн-эрүүл хүн” (Healthy Parks - Healthy People)

хөдөлгөөн нь ТХГН-ууд нь хүний эрүүл мэндийн асар их нөөц, эх сурвалж болохыг харуулж байна (НРНР, 2017; Шигтгээ 2.9).

2.6 Аялал жуулчлалын сөрөг нөлөөлөл

ТХГН-т түшиглэсэн аялал жуулчлал нь олон талын ашиг тустай байсан ч хэрэв зөв менежментгүй бол байгаль орчин болон орон нутагт олон сөрөг нөлөөлөл үзүүлдэг (Шигтгээ 2.10). ТХГН-ийн үндсэн үүрэг нь байгаль орчноо хамгаалах явдал тул менежерүүдийн хувьд байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг үр дагаварыг гарах, хүндрэхээс нь өмнө аль болох эрт илрүүлж байх нь чухал байдаг (CBD, 2015). ТХГН дахь аялал жуулчлал нь нутгийн иргэд, болон газар эзэмшигчдэд сөрөг нөлөө үзүүлдэг. ТХГН-ийн менежерүүд хийгээд аялал жуулчлалын салбарыхан нутгийн иргэдтэй сайн хөршийн холбоотой, сайн түншүүд байх үүрэгтэй байдаг. Менежерүүдийн хувьд ТХГН ба түүний орчны бүсэд аялал жуулчлалаас байгаль орчин болон олон нийт, нийгэмд үзүүлж буй үр дагаварыг тогтмол хянаж байх ёстой билээ. Ингэснээр асуудлыг олж тогтоох, ямар өөрчлөлт явагдаж байгааг ажиглах, шаардлагатай үед хариу арга хэмжээ авах, дараа нь хэр үр дүнтэй болов гэдэг дээр үнэлэлт, дүгнэх боломжууд бүрднэ. Энэ хэсэгт аялал жуулчлалаас гарч болзошгүй сөрөг үр дагаваруудыг гаргаж хэрхэн үнэлж, засч, залруулах талаар зөвлөмжүүд өгнө.

Сөрөг үр дагавар хаа ч байдаг

Менежмент хичнээн сайн байлаа ч аялал жуулчлалаас тодорхой хэмжээнд сөрөг нөлөө гардагыг мартахгүй байх нь чухал. Жуулчид ТХГН-н нутаг дэвсгэрт хөл тавих төдийд нүүрстөрөгчийн хийн ул мөр үлдээдэг. Жуулчдын хөлд байгалийн эмзэг орчин үрэгдэж гэмтэхээс сэргийлэхийн тулд менежментийн бодлого хэрэгжүүлэхээс өөр аргагүй болдог.



Сербийн Сопотникийн хөндөгдөөгүй газар. © Ivana Damjanović.

2.7 Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүд

Аялал жуулчлалтай холбоотой бүхий л үйл ажиллагаа том, жижигээс үл хамаараад, тухайлбал зорих газарт хүрэх, байрлах хэрэгслийн зориулалттай томоохон хэмжээний дэд бүтцийн төслүүд ч бай, эвэл хоноглох цэг, явган аяллын жим зэрэг багавтар хэмжээний ажлууд ч бай ТХГН-ийн байгаль хамгаалах ажилд сөрөг үр дагавар үзүүлэх талтай байдаг. Менежментийн зүгээс аливаа бүтээн байгуулалтын барилгын ажлыг эхлэхээс нь өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж (доор харна уу), шаардлагатай хариу арга хэмжээг авсан байх ёстой байдаг.

Биофизикийн болзошгүй нөлөөнүүд

Биофизикийн болзошгүй нөлөө гэдэгт ландшафтын түвшинд ТХГН-ийг бүхэлд нь хамарч болох үр нөлөөг хамтатгаж ойлгоно. Үүнд жишээ нь агаар, усны чанар доройтол, усны хэрэглээ ихсэх, хэт овортой дэд бүтэц байгуулснаар газрын төрх байдлыг бүрмөсөн өөрчлөх (Шигтгээ 2.11), эрдэс баялаг болон эрчим хүчний ашиглалт,



Гватемалагийн Сан Маркос Ла Лагунад нэвтэрхийг хориглосон бүсийн хашаа ба дамнуурга. © Sandra De Urioste-Stone

Шигтгээ 2.11

Дэд бүтэцтэй холбоотой нөлөөнүүд

ТХГН дахь дэд бүтэц нь явган аялалын жим, эргийн модон тавцан, гүүр, хад асга, өндөр мод руу гарах шат, өндрөөс харах цэг, тэмдэг тэмдэглэгээ, отоглох цэг, сууц байшин болон мэдээллийн төв зэрэг бүтээн байгуулалтаас бүрднэ. Зарим газарт байр сууцыг нь захиргаа нь эзэмшдэг. Бусад байр сууц, катеринг хийх, аялалын бүтээгдэхүүний дэд бүтцүүдийг хувийн хэвшлийнхэн өмчилнө. Жишээ нь цанын дүүжин лифт, усны эргийн мондон тавцан, агаарын кабел зөөгч зэрэг орно.

Дэд бүтцийн байгаль орчинд үзүүлэх хор нөлөө нь усны бохирдол, харагдах байдалд гарсан өөрчлөлт, дуу чимээ болон нутагшуулсан амьтан, ургамал зэргээс бүрднэ. Байгаль орчинд үлдээх үл мөр нь дэд бүтцээсээ илүү том цар хүрээг хамардаг. Үүнд гэрэлтүүлэг, барилгын ажлын дуу чимээ, машин техникийн хөдөлгөөн, газар ухагч машин механизм, овоолсон далан шороо, барилгын хаягдал ус, агаар, усны бохирдол, хог хаягдал, зэрлэг ургамал, амьтан ургамлын өвчин, зэрлэгшсэн гэрийн амьтад гэх мэт орно. Иргэдэд зориулсан томоохон хэмжээний дэд бүтцийн бүтээн байгуулалтууд нь ан, амьтдын тоо, толгойг таслан хуваах, зэрлэг амьтад машинд дайруулах, машины дуу чимээ, гэрлээс үүдэлтэй сөрөг нөлөө үүсгэх магадлалтай. Шинэ машин зам, явган хүний жим нь нутаг оронд халтай шинэ амьтан, ургамал суурьшиж дэлгэрэх аюулыг агуулдаг. Шинэ бүтээн байгуулалт нь аялагчдын тоог нэмж, байгальд үзүүлэх нөлөөг нэмж, цаашид дарамт бий болгож, нягтаршил бий болгодог.

ТХГН-тучирч болзошгүй үр дагаваруудтай тэмцэх арга хэлбэрийн талаар Buckley (2004, 2009, 2011, and 2012 онуудад) судалсан байдаг. Жишээ нь бохирын болон хаягдал усыг цөөн тооны жуулчид очдог чийглэг уур амьсгалтай газарт ялзмагт суурилсан бага оврын жорлон хэрэглэх байдлаар шийдэж болдог бол аялал жуулчлал өндөр хөгжсөн газарт хажуудаа цөөрөмтэй, олон дамжлага цэвэрлэх төхөөрөмж бүхий үйлдвэрийн аргаар шийддэг. Ургамал тархалтын үр нөлөөг хянах онцгой хэцүү. Жишээ нь машин техникийн дугуй, аялагчдын гутлын ул, майхны гадсаар ямар нэг мөөгөнцөрийн үрэнцэрийг тархаахгүйгээр бүрэн устгая гэвэл угааж, ариутгах хэрэгтэй боловч бодит байдал дээр энэ стандартыг дагаж мөрдөх бараг боломжгүй. Хогийн ургамлын үр нь машин техник болон хүний хувцсанд наалдаж дамждаг байна.

Жуулчид олноор очдог тусгай хамгаалалттай газарт жуулчдын аюулгүй байдал болон тохь тухыг хангах үүднээс дэд бүтцийн том бүтээн байгуулалт хийх шаардлагатай болдог. Технологийн шийдэл ашиглаж болох тодорхой хэсэгт зочдыг төвлөрүүлэх замаар сөрөг үр дагаварыг багасгаж болдог боловч үүний тулд хийх бүтээн байгуулалт нь мөн л сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Байршуулах хэрэгсэл, катеринг үйлчилгээ, тээврийн төвлөрсөн цэг гэх мэт өргөн цар хүрээтэй дэд бүтцийг тусгай хамгаалалттай газрын гадна орших хувийн эсвэл нийтийн газар барих нь зохимжтой байдаг. Гольфийн талбай, иргэдийн тухлаж амрах байр болон цанын бааз зэрэг амарч, зугаалах зориулалттай дэд бүтцүүд нь байгаль хамгаалалд хэд хэдэн сөрөг үр нөлөө үзүүлж байдаг. Эдгээр нь аялагчдаас байгаль эхээс хүртэх үр өгөөжид нь огтхон ч нөлөөлөхгүйгээр барахгүй тусгай хамгаалалттай газар нутаг дотор байрлах туйлын тохиромжгүй. Үүнд мөн цахилгааны шугамнууд, харилцаа холбооны камхагууд, хурдны замууд, усан цахилгаан станц гэх мэт байгаль хамгаалал болон амарч зугаалахад огтхон ч холбоогүй дэд бүтцүүд мөн багтна. Дэд бүтцийн эдгээр төрлүүд нь байгаль орчинд хор хөнөөлтэй бөгөөд байгаль орчин болон амарч, зугаалахад огтхон ч ач холбогдолгүй байдаг.

Эх сурвалж: Liddle, 1997; Buckley, 2004; Buckley, 2009; Buckley, 2011; Buckley, 2012b

ургамал амьтдын амьдрах орчинг сүйтгэх, гаднын төрөл зүйлийг авч ирж нутагшуулах, хөрсний бохирдол үүсгэх, үзэгдэх харагдах орчинд нөлөөлөх, шөнийн харанхуй орчинг алдагдуулах, гэрлийн бохирдол үүсгэх, байгалийн дуу чимээг алга болгох зэрэг орно. Эдгээр бүх үр дагавар нь ТХГН-н тодорхой нэг байршилд илэрч болно. Хэр ноцтой байгаа нь илэрч буй давтамж нь нэг, хоёр байна уу гэх мэт нөхцөл байдлаас шалтаалан байршил бүрт өөр, өөр байж болдог.

Ургамал, амьтанд үзүүлэх нөлөөнүүд

Ургамал, амьтанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөнүүд нь мөн адил ТХГН-ийг бүхэлд нь, эсвэл тодорхой байршилыг хамарсан шинжтэй байна. Ургамлын аймагт үзүүлэх сөрөг нөлөөнд санаандгүй байдлаар гаднын ургамал буюу өвчин үүсгэгч бичил организм бий болгох, гишгэж талхлах, олон салаа зам мөр гаргах, ховор төрөл зүйлийн ургамлыг санаатай тасдаж авах зэрэг орно. Зэрлэг амьтанд учрах нөлөө шууд шинжтэй. Үүнд амьтад машинд дайруулж үрэгдэх, тэднийг агнах, загасчлах, хүний үр нөлөөтэй холбоотой өвчинд нэрвэгдэх, амьтдийг ижил сүргээс нь таслах, холдуулах үйлдлүүд гарч байна. Ялангуяа ан, амьтдийг зориудаар хооллох, хаяж орхисон хүнсний үлдэгдэл идэж занших зэрэг нь зарим ТХГН-ийн хувьд ноцтой асуудал үүсгэж байна. Үүнд мөн аялагчид (ихэвчлэн санамсаргүй үйлдлээр) амьтдийн тав тух, аюулгүй байдлыг алдагдуулдаг явлууд орно. Жуулчдаас зэрлэг амьтдийн ертөнцөд учруулах сөрөг нөлөө нь дам шинжтэй байх нь бий. Жишээ нь зарим төрөл зүйлийн зан төлөвийг өөрчилж, тэр бүү хэл тодорхой хугацааны явцад ТХГН дахь нийт төрөл зүйлсийн бүтэц, бүрэлдэхүүнийг өөрчилж ч магадгүй байдалд хүргэнэ. Мөн, “зэрлэг амьтан”-ы төрөлд тооцогддоггүй бичил организм болон хөрсний амьд биетүүд дээр ч үр дагавар гарч болно.

Цаашилбал биологийн төрөл зүйлийн онцлог, мэдрэг байдал нь нөлөөний хэмжээг тодорхойлох явдал бас байна. Жишээ нь бат бэх гадаргуутай, мэдрэмтгий бус ургамалтай чулуулаг газарт явах нь мэдрэмтгий эмзэг ургамал, хөрсний давхаргатай чийглэг газарт явахаас бага сөрөг нөлөө үзүүлнэ. Үүнтэй адилаар аялал жуулчлалаас учрах үр дагаварыг авч үзэхдээ экосистемийн эмзэг байдал нь цаг уурын өөрчлөлтөөс болжуу гэх мэтчилэн олон талыг нөхцөл байдал дунд харьцуулан дүн шинжилгээ хийж үзэх ёстой ажээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Аялал жуулчлалын салбарын судалгаанд байгаль орчны нөлөөллийн судалгаа нь түгээмэл хэрэглэгддэг (Gutzwiller, 1995; Buckley, 2004). Хүснэгт 2.3-т байгаль орчны өөр өөр бүрдэл хэсгүүдэд аялал жуулчлалын үзүүлж болзошгүй үр дагаваруудыг харуулав.

ТХГН ба орчны бүсэд нь аялал жуулчлалыг хөгжүүлэх санал, санаачилгыг хэрэгжүүлэхдээ Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ (EIAs)-г хийх ёстой болдог. EIAs-д төсөл, бүтээн байгуулалтын ажлыг тодорхойлж, байгаль орчинд үзүүлэх үр дагавар, цар хүрээг таамаглан тандаж, олон нийттэй зөвшилцөх, оролцоог хангах үйл явцыг зааж, сөрөг нөлөөллийг арилгах талаар авах арга хэмжээнүүд, шийдвэр гаргах үйл явцыг баримтжуулах, төслийн дараах мониторинг болон аудит хийх зэрэг ажлуудыг

санал болгосон байдаг (Bagri, et al., 1998). Үндэсний хууль тогтоомжуудад EIAs-ийг хийх талаар тусгаж өгсөн байдаг бөгөөд ТХГН-т тухайлан зориулсан заалтууд нь нилээд өндөр чанга шаардлагатай байдаг. Тэдгээр нь улмаар ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөнүүдэд тусгагдсан байдаг. Тухайлбал, Мозамбик улсад БЦГ, БНГ-ууддаа бүтээн байгуулалтын ажил хийлгэх бол хамгийн хатуу “А” ангилалын БОНУ хийсэн байхыг шаарддаг ажээ.

Байгаль орчны стратегийн үнэлгээ-гээр (SEAs) бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр болон бусад холбогдох баримт бичгийн байгаль орчинд үзүүлэх нөлөөг үнэлдэг. ТХГН-ийн хувьд аялал жуулчлалтай холбоотой бүх бүтээн байгуулалт, үйл ажиллагааны ерөнхий нөлөөллийг SEAs-аар хийж болдог бөгөөд, үүнийг аялал жуулчлалын концессын анхан шатны төлөвлөлтийн хэрэгсэл болгон ашиглаж болно (Therivel, et al., 1992). Тухайн нэг төслийн (зочид буудлын бүтээн байгуулалт г.м.) үр нөлөөг үнэлэхдээ EIAs-г ашиглаж болох бол олон улс болон бүс нутгийн хэмжээнд нөлөө үзүүлэх олон төслүүдийг хамаарсан бодлогыг үнэлэхэд SEAs хэрэглэж болдог (Therivel & Thompson, 1996).

2.8 Нийгэм, соёлын сөрөг нөлөөнүүд

Аялал жуулчлалын нийгэм, соёлын сөрөг нөлөөний судалгаа нь жуулчдад (аялал жуулчлалын үйлчилгээний эрэлт, хүсэл зорилго, сэтгэл ханамж г.м.), зорин очих нутгийн иргэд (ажил эрхлэлт, үйлчилгээ ба боломжит ажлуудын зардал г.м.) мөн жуулчид ба зорин очих нутгийн иргэд хоорондын харилцаа эдгээрийн харилцан уялдаа хамаарал (шинж чанар, үр дагавар) зэрэгт чиглэгдсэн байдаг (Deery, et al., 2012). Орон нутагт үзүүлэх үр нөлөө нь сөрөг байх нь уу, хор уршиггүй байх нь уу, эсвэл эерэг байх нь уу эсэхийг тодорхойлоход судалгаа хийсэн цаг хугацаа, давтамж тодорхой хамааралтай. Хүснэгт 2.4-т аялал жуулчлалын салбарын орон нутагт болон ТХГН-т үзүүлж болзошгүй нийгэм, соёл болон эдийн засгийн нөлөөг харуулав. Эдгээр нөлөөний зарим нь хурц мөртлөө илрэх нь, тод биш байж болно. Жишээ нь түүхий эд (эрчим хүч, хоол хүнс, ус гэх мэт) зэрэг хэрэглээний зүйлийг орон нутгийн иргэд, салбаруудын хэрэгцээ шаардлагыг хангахаас илүү жуулчлалын эрэлт хэрэгцээнд зориулсан байж болно. Өөр нэг сэм аюул бол орон нутгийн иргэд жуулчдын соёл, урлаг, гар урлалын зүйлийг сонирхох эрэлтийг хангахын тулд уламжлалт амьдралын хэв маягаа алдагдуулж болох тал юм. Ийм “хуурмаг соёл” бий болсоноор шашин шүтлэг, хэлэнд ч нөлөөлж болох юм. Иймд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тодорхой бодлого, үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын үр дүнд гарч болзошгүй нийгмийн нөлөөг тооцоход Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ (SIAs) чухал хэрэгсэл болдог (Burdge & Vancly, 1995; Esteves, et al., 2012). ТХГН-т тулгуурласан тогтвортой аялал жуулчлал нь орон нутгийн үнэт зүйлс, соёлын талаар жуулчдад зөв мэдлэг, мэдээлэл өгч, улмаар жуулчдад нутгийн иргэдтэй харилцахдаа хүндэтгэлтэй, амьдрал ахуйд нь саад болохгүй байхуйцаар харьцах боломжийг олгодог. Зөв зүйтэй хийж чадвал энэ нь соёл хоорондын ойлголцлыг сайжруулж, орон нутгийн соёлын үдсэн мөн чанарыг хадгалж үлдэхэд тусалдаг. ТХГН дахь аялал жуулчлалаас гарах шууд орлого болон шууд бус үр ашиг хэдий тодорхой, тааламжтай байсан ч нутгийн иргэдийг ашгийн хуваарьлалтын тал дээр ноцтой зөрчилдөөнд хүргэж болдог байна.

Хүснэгт 2.3. Аялал жуулчлалын үйл ажиллагааны байгаль орчин, экологийн сөрөг нөлөөлөл

Нөлөөний хамрах хүрээ	Аялал жуулчлалын үйл ажиллагаа	Гарах үр дагаварын жишээнүүд
Агаар	Тээврийн хэрэгсэл ба гэрэл цахилгаан	<ul style="list-style-type: none">Тээврийн хэрэгслээс гаралтай агаарын бохирдол, чимээ шуугианаас үүдэлтэй бохирдолНүүрсхүчлийн хийн ялгарал
Гэрэл	Байгууламжийн ойролцоох болон дотор гэрэлтүүлэг	<ul style="list-style-type: none">Гэрлийн нөлөө дөнгөж төрсөн далайн яст мэлхийг тэнгис далайн усанд хүрч очиход нь саад болдог
Дуу чимээ	Барилгын ажил болон байгууламжийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none">Тээврийн хэрэгслийн дуу чимээний бохирдол шувуудын үржилд сөргөөр нөлөөлж болно
Ус	Хог хаягдлыг зайлуулах	<ul style="list-style-type: none">Эрдэс бодис, шим тэжээлийн бодис, хаягдал ус, хатуу хог хаягдал, бензин болон хорт бодис орчинд хаягданаБохирдол усны чанарыг бууруулнаУсны хэрэглээ нэмэгдэнэ
Геологи ба хөрс	Түүж цуглуулах, тонох, нураан гэмтээх	<ul style="list-style-type: none">Эрдэс, хад, чулуужсан яс, модон дээр бичих, зөвшөөрөлгүй түүж цуглуулахХөрсний физик, химийн өөрчлөлт
Ландшафт	Бүтээн байгуулалт	<ul style="list-style-type: none">Газар, орон нутаг дахь харагдах байдлыг алдагдуулах
Амьдрах орчин	Цэвэрлэх, байгалийн нөөцийг ашиглах, бохирдол	<ul style="list-style-type: none">Байгалийн амьдрах орчныг хэсэгчилэн хуваах (ус, намгархаг газар гэх мэт)Унаган болон харь ургамлын төрөл зүйлийн хооронд амьдрах орчны төлөөх өрсөлдөөн бий болгохЗориудаар гал гаргах давтамжаас улбаатайгаар амьдтын амьдрах орчин өөрчлөгдөх (гэнэтийн түймэр мөн хамаарна)Байгаль орчныг сүйтгэх, ой модыг устгахЖуулчдын хүнсэнд ашиглах зорилгоор хэтрүүлэн загасчлахХөвөө замагт хучигдах ба тунадасжилт үүсэх
	Явган хүний болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	<ul style="list-style-type: none">Ургамлын өсөлт, хөгжил, нөхөн төлжилтөд өөрчлөлт орсоны улмаас ургамлын олон янз байдал, найрлага, морфологи өөрчлөгдөх (жишээ нь, гишгэх замаар)
Зэрлэг амьтад	Агнах, загасчлах	<ul style="list-style-type: none">Зүйлийн бүтэц, нөхөн үржихүй, зан үйлийн өөрчлөлтАмьтдыг ижил сүргээс нь таслах, холдуулах
	Бохирдол	<ul style="list-style-type: none">Сэтгэлзүйн стресс, зан үйлийн өөрчлөлт гарч, нөхөн үржилт буурахХог хаягдлын цэгүүдийг хүнсний эх үүсвэр болж хувирахУс хөвөө замагт идэгдэх
	Амьтдыг харж ажиглах, зураг авах гэж үргээх	<ul style="list-style-type: none">Зан үйлийн өөрчлөлт (зугатах, дасах, эсвэл хүмүүсийг өөртөө татах гэх мэт)Физиологийн өөрчлөлт (зүрхний цохилт ихсэх, нөхөн үржихүйн түвшин өөрчлөгдөх, олдоц, тархац цөөрөх гэх мэт)Зүйлийн өөрчлөлт (бүтэц, олон янз байдал, олдоц тархац өөр хоорондын харилцаанд гарах өөрчлөлт)
	Байгальд барьсан хурдны зам, жимүүд	<ul style="list-style-type: none">Махчин амьтдад саад учруулах, хулгайн анчдад хүрч очих боломж олгохАялалын зам харгуйн дагуу нарны гэрэлд тэмүүлдэг ургамлын төрөл зүйл нэмэгдэхАмьтад дайруулж үхэх буюу шархдаж, сэгээр хооллогчдыг татах

Эх үүсвэр: Knight & Cole, 1995; Sun & Walsh, 1998; Buckley, 2004; CBD, 2004; Spenceley, et al., 2015

Аялагчид өөрсдөө ч олон нийтийг хамарсан нийгмийн үр нөлөөнд автамтгай байдаг. Өндөр ачаалалтай аялал жуулчлал нь жуулчдын аялалын үр өгөөжид олон янзаар нөлөөлнө. ТХГН-т зэрлэг онгон байгалийг хүсэмжилсэн жуулчид олон хүний хязгаарлалт үүссэний улмаас үзэх, харах зүйлсээ хангалтгүй үзсэнээс сэтгэл гонсойх, тэр бүү хэл өөр аялагчдын бүлгүүдтэй зөрчилдөж болно (Needham & Rollins, 2009). Цаашилбал, жуулчдын сэтгэл санааг хүрч ирэхээс нь ч өмнө өөрчилж, зөв буруу хүлээлт үүсгэж болдог (McCool, 2006). Менежерүүдийн хувьд жуулчдыг биеэ зөв өвч явахад нь удирдамж өгсөн мэдээллийн самбар, тэмдэг тэмдэглэгээ, эмхэтгэл бий болгох, жуулчдын хөл хөдөлгөөнийг зөв зохион байгуулж, хэт бөөгнөрөл үүсгэхээс сэргийлэх зэрэг ажлуудыг хийж болно. Үүний тулд тур оператор компаниудтай цагийн

хуваарь зохиох, гол газрууд дахь машины зогсоолын багтаамжийг хязгаарлах гэх мэт арга хэмжээ авч болно. ТХГН дахь аялал жуулчлалаас жуулчдад ирэх үр өгөөжийг өндөр хэмжээнд байлгах нь нутгийн иргэдийг дэмжих, байгаль хамгаалахад чухал ач холбогдолтой байдаг.

Орон нутаг болон жуулчдад үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахын тулд тур операторууд болон тэдгээрийн харилцагчид, ТХГН-ийн удирдлага, менежерүүд ба нутгийн иргэдийн хооронд түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь хамгийн чухал юм. Ийм түншлэлийн ачаар аялал жуулчлалын төлөвлөгөөг уялдаа холбоотойгоор гаргаж, болзошгүй үр дагаварыг тодорхойлж, байгаль хамгааллыг дэмжиж, урт хугацааны харилцааг дэмжиж, жуулчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

Хүснэгт 2.4. ТХГН-ийн орон нутгийн иргэдийн нөлөө: Нийгэм, соёлын болон Эдийн засгийн нөлөө

Нөлөөний хамрах хүрээ	Болзошгүй үр дагаварын жишээнүүд
Нийгэм ба соёлын	
Зан заншил	Жуулчдад зориулж зан үйлийг жүжигчилэн тоглох хэлбэрээр ёс заншлыг эд барааны хэлбэрт оруулж, ач холбогдолыг нь бууруулах Соёл ба шашны зан үйлийн гүйцэтгэл, түүний календарт хугацаанд саад болох Жуулчдад зарах тоо ширхэгт анхаарсны улмаас гар урлалын чанарт муугаар нөлөөлөх
Сэтгэл зүйн	Бусдыг ажигласны дүнд өөрийгээ илүү, гоц гойд болж харагдуулахын тулд хуулан дуурайх Соёл, зан заншлыг нь буруу ташаагаар үзүүлж, харуулах, жуулчдын ёс бус үйлдлээс болж нутгийн иргэд эгдүйцэх, үүнээс болж нутгархах үзэл гарах, иргэд болон жуулчдын хооронд зөрчилдөөн үүсгэх
Гэмт хэрэг, Тогтвортой байдал	Орон нутгийн иргэдийн аж амьдралд тогтворгүй байдал үүсгэж, гэмт хэрэг, биеэ үнэлэх явдал, мөрийтэй тоглоом, гуйлгачилал, архидалт болон хар тамхины хэрэглээ нэмэгдэх Эмэгтэй хүмүүс ба насанд хүрээгүй хүмүүс бэлгийн дарамтанд өртөх Аялал жуулчлалын бүтээн байгуулалтаас болж нутгийн иргэд байнгын оршин суудаг газраа алдаж, нүүн шилжихээс өөр аргагүй байдалд хүрэх
Үүрэг оролцоо	Аялал жуулчлалын салбарт холбогдоогүй ялангуяа эрэгтэй хүмүүс, ахимаг, өндөр настнууд үйл хэргийн гадна хоцорсон мэт ганцаардаж, өөрт итгэх итгэлээ алдах
Эдийн засгийн	
Ажлын байр	Олдож буй ажлын байр нь анхан шатны шинжтэй, бага цалинтай, ур чадвар шаарддаггүй, нутгийн иргэдэд хөгжиж дэвших, суралцах боломжийг бараг олгодоггүй. Улирлын бус цагт ажлын байрны тоо багасдаг
Орон нутгийн бизнес хөгжил	Эдийн засгийн орлого тасалдах. Орж ирсэн гадаад валют эргээд гараад явчихвал орон нутгийн эдийн засгийн хөгжлийг удаашруулна. Улирлын шинжтэй бизнес нь аж ахуйн нэгжүүдэд улирлын бус үеэр хүндрэл учруулдаг
Эдийн засгийн төрөлжилт буюу солонгоширолт	Хөдөө аж ахуй, уул уурхай гэх мэт аялал жуулчлалаас өөр аж үйлдвэрийн салбаруудаас татгалзсаны улмаас Алдагдсан боломжийн өртөг үүсэх Эдийн засгийг аялал жуулчлалаас хамааралтай болгож, жуулчдын тоо цөөрөхөд бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэгчид эрсдэлд орох Орлогыг цөөн тооны, элет бүлэг хувааж авсанаар үр ашгийн тэгш бус хуваарьлалт бий болох Инфляц гарсанаар аялал жуулчлал хөгжсөн бүс нутаг дах зорих газрууд хэт их өртөгтэй болох.

Эх үүсвэр: Mathieson & Wall, 1982; Krippendorf, 1987; Diaz, 2001; Spenceley, et al., 2015



Хорватын Плитвиче нуур БЦГын нууранд амарч буй аялагчид. © Mei Yee Yan

Хэрэв жуулчид сэтгэл ханамжгүй байвал аялал жуулчлал амжилттай хөгжихгүй билээ. Олон нийтийн сүлжээ хөгжиж, аялагчид онлайнаар сэтгэгдлээ үлдээдэг тогтолцоо үүссэн өнөө цагт сөрөг сэтгэгдэлүүд нийтлэгдсэн даруйдаа олны хүртээл болход тогтвортой хөгжилд аюул учруулдаг болжээ. Нутгийн иргэд сэтгэл ханамжгүй байвал үр дагавар нь илүү адармаатай бөгөөд юунаас ч дутахааргүй хор уршиг авч ирнэ. Нутгийн иргэд сэтгэл дундуур байхаар нийгэм, олон түмний тогтворгүй орчинг (жуулчдын эсрэг гэмт хэрэг үйлдэх, халдах г.м.) үүсгэж, аялал жуулчлал хөгжихөд саад болдог. ТХГН-аас үр өгөөж хүртэхгүй юм байна гэж үздэг нутгийн иргэдийн хувьд байгаль хамгаалах зорилго, зорилтыг нь дэмжих сэтгэл тээхгүй, харин ч байгалийн нөөц, баялгийг хууль бусаар хураах, цуглуулах үйлдлэл гаргадаг. Харин нутгийн иргэд сэтгэл ханамжтай байхул тогтвортой аялал жуулчлалын үүд хаалгыг нээдэг. Өмнөд Африкийн Ишимангалисогийн Ус, Намгархаг Нөөц Газрын цогцолборт газарт аялал жуулчлал, бизнес хийх дэмжлэг нутгийн нэгэн иргэн ярихдаа “Манай нутагт аялал жуулчлал чухал үүрэгтэй болохыг одоо бид мэдсэн болохоор цогцолборт газраа хамгаалж, чадах бүхнээрээ туслах хэрэгтэй байгаа” хэмээн ярьж байжээ (iSimangaliso Wetland Park, 2017).

2.9 Шилдэг туршлагауд

- Аялал жуулчлалын үйл ажиллагаагаар дамжуулан байгаль хамгаалалд шууд хувь нэмэр оруулдаг, хамгаалалтын захиргаа, нутгийн иргэдэд эдийн засгийн үр өгөөж өгдөг, олон түмэн, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулхад чиглэсэн “гурвалсан суурь зарчим” бүхий үндэсний бодлого хэрэгжүүлэх.
- Зах зээлийн эрэлтэнд суурилсан аялал жуулчлалын үйлчилгээг нутгийн иргэдээр дамжуулан хөгжүүлэх. Бизнесийн амжилтыг нэмэгдүүлэх үүднээс орон нутгийн санал санаачилга, хувийн хэвшлийнхэний хооронд түншлэл бий болгох.
- Нутгийн иргэдээр дамжуулсан аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэсэн бизнес хөгжил, менежментийн үр чадварын сургалтууд явуулж, нутгийн иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөгчид, ТХГН-ийн менежерүүдийг хамруулах.
- ТХГН дахь амралт зугаалгын үйл ажиллагааг нутгийн иргэд, олон нийтийн хэрэгцээг хангах чиглэлээр дахин харж, хүний эрүүл мэнд, сайн сайхан оршихуй гэх мэт нийгмийн илүү том хэрэгцээг хангахад чиглүүлэх.

МЕНЕЖМЕНТИЙН ЗОРИЛТУУДЫГ АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН НӨЛӨӨТЭЙ УЯЛДУУЛАХ НЬ

3



3.1 Аялал жуулчлалын менежмент нь урьдчилан таамаглах боломжгүй нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх үйл хэрэг

Энэхүү удирдамжийн үндсэн зорилго нь ТХГН дахь аялал жуулчлал, аялагчдын нөөц ашигласны менежментийг тогтвортой удирдаж, зохион байгуулсан тохиолдол нь байгаль хамгаалалд, цаашилбал нутгийн иргэдийн хөгжилд эерэг нөлөөтэй байж чадахыг харуулах явдал юм. Шилдэг туршлагауудыг нэвтрүүлсэнээр тогтвортой аялал жуулчлал нь олон нийтэд байгаль, нийгмийн өргөн хүрээг хамарсан үнэ цэнийг таниулж, ТХГН-ийг хамгаалах зорилгод хувь нэмэр оруулж, цаашилбал нутгийн иргэдэд үр өгөөжөө өгөх боломжтой. Энэ хүрээнд хоёр үндсэн асуудал үүсдэг. Нэгдүгээрт, ТХГН-н үнэ цэнэт зүйлс болох байгаль, түүх, соёлын өвд аюул учруулахгүйгээр аялал жуулчлалыг хэрхэн хөгжүүлэх вэ? Хоёрдугаарт, ТХГН-т өндөр чанартай амралт зугаалга, аялал жуулчлалын боломжуудыг нээхийн зэрэгцээ үр ашгийг нь бүх оролцогч талуудад хэрхэн жигд хүртээх вэ? Энэ хоёр асуудлыг хамтад нь авч үзэвэл энэхүү удирдамжийн эхэн хэсэгт дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн асуулт дээр эргэн очих буюу аялал жуулчлалын үр ашгийг хэрхэн боломжит дээд төвшинд хүргэж, сөрөг үр нөлөөг хамгийн доод төвшинд барих вэ гэсэн асуултуудыг гаргаж ирнэ.

Аялал жуулчлал, амралт зугаалга нь нарийн уялдаа холбоо бүхий ажиллагаа бөгөөд урьдчилан таамаглах боломжгүй олон нөхцөл байдлаас хамаардаг (Lausche, 2011). Жишээ нь жуулчдын сонирхол, эдийн засгийн нөхцөл байдал, түүнчлэн аялал жуулчлалтай холбоотой олон нийтийн дэд бүтцэд хийгдэх болон хувийн хэвшлээс гаргах хөрөнгө оруулалт зэргээс шалтгаалан зах зээлийн эрэлт нь өөрчлөгддөг. Ихэнх улс орны хувьд ТХГН-ууд нь аялал жуулчлалын чухал ач холбогдолтойд тооцогдож, гол зорих газар нь болдог бол зарим орны хувьд жуулчдыг татах үндсэн газруудал тооцогддог (Кени, Австрали, Шинэ Зеланд гэх мэт).



Аялагчид Есөмети үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зураг авч буй байдал, Калифорни муж, АНУ. Зургийг Yu-Fai Leung

Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) зөвлөмжид бүхий л эрх эзэмшигч этгээдүүд, оролцогч талуудыг хамруулж, шинжлэх ухааны хамгийн шилдэг арга хэрэгсэл, мэдээллийг ашиглаж, дасан зохицох менежментийн арга зүйг (IUCN-WCPA, 2007) хэрэгжүүлэхийн чухлыг тэмдэглэдэг.

Аялал жуулчлал болон аялагчдын менежментэд баримтлах 10 зарчим

Хүснэгт 3.1-т 10 үндсэн зарчмыг хураангуйлав (McCool, 1996, Eagles, et al., 2002 and EUROPARK Federation, 2012).

Эдгээр 10 зарчим нь ТХГН-т тогтвортой аялал жуулчлал болон аялагчдын менежменттэй холбоотой үндсэн шийдвэрүүд гаргахад туслах зорилготой. Энэхүү бүлгийн сүүл хэсгүүдэд IUCN-наас аялагчдын ашиглалтын менежментийн талаар өмнө нь гаргаж байсан зөвлөмж дээр суурилсан (Eagles et al., 2002) арван зарчмын эхний зургааг дэлгэрэнгүй тайлбарлах юм. Тэдгээрт аялал жуулчлалаас гарч болзошгүй сөрөг нөлөөний эсрэг хийх төлөвлөлт, менежментийн хариу үйлдэлтэй ТХГН-уудын зорилт ба үнэт зүйлсийг хэрхэн уялдуулах тодорхой заавар, аргачилалуудыг дэвшүүлнэ. Мөн аялал жуулчлалын менежментийн дөрвөн хамрах хүрээг тодорхойлж, холбогдогдох зарчмуудтай нь уялдуулна. Үүнд: (1) Амралт зугаалгын хамрах хүрээ (ROS), (2) Даац, (3) Тэвчиж болох өөрчлөлтийн дээд хязгаар (LAC) ба (4) Шалгуур үзүүлэлтүүд болон чанарын стандарт тус тус орно. Хамрах хүрээ тус бүр нь сөрөг нөлөөллийг үнэлж, хариу арга хэмжээ авах тус тусын арга замуудтай.

Дээр дурдсан арга хэрэгсэл, техник арга ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн нөхцөлд нөөц баялагийн мониторинг, дотоод хяналт, нутгийн иргэдийн оролцоо болон олон нийтийн арилцах холбоо зэргийг нэтгэсэн дасан зохицох хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Энэ тухай удаах бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлана.

3.2 Нэгдүгээр зарчим: Менежментийн арга барилыг ТХГН-ийн зорилго, үнэт зүйлс тодорхойлно

ТХГН-т тохирсон, тогтвортой аялал жуулчлалын үндэс суурь нь байгаль хамгаалах үнэт зүйлстэй уялдсан аялал жуулчлал, аялагчдын нөөц ашиглалтын менежментийн зорилго, зорилтуудыг зөв тогтоох явдал юм. Зорилго, зорилтуудыг хооронд нь тогтмол, уялдаа холбоотой холбож ажиллах явдлыг аялал жуулчлалын менежментийн хүрээн доор хийвэл ихээхэн тустай байдаг. Аялал жуулчлалын хүрээ нь менежментийн шийдвэрийг гаргах, гаргасан хойно хамгаалах чухал хэрэгсэл болдог. Аялал жуулчлалын менежментийн хүрээ нь дараах зүйлсийг өөртөө багтаана:

- Байгаль хамгаалах зорилготой уялдсан аялал жуулчлалын стратеги, төлөвлөгөө;
- Тодорхой цэгүүдэд зөвшөөрсөн аялал жуулчлалын дэд бүтэц, үйл ажиллагааны бүтээн байгуулалт, төрөл, цар хүрээ болоод аялал жуулчлалыг зөвшөөрөөгүй цэгүүд;

Хүснэгт 3.1. ТХГН-ийн аялал жуучлал ба аялагчдад хандсан менежментийн 10 зарчим

Зарчимууд	Хураангуй тайлбар	Авах арга хэмжээнүүд
1. Менежментийн арга барилыг ТХГН-ийн зорилго, үнэт зүйлс тодорхойлно	<ul style="list-style-type: none"> Менежментийн төлөвлөгөөний зорилтууд нь ТХГН-ийн менежментийн хүсэн хүлээгдэх үр дүнг илэрхийлдэг. Тэдгээр зорилтууд нь менежментийн үйл ажиллагаануудын зөв зохистойг тодорхойлж, хүлээн зөвшөөрөгдөх нөөц эх булаг, нийгмийн нөхцлийг тодруулж өгдөг. Мөн менежментийн үйл ажиллагааны амжилтыг үнэлэх боломжийг олгодог. 	<ul style="list-style-type: none"> Менежментийн төлөвлөгөөнд ялангуяа байгаль хамгааллыг үндсэн зорилгоо болгосон тодорхой зорилтууд оруулсан байх. Зорилтуудыг олон нийтийн оролцоотойгоор тодорхойлж, талууд зөвшөөрсөний үндсэн дээр батлах.
2. Аялал жуулчлал болон аялагчдын менежментийг урьдчилан төлөвлөх нь үр дүнг сайжруулна	<ul style="list-style-type: none"> Идэвхтэй менежментийн үйл ажиллагаа нь ТХГН-ийн үнэ цэнэ, менежментийн зорилтуудыг тодорхойлохоос эхэлнэ. ТХГН-ийн бодлого болон менежментийн шийдвэрүүд нь дээрхи үнэ цэнэтэй холбогдсон бол үр дүнтэй хэрэгжихэд илүү хялбар байдаг. Ирээдүйг ямагт тооцоолж занших нь аялал жуучлалыг хөгжүүлэх нөөц, боломжийг алдалгүй олж харах боломж олгоно. 	<ul style="list-style-type: none"> Мэдээлэл, хөтөлбөрүүдээр дамжуулан аялагчдад ТХГН-ийн үнэ цэнийн талаар мэдлэг олгох. Менежментийн үйл ажиллагаанд үр дагавар учруулж болзошгүй аялагчдын шинэ үйл ажиллагааг ямагт анзаарч, хянаж байх.
3. Аялагчдын үйл ажиллагаа буюу ашиглалтын нөхцлийг өөрчлөх нь зайлшгүй бөгөөд эерэг үр дүнд хүргэх магадлалтай	<ul style="list-style-type: none"> Нөлөөллүүд, ашиглалтын түвшин, хүлээгдэх нөхцөл байдлууд нь өөр өөр байдаг (жишээ нь ТХГН-ийн хилийн захад болон хамгаалалттай газрын төвд байрласан отоглох цэгүүд дэх үр нөлөө). Хүрээлэн буй орчны харилцан адилгүй байдлаас шалтгаалж аялагчдын ашиглалт, нөлөөний хэмжээ нь өөр өөр байна (жишээ нь газрын гадаргуу, ургамал, хүрч очих байршил гэх мэт) 	<ul style="list-style-type: none"> Амралт зугаалгын олон төрлийн үйл ажиллагаануудыг удирдлага зохион байгуулалтаар хангахын тулд бүсчлэлийг ашиглах. Тодорхой цэгүүдэд аялал жуучлалын ямар төрлийн үйл ажиллагаа явуулахыг шийдэхдээ олон ургальч үзлийг баримтлах. (ингэснээр техникийн чанартай шийдвэрүүдийг, үнэ цэнийн шинжтэй шийдвэрээс ялгаж салгана)
4. Хүний ашиглалтаас болж байгалийн нөөц баялаг болон нийгмийн орчин нөхцлүүд өөрчлөгдөх нь зайлшгүй	<ul style="list-style-type: none"> Аялал жуучлалын ямар ч үйл ажиллагаа нь тодорхой нөлөө үзүүлнэ. Ихэнх тохиолдолд анхан шатны, багахан хэмжээний ашиглалт нь нэг нэгжид ноогдох хамгийн их үр нөлөөг бий болгодог. Байгаль хамгаалал болон бусад зорилтуудын хооронд ямар нэгэн зөрчил байвал байгаль хамгаалах зорилтоо урьтал болгоно. Аялал жуучлалаас үүдэлтэйгээр учрах үр нөлөөг ямар төвшинд байхыг хүлээн зөвшөөрөх нь аялал жуучлалтын ашиглалтын төлөвлөлт болон менежментийн гол хэсэг юм. Гарч буй үр нөлөөг баримтжуулж, ирсэн аялагчдад байгаль орчны сургалт, мэдээлэл болгон ашиглаж болно. 	<ul style="list-style-type: none"> Менежерүүдийн хувьд “ТХГН-ийн баримтлах зарчим болон зорилтуудын хүрээнд ямар цар хүрээтэй нөлөөг хүлээн зөвшөөрөх вэ?” гэдгийг өөрсдөөсөө байнга асууж байх хэрэгтэй болдог. Хүлээн зөвшөөрсөн нөлөөг удирдан зохицуулах арга хэмжээнүүдийг менежерүүд авч байх ёстой.
5. Менежментийн арга хэмжээ нь хүний зан авирт нөлөөлж, аялал жуучлалаас үүдэлтэй нөлөөг боломжит доод төвшинд хүргэхэд чиглэнэ.	<ul style="list-style-type: none"> ТХГН-ийн зорилго нь байгалийн үйл явц, үзэгдлийг хамгаалах зорилготой байдаг тул менежментийн зорилго нь хамгийн их хор хөнөөлтэй байдаг хүний үйлдлээс үүдэлтэй өөрчлөлтүүдийг хянахад чиглэдэг. Хүний үйлдлээс улбаатай өөрчлөлтүүд нь тааламжгүй нөхцөл байдалд оруулж болно. Зарим өөрчлөлтүүдийг авч ирэх нь тухайн ТХГН-ийг үүсгэн байгуулсан зорилго нь байж болно. Жишээ нь амралт зугаалга, аялал жуучлалын боломжийг нээх, орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор олон ТХГН-ийг байгуулсан байдаг. 	<ul style="list-style-type: none"> Менежментийн зүгээс өөрчлөлтийн хэмжээ, төрөл, байршилд тохирсон ямар арга хэмжээ авахыг шийднэ.

Хүснэгт 3.1. үргэлжлэл

6. Нөлөөлөл нь олон хүчин зүйлсээс шалтгаалдаг учир ашиглалтыг хязгаарлах нь менежментийн олон сонголтуудыг нэг юм	<ul style="list-style-type: none"> • ТХГН-ийн ашиглалт, үр нөлөөний харилцаанд ашиглалтын түвшнээс гадна өөр олон хүчин зүйлс нөлөөлнө (аялагчдын зан төлөв, ямар унаагаар аялж байгаа, аяллын багийн хэмжээ, улирал болон биофизикийн нөхцөл гм). • Аялал жуулчлал, менежментийн үйл ажиллагааны үр нөлөө нь ТХГН-ийн хилийн гадна, эсвэл хожим илэрч болно (ашиглалтыг хориглосноор өөр газар нутагт шилжиж бий болох, усыг зүй бусаар ашигласнаар усны адаг бохирдох гэх мэт). • Ирээдүйд гарах үр нөлөө, цар хүрээ, үргэлжлэх хугацааны талаар урьдчилан мэдэхийг тулд төлөвлөгөө зохиогчид нь ашиглалт ба нөлөөний хамаарлын талаар гүнзгий мэдлэгтэй байх шаардлагатай байдаг. 	<ul style="list-style-type: none"> • Аялагчдын зан авирыг хязгаарлахад чиглэсэн боловсрол, мэдээллийн хөтөлбөр, дүрэм журмууд шаардлагатай байж болно.
7. Мониторинг нь мэргэжлийн менежментийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг байна	<ul style="list-style-type: none"> • Тохируулах менежмент, эрсдлээс сэргийлсэн менежментийн бүтцэд байгалийн нөөц баялаг, орон нутгийн иргэдийн нийгэм эдийн засгийн нөхцөл байдлын талаар өгөгдөл өгдөг хамгийн чухал алхам бол мониторинг юм. • Мониторинг заавал өндөр өртөгтэй, эсвэл төвөгтэй байх шаардлагагүй. Мониторинг хийх хэд, хэдэн хувилбар байдаг. 	<ul style="list-style-type: none"> • Мониторинг хийх үйл явцад олон нийтийг татан оролцуулж, мөн аялагчдын боловсролыг дээшлүүлэх давхар зорилгоор ашиглаж болно.
8. Шийдвэр гаргахдаа ямар нь техникийн шинж чанартай, ямар нь үнэт зүйлсийн шинж чанартайг ялгаж салгадаг байх	<ul style="list-style-type: none"> • ТХГН-ийн менежментийн шийдлүүд ихэнхдээ техникийн шинж чанартай байдаг (аяллын жимийн байршил, мэдээллийн төвийн загвар гэх мэт) бол өөр зарим нь үнэт зүйлсийн шинж чанартай байна (ашиглалтыг хязгаарлах бол хэрхэн яаж, ашиглагдах байр хэрэгслийн төрөл, аялал жуучлалын үйлчилгээ эрхлэх ямар боломжууд олгох гэх мэт). 	<ul style="list-style-type: none"> • Шийдвэр гаргахдаа “одоогийн нөхцөл байдал”-ыг “хүсэмжит нөхцөл байдал”-аас ялгаж цэгнэх.
9. Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэгдсэн байр суурь ба түншлэл шаардлагатай учир хамааралтай талуудын оролцоог хангах	<ul style="list-style-type: none"> • Менежментийн бүх шийдвэрүүд зарим бүлэг, хувь хүмүүст нөлөөлдөг. Эдгээр бүлгүүдийг шийдвэр гаргах үйл явцыг эхлэхээс өмнө тодорхойлох шаардлагатай. 	<ul style="list-style-type: none"> • Эрх эзэмшигчид хийгээд оролцогч талууд бүгд ТХГН-ийн баримтлах үнэ цэнэ болон хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлоход оролцох хэрэгтэй. • Зохих сургалтад хамрагдсанаар эрх эзэмшигчид болон оролцогч талууд хяналт үнэлгээ, менежмент, сургалтын үйл ажиллагаанд оролцох боломжтой.
10. Тогтвортой хөгжлийн талаар мэдээлэл түгээж, дэмжлэг авахад харилцаа холбоо туйлын чухал	<ul style="list-style-type: none"> • Аялал жуучлалаас байгаль хамгаалал болон нутгийн иргэдэд үзүүлж буй үр нөлөөний хяналт үнэлгээний үр дүнг олон нийтэд таниулж, сурталчилах нь менежментийн багийн гаргаж буй шийдвэрийг ойлгуулахад дөхөм болдог. 	<ul style="list-style-type: none"> • Тохируулах болон эрсдлээс сэргийлсэн менежментийн үйл ажиллагаанд харилцаа холбооны стратеги хэрэг болдог.

Эх сурвалж: McCool, 1996; Borrie, et al., 1998; Eagles, et al., 2002; CBD, 2004; EUROPARC Federation, 2012

- Аялал жуучлалын бүтээн байгуулалт болон үйл ажиллагаанаас гарч буй хийгээд гарах магадлалтай үр нөлөөг хянах, зохицуулах арга хэмжээнүүд;
- Аялал жуучлалын бүтээн байгуулалт болон үйл ажиллагаанд мониторинг хийж, тайлагнах;
- Аялал жуучлалын зөвшөөрөгдсөн бүтээн байгуулалт болон үйл ажиллагаа гэрээний дагуу явж буй эсэхийг хянах;
- Орон нутаг болон нутгийн уугуул иргэдэд үр ашгаас хүртээх;
- Байгаль хамгаалал болон экологийн ашиглалтыг хамгаалахад үр өгөөж өгөх.

Шигтгээ 3.1

ТХГН-т арилжааны аялал жуулчлал хөгжүүлэх гарын авлагад оруулбал зохих сэдвүүд

- Гэрээ байгуулах хууль эрх зүйн асуудлууд (эрх, үүрэг, нөхцлүүд, шинэчлэх боломжууд, эрх шилжүүлэх, эрсдэл, зөрчил маргааныг хэрхэн шийдвэрлэх, оюуны өмчийн эрх эзэмших);
- Төслийн амьдралын мөчлөг;
- Харилцаа, холбооны сүлжээ;
- Байгаль орчин болон байгаль хамгаалах шаардлагууд (байгаль орчны нэгдсэн менежмент, байгаль орчны хяналтын байцаагч ажиллах, байгалийн болон соёлын нөөцийг хамгаалах, зэрлэг амьтдын орчинд нэвтрэх хил хязгаарыг тогтоох, ан агнуурын үйл ажиллагааг хяналтандаа байлгах, мониторинг ба судалгаа, эргүүл хийх, галын менежмент, хортой амьтдын менежмент, галт зэвсэг ашиглах тухай, ажилтнуудтай холбоотой харилцаа, нисдэг тэрэг болон машин механизм ашиглах, ан агнуур хийх болон хөтөчтэй явган аялах үйл явц, баримтлах ёс зүйн дүрэм, аюулгүй ажиллагааны дүрэм журам);
- Дэд бүтцийн менежмент (барилга байгууламжийн загвар, төлөвлөлт, цахилгаан, усан хангамж, харилцаа холбооны дэд бүтэц, хогийн менежмент, зам тээврийн хөгжил);
- Байгаль орчны болон техникийн мониторинг;
- Олон түмнийг чадавхижуулах шаардлагууд (хувь эзэмших, сургалт авах, албан тушаал ахих, нутгийн иргэдийн бизнес эрхлэх боломжууд);
- Санхүүгийн шаардлагууд (концессийн төлбөр, түрээсийн доод хэмжээ, тогтмол төлбөрүүд, жилийн тогтмол төлбөрүүд, мониторинг);
- Гэрээний заалтуудыг зөрчихөд авах арга хэмжээ (санхүүгийн чанартай, чадавхижуулах болон байгаль орчны асуудлууд, залруулах арга хэмжээ авах процесс дарааллууд, барьцааны бонд, сануулгууд, гэрээ цуцлалтууд гэх мэт)
- Торгууль, шийтгэлийг тогтоох;
- Ёс зүйн зарчим (концесс олгогч нартай харилцах харилцаа, түр зуурын болон байнгын оршин суугчид гэх мэт);
- Хэрэгцээтэй мэдээллүүд (ТХГН-ийн хууль журмууд, тайлангийн маягтууд, анкет бөглөх маягтууд)

Эх сурвалж: SANParks, n.d.

Шигтгээ 3.2

Биологийн олон янз байдлыг харгалзан зочид буудал, амралтын баазуудын байршил, загварыг сонгоход баримтлах зарчмууд

IUCN-с зүгээс зочид буудлууд, амралтын баазуудын байршил, загварыг гаргахад биологийн олон янз байдлыг харгалзан дараах таван зарчмыг оролцогч талуудад санал болгодог. Эдгээр зарчмууд нь биологийн олон янз байдлыг хамгаалахын зэрэгцээ эрх-эзэмшигчид болон оролцогч талуудын оролцоог хангахад чиглэгднэ.

1. Аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлтөд экосистемд суурилсан арга зүйг ашиглах
2. Зочид буудал барьснаар биологийн олон янз байдалд нөлөөлөх хүчин зүйлд зохих арга хэмжээ авч, ерөнхий дүнгээрээ эерэг үр нөлөө бий болгохыг зорих;
3. Аливаа загвар, шийдэл гаргахдаа байгаль орчинд нийцүүлэх;
4. Нутгийн иргэдийг хүндлэх, тэдний оролцоог дэмжих;
5. Эрх-эзэмшигчид болон оролцогч талуудын хооронд хамтын ажиллагааг бий болгох;



Австрали улсын Фрейзер арал дээр байрлах Кингфишир бэй амралтын газар. Уг амралт нь Ногоон бөмбөрцөг (Green Globe) болон Австралийн Экотуризм байгууллагуудаас эко батламжаа авчээ. Зургийг Yu-Fai Leung.

3.3 Хоёрдугаар зарчим: Аялал жуулчлал болон аялагчдын удирдлага, зохион байгуулалтыг урьдчилан төлөвлөх нь үр дүнг сайжруулна

ТХГН нь аялал жуучлалын үйл ажиллагааг төлөвлөх, хөгжүүлэх, хэрэгжүүлэх, мөн үйл ажиллагааг нь зогсоох зэрэг арга хэмжээнд оролцох шаардлагатай болдог. Энэ арга ажиллагаанд аялал жуучлалын менежментийн хүрээнүүд тус дэмтэй байж болох талаар Нэгдүгээр зарчимд заасан. Төлөвлөлтийг хоёр үндсэн төрлөөр хийнэ. Эдгээр нь ашгийн төлөөх арилжааны аялал жуучлал ба хувь аялагчдын төлөвлөлт

Арилжааны аялал жуучлалын менежментийн гурван тулгуур багана

Арилжааны аялал жуучлалын менежмент нь бодлогын хүрээ, хөгжлийн төлөвлөлт, үйл ажиллагааны үе шат гэсэн гурван тулгуур багана дээр тогтно (Eagles et al, 2002):

- Бодлогын хүрээ нь хөтөлбөрүүдийг тодорхойлж, хэрэгжүүлдэг шилдэг туршлагуудыг тодорхойлж байдаг. Энэхүү хүрээ нь газар өмчлөл, хувийн салбарын оролцоо, тогтвортой байдлын бүрэлдэхүүн хэсгүүд, биологийн төрөл зүйл болон байгаль орчны менежмент, орон нутгийн иргэдийн эрх, ашиг тус, мөн аялагчдын хүртэх өндөр зэрэглэлийн үр өгөөж гэх мэт олон түмний хэрэгцээ шаардлагыг хангасан төрийн удирдлагын удирдамжууд, стратегийн хэрэгжилтийн хамарсан байна. Бодлогын хүрээ нь мөн төрийн захиргааны шат, шатны хууль, журмыг багтаасан хууль эрх зүйн тогтолцоог өөртөө агуулж байдаг (Spenceley & Casimiro, 2012).
- Хөгжлийн төлөвлөлтөөр бизнесийн боломжуудыг тодорхойлж, бүтцэд оруулж, үнэ тогтоож, зах зээлд нэвтрүүлж, төслийн санал авах хэлбэрээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж байдаг. Хөгжлийн төлөвлөлтөнд бизнесийн гэрээ байгуулах загваруудыг хавсаргасан байна (Spenceley & Casimiro, 2012). Төсөлд саналаа өгөх боломж олгох нь өндөр зэрэглэлийн операторуудад урам өгч байдаг.
- Үйл ажиллагааны үе шат нь бизнесийн гэрээнд гарын үсэг зурсанаар эхлэх бөгөөд гэрээг/концессыг хэрэгжүүлэх хугацаанд үргэлжилнэ (жишээ нь 10-30 жил). Гэрээг хэрэгжүүлэх нь зөвхөн техникийн заалтуудыг хэрэгжүүлэхийг хэлэхгүй. Оролцогч талуудын харилцааг мөн зохицуулна. Үйл ажиллагааны үе шатанд ТХГН-ийн менежментийн удирдлагад дараах арга хэрэгсэл, механизм хэрэгтэй болдог. Эдгээр нь (1) Гүйцэтгэлийг хангалттай хэмжээнд хүргэхийн тулд бизнесийн үйл ажиллагааг удирдаж, хянах (2) харилцан тохиролцсон урамшууллыг олгодог байх зэрэг болно.

Арилжааны аялал жуулчлалын гарын авлагууд

Бизнесийн гарын авлагууд нь гэрээнд оролцогч бүх талуудад үйл ажиллагаа явуулахад нь чиглэл өгч,



Машинаар зорчихыг хориглосон Нидерландын Де Хорге Велүве цогцолборт газрын ажилчид дугуй зөөвөрлөж байгаа нь. Зургийг Yu-Fai Leung.



Германы Торфхаус Үндэсний Цогцолборт Газрын модон хөшөө. Зургийг Yu-Fai Leung

гэрээний зүйл заалт тус бүрийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой мэдээллүүд өгж байдаг (Шигтгээ 3.1). Концессын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 6-р бүлэгт оруулсан бөгөөд аялал жуучлалын концесстой холбоотой мэдээллийг бусад эх сурвалжуудаас олж харж болно (e.g. Eagles, et al., 2009; Spenceley, 2014b; Thompson, et al., 2014; Spenceley, et al., 2015; Spenceley, et al., 2017b).

Арилжааны аялал жуучлалын үр нөлөөг хэмжих нь

ТХГН-т арилжааны аялал жуучлалын дэд бүтцийн үзүүлэх нөлөө нь байгууламжийг хаана, хэрхэн байршуулахаас маш ихээр хамаардаг. Мэдээлэн тайлбарлах төвүүд, ариун цэврийн байгууламж, зочид буудал, хоноглох сууцнууд болон отоглох цэгүүд, зоогийн газар, машины зогсоол, аяллын жим зэрэг олон төрлийн байгууламжийг аялал жуучлалын дэд бүтэц хэмээн нэрлэж болно. Эдгээр дэд бүтцүүд тогтвортойгоор үйл ажиллагаа явуулж, орон нутгийн байгаль орчин, соёлд нийцэж байгаа эсэх нь чухал юм.


Шигтгээ 3.3

Аялагчдад өгч буй сэтгэл ханамжаар дамжуулан байгалийг хайрлан хамгаалах сэтгэл зүйг бий болгох нь: Вади Ел-Хитан—Халим загасны хөндий Дэлхийн соёлын өв газар (Египет)

Вади Эл Хитаний Халим загасны хөндий нь Египетийн баруун цөлд, Кайро хотоос баруун өмнөд зүгт 170км-т оршдог. 2005 онд Дэлхийн өвд бүртгэгдсэн бөгөөд 38-42 сая жилийн тэртээх Эоцений эпохоос гаралтай халим загасны газрын амьтнаас далайн амьтан болж хувирсан хувьслыг тайлбарлах дэлхийн хамгийн чухал өв сан бүхий газар юм. Уг бүсийг Дэлхийн соёлын өвт газраар нэрлэхээс өмнө албан ёсны менежменттэй байгаагүй юм. Иймээс ч чулуужсан яс цуглуулах, авто машинаар энд тэндгүй, эмх замбараагүй явсан зэрэг нь уг газрын үнэ цэнэд сөргөөр нөлөөлж байжээ. Дэлхийн өвөөр тодорч, хандивлагч байгууллагууд анхаарлаа хандуулж эхэлснээр төлөвлөлтийг илүү оновчтой болгож, менежмент болон эко аялал жуулчлал хөгжих болсон. Хамгийн чухал ач холбогдолтой үйл ажиллагаа нь төслийн төлөвлөгөө боловсруулах байсан бөгөөд үүнд талбайн загвар гаргах, дэд бүтэц, тээвэрт хамаарах дараах санаачилгуудыг багтаасан байжээ:

- **Дурсгалт газарт хүрч очих байдал:** Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийсний эцэст таван шалгуур үзүүлэлтүүдийн дагуу таван маршрутын хувилбарт үнэлгээ хийсэн. Үүнд: туулах замын урт, барилгын ажил гүйцэтгэхэд амар хялбар байдал, ТХНГ-ийн үнэ цэнэд үзүүлэх нөлөө, нутгийн иргэдэд өгөх эдийн засгийн өгөөж болон аялагчдад аялахад тохиромжтой байдал зэрэг байв;
- **Чулуужсан ясны үнэ цэнийг хамгаалах:** Чулуужсан ясны гол бүсийг хамгаалалтад авч, нэвтрэх газруудад хаалт бэхлэлт ашигласан. Тэмдэг, тэмдэглээ тавьж, тодорхой цэгүүдэд мэдээллийн цэгүүд байгуулж, өдөр тутмын эргүүл гаргажээ.
- **Аялагчдын хэрэгцээ:** Аялагчдаас авсан судалгаа болон аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөгөөр сүүдрэвч, чиглэл заасан тэмдэглэгээ, машины зогсоол, ариун цэврийн байгууламж, цайны газар, дотоод тээвэр, бэлэг дурсгалын дэлгүүр, отоглох газар гэх мэт тохиромжтой үйлчилгээний төрлүүдийг тодорхойлсон.
- **Тайлбарлан таниулах:** Дурсгалт газрын төв хэсэгт орон нутгийн гар урлалын бүтээлээс бүрдсэн задгай музей байгуулахаар төлөвлөсөн. Цөлийн элсээр явах зам харгуйг тогтоосон. Чулуужсан яс олддог хэсгийг шохоон чулуун багана, далдуу модны навчаар гараар хийсэн олс, шаазан самбараар тэмдэгжүүлсэн. Тайлбар, мэдээллийн самбаруудыг тухайн байгалийн төрхтэй уусан зохицуулахын тулд шавар тоосго, шохойгоор урласан.
- **Гол бүс дэх аялал:** Гол бүсэд тохиромжтой аяллын төрлийг тодорхойлохдоо зуны хэт халалт, аялагчдын нас болон тухайн газрын онгон хээр байдлыг тооцож тодорхойлсон. Үүний үр дүнд тодорхойлсон аяллын төрөлд явган алхалт, тэмээ унах тэмээн тэргээр аялах зэргийг сонгожээ. Учир нь тэдгээр нь ашиглахад тогтвортой, цэвэр мөн орон нутгийн бизнесийн боломж олгосон төрлүүд байв.
- **Байршилын төлөвлөлт:** ТХНГ дээрх үндсэн дэд бүтцийн бүтээн байгуулалтын байршилыг төлөвлөхдөө ирээдүйд ирэх боломжтой зочдын тоо, тэдний хөдөлгөөн, хөдөлгөөнд авто машины төрлүүдийг анхаарч үзсэн байдаг.
- **Байгууламжуудын загвар, материал болон технологи:** Элсэн чулуу, дулаан уур амьсгал, нутгийн урчуудын ур чадвар дээр үндэслэн харгалзсан архитекторын төлөвлөлт, удирдамжийг боловсруулж гаргасан. Газрын өнгө, бүтэц болон хэлбэр дүрсийг дуурайлган хийсэн шавар тоосго, шохойн чулуун хийц нь чулуужсан яс болон ерөнхий орчны үзэгдэх байдалд нөлөөлөхгүй шахам болсон байдаг. Шороогоор хийсэн бүтээн байгуулалтууд нь бөх бат, байгальд шингэж уусах төлөвтэй бөгөөд цаг нь болж нурж унахад буцаад газартаа шингэж, үзэгдэх орчинд ямар нэг сөрөг үр нөлөө үзүүлдэггүй.
Тохижилтийн бүтээн байгуулалт: Барилгын ажлыг гүйцэтгэхдээ байгальд аль болох сөрөг нөлөө үлдээхгүйгээр ажилласан бөгөөд орон нутгийн мужаан, ажилтнуудыг ажиллуулсан нь тэдний өөриймсөг сэтгэлгээг сэргээгээд зогсохгүй ажлын байр бий болгосон.
- **Үнэлгээний арга хэрэгслүүд:** Үнэлгээний арга хэрэгслүүдэд чулуужсан ясны олдворт газар болон зочдыг хянах, эргүүл хийх гэх мэт аргууд ордог. Менежментийн үр дүнтэй байдалд хяналт хийсэн нь Дэлхийн өвийн статус бүхий дурсгалт газруудын тогтмол тайланд шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлж өгсөн.

Эх сурвалж: <http://egyptheritage.com/Eco%20Hitan%20Open%20Air.html>




Дэлхийн өвд бүртгэгдсэн Вади Ел-Хитан нэртэй Халим загасны үлдэц бүхий хөндий дэхь Эко-археологийн газар.
© Dan Paleczny

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Байршилын дизайн болон барилгын ажлыг төлөвлөхдөө байгаль орчинд үзүүлэх нөлөө нь хамгийн бага, урт удаан хугацаанд ашиглагдах, дахин боловсруулах боломжтой, хүртээмжтэй, тогтвортой материалууд

График 3.1. Амралт зугаалгын боломжийн хамрах хүрээний хялбаршуулсан жишээ



Эх сурвалж : Manning, et al., 2017

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ: 2-р бүлэгт дурдсан) нь дэд бүтцийн байршил, цар хүрээг тодорхойлох эхний алхам болдог. ТХГН-ийн менежментэд орон нутгийн иргэд, гүйцэтгэгчид болон жуулчдын санал, зөвлөмж, оролцоо чухал байдаг. Тогтвортой дизайн, загварын шийдэл нь аялал жуучлалын байгууламж болон түүнийг хүрээлэн буй экосистемийг хооронд нь холбосон нарийн мэдрэмжийг аялагчдад төрүүлэхэд голлон чиглэсэн байна (Шигтгээ 3.2). Барилгын ажил гүйцэтгэгч нарт экосистемийн байгалийн үйл явцын талаар ойлголт, мэдэгдэхүүн өгөх нь хожим гарч болзошгүй экосистемийн доройтлоос сэргийлэхэд тус болох бөгөөд таталцах хүч, салхи, усны эх үүсвэр, ургамал, халхавч зэргийг хэрхэн давуу тал болгон ашиглах тухай санаа, мэдлэг өгдөг. Аялал жуучлалын үйлчилгээний зорилгоор дэд бүтцийн бүтээн байгуулалт хийхийн өмнө дараах зүйлсийг анхааралдаа авах нь зүйтэй. Үүнд: үзэгдэх орчин, байгалийн аюулт үзэгдэл, уламжлалт үйл ажиллагаа, ажилчид болон жуулчдын тээврийн асуудал, уур амьсгал, газрын хэвгийг налуу байдал, байгалийн болон соёлын онцлог зүйлст хүрч очих боломж, эрчим хүч болон бусад хэрэглээний эх үүсвэрүүд, шаардлагатай бараа, үйлчилгээнд хүрэх боломж, ажиллах хүчний нөөц бололцоо болон орон сууцны хүрэлцээ гэх мэт. Эдгээр хүчин зүйлсийг тооцсоноор нилээдгүй зардал хэмнээд зогсохгүй гоо зүйд

нийцсэн орчин бүрдүүлж, жуулчдад илүү таатай үйлчилгээ үзүүлэх боломж бүрддэг аж (Sweeting, et al., 1999).

Тогтвортой дэд бүтцийг төлөвлөх нь

Аялал жуучлалын байгууламжуудыг аль болох энгийн байдлаар байгуулж, эсвэл зориудаар огт хөгжүүлэхгүй ч байснаараа ТХГН дахь аялагчдын бөөгнөрөл, сөрөг нөлөө бүхий ашиглалтыг бууруулж, улмаар өндөр өгөөжтэй аялал хийх боломж олгож чаддаг. (Pedersen, 2002). Шигтгээ 3.3-т харуулсан Вади Ел-Хитаны Дэлхийн Өв газарт (Египет) байгаль хамгаалал, зочдын хүртэх үр өгөөжийг сайжруулахын тулд бүтээн байгуулалтыг минималист байдлаар шийдсэн байдаг. Апалачийн байгалийн үзэсгэлэнт жимд (АНУ) аялагчдын үйл ажиллагаа-ашиглалтыг зохицуулахын тулд тэгш газар орших маш ихээр талхлагдсан отоглох цэгүүдийг хааж нөхөн сэргээгээд, оронд нь талбай багатай отоглох цэгүүдийг налуу газруудад байгуулсан нь аялагчдад хувийн орон зай бий болгох боломж олгож, отоглох цэгүүд тэлж, томрохыг зогсоосон нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, аялагчдын сэтгэл ханамжийг ч нэмэгдүүлжээ (Daniels & Marion, 2006). Акадигийн Цогцолборт Газарт (АНУ) аялагчдыг жимгүй газар алхахаас сэргийлэх үүднээс бэлэг тэмдэгийн чанартай олсон хашлага хийжээ (Park, et al., 2008). Энэхүү аргууд нь өмнө нь хэд хэдэн удаа хийгээд байсан сургалт, мэдээллийн үйл ажиллагааг бодвол хавьгүй илүү үр дүнтэй болсон аж. Аялал жуучлалын байгууламжуудын дэд бүтэц, загвар, ашиглалт үйлчилгээ зэргийг сайтар бодож, зохион байгуулах нь жуулчдын авах үр өгөөжийг дээшлүүлж, буцаж ирэх сэдэл төрүүлж, ам дамжин сурталчилах замаар эерэг сэтгэгдэл тарааж, аялагчдыг өөриймсөг, үнэнч сэтгэлтэй болгоход хөтөлдөг байна.

Тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудлууд

Тээврийн хэрэгсэл болон дэд бүтцийг зөв шийдэх асуудал нь арилжааны аялал жуучлалд хамгийн чухлаар тавигддаг асуудал юм. Учир нь тэдгээрээс ТХГН болон нутгийн иргэдэд аюултай сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөр байдаг. АНУ-ын Тусгай хамгаалалттай газар нутгийн системд зочдын тав тухыг алдагдуулахгүй байхын



Индонез улсын Комодо Байгалийн цогцолборт газрын Падар арлын явган хүний жим. Зургийг Mei Yee Yan

Шигтгээ 3.4

Даацын талаархи товч түүх

Аялал жуулчлалын салбарт “даац” гэх ойлголт нь (тусгай хамгаалалттай газар нутаг дахь) аялал жуулчлалын нэг цэгт зочлох хүний тооны дээд хязгаар бөгөөд байгаль орчинд, биет хэлбэр, эдийн засаг, нийгэм соёлын түвшинд ямар нэгэн хор хөнөөл учруулаагүй байх (1), аялагчдын сэтгэл ханамжинд сөрөгөөр нөлөөлөөгүй байх (2) нөхцлүүдийг хангасан байх ёстой.

1960-д оноос эхлэн тусгай хамгаалалттай газар нутаг болон байгальд түшиглэсэн амралт, зугаалгад ашиглагдаж ирсэн энэ ойлголт нь эхэндээ байгаль орчинд нөлөөлөх агуулгыг илүү илэрхийлж байв. Тухайн үед “ТХГН-т ямар үед ашиглалтын түвшинг байгалийн баялагт нөхөн сэргээгдэхгүй хор хөнөөл авчрах дээд шатандаа хүрлээ гэж үзэх вэ?” гэсэн асуултад хариулахад ашиглаж байв. Төд удалгүй энэ ойлголтод нийгэм, олон нийтийн буюу аялагчдын хүртэх үр өгөөжийн асуудлууд хамрах ёстой нь тодорхой болж “Ашиглалтын ямар хэмжээ нь ТХГН дахь зочдын авах үр өгөөжид сөрөгөөр нөлөөлөх дээд хязгаар вэ?” гэх болжээ. Үүнтэй төстэй “зочдын багтаамж” гэх ойлголтыг зочдын менежментийн тулгарч буй асуудлуудыг шийдэхэд ашиглах болсон. Үүгээр тухайн ТХГН-т хүлээж авах зочдын тооны дээд хэмжээг тодорхойлоход ашиглаж байна.

Байршил дахь зочдын багтаамжийг тодорхойлох нь хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай байж болох ч (мэдээллийн төвийн нэг дор жуулчин хүлээж авах багтаамжийг тодорхойлох гэх мэт) өнөө цагт энэхүү ойлголтыг ТХГН-ийн үнэт зүйлсэд суурилсан стандарт бүхий менежментийн тогтолцоо, зорилго зорилт, тэдгээртэй холбоотой шалгуур үзүүлэлт болон стандартуудаар дамжин хэрэгжих болсон. Гэвч сүүлийн жилүүдэд “аялал жуулчлалын хэт ачаалал” гэх ойлголт гарч ирснээр “зочдын багтаамж” гэдэг ойлголтыг дахин сөхөх болжээ. Гэхдээ багтаамжийн асуудлыг дангаар нь ашиглахаас илүүтэйгээр LAC болон ROS-ын арга зүйгээр дамжуулан хэрэглэж, зочдын ашиглалтын дээд хязгаарыг тогтоох зэрэг нь даацын асуудлыг суурь болгож авч үзэхээс илүү үр дүнтэй байна.

Эх сурвалж: Lucas, 1964; Wagar, 1964; Graefe, et al., 1984; Shelby & Heberlein, 1986; McCool & Cole, 1997; Manning, 2007; McCool, et al., 2007; Manning, 2011; Whittaker, et al., 2011; IVUMC, 2016; IVUMC, 2017



Жуулчид Плитвицийн Нуурын Тусгай Хамгаалалттай газарт завинд суухаар хүлээж байна. Хорват улс. Mei Yee Yan

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА


ТХГН-ийн баримталдаг үнэ цэнэ, зорилго зорилтууд, холбогдох шалгуур үзүүлэлтүүд, стандартад суурилсан менежментийн тогтолцоог хэрэгжүүлсний үндсэн дээр ТХГН дахь аялал жуулчлал болон байгаль хамгааллын тэнцвэрийг хадгалахад хэрэгцээтэй мэдээллүүдийг боловсруулан өгч байх.

зэрэгцээ эрчим хүчний хэрэглээ, нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарал, дэд бүтцийн ул мөр зэргийг бууруулсан тээврийн тогтвортой шийдлүүдийг илүүтэйгээр эрэлхийлж, хэрэгжүүлэх болжээ. Тээврийн мэргэжилтнүүд АНУ-н Тусгай хамгаалалттай газрын захиргаатай хамтран, дурсгалт газруудад хүрч очих нийтийн тээврийг сайжруулах замаар автомашины хэрэглээг багасгах (жишээ нь трамвайн систем гэх мэт), дугуйн зам барих, загвар хийцийг ухаалагаар шийдсэн тэмдэг, тэмдэглэгээ суурьлуулах зэрэг ажлууд хийж, гүйцэтгэж байна (Manning, et al., 2014). Үндэсний Тусгай Хамгаалалттай Газар Нутагт Үүссэн Түгжрэлийг Шийдэх Гарын Авлага –д (АНУ-н ТХГНС, 2017b) тээвэртэй холбоотой маш олон төрлийн асуудлыг шийдвэрлэх арга замуудыг санал болгосон байдаг. Канадын Гатинау болон Нидерландын Де Хоге Велүве тусгай хамгаалалттай газруудад аялагчдыг ТХГН-т машинаа зогсоолд байрлуулж, дугуй түрээслэн аялахыг дэмждэг.



Чападагийн Цогцолборт газарт биологийн олон төрөл байдал нь аялагчдын хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлдэг. с Yu-Fai Leung

График 3.2. Аялагчид, аялал жуулчлалыг зохицуулах стратегиуд



Эх үүсвэр: Manning, et al., 2017

3.4 Гуравдугаар зарчим: Аялагчдын үйл ажиллагаа буюу ашиглалтын нөхцлийг өөрчлөх нь зайлшгүй бөгөөд эерэг үр дүнд хүргэх магадлалтай

Тухайн ТХНГ-т тохирох аялал жуулчлал, амралт зугаалгын төрлүүд нь газрынхаа онцлогоос шалтгаалж харилцан адилгүй байх хэдий ч хамгийн гол нь цаг хугацааны явцад хувиран өөрчлөгдөж болдог. Жуулчдын шинэ эрэлт хэрэгцээ нь ТХНГ-ийн удирдлага, зохион байгуулалтад адармаатай байж болох ч басхүү эерэгээр хүлээн авч, байгаль хамгаалалд ээлтэй аялалын үр өгөөж бүтээхэд чиглүүлж болдог. Амралт Зугаалгын Боломжийн Хамрах Хүрээ (ROS) нь менежерүүдэд шинэ тутам гарч болох эрэлтэд хэрхэн хариу үйлдэл үзүүлэх талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх аялал жуулчлалын менежментийн хүрээ юм.

Амралт зугаалгын боломжийн хамрах хүрээ

Амралт Зугаалгын Боломжийн Хамрах Хүрээ (ROS) нь бүсчлэлийн аргыг ашиглах замаар ТХНГ дахь аялал жуулчлал болон байгаль дахь амралт зугаалгын

үйл ажиллагааг төрөлжүүлэхэд өргөн ашиглагддаг менежментийн хүрээ юм (McCool, et al., 2007; Manning, 2011). ROS нь цогцолборт газар, амралт зугаалгын гурван бүрэлдэхүүн хэсэг болох нөөц, үр өгөөж болон менежментүүдийн шалгуур үзүүлэлт ба стандартуудыг илэрхийлдэг. Улмаар амралт зугаалгат байж болох олон төрөл, өргөн нөөц боломжийг харуулдаг юм. Жишээ нь График 3.1 ТХНГ-ийн байгальд түшиглэсэн амралт зугаалгын нөөц, эх ундаргын нөхцөл боломжийг “зэрлэг амьтад”-аас гэрийн тэжээвэр амьтад хүртэлх хэлбэлзлээр харуулжээ. Үүний нэгэн адил “хүнээс ангид байх” гэдэг нь байгальд түшиглэсэн аялал жуулчлалын үр өгөөжийн бүрдэлдэхүүн хэсэг агаад ихээх бага хүртэл төвшинд хэмжигддэг. Барилга, байгууламжийн “хөгжлийн түвшин” гэдэг нь байгальд түшиглэсэн амралт, зугаалгын үйл ажиллагааны менежментийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэг талдаа бүтээн байгуулалт огт хийдэггүй, нөгөө талдаа бүтээн байгуулалт өндөр хөгжсөн хэмээх хоёр туйлын дунд хэмжигднэ. Энэхүү бүтцэд оруулсан аргачлалыг ТХНГ-ийн менежерүүд ашигласнаар аялагчдын харилцан адилгүй эрэлт хэрэгцээнд тохирох байр суурийг тодорхойлно. Мөн тухайн газрын амралт зугаалгын боломжуудыг байгаль хамгаалал болон менежментийн зорилтууд, нөөц баялаг ба нийгмийн нөхцөл байдалтай нь уялдуулан тодорхойлох боломжтой болно.

3.5 Дөрөвдүгээр зарчим: Хүний ашиглалтаас болж байгалийн нөөц баялаг болон нийгмийн орчин нөхцлүүд өөрчлөгдөх нь зайлшгүй

Даац

Энэхүү удирдамжийн эхэн хэсэгт аялал жуулчлал болон аялагчдаас тухайн ТХГН-т тодорхой хэмжээний нөлөө үлдэх нь зайлшгүй тул менежерүүдийн хувьд хамгийн шилдэг туршлагаудыг ашиглан тэрхүү сөрөг нөлөөнүүдийг аль болох бууруулж, эерэг нөлөөг аль болох боломжит дээд төвшинд хүргэх үүрэгтэйг цохон тэмдэглэсэн

билээ. Энэхүү зорилтыг хангахад аялагчдын даац гэсэн ойлголтыг авч үзэх шаардлагатай болдог. Аялал жуулчлал болон амралт зугаалгаас ТХГН-ийн нөөцөд үзүүлдэг үр нөлөө, зочдын хүртэх үр өгөөжийн талаар судалгааны олон ажлууд хийгдэж иржээ. Зочдын тоо нэмэгдэх тусам ТХГН-т бөөгнөрөл үүсэж, байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь нэмэгдэж, ТХГН-ийн үнэ цэнэд аюул учруулж болзошгүй байдаг. Зарим тохиолдолд бодит хор уршиг, хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнээсээ хамаагүй давсан байх нь аялагчдын санал хүсэлтээр ил тодорхой болж болдог (Shelby & Heberlein, 1986; Whittaker, et al., 2011). Өөрөөр хэлбэл аялагчдын тоо нь зочид хүлээн авах даацаас хэтэрсэн байж болох юм. Шигтгээ 3.4-т энэхүү ойлголт хэрхэн үүссэн түүх хийгээд нэмэлт тайлбарыг агуулсан болно.

Шигтгээ 3.5

Гранд Каньон Үндэсний Парк (АНУ)-н төлөвлөлт ба бүсчлэл

Гранд Каньон Үндэсний Парк тусгай хамгаалалттай газар нутаг нь АНУ-ын хамгийн үнэ цэнэтэй үндэсний паркуудын нэг бөгөөд ЮНЕСКО-н Дэлхийн өвийн санд бүртгэлтэй. Гранд Каньоны амин зүрх болсон Колорадо гол нь 12,000 жилийн турш уугуул америк омгуудын ундны усны үндсэн эх үүсвэр нь болж, урлагийнхан, зохиолчдын онгодыг хөглөдөг зэрэгцээ сүүлийн жилүүдэд АНУ-ын түүхэнд гарсан байгаль орчны талаарх олон нийтийн санал хуваагдсан мэтгэлцээний анхаарлын төвд байсаар ирсэн. Мөн сүүлийн жилүүдэд Колорадо голд хийлдэг завиар явах сонирхолтой хүмүүсийн хамгийн их цугладаг цэг болсон бөгөөд уг гол дагуу 300 бээр орчим хөвөхдөө 100 гаруй ширүүн урсгалтай хэсгүүдийг давах шаардлагатай болдог ба үүнд тодорхой хэмжээний ур чадвар, авхаалж самбаа хэрэг болдог.



Гранд Каньон дахь завиар аялах. © Robert Manning

Паркийн одоогийн менежментийн төлөвлөгөө нь голыг хэт их ашиглахаас сэргийлэх зорилготой бөгөөд үндсэн зорилт нь "паркийн байгалийн нөөц баялаг болон зочдод өгөх үйлчилгээний чанарыг тогтвортой байлгахын зэрэгцээ гол дагасан аялал зугаалгын үйл ажиллагааг сайжруулах" юм. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд ашиглалтыг хязгаарлах, дүрэм журмаар зохицуулах, бүсчлэх зэрэг менежментийн аргуудыг ашигладаг.

Голын аялал зугаалгын зориулалтаар ашиглах ашиглалтыг хязгаарласан нь байгалийн болон соёлын нөөц баялагт үзүүлэх сөрөг нөлөөг нь багасгах, зочдын авах үйлчилгээний чанарыг бууруулахгүй байх зорилготой. Энэхүү хязгаарлалтад арилжааны (тусгай зөвшөөрөл бүхий) болон арилжааны бус (хувь хүмүүс) аялалууд хамаарагддаг. Арилжааны бус аяллын хэрэглэгчид зөвшөөрөл авах ёстой ба зөвшөөрлийг маш нарийн боловсруулсан "тооцоолсон сугалааны систем"-ээр дамжуулан олгодог. Зөвшөөрөл олгодог өмнөх системийг ашигладаг байхад 20 хүртэл жил хүлээх шаардлага гардаг байжээ. Одоогийн систем нь бизнесийн бус хэрэглэгчдийг нэг жилийн өмнө хүсэлтээ, аялахаар төлөвлөж буй өдрийн хамт гарган системд бүртгүүлэхийг шаарддаг бөгөөд санамсаргүй түүврийн аргаар сонголтоо хийдэг. Хэрэв хүсэлт гаргагч нь сүүлийн жилүүдэд голд завиар аялаагүй бол сонгогдох магадлал нь өндөр болдог. Нөгөө талаараа энэ нь жил ирэх тусам сугалаанд сонгогдох магадлал ихэсэх болно гэсэн үг юм.

Гол усны менежментэд дүрэм, журам нэвтрүүлэн ашиглах нь менежментийн төлөвлөгөөний нэг чухал хэсэг нь юм. Жишээ нь бизнесийн аялалын онгоцонд Үндэсний паркийн үйлчилгээний ажилтан заавал хамт явах бөгөөд, зарим ургамлын төрөл зүйлийг хамгаалах зорилгоор паркын зарим нэг хэсгийг тодорхой улирлуудад ашиглахыг хориглодог.

Бүсчлэлийг орон зай болон цаг хугацааны хувьд хийдэг. Голыг гурван хэсэгт ("онгон зэрлэг", "хагас онгон", "хөдөөгийн орчин") хуваах ба эдгээр хэсгүүд тус бүр зочдод харилцан адилгүй үр өгөөж өгөх зорилготой.. Харин цаг хугацааны хувьд бүсчлэл тогтоох нь механикжсан болон механикжсан бус хэрэглээг зохицуулах үүрэгтэй. Жишээ нь механикжсан хэрэглээг зөвхөн 4 сарын 1-нээс 9 сарын 15-ны хооронд зөвшөөрдөг гэх мэт.

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Менежментийн харилцан уялдаатай арга хэрэгсэл, арга замуудыг сонгож ашиглах

Тэвчиж болох өөрчлөлтийн дээд хязгаар

Орчин үед аялагчдын даац, багтаамжийг ойлгож, арга хэмжээ авъя гэвэл ROS-ний адил сайтар боловсруулагдсан аялал жуулчлал, зочдын менежментийн хүрээ болох Тэвчиж болох өөрчлөлтийн дээд хязгаар (LAC) –ыг тодорхойлох хэрэгтэй болдог. LAC нь ТХГН дахь байгаль орчин болон нийгэмд хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй өөрчлөлтүүдийн тэвчиж болох хязгаарыг хэмжигдэхүүнээр гаргаж ирсэний үндсэн дээр шаарлагатай стратеги, төлөвлөгөөг гаргаж өгдөг. LAC нь оновчтой төлөвлөлт, чанарын менежмент болон олон нийтийн оролцоо зэргийг харгалзан байгаль хамгаалалтай холбоотой чанарын хэмжигдэхүүнийг тодорхойлж, чанарын төвшинд мониторинг хийнэ (Sidaway, 1994). Зорилтод суурилсан менежментийн энэ аргыг мөн “шалгуур үзүүлэлтэнд үндэслэсэн” эсвэл “стандартад суурилсан” арга гэж нэрлэдэг (Leung, et al., 2008; McCool, et al., 2007; Manning, et al., 2017).

LAC ямар байх нь хүмүүсийн итгэл үнэмшил, соёл ахуйгаас гадна аялагчдын тоо хэмжээ, төрлөөс ихээхэн хамаардаг (Manning, 2007; Manning, 2011; Manning, et al., 2017). LAC-г ашиглаж буй тохиолдолд хэмжүүр нь ТХГН-н хувьд менежментийн зорилтууд юм. Тэдгээр нь нөөц баялагийн хамгаалалт, амралт зугаалгын үр өгөөжийн хүсэмжит байдлыг илэрхийлэхийн зэрэгцээ байгаль хамгаалах үндсэн зорилгыг ямагт тэргүүн ээлжинд тавьсан байна.

Чанарын шалгуур үзүүлэлтүүд ба стандартууд

Чанарын шалгуур үзүүлэлтүүд нь менежментийн зорилтуудын тусгал байдаг. Өөрөөр хэлбэл менежментийн зорилтуудыг хэмжигдэхүйц хэлбэрт оруулж байгаа үзүүлэлтүүд юм. Чанарын стандарт гэдэг нь чанарын шалгуур үзүүлэлтүүдийн хүлээн зөвшөөрөгдөх хамгийн доод түвшинг тодорхойлно. Жишээ нь бусад хүмүүсээс тусдаа, хол байхыг хүсдэг аялагчид нэг өдөрт зургаагаас илүү тооны бүлэг аялагчидтай таарахыг хүсдэггүй ба бусдад харагдахгүй, бусад аялагчдын дуу чимээг сонсохооргүй зайнд отоглохыг илүүд үздэг байна (Manning, 2011). Иймд зарим алслагдсан, зэлүүд газарт “аяллын жимд өдөртөө таваас олонгүй бүлэг аялагчидтай тааралдаж, бусад аялагчид харагдаж, дуу чимээ нь сонсогдохооргүй газар буудаллах” гэсэн стандартыг баримтлан ажиллаж болно. Менежментийн зорилтуудыг томъёолж, тэдгээрийг хэмжих боломжтой шалгуур үзүүлэлт болон чанарын стандарт байдлаар илэрхийлэх нь зочдын менежментийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас (UNWTO) гаргасан шалгуур үзүүлэлтийн гарын авлага дотор тогтвортой аялал жуулчлалд мөрдөхөд тохиромжтой шалгуур үзүүлэлтүүдийн жишээнүүд олон байдаг (UNWTO, 2004).

3.6 Тавдугаар зарчим: Менежмент нь хүний зан төлөвт нөлөөлж, аялал жуулчлалаас үүдэлтэй нөлөөллийг боломжит доод төвшинд хүргэхэд чиглэнэ

Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь ТХГН-ийн байгалийн үнэ цэнэд сөргөөр нөлөөлдөг учир менежментийн үндсэн

дөрвөн стратегийг боловсруулжээ. Энэ дөрвөн нь бүгд эрэлт ба нийлүүлэлт (График 3.2) гэсэн үндсэн стратегид суурилсан байна. Эхний хоёр стратеги нь аялал жуулчлалын боломжуудыг нэмэгдүүлэх эсвэл нийлүүлэлтийг тэгш хувиарлах байдлаар нийлүүлэлтийг нэмэгдүүлэх (График 3.2-н зүүн дээд талын цонх), эсвэл албан бус хэлбэрээр зохисгүй ашиглалтыг түр хязгаарлах, эсвэл бүр хориглох замаар (дээрээсээ хоёр дахь цонх) эрэлтийг багасгаж, эрэлт нийлүүлэлтийн харьцааг өөрчлөхөд чиглэгддэг. Сүүлийн хоёр стратегит эрэлт ба нийлүүлэлтийг тогтмол гэж үздэг. Ийм төрлийн менежмент нь жуулчдын сэтгэл зүйд нөлөөлөх байдлаар ашиглалтын үр нөлөөг багасгах, эсвэл ТХГН дахь эмзэг цэгүүдийн ачаалал даах чадварыг нэмэгдүүлэх, эсвэл бүр асуудал үүсгээд байгаа аялал жуулчлалын тодорхой ашиглалтыг хязгаарлах (дөрөв дэхь цонх) арга хэмжээнүүд авхад чиглэгддэг. Дараах хэсэгт бид менежментийн дөрвөн стратегийн талаар товч ярилцаад, аялал жуулчлалын нөлөөг удирдан зохицуулахад хамгийн түгээмэл ашиглагддаг арга хэрэгслүүдийн талаар үзэх болно. Үүнд: бүсчлэх, квот тогтоох, хууль, дүрэм журмыг мөрдүүлэх зэрэг орно. Энэ хэсгийн төгсөлд аялал жуулчлалын менежментийн бүхий л хүчин чармайлттай холбоотой аюул, осолгүй үйл ажиллагааны талаар дурьдах болно.

Аялал жуулчлалын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нь

Аялал жуулчлалын нийлүүлэлтийг хугацааны хувьд эсвэл орон зайн хувьд нэмэгдүүлж болно (График 3.2-ын зүүн дээд талын цонх). Цаг хугацааны хувьд ТХГН-ийн ашиглалт нь аялж болох өдрүүд хийгээд тодорхой цагуудын хооронд явагдах болдог. Хэрэв өндөр ачаалалтай үеийн жуулчдын ашиглалтын заримыг бага ачаалалтай үе рүү шилжүүлж чадвал тухайн газрын ачаалал буурч болдог. Нийлүүлэлтийг ихэсгэдэг илүү уламжлалт арга нь аялагчдын аялж болох талбайг тэлж томосгодог явдал юм (жишээ нь ТХНГ-ийн талбайг тэлэх эсвэл нэмэгдүүлэх, байгууламж, тоног төхөөрөмжийг сайжруулах, нэмэх гэх мэт).

Жуулчдаас гарах сөрөг нөлөөлөл ихтэй эрэлтийг бууруулах нь

Сөрөг нөлөөлөл ихтэй ашиглалтын эрэлтийг бууруулах нь аялал жуулчлалын менежментийн хоёр дахь үндсэн стратеги юм (График 3.2- хоёр дахь цонх). Үүнийг ашиглалтыг өөрчилж сөрөг нөлөөг бууруулах замаар гүйцэтгэнэ. Ингэснээр сөрөг нөлөөтэй үйл ажиллагааг бүхэлд нь зогсоохгүйгээр харин өөрчлөх боломжтой болно. Үүнд цаг хугацааны хувьд (Энэтхэгийн бар хамгаалах ТХГ нь борооны улирлын эхний хоёр сарын хугацаанд олон нийтэд хаалттай байдаг), байршлын хувьд (модтой зурвасаас доош хэсэгт нэвтрэхийг хориглох), зөвшөөрөгдөх үйл ажиллагаагаар (хоноглохыг зөвшөөрөх боловч ил гал түлэхийг хориглох) гэх мэтээр хязгаарлаж болдог. Өөр нэг арга зам нь ашиглалтын талбайг аль болох өргөн газар нутаг хамрах байдлаар шийдэх замаар нөлөөг нь сарниулах явдал болно. Амрах, зугаалах талбайг боломжтой бол тэлэх, эсвэл харилцан адилгүй ашиглагч бүлгүүдэд зориулан ангилж хуваавал дараах үр дүнгүүд гарч ирнэ. Үүнд: (1) Зөвшөөрөгдсөн хэмжээнээс давсан сөрөг нөлөө үзүүлэх явдал нэг газарт төвлөрөхгүй (2) ашиглагч бүлгүүдийн хооронд орших зөрчил буурах буюу арилна гэж үзнэ. Дээрхи төсөөлөл нь ямагт хүссэн үр дүнд хүргэнэ гэж үзэх нь мэдээж учир дутагдалтай юм.

Гурав дахь арга зам нь огт эсрэг байр суурь баримталж, ашиглалтыг зөвхөн нэг газарт төвлөрүүлсэнээр бүхий л сөрөг нөлөөг нэг газарт барих явдал юм. Жишээ нь аялал жуулчлалын үйл ажиллагааг хөрс, ургамал гэх мэт байгалийн баялаг нь харьцангуй тэсвэртэй бүс рүү эсвэл мэдээллийн төвийн ойр орчимд төвлөрүүлж болно. Мөн амралт, зугаалгыг хоорондоо ойролцоо, бие биедээ саад болохооргүй, адил төстэй үнэт зүйлтэй, хүсэл эрмэлзэлтэй ашиглагчдыг хамтадган, нэг газарт төвлөрүүлж мөн болно.

Байгалийн нөөцийг “бэхжүүлэх нь”

Эрэлт болон нийлүүлэлтийг тогтмол байна гэж үзсэн тохиолдолд гуравдахь стратеги нь ТХГН-ийн сөрөг нөлөөтэй ашиглалтад өртөмтгий нөөцийн даацыг илүү тэсвэртэй болгоход чиглэдэг (График 3.2-ын гурав дахь цонх салбар цонхнуудын хамт). Энэхүү арга хэмжээг голдуу “бэхжүүлэх” гэдэг нь машин, явган зам болон отоглох газрын хөрсөнд шууд ирэх нөлөөллийг даах чадварыг нэмэгүүлэх зорилгоор хатуу хучилттай болгохтой холбоотой юм. Хамгийн түгээмэл хийгддэг ажил бол аялалын маршрут дагуух намгархаг хөрстэй хэсэгт модон шалтай зам барих. Үүнийг эсвэл хүний хөлөнд өртөмтгий хэсэгт хатуу биетэй ургамалууд тарьж ургуулах замаар байгалийн аргаар шийдэх тохиолдол байна. Бас нэг өөр арга нь аялагчдад тэдний үйл ажиллагаанаас үүдэн гарч буй сөрөг нөлөөний талаар мэдээлэл өгөх замаар сэтгэл зүйд нь нөлөөлж, илүү анхаарал болгоомжтой явах хүсэл эрмэлзэлтэй болгох явдал юм.

Сөрөг нөлөөтэй ашиглалтыг хязгаарлах нь

Дөрөв дэхь буюу нийтлэг менежментийн стратеги нь сөрөг нөлөөтэй ашиглалтад хатуу квот (тэд хүртэл, хориглох зүйлс гэх мэт) тогтоох юм (График 3.2, дөрөв дэхь цонх). Дүрэм, журмуудыг зочдын менежментэд өргөн хэрэглэдэг (Lucas, 1982; Lucas, 1983; Monz, et al., 2000; Manning, 2011). Байгаль орчны нөөцөд сөргөөр нөлөөлөх нөлөөллийн эсрэг хэрэгжүүлдэг дүрэм журмын түгээмэл зохицуулалтанд группийн хэмжээ, отоглох байршил, аяллын маршрут, нэвтрэхийг хязгаарласан газрууд, нийт аялах хоногийн дээд хязгаар, амралт, зугаалга, хандлагын зөвшөөрөгдсөн хэлбэр, хэм хэмжээ гэх мэт үйл ажиллагаанууд ордог. Гэвч, нэвтрүүлж буй дүрэм, журам нь хэр үр дүнтэй байгааг ТХГН-ийн менежерүүд хянаж байх нь чухал байдаг. Жишээ нь АНУ-ын ТХГН-уудад отоглох газрын ил задгай түүдэг галыг зохицуулах талаар хийгдсэн дүрэм, журмын гурван ажилд судалгаа хийж үзжээ. Тэдгээр нь: бүр мөсөн хориглох, зарим цэгүүдэд зөвшөөрөх, мөн огт зохицуулалтгүй орхих (Reid & Marion, 2004) зэрэг байв. Судалгаанаас харахад түүдэг галыг огт хориглосон нь үр нөлөөг багасгахад мэдэгдэхүйц үр дүн үзүүлж чадсан бол ямар ч зохицуулалтгүй орхисон нь байгалийн нөөцийг улам доройтуулж байжээ. Харин тодорхой цэгүүдэд түүдэг гал түлэхийг зөвшөөрч, сүх, хөрөө зэргийг ашиглахыг хориглож өгсөн нь аялагчдын амралт, зугаалгад эрхэмд тооцогддог хээрээр гал түлэх эрхийг нь хэвээр үлдээхийн зэрэгцээ, галын аюулыг хянах боломжтойг харуулжээ. Менежерүүдийн хувьд дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахын тулд заавал мэдэх ёстой дүрэм, журмууд, тэдгээрийг гаргах болсон шалтгаан, дагаж мөрдөөгүй нөхцөлд авдаг арга хэмжээ (торгууль, шийтгэл) зэргийг аялагчдад маш тодорхой тайлбарлах ёстой байдаг.

Бүсчлэх

Бүсчлэх нь аялал жуучлалтын менежментэд хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга

бөгөөд аялал жуучлал болон зочдын менежментийн чухал хэсэг нь юм (Manning, 2011; Manning, et al., 2017). Энгийнээр тайлбарлавал бүсчлэл бий болгосноор аялал жуучлалын тодорхой нэг үйл ажиллагааг ТХГН-т тодорхой газар нутагт, тодорхой цагт, явуулахыг хэлнэ (Шигтгээ 3.5). Мөн бүсчлэл бий болгосноор байгаль орчны хувьд эмзэг цэгүүдэд байгалийн нөөцөд сөрөг нөлөөтэй үйл ажиллагааг хориглох, аялал жуулчлалын хоорондоо тохирохгүй үйл ажиллагааг ялгаж салгах зэрэг боломжийг өгдөг. Уганда улс ТХГН-ийн менежментийн ерөнхий төлөвлөгөөндөө бүсчлэлийн системээр орон сууц, тээвэр болон зочдын хийх боломжтой үйл ажиллагаанууд, группийн бүрэлдэхүүний хязгаарыг тодорхойлсон байдаг (Bintoora, 2014). Бүсчлэлийг ашиглан аялал жуучлалын олон төрлийн бүтээгдэхүүн бий болгох боломжтой бөгөөд мөн түүнчилэн өмнө дурдсан Амралт Зугаалгын Боломжийн Хамрах Хүрээний суурь ойлголт болно.

Квот тогтоох

Аялал жуучлал болон амралт зугаалгын боломжуудад квот тогтоох нь бас нэг боломжит аргад тооцогддог (Хүснэгт 3.2). Нэвтрэх зөвшөөрөл олгох зорилгоор сугалаа, дуудлага худалдаа зохион байгуулах аргыг АНУ-ын цогцолборт газруудад түгээмэл ашигладаг (Шигтгээ 3.5). Ашиглалтыг тэнцвэртэй хуваарилах, сугалаа сугалах зэрэг арга нь эрх тэгш байдал, чанар, тэнцэтгэлийг хангаж буй хэлбэрүүд юм (жишээ нь дан ганц өндөр үнэтэйгээр зөвшөөрөл олгох нь нийгмийн тодорхой нэг хэсгийг нийгэм-эдийн засгийн статусаар нь ялгаварлан гадуурхсанд тооцогдож болох талтай).

Албадан хэрэгжүүлэлтийн “зөөлөн” ба “хатуу” хэлбэрүүд

Аялагчдын ашиглалтыг хязгаарласан дүрэм, журмуудын хэрэгжилтийг дэмжсэн албадан шахах механизм зайлшгүй шаардлагатай болдог. Дүрэм журам сахиулах олон арга тактик бий. Тухайн ТХГН-т ямар арга хэрэглэх нь гарч буй зөрчлийн төрлөөс шалтгаална. “Зөөлөн” гэх аргуудад аялагч, жуулчдыг дүрэм мөрдүүлхэд чиглэсэн менежментийн арга хэмжээнүүд ордог. Жишээ нь паркийн тэмдэг, тэмдэглэгээ, аялагчдыг зөв бөгөөд (Marion & Reid, 2007) аюулгүй аялахад чиглэсэн мэдээллийн самбарууд (зэрлэг амьтадтай хэрхэн харьцах, анхаарал болгоомжтой байх явган хүний зам болон цаг агаарын нөхцөл байдлууд гэх мэт) байрлуулж болно. Үйл ажиллагааны дүрэм нэвтрүүлэх нь аялагчдын тооноос гадна бүтээн байгуулалт, барилгын ажилд эерэгээр нөлөөлж, аюулгүй байдлыг сайжруулах үүднээс зарим тодорхой үйл ажиллагааг хязгаарлаж болдог (Eagles et al., 2002). Эдгээрийг амьдрал дээр хэрэгжүүлэхэд тур операторууд болон концесс эзэмшигчид чухал үүрэгтэй учир заавал дэмждэг байх нь зүйд нийцнэ. “Зөөлөн” аргыг ашиглаад үр дүнд хүрээгүй нөхцөлд “хатуу” буюу торгууль тавих, цаашлаад шаардлагатай нөхцөлд баривчлах зэрэг хуулийн дагуу арга хэмжээ авахаас өөр аргагүй болдог (Wynveen, et al., 2007).

Тухайн тусгай хамгаалалттай газар нутагт дүрэм журам сахиулах аливаа арга хэмжээг авахдаа аялагчдын аюулгүй байдал, хууль дүрэмд нийцсэн байх, аялагчдын сэтгэл ханамж гэсэн гурван хүчин зүйлсийн тэнцвэрийг

хангасан байх ёстой (Manning, et al., 2017).

ТХГН-т авч хэрэгжүүлэх “хатуу” арга хэмжээнүүд чухам хэр хатуу байх ёстой талаар өнөөг хүртэл хэлэлцсээр буй бөгөөд энэ талаар дорвитой судалгаа тун бага өдий хүрчээ. АНУ-н Райниер Уулын Байгалийн цогцолборт газарт хийсэн судалгаанаас үзэхэд дүрэмт хувцас өмссөн байгаль хамгаалагч харагдсан газарт зөвшөөрөгдсөн замаас хазайж гарах тохиолдлууд эрс багасчээ (Swearingen & Johnson, 1995). Дүрэмт хувцас өмссөн байгаль хамгаалагч нь аялагчдад хэрэгцээтэй мэдээлэл тараах, тэдний аюулгүй байдлыг, байгаль орчныг хамгаалах үүрэгтэй гэдгийг ойлгосон үед жуулчдын хандлага нь илүү эерэг болдог аж. Филиппин дэхь тусгай хамгаалагдсан далайн дөрвөн эргийн бүсэд урт хугацаанд хийгдсэн судалгаагаар нутгийн шүрэн арлын экологийн нөхцөл байдал сайжирч, загасны төрөл зүйл нэмэгдэн олширсон нь хууль журмын биелэлт, менежментийн үйл ажиллагаа болон олон нийтийн дэмжлэг нэмэгдсэнтэй холбоотой байжээ (Walmsley & White, 2003).

Аюулгүй байдалтай холбоотой асуудлууд

Болзошгүй аюулаас хамгаалах, аюулгүй байдлыг хангах асуудал нь бүх аялагчдад хамаатай. Аюулын эх үүсвэр нь бусад аялагчид, зэрлэг амьтад, байгалийн аюултай үзэгдэл, хууль бус үйл ажиллагаа зэрэг байж болно. Хамгийн ноцтой тохиолдолд аялагчид ТХГН дотор зохион байгуулалттай хууль бус ан агнуурын үйл ажиллагаа

болон орон нутгийн чанартай зэвсэгт мөргөлдөөнд өртөж болзошгүй (Ардчилсан бүгд найрамдах Конго улсын Вирунга Үндэсний Цогцолборт газар, 2018 он). Хууль хүчний байгууллагын төлөөллийг ТХГН-т ажиллуулах нь болзошгүй аюулыг багасгах нэг арга зам болдог. Хууль сахиулагчдыг харах төдийд л аялагчдын хувьд аюулгүй, найдвартай орчинд байгаа мэдрэмж төрдөг нь батлагдсан боловч (Wynveen, et al., 2007) өртөгийн хувьд өндөр байдаг. Хөгжиж буй орнуудад ТББ-ууд болон орон нутгийн иргэд хамтран хяналт, шалгалт хийх нь нэг боломжит арга байж болдог (Coad, et al., 2008).

ТХГН-ийн менежмент нь иргэд, жуулчид, аялал жуулчлалтай холбоотой бизнесүүдийг эрсдлээс хамгаалах тодорхой, оновчтой төлөвлөгөөтэй байх ёстой юм. Үүнийг тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөтэй уялдуулсан байх ёстой бөгөөд дотроо ажиллаж, аялж буй хүмүүст, мөн ирэх магадлалтай аялагчдад ч зориулсан байна. Жишээ нь Кругер Байгалийн Цогцолборт Газар нь (Өмнөд Африк) далайн Ел Нино урсгалтай холбоотой цаг уурын хэлбэлзлээс болж гамшигт үеэрт автсаны улмаас зам, гүүр зэрэг дэд бүтцүүд нь эвдэрчээ. Өмнөд Африкийн Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэн нь өөрийн олон нийтийн мэдээлэлд ашигладаг хамгийн чухал хэрэгслүүд болох цахим хуудас хийгээд олон нийтийн сүлжээгээр дамжуулан аялал жуулчлалын салбарынхан болон аялагчдад тус аюултай байдлын талаар мэдээлэл хүргэж байсан аж.

Хүснэгт 3.2. Квот тогтоох төрлүүд

Аялал жуулчлалын квот тогтоох систем	Шинж чанарууд
Захиалга өгөх систем	Аялагчдыг ТХГН-т ирэхээсээ өмнө урьдчилан захиалга өгөх, эсвэл зөвшөөрөл авсан байрыг шаарддаг
Сугалаа	Зөвшөөрөл эсвэл бусад боломжуудыг түүврийн маягаар хувиарладаг
Хэн түрүүлж хандсан нь үйлчлүүлдэг зарчим	Аялах хүсэлтээ илэрхийлсэн хүмүүс сул зай гартал хүлээхийг шаарддаг
Үнэ	Зөвшөөрөл авахын тулд тодорхой хэмжээний төлбөр төлөхийг шаарддаг нь тухайн төлбөрийг төлөх чадваргүй, эсвэл хүсэлгүй хүмүүсийг “ялгаж салгах” зүйл болдог
Чансаа, давуу тал	Аялагчид зөвшөөрөл авах эрхээ авахын тулд ямар нэгэн мэдлэг, ур чадвараа харуулах шаардлагатай (жишээ нь байгаль орчинд сөрөг нөлөө багатай байдлаар аялах чадамжаа харуулах гэх мэт)

Эх сурвалж: Stankey & Baden, 1977; Cable & Watson, 1998; Whittaker & Shelby, 2008; Manning, 2011



Эквадор улсын Галапагос БЦГ-ын Тортуга Бей дэхь аялагчдад зориулсан мэдээлэл © Yu-Fai Leung

Хүснэгт 3.3. Менежментийн шууд ба шууд бус аргуудын жишээ

Төрөл	Жишээ
Шууд (Аялагчдын хандлагыг чиглүүлсэн, хувь хүний сонголтыг хязгаарласан, өндөр түвшний хяналт, удирдлага)	<ul style="list-style-type: none"> Хяналт ажиглалт хийх нутаг дэвсгэрийг нэмэгдүүлэх Бүсчлэлүүд нь цаг хугацаа, орон зайны хувьд давхцах боломжгүй (зөвхөн дугуй унахыг зөвшөөрөх хэсэг, зөвхөн алхахыг зөвшөөрөх хэсэг, авто машин хориглох хэсэг гэх мэт) Зарим отог дээр зөвхөн нэг хонохыг зөвшөөрөх Ашиглалтыг сөөлжих (зам хаах эсвэл нээх, орох гарах цэгүүд, зам харгуй, отог бууц) Урьдчилсан захиалга өгөхийг шаардах Аялагч баг тус бүрт отоглох байршил, аялах маршрутыг нь давхцуулахгүйгээр хувиарлах Орох гарах цэгээр дамжуулан хэрэглээг хязгаарлах Аяллын багийн гишүүдийн тоог хязгаарлах (морь, машины тоонд хязгаар тогтоох гэх мэт) Зөвхөн хуваарьласан отогт буудаллах Нэг орчинд буудаллах хугацааг зааж өгөх (буудаллаж болох хугааны хязгаар) Ил гал түлэхийг хориглох Загасчлах, ан хийхийг хориглох Хөтөчтэй аялахыг шаардах, эсвэл санал болгох Торгууль ноогдуулах
Шууд бус (Аялагчдын зан хандлагад нөлөөлөх, өөрчлөх; хувь хүн сонголт хийх боломжтой; хяналт арай сул, ашиглалтын илүү олон хувилбартай)	<ul style="list-style-type: none"> Отоглох цэг болон бусад төвлөрсөн ашиглалтын цэгүүдийг сайжруулах (эсвэл сайжруулахгүй байх); Тухайн бүс нутгийн онцлог зүйлсийг сурталчилж, хамгаалахыг сануулан дэмжих Ойр орчмын бүс нутагт амралт зугаалгын боломжуудыг нээн тодруулах Зочдод экологийн мэдлэг, аяллын үед баримтлах ёс зүйн талаар мэдлэг, мэдээлэл олгох Ашиглалт багатай бүс нутаг, аяллын боломжуудын талаар сурталчилгаа хийх Нэвтрэх төлбөр авах Харилцан адилгүй төлбөрийн системтэй байх (жишээ нь аяллын маршрут, бүс, улирлаар) Экологийн боловсрол, аялах чадвараа нотлон харуулахыг шаардах

Эх сурвалж: CBD, 2004; Manning, et al. 2017

3.7 Зургаадугаар зарчим: Нөлөөлөл нь олон хүчин зүйлсээс шалтгаалдаг учир ашиглалтыг хязгаарлах нь менежментийн олон сонголтуудыг нэг юм

Өмнөх зарчимд тайлбарласны дагуу аялагчдын үйл ажиллагаа буюу ашиглалтыг хязгаарлах нь аялал жуулчлалаас үүдэлтэй өөрчлөлтийг зохицуулах наад захын аргуудын нэг нь юм. Иймээс ч аялал жуулчлалтай холбоотой менежментийн сөрөг асуудал гарахад энэхүү аргыг эхлээд ашигладаг. Гэхдээ 4-р зарчимд дурдсанчлан жуулчин хүлээн авах даацын талаар хийсэн хэдэн арван жилийн судалгаа, туршилт зэрэг нь жуулчин хүлээж авах болон аялал жуулчлалын менежментийн шийдвэр гаргалтыг эрс сайжруулсаныг ТХГН-ийн үнэ цэнэ хийгээд менежментийн зорилго, зорилтуудыг нэгтгэсэн стандартад түшиглэсэн хүрээнүүдээс харж болно. ТХГН-ийн менежерүүд нь тухайн орчинд үзүүлж буй сөрөг нөлөөнүүд олон эх үүсвэрээс гаралтай байдгийг ойлгосоор иржээ (тээврийн хэрэгслийн хэлбэр, аяллын багийн хэмжээ, аялаж буй улирал гэх мэт). Сөрөг нөлөө үзүүлж буй ашиглалтыг дан ганц хорих төдийгээр

асуудлын уг шалтгааныг нь шийдвэрлэх боломжгүй юм. Харин аялагчдын хэзээ, хаана, ямар аялал төлөвлөж буйд нөлөөлөх замаар илүү үр дүнд хүрэх гэх мэт өөр арга замууд илүү үр дүнтэй байж болох юм (хүснэгт 3.3). Ерөнхийдөө шууд бус арга хэмжээнүүд нь зочдын хүртэх үр өгөөжид халдахгүй сайн талтай авч хэрэв үр дүн муутай, эсвэл нөөц баялагийн нөхцөл байдалд яаралтай арга хэмжээ авах шаарлага үүсвэл шууд арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүдэхээс өөр аргагүй болдог билээ (Hall & McArthur, 1998; Manning, et al., 2017).

Үнийн аргаар аялагчдын тоог зохицуулах нь

Аялагчдын тоог зохицуулахад хэрэглэж болох нэг энгийн арга нь үнийн бодлого юм. Шатлалтай үнийн тариф нь үнийг аялагчдын нас, оршин суух хаяг гэх мэт хүчин зүйлсүүд дээр түшиглэн өөр, өөрөөр тогтоодог бөгөөд ингэснээрээ ТХГН-ийн хувьд хүссэн зорилтод бүлэгтээ илүүтэй хүрч, тэднийг татах арга болгон ашиглаж болох юм. Харилцан адилгүй үнэтэй байна гэдэг нь харилцан адилгүй үйлчилгээ авна гэсэн үг болно. Жишээ нь үзэсгэлэнт байгальд орших голын дэргэдэх отоглох цэг нь өөр газрыг бодвол илүү үнэтэй байж болно. Аялал жуулчлалын оргил үед үнийг зориуд өсгөж өгөх нь жуулчид хэт ихээр төвлөрөхөөс сэргийлж болдог.

Нүүлгэн шилжилтийн асуудал

Зочдын ашиглалт хийгээд менежментийн үйл ажиллагаанаас тооцоолгүй байсан үр дүнгүүд ТХГН-д тэр даруйдаа мэдэгдэхгүй, эсвэл бүр хилийнх нь гадна талд ч илрэх тохиолдол байна. Жишээ нь ТХГН дотор сөрөг үр нөлөөтэй ашиглалтыг хориглосон байсныг ТХГН-ийн гаднах бүс нутагт үргэлжлүүлж хийгээд эхэлсэн тохиолдол байна. Энэ тохиолдолд асуудлыг шийдвэрлэсэн хэрэг огтхон ч болохгүйгээр барахгүй харин ч хортой ашиглалтын байршлыг л өөр газар руу шилжүүлсэн хэрэг болж орхино. ТХГН-ийн төлөвлөгөө зохиогчид ашиглалт ба түүний үр нөлөөний ирээдүйд гарах үр нөлөө, цар хүрээг мэдэхийн тулд тэдгээрийн хоорондын харилцаа, уялдаа холбооны талаар ихээхэн сайн мэдлэгтэй байх хэрэгтэй болдог. Боловсрол, мэдлэг олгох хөтөлбөрүүд мөн, аялагчдын баримтлах дүрэм, журмууд нь зайлшгүй л хэрэгтэй болдог аргууд билээ.

3.8 Шилдэг туршлагаууд

- Байршлын дизайн болон барилгын ажлыг төлөвлөхдөө байгаль орчинд үзүүлэх нөлөө нь хамгийн бага, урт удаан хугацаанд ашиглагдах, дахин боловсруулах боломжтой, хүртээмжтэй, тогтвортой материалууд сонгох. Загвар хийцийн хувьд орон нутгийн соёл, газар нутгийн онцлог, уур амьсгалын онцлогийг тусгаж, гадна тохижилт, шавьж хорхойгоос сэргийлэх зорилгоор нутгийн унаган ургамлуудыг ашиглах.
- ТХГН-ийн баримталдаг үнэ цэнэ, зорилго зорилтууд, холбогдох шалгуур үзүүлэлтүүд, стандартад суурилсан менежментийн тогтолцоог хэрэгжүүлсний үндсэн дээр ТХГН дахь аялал жуулчлал болон байгаль хамгааллын тэнцвэрийг хадгалахад хэрэгцээтэй мэдээллүүдийг боловсруулан өгч байх.
- Харилцан бие биенээ нөхөж, дэмжиж байдаг менежментийн арга, техникүүдийг нэгтгэн ашиглах.



Усанд хөвөх завь ба шумбалтын аяллын төрлүүд. Виржин Арлуудын Үндэсний Цогцолборт Газар, АНУ. Зургийг Yu-Fai Leung



Жуулчдын цасны гуталтай аялал. Полистовски Заповедник, Орос. Зургийг Elena Nikolaeva



Малайз улсын усан паркын нэвтрэх тасалбар. Зургийг Elizabeth Halpenny

Тогтвортой аялал жуулчлалын дасан зохицох менежмент

4



Өмнөх бүлгүүдэд дурдсан арга, техникүүдээс тохирохыг сонгож, хэрэгжүүлэхэд бэлэн болсоны дараа менежерүүдийн зүгээс байгалийн нөөцөд мониторинг хийх, өөрийгөө тогтмол үнэлэх, олон нийтийн оролцоог хангах, харилцаа холбооны хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай болно. Энэ бүлгийн Хүснэгт 3.1-д үзүүлсэн менежментийн арван зарчмын үлдсэн дөрвөн зарчмыг танилцуулах бөгөөд долоодугаар зарчмаас эхэлнэ. Дараа нь төрөл бүрийн гэрчилгээжүүлэх хөтөлбөрөөр дамжуулж аялал жуулчлалын менежментийн чанарыг сайжруулах боломжийг авч үзнэ. Эцэст нь ТХГН-т тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх гол элементүүдийг нэгтгэсэн аялал жуулчлал, аялагчдын менежментийн гурван талт тогтолцооны хүрээг авч үзэх болно.

4.1 Долоодугаар зарчим: Мониторинг үнэлгээ бол менежментийн салшгүй хэсэг мөн

Мониторинг үнэлгээний нэгдсэн үүрэг

Аялал жуулчлалын менежментийн аливаа стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг нь өнөөгийн нөхцөл байдлыг хянах, менежментийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, зохих арга хэмжээг авах үндэслэл, менежментийн төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлт оруулах явдал юм. Төслийн менежментийн мөчлөгийн үндсэн алхамуудыг тахирмаг хүснэгт 4.1-д үзүүлэв. Тогтвортой, үр дүнтэй хяналтын хөтөлбөрүүд нь зөв загвар гаргах, шалгуур үзүүлэлт, хэмжилтийг нарийн сонгох, санхүүжилт, ажилтнууд, тоног төхөөрөмж, дэд бүтцийг урт хугацаанд хэрэгжүүлэхэд шаардагдана (Miller and Twining-Ward, 2005; Gitzen, et al., 2012).

ТХГН-ийн олон агентлагууд, байгаль хамгаалах байгууллагууд эдгээрийн бүгдийг, эсвэл зарим шаардлагыг хангаж чаддаггүй (Price and Daust, 2009; Groves and Game, 2016). Иймд мониторинг хийх хөтөлбөрүүд нь санхүүжилт эсвэл боловсон хүчний өөрчлөлтөөс болж урт настай байж чаддаггүй. ТХГН-ийн менежерүүд нь мониторинг яагаад бүтэлгүйтсэн, түүний шалтгааныг хэрхэн арилгах талаар ойлгосон байх хэрэгтэй юм.

Байгаль хамгаалахад хяналт, үнэлгээ хийх ач холбогдолыг нь харгалзан үзсэний дээр мониторингийн хөтөлбөрийн чанар, өртөг, үр ашиг, тогтвортой байдлыг сайжруулах удирдамжууд боловсруулагджээ. Жишээ нь Гровес ба Гэймс нарын (2016) зүгээс зорилтот бүлгийг тодорхойлж, шаардлагатай мэдээлэл өгөхүйц мониторингийн ухаалаг хөрөнгө оруулалт хийхэд менежерүүдэд туслах зорилгоор байгаль орчны хяналт, үнэлгээний үндсэн арга зам, загваруудын сонголтуудыг гаргаж өгсөн байдаг (Gitzen, et al., 2012 үзнэ үү). НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Дэлхийн байгаль орчны мониторингийн төв болон Биологийн олон янз байдлын шалгууруудын түншлэл зэрэг дэлхийн хэмжээний хөтөлбөр, санаачлагууд нь ТХГН-ийг хянах хөтөлбөрүүдийг хялбаршуулах, ялангуяа үзүүлэлтүүдийг боловсруулах, тайлагнах, мэдээлэл солилцоход дэмжлэг үзүүлдэг.

Хариулах үндсэн асуултууд

Хяналт мониторингийн ашигтай, үр дүнтэй хөтөлбөрийг боловсруулахын тулд менежерүүд дараах үндсэн асуултуудыг авч үзэх хэрэгтэй (Eagles, et al., 2002):

1. **Хяналт тавих нь ямар ач холбогдолтой вэ?** Хяналт нь урт хугацааны нөөц болон ашиглалтын чиг хандлагыг илрүүлэх (ихэвчлэн “орчны хяналт” гэж нэрлэдэг), менежментийн хүрээг дэмжих, эсвэл менежментийн стратеги үр ашгийн богино хугацааны үр дүнг үнэлэх зорилготой (ихэвчлэн “үр дүнгийн хяналт” гэж нэрлэдэг).

График 4.1. Төслийн менежментийн тойрог



Шигтгээ 4.1

Сайн дурынхан ТХГН-т судлаач-иргэн, хянагчаар ажиллах нь

ТХГН-ийн хамгаалалтын захиргааныхан хөтөлбөр хэрэгжүүлэх, дэд бүтцийг хадгалах, төлөвлөлтийн ажилд сайн дурынхны оролцоо, дэмжлэг дээр түшиглэх нь улам ихсэж байна. Сайн дурын ийм үйл ажиллагаанууд нь ТХГН-ийг хамгаалах, амралт зугаалгын хэлбэрээр ажиллах зорилгуудаа хэрэгжүүлэхэд дэм болж байдаг. Сайн дурынхны анхаарлыг татахуйц утга учиртай, сонирхолтой хөтөлбөрүүд зохиохын өмнө тэдний хүсэл эрмэлзлэлийг юу өдөөдөгийг ойлгох нь чухал байдаг. Сайн дурын үйл ажиллагаа нь тухайн улсын иргэд ба ТХГН-ийн хоорондын холбоог бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг (Waithaka, et al., 2012 шилдэг жишээ).

ТХГН-т сайн дурын ажилд оролцох түгээмэл хэлбэр нь иргэний зохион байгуулалттай судалгааны ажилд олон нийтийн оролцоог дэмжих явдал байдаг. Жижиг төслүүдээс эхэлж болно (нэг л байгууллага удирдаж олон нийтээс нэг л хүн оролцуулах гэх мэт). Эсвэл томоохон төсөл байж болно (олон улс орны сайн дурынхныг хамарсан гэх мэт).

Сайн дурынхны цуглуулж буй тайлан, мэдээлэл нь маш энгийн байж болох бөгөөд ерөнхий хэв шинжийг таньж мэдээллийн сан бий болгож өгөх төдий хэмжээнд байж болно. Эсвэл сайн дурынхны цуглуулсан өгөгдөл нь судалгааны тодорхой асуултыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах зорилготойгоор маш нарийн мэдээлэл шаардаж бас болно. Судлаач-иргэн нь заримдаа тухайлан ийм зорилгоор ТХГН-т аялахаар ирсэн жуулчин мөн боловч ихэнх тохиолдолд амралт чөлөөт цагаа ТХГН-т өнгөрөөж таашаал авах зуураа энерги, ур чадвараа шинжлэх ухаанд хувь нэмэр оруулах гэсэн, хөдөө аялах дуртай хүмүүс байдаг.

ТХГН-ийн менежерүүд сайн дурын судлаачдыг ашиглан нөөцийн менежментийн асуудалд үр дүнтэй интервенц хийх боломж бүрдүүлэх боломжтой.

Жишээлбэл: Австрали улсад, Викториагийн Далайн БЦГ-т Викториагийн далайн тусгай хамгаалалттай газрууд болон нөөц газруудын эрүүл орчны талаархи мэдээллийг цуглуулах зорилгоор Тэнгисийн эрэл хэмээх судлаач-иргэний төслийг эхлүүлжээ.

Үүнтэй нэгэн адилаар Их Британийн Иоркийн Их Сургууль сайн дурын судлаачдын тусламжтайгаар сээр нуруугүй 250 зүйлийн амьтдыг бүртгэжээ.

Иргэн-судлаач хөтөлбөр нь агентлаг хоорондын үйл ажиллагаа, олон нийтийн түншлэлийг хөгжүүлж, сайн дурынхан дээр түшиглсэн байгаль хамгааллыг бий болгож, нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх тустай байдаг. Шаардлагатай сургалт, зааварчилгаагаар давхар хангаж өгвөл бүр их илүү үр дүнтэй байдаг билээ.

Эх үүсвэр: Cassie and Halpenny, 2003; Halpenny & Cassie, 2003; Koss, et al., 2009; Dickinson & Bonney, 2012; University of York, 2012; Waithaka, et al., 2012; Follett & Strezov, 2015; Parks Victoria, 2017



Сайн дурынхан сургалтын явцад мэдээлэл цуглуулж байгаа нь, Есөмети БЦГ, USA. © Yu-Fai Leung

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Судлаач-иргэн болон бусад хөтөлбөрөөр дамжуулан сайн дурын ажилтнуудын ур чадвар, урам зоригийг менежментийн үйл ажиллагаанд ашиглах. Ингэхдээ зохих хяналт, чанарын шаардлагыг мөрдөж ажиллуулах.

2. **Юуг хянах вэ?:** Ямар үзүүлэлтүүд ТХГН-д үнэ цэнтэй, эсвэл удирдлагын шийдвэр гаргахад шууд хамааралтай вэ? Нөлөөллийн ямар хэлбэр (жишээ нь, байгаль орчин, эдийн засаг, нийгэм олон нийт, соёл) хамгийн чухал вэ? Менежерүүдийн хувьд хамгийн чухал нь юу вэ? Харьцуулж үзэх, оролт (жишээ нь: аялагчдын тоо, аялагчдын зан чанар) болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд (жишээ нь: эдийн засгийн үр ашиг, аялагчдын авах үр өгөөж, экологийн нөлөөлөл).
3. **Хяналтыг хаана, хэзээ явуулах вэ?:** Хяналт нь хамгийн эмзэг газар, хурдацтай өөрчлөгдөж байгаа газруудад явагдах ёстой юу? Зөвхөн эмзэг улиралд (жишээ нь шувууны үржлийн улирал) эсвэл жилийн турш улирлын

өөрчлөлтийг үнэлэх ёстой юу? Ямар үзүүлэлтүүдийг хамгийн олон удаа хянах ёстой вэ? Хяналтын давтамж өөрчлөгдөхөд юу нөлөөлөх ёстой вэ?

4. **Хэн хяналт тавих ёстой вэ?:** Хяналтын мэдээллийг байгаль хамгаалагч, менежерүүд, судлаачид эсвэл сайн дурынхан цуглуулах ёстой юу? Хяналтын хөтөлбөрийн зарим хэсгийг орон нутгийнхан хийж чадах уу? Хяналтын хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэхэд ТХГН нь өөр байгууллага, олон нийтийн чадавхийг ашиглах боломжтой юу? Мэдээллийн чанарыг баталгаажуулахын тулд ямар түвшний сургалт явуулах шаардлагатай вэ? Мэдээллийг аялал жуулчлалын эсвэл концессийн операторууд цуглуулж чадах уу?

5. **Мэдээлэлд хэн дүн шинжилгээ хийх вэ?:** Хяналтын үр дүнг ТХГН-ийн менежерүүд, судлаачид, эсвэл хамтран дүн шинжилгээ хийх үү?
6. **Мэдээллийг хэрхэн ашиглах вэ?:** Үр дүнг менежерүүд хэрхэн нэгтгэж, ашиглах вэ?

Эдгээр асуултыг нарийвчлан авч үзэх нь хяналтыг үр дүнтэй боломжийн зардлаар хэрэгжүүлэхэд тусалдаг. Аялал жуулчлалын хяналт шинжилгээний арга зүй, хөтөлбөрүүдийн жишээг өгөх олон удирдамж, гарын авлага байдаг (тухайлбал, Hornback & Eagles, 1999; UNWTO, 2004; Miller & Twining-Ward, 2005).

Нутгийн иргэдэд түшиглэсэн мониторинг

Аялал жуулчлал, аялагчдын үйл ажиллагаа, ашиглалтад хяналт тавих нь өртөг шаардсан, ТХГН-ийн хүчин чадлыг давсан ажил байдаг хэдий ч хяналт тавих шалгуур үзүүлэлтүүдээс хамааран зарим хөтөлбөрийг харьцангуй энгийн бөгөөд хямдаар шийдэж болно.

Цаашилбал мэдээлэл цуглуулах ажилд сайн дурын ажилтнууд, аялагчид эсвэл аялал жуулчлалын концессийн операторуудыг татан оролцуулах (Miller, et al., 2012; Chase & Levine, 2016), мөн судлаач-иргэнээр дамжуулан жуулчдын тоо, төрөл зүйлийг хянах замаар зардлыг дахин бууруулж болдог (Шигтгээ 4.1).

Шигтгээ 4.2

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн мониторинг, Намиби улсын жишээ: Эвент Захиалах Систем



Намиби улсын Зээрийн (*Oryx spp.*) нүүдэл, шилжилт хөдөлгөөн. © Ralf Buckley

Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн мониторинг нь (CBNRM) уламжлалт мониторингийн хөтөлбөрүүдэс ялгаатай нь нутгийн иргэдэд байгалийн ямар нөөцөд мониторинг хийхийг шийдэх эрхийг олгож, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээг ихэвчилэн нийтийн оролцоотойгоор хэрэгжүүлдэгээрээ онцлог.

CBNRM-ийг Намиби улсад зэрлэг ан амьтны хууль бус хулгайн антай тэмцэх, ан амьтныг хамгаалахад дэмжих, аялал жуулчлалын боломжийг сурталчлах зорилгоор нэвтрүүлжээ. 1996 онд байгаль хамгаалах үйл хэргийн хүрээнд CBNRM хөдөлгөөнийг эхлүүлсэн бөгөөд нутгийн иргэдэд нийтийн эзэмшлийн газарт орших зэрлэг ан амьтдаас ашиг хүртэх эрхийг нь олгосон байдаг. Үүний өмнөх мониторингийн загварыг гадны зөвлөхүүд боловсруулсан байдаг бөгөөд байгаль хамгаалагчдын цуглуулсан мэдээллийг мөн гадны зөвлөхүүд шинжлэн дүгнэснээ эргээд тайлагнадаггүй байсан байна. Үүний хариуд 2000 оноос эхлэн “Эвент Бүртгэлийн Систем”-ийг хөгжүүлж эхэлжээ. Үүгээр нутгийн иргэд юунд мониторинг хийх, ямар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх зэргийг шийддэг болсон байна.

Мониторингийн үзүүлэлтүүдийг нутгийн иргэдийн зүгээс байгалийн нөөцийн менежментэд эрэмбэлсэн эрэмбийн дагуу тогтоодог болжээ. Мэдээлэл цуглуулах, тайлагнах, урт хугацааны өөрчлөлтөд тавих хараа хяналт зэрэгт зориулсан нэгдсэн стандартыг боловсруулж, дундаа ашигладаг. Гадны зөвлөхүүдийн зүгээс ур чадвар дээшлүүлэх сургалт зохион байгуулж, жил бүр аудит хийж цуглуулсан мэдээллийг холбогдох байгаль хамгаалах байгууллагаас авч, гарсан мэдээллийг нь эргээд шийдвэр гаргах үйл явцад оруулдаг ажээ.

“Эвент Бүртгэлийн Систем”-ийн дагуух байгаль хамгаалах үйл ажиллагаанд бүтэц, зохион байгуулалтын хувьд гурван үндсэн шатлал байх бөгөөд үүнд орон нутгийн байгаль хамгаалагчид, байгалийн нөөцийн зөвлөх ба байгаль хамгаалах менежер буюу эсвэл сонгогдсон дарга байна. Энэхүү олон түвшний удирдлагын бүтэц нь хөтөлбөрийг тогтвортой хэрэгжихэд хувь нэмэртэй байдаг. 2010 онд Намиби улсад CBNRM-ийн 50 орчим хөтөлбөр хэрэгжиж байсан бөгөөд “Эвентийн бүртгэлийн систем”-ийг Мозамбик, Танзани, Ботсвана болон Камбожи улсуудад мөн амжилттай хэрэгжүүлжээ.

Эх сурвалж: Ashley and Barnes, 1996; Stuart-Hill, et al., 2005; Conrad and Daoust, 2008; Boudreaux and Nelson, 2011; Stuart-Hill, 2011

Шигтгээ 4.3

Аялагчдын стандартчилсан хяналт: Нордикийн болон Балтийн орнууд хоорондын уялдаа холбоотой хүчин чармайлт



Шведийн Туриста Цогцолборт Газрын нарийн зам жуулчдын бөөгнөрөлийг үүсгэнэ (Зүүн талд). © Yu-Fai Leung. Эстони улсын Соомагийн Цогцолборт Газар дахь таруу байрлалтай газраар зориулалтын гутал өмсөж алхана. (Баруун талд) © Mark Ballantyne

Бүс нутаг, улс орны хийгээд олон улсын аялагч, жуулчдын мэдээлэл нь ТХГН-ийн төлөвлөлт болон бодлогын шийдвэр гаргахад чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Аялагчдын талаархи мэдээллийг тухайн байршилын буюу орон нутгийн түвшинд цуглуулах олон аргууд байдаг ч байршил, агентлагууд, улс орнуудын хооронд болоод ирэхээр харьцуулах аргагүй түвэгтэй болоод ирдэг. Аялагчдад ашиглах мониторингийн нэгдсэн удирдамжтай байвал нийтлэг ашиглагдаж болох аргачлал, гол шалгуур үзүүлэлтүүд болон тайлан хийх стандартууд зэргийг тодорхойлоход тустай байдаг. Ингэснээр орон зайн болон цаг хугацааны өөр өөр түвшинд хамааралтай өгөгдлүүдийг үнэн зөв харьцуулах боломжтой болдог.

Байгалийн аялагчдын мониторинг: Нордик болон Балтийн орнуудын туршлагаад үндэслэн боловсруулсан гарын авлага нь жуулчдын талаархи нэгдсэн мэдээлэл цуглуулж, тайлагнахад хэд хэдэн улс орнуудын хооронд мэдээлэл хуваалцах чиглэлээр хийгдсэн анхны зохион байгуулалттай оролдлого юм. Нордикийн Сайд нарын Зөвлөл, Шведийн Байгаль орчныг хамгаалах агентлаг (Naturvardsverket)-аас санхүүжүүлэн гаргасан энэхүү гарын авлага нь тухайн газарт аялагчдыг хянах гол үзүүлэлтүүдийн нийтлэг арга, зөвлөмжийг нарийвчлан гаргаж, Нордикийн (Дани, Финланд, Исланд, Норвеги, Швед зэрэг улсуудад), Балтийн улсууд (Эстон, Латви, Литва) зэрэг улсуудын ТХГН-дын үр дүнгийн тайлангийн форматын загварыг санал болгожээ.

Тус гарын авлагад тухайн бүс нутаг орчмын ТХГН-уудад хийсэн аялагчдын мониторингийн ажлын жишээнүүдийг харуулсан байна. Тухайлбал, Финландын Хамгаалалттай Газрын Захиргаанаас (ХГЗ) аялагчдын мониторингийн хөтөлбөрийг ойролцоогоор 400 орчим ТХГН-т амжилттай хэрэгжүүлсэн байна. (Metsähallitus, ТХГН ба Wildland Finland). Энэ хөтөлбөр нь 60 гаруй ТХГН-т (цогцолборт газрууд, үндэсний амралтын газрууд, хөдөө онгон байгаль гэх мэт) аялагчдыг тогтмол тоолж, Финландын ХГЗ-ны боловруулсан удирдамжийн дагуу таван жилд нэг удаа явуулдаг аялагчдын судалгаанаас бүрдэнэ.

ТХГН-ийн менежментэд чухал ач холбогдол бүхий гол түлхүүр шалгуур үзүүлэлтүүдэд аялагчдын тоо, тэдний мэдээлэл, үйл ажиллагаа, зардал, хүсэл сонирхол, сэтгэл ханамж, аяллын шинж чанар (аяллын үргэлжлэх хугацаа, аяллын тархалт гэх мэт) орно. Судалгааг стандартын дагуу хурдан хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор загвар асуултуудыг багтаажээ. Тайлангаас хархад харьцуулалтыг хялбарчлахын тулд ангилал гэхээсээ илүү нарийвчилсан мэдээллийг ашиглахыг санал болгосон байдаг.

Уг төслүүдийн мэдээллийн сан нь тодорхой ТХГН-уудыг хооронд нь харьцуулах боломжтой төдийгүй тухайн улс орны эдийн засгийн нөлөөлөл, жуулчдын сэтгэл ханамжийг үндэсний түвшинд хянах, нэгдсэн мэдээллийн сангийн мэдээнүүдийг олон нийт ашиглах, түгээх өргөн боломжтой байдаг.

Эх сурвалж: Kajala, et al., 2007; Kajala, 2013; <https://www.naturvardsverket.se/Documents/publikationer/620-1258-4.pdf>

Аялал жуулчлалаас байгалийн нөөцөд нөлөөлж буй байдалд хяналт тавихад нугийн иргэдийг ч татан оролцуулах боломжтой. Шигтгээ 4.2-т Намиби улс аялал жуулчлалын нөлөөгөөр байгуулсан нутгийн иргэдэд түшиглэсэн ан амьтдыг хянах хөтөлбөрийн жишээг үзүүлэв.

Дараагийн хэсэгт нь аялал жуулчлалын менежментийн мониторингийн томоохон хэлбэрүүд болох аялагчдын үйл ажиллагаа буюу ашиглалтын мониторинг, аялагчдын нөлөөллийн мониторинг, аялагчдын авах үр өгөөжийн мониторинг болон менежментийн үр ашигт байдлын мониторинг зэргийг авч үзэв.

Хүснэгт 4.1. Аялагчдын нөлөөллийн мониторингд ашигладаг зарим нийтлэг аргууд

Хяналтын хамрах хүрээ	Бага өртөгтэй	Дунд өртөгтэй	Өндөр өртөгтэй
Амралт, зугаалгын дэд бүтцүүд (жимүүд, отоглох газар, байгалийн харагдацтай газрууд гэх мэт)	Давтан гэрэл зураг авах	Давтан хэмжээс авах	Нарийвчилсан тооллого ба үнэлгээ хийх
Экологийн нөөцүүд (хөрс, ургамал, зэрлэг амьтан, ус)	Давтан гэрэл зураг авах	Давтан хэмжээс авах; автомат гэрэл зураг авах төхөөрөмжүүд тавих	Экологийн нарийвчилсан үнэлгээ хийх
Аялагчдын ашиглалт ба авир үйлдэл (ашиглалтын төрлүүд ба тархалт, зохисгүй үйлдлийг баримтжуулалт)	Аялагчдыг тоолох	Авир, үйлдлийн ажиглалт ба зурагжуулалт хийх	Зургийн аппарат/ видео мониторинг хийх; аялагчдаас судалгаа авах

Шигтгээ 4.4

Есөметигийн Байгалийн Цогцолборт Газар (АНУ) дахь аялагчдын үйл ажиллагаа-ашиглалт, нөлөөллийг хянах нь

1890 онд байгуулагдаж, 1984 онд ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэгдсэн Есөметигийн БЦГ (YNP) нь биологийн олон янз байдал, байгалийн үзэсгэлэнт төрх байдлаараа гайхамшигтай бөгөөд жил бүр олон сая жуулчид зорин очдог.

2004 оноос YNP-т байгалийн ба соёлын өвийн нөөцүүдийнхээ бүрэн бүтэн байдал, аялагчдад өгөх үр өгөөжид нь нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах зорилгоор мэдээлэл цуглуулах ажиллагааг эхлүүлж, туршиж, сайжруулсаар иржээ. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг YNP-ийн менежерүүд, төлөвлөгөө зохиогчид, агентлагийн түншүүд, гэрээт байгууллагууд болон судалгааны байгууллагуудаас бүрдсэн хамтарсан бүлгээс тогтоосон. Ингэхдээ цогцолборт газрын болон гол, усыг ашиглах менежментийн төлөвлөгөөнүүдэд заасан үнэт зүйлс дээр үндэслэжээ. Өнгөрсөн хугацаанд сайжруулалт хийж ирсэн ба ач холбогдлоо алдсан мэдээлэл байвал устгаж, мэдээлэл нь үнэн зөв байх, гадаад орчиноо бодитой тусгаж байх чанарыг хадгалах үүднээс шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулж иржээ. Хөтөлбөрийн хэмжээнд найман үндсэн шалгуур үзүүлэлтийг мониторинг хийхэд ашиглаж байна. Үүнд:

- 1. **Усны чанар:** эрдэсийн түвшин, савханцар хорхой болон газрын тосны нүүрстөрөгч;
- 2. **Голын эргийн орчин:** Голын сувгуудын зүй тогтол, ургамлын байдал, тухайн байршил дээрхи тодорхой цагт байгаа хүмүүсийн мониторинг тооллого;
- 3. **Аялагчдын бий болгосон албан бус жим:** талбайн хэмжээ, нөхцөл байдал, биологийн төрөл зүйлийн нэг нь нөгөөгөөс давуу болгох “хуваагдлын нөлөөлөл”;
- 4. **Байгалийн дуу чимээ:** дуу чимээний түвшин, хүч, үргэлжилэх хугацаа, нөлөөний хэлбэрүүд;
- 5. **Археологийн олдворт газруудын тогтвортой, бүрэн бүтэн байдал:** Хүний нөлөөтэй эвдрэл, сүйтгэлийн төрлүүд; Ёсемите ТХГ-т аялагчдын албан бус замтай холбоотойгоор үүссэн эдвэрсэн газруудын нөлөөллийн эрчим (Дээд). Энгийн аялагч
- 6. **Аялагчдын ашиглалтын төрлүүд:** Нэг цаг хугацаанд, нэг байгалийн үзвэрт байгаа аялагчид, завь, тээврийн хэрэгслүүдийн тоо (нягтралаар)
- 7. **Зэрлэг амьтад харах:** нэг өдөрт, нэг цагт груп, хувь хүмүүстэй тааралдаж буй амьтдын тоо болон нууц газраас ажиглалт хийсэн сүрэг амьтдын бүтэц
- 8. **Зэрлэг амьтад хүний хоол хүнснээс хамаарах явдал:** Хоноглох цэг ба тээврийн хэрэгслийн зогсоол дээрхи хүнсний хадгалалтын дүрэм журмын биелэлтийн түвшин.



Албан бус зам, түүнтэй холбоотой эвдэрсэн газрууд нь Есөметийн БЦГ (Дээд) -д зочлох нөлөөллийн үзүүлэлтүүдийн нэг юм. Есөметийн БЦГ, Мөсөн цэг (Доод) дахь алдартай зочдын сонирхол. © Yu-Fai Leung

Олон давталттай мониторингоос суурь хэмжигдэхүүнийг авсанаар шинжлэх ухааны үндэслэлтэй урт хугацааны төлөвлөлт, менежментийн үйл ажиллагаа явуулах боломжтой болдог. Мониторингийн шалгуур үзүүлэлтүүд болон мониторинг хийх цагийн хуваарь зэргийг харуулсан “Хээрийн Мониторингийн Гарын Авлага”, мөн жилийн эцсийн тайлангууд, санал болгосон авч хэрэгжүүлэх стандартууд зэрэг мэдээллийг Есөмети БЦГ-ын веб хуудас дээр байрлуулж, олон нийтийн уулзалтууд дээр дэлгэн тавьж үзүүлдэг байна. Том хэмжээний хяналтын хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах үүднээс цогцолборт газрын ажилтнуудаас гадна түнш нар, дадлагажигчдыг мэдээлэл цуглуулах ажилд оролцуулсан нь цаг хугацаа, зардалд хэмнэлттэй болохыг батлан харуулжээ.

Эх сурвалж: Yosemite National Park, 2015

Аялагчдын үйл ажиллагаа, ашиглалтын мониторинг

Амралт, аялал жуулчлалын хэмжээ, төрөл, тархалт нь суурь мэдээллүүд байдаг хэр нь тэдгээрийг тогтмол бөгөөд системтэйгээр цуглуулдаг ТХГН-ууд олон байдаггүй (Hornback and Eagles, 1999). Жуулчдын үйл ажиллагаа буюу ашиглалтын хамгийн түгээмэл хэмжигдэхүүн нь дараах зүйлийг агуулсан байдаг:

- **Аялагчдын тоо:** Үргэлжилэх хугацаанаас үл хамааран ТХГН-т орж, гарсан аялагчдын тоо;
- **Аялагчдын ор хоног:** ТХГН-т хоносон аялагчдын тоо;
- **Аялагчдын зарцуулсан цаг:** Аялагчдын ТХГН-т нэвтэрч өнгөрөөсөн нийт хугацаа цагийн хэмжилтээр;
- **Аялагчдын өдөр:** Аялагчдын ТХГН-т нэвтэрч өнгөрөөсөн нийт хугацаа өдрийн тоогоор;
- **Аялагчдын зарцуулсан зардал:** Аялагчдын ТХГН-т байх хугацаандаа бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээнд зарцуулсан нийт зардал.

Хэр хэмжээнд мониторинг хийж чадах нь тогтвортой аялал жуулчлалын менежментийн зорилго, ажилтнууд болон төсвийн боломжоос хамаарна. (Hornback and Eagles, 1999).

Шигтгээ 4.3-т Нордик болон Балтийн орнуудын боловсруулсан аялагчдын үйл ажиллагаа, ашиглалтын мониторингийн хөтөлбөрийн жишээг харуулав.

Аялагчдын нөлөөллийн мониторинг

Аялагчдын нөлөөллийн мониторингийн шалгуур үзүүлэлтүүдийг экосистемийн маш олон үзүүлэлтийг харгалзан боловсруулсан байна (Хүснэгт 4.1) (Buckley, 2003a; НҮБ-ын UNWTO, 2004). Хяналт мониторингийг аялал жуулчлалын дэд бүтцийн нөхцөл байдал, дизайн болон менежментэд тохируулан хийдэг. Экологийн нөөцөд, ялангуяа эмзэг ландшафт, амьдрах орчны болон (ямар?) зүйлүүдийг хамруулан авч үзнэ. Аялагчдын үйл ажиллагаа-ашиглалт, хандлагад хийх мониторинг нь тухайлбал хог хаях, замгүй газраар явган аялах зэрэг авируудыг үнэлж цэгнэнэ. Мониторинг хийх нарийвчилсан зорилтууд болон шалгуур үзүүлэлтүүд нь менежментийн



Африкийн ховордсон зэрлэг нохойнуудыг Ботсвана улсын Линяанти орчим дахь Дума Тау дахь жуулчид харж баясана.
© Wilderness Safaris and Russel Friedman

Шигтгээ 4.5

Аялагчдын мониторингод ашигладаг олон аргууд: Вилморийн онгон зэрлэг газар (Канад улс)



Морин аялагчид нь ТХГН дахь ашиглалтын томоохон бүрэлдэхүүн хэсэг тул тэдний тоо, шинж байдалд нь урт хугацааны турш хяналт тавих нь ТХГН-ийн менежерүүдэд ихээхэн чухал ач холбогдолтой байдаг. © Debbie Mucha

Вилморийн онгон зэрлэг газар (WWP) нь Канад улсын Роки ууланд оршдог, 4,600 км² талбайг хамарсан, Алберта мужийн хамгийн том цогцолборт газар юм. Вилморийн WWP-т олон төрлийн ландшафт болон зэрлэг ан амьтан, ургамал тархжээ. Тухайлбал Нохой зээх (*Gulo gulo*), Модны үен (*Martes pennantei*), Хүрэн баавгай (*Ursus arctos*), Цагаан холтост нарс (*Pinus albicaulis*), Хөвд (*Mielichhoferia macrocarpa*) байдаг. Вилмори нь ховор, өвөрмөц онгон байдлыг бий болгосон, олон төрлийн амралт, зугаалгын үйл ажиллагаа явуулж болох алслагдсан, өргөн уудам байгалийн үзэсгэлэнт газруудаас бүрддэг.

WWP-ын алслагдмал байдал, өргөн уудам нутагт тархсан ан амьтдыг хянах хэцүү, хүчин чадал хүрдэггүй зэргээс болж жуулчдын талаар мэдээлэл цуглуулах ажил тун цөөхөн удаа хийгджээ. Аялагчид бүртгүүлэх шаардлагагүй тул хэд нь зөвшөөрөлтэй аялж буйг тоолох боломжгүй байдаг. Аялагчдын болон тэдгээрийн хэрхэн аялсан талаар мэдээлэл байхгүйгээс болж цогцолбот газрын менежерүүдэд оновчтой шийдвэр гаргахад хүндрэлтэй байдаг байна.

Аялагчдын талаархи мэдээлэл нь хуучирсан эсвэл тогтмол биш байсан тул WWP-ын зүгээс шинэ хөтөлбөр хэрэгжүүлж эхлэв.

WWP-т ирсэн аялагчдын талаархи мэдээллийг сайжруулахын тулд менежерүүд уламжлалт судалгааны аргыг (жишээлбэл судалгаа бөглүүлэх) орчин үеийн арга технологтой хослуулсан байна (жишээлбэл жим дагуу камер суурилуулах, GPS төхөөрөмж, зөөврийн бичлэг хийгч зэрэг). Жим дагуу байрлуулсан лангуу, мэдээллийн төв болон интернет ашиглах замаар жуулчдаар өөрсдөөр нь судалгаа бөглүүлжээ. Энэхүү жим дагуу судалгааны хуудсанд хаягаа үлдээсэн жуулчдын араас бичгээр дэлгэрэнгүй судалгаа авч эхлэв. Вилмор руу нэвтэрдэг дөрвөн гол хаалганууд дээр (Албертагийн талд) жим ажиглах камер байрлуулснаар аялагчдын зан төлөв, аялалын мэдээллийг цуглуулж эхлэв. Аялагчдын хөдөлгөөнийг хиймэл дагуулаар заасан мэдээлэл гаргуулах зорилгоор GPS төхөөрөмжүүд суурьлуулав. Эцэст нь цогцолборт газар жуулчдын хандах хандлагыг мэдэх зорилготой уян хатан асуултуудтай ярилцлагууд авч өмнөх жуулчдаар өөрсдөөр нь дараагийн аялагчдыг түүвэрлэн сонгох замаар ярилцлага авах хүмүүсээ сонгожээ. Энэхүү төсөлд ашигласан олон арга техник нь Вилморийн онгон зэрлэг газрын менежерүүдэд цогцолборт газар дахь аялагчдын авах үр өгөөжийг хадгалах, сайжруулхад тустай баялаг их мэдээллийг өгсөн байдаг.

Энэхүү төсөл нь хязгаарлагдмал нөөцөд түшиглэж, судалгааны өргөн том талбайг хамарсан хэрнээ аялагчдын талаар чухал мэдээлэл цуглуулсан байдаг. Цогцолборт газарт зорин ирэх жуулчдын талаархи мэдээлэл сайжирснаас зөвхөн хамгаалалтын захиргааны менежерүүд төдийгүй тур операторууд, аялагчид, тусгай сонирхолын болон хэрэглэгчдийн бүлгүүд хийгээд олон нийтэд ач холбогдолтой болсон байдаг. Гэсэн хэдий ч аялагчдын хяналт нь цаг хугацааны хувьд түр зуурын байж болохгүй бөгөөд тогтмол хийгдэж байх шаардлагатай байдаг. Урт удаан цаг хугацааны явцад ТХГН-н аялагчдын талаар илүү их мэдлэг өгөх энэхүү одоо ч үргэлжилж буй төсөл нь WWP дахь байгаль хамгаалах зорилго, зорилтыг аялал жуулчлалтай тэнцвэржүүлэх болно.

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн мониторингийг шаардлагатай техник технологи, санхүүгийн хангалттай үүсвэртэй уялдуулан холбох.

зорилгуудаас ихээхэн хамаардаг. Зарим мониторингийн шалгуур үзүүлэлтүүд, тухайлбал хөрсний элэгдэл эвдрэл нь бүс нутаг, экосистемүүдийн хувьд түгээмэл байдаг бол зэрлэг амьтдын үржихэд саад болох, аялал жуулчлалын өвөрмөц дэд бүтцийн доройтол зэрэг нь бүс нутгууд тус бүр дээр өөр байж болох юм (Leung, 2012).

Бага өртөгтэй мониторингийн хөтөлбөрт судалгаанд хамаарах газрын нэг байрлалаас тогтмол хугацаанд зураг авах арга хэрэглэх бөгөөд тийм газрыг ихэвчлэн "гэрэл зургийн цэг" хэмээнэ (Lucey and Barraclough, 2001; Augar and Fluker, 2015). Байгалийн нөөцийн өөрчлөлтийн байдлыг ондоо цаг үед авсан зургуудыг хооронд нь харьцуулан

Шигтгээ 4.6

Прухоник Байгалийн Цогцолборт Газар дахь аялагчдын төрөл дээр хийсэн мониторинг (Чех улс)



Прухоникийн БЦГ-ын аялагчдын жимүүдийн дэлгэмэл харагдац (зүүн). Аялагчдын хамгийн их хийдэг үйлдэл бол явган явах, цэцэг ажиглах болон бусад байгалийн зураг авах юм. (баруун). © Luis Monteiro

Прухоник БЦГ нь 1992 онд Праг хотын түүхэн дурсгалт гол газар болохын хувьд Дэлхийн өвд бүртгэгдсэн, Чех улсын хамгийн их жуулчид, амрагчид зорьж очдог цогцолборт газар юм. Газар нутгийн хувьд 250 га, нийт 30 км урт явган аялалын жимтэй бөгөөд Праг хотоос урагш 15 км-т оршдог, экологи, соёлын өв цогцолсон, төрөл бүрийн хэлбэрээр аялах, зугаалах боломжтой газар юм. Жилд дунджаар 150,000 гаруй жуулчид авдаг ТХГН-т хамгийн ачаалалтай үе нь 4-5 дугаар сарууд аж. Хүний хөдөлгөөн тасардаггүй тул зарим үед цогцолборт газрын тодорхой цэгүүд хэт ачаалал авдаг ажээ. Олон нийт, нийгмийн чанартай үр нөлөөллийг арилгах зорилгоор Прухоник БЦГ-ын менежерүүд аялагчдад ирэх үр өгөөжид мониторинг хийж, тэдний хөл, хөдөлгөөн, зан төлөвийн шинж чанарыг таниж мэдэхийн тулд судалгааны хөтөлбөр гаргажээ. Энэхүү судалгаа нь асуулт хариулт болон GPS-ийн тусламжтай судалгааны хоёр аргыг хослуулан ашигласан ба мэдээлэл цуглуулах, судалгаа бөглүүлэх, мэдээлэл нэгтгэх гэсэн гурван хэсэгт хуваагджээ.

2012 оны 6-р сард 11 өдрийн туршид БЦГ-ын нэвтрэх хаалга дээр бүртгүүлэхээр зогсох жуулчдаас санамсаргүй аргаар сонгон, сайн дураараа санал асуулга бөглөхийг урьжээ. Тэдэнд төслийн зорилгын талаар танилцуулж, нийгэм хүн амзүйн энгийн асуултууд бөглөхийг урьсан байна. Дараа нь судалгаанд оролцогч бүрт GPS төхөөрөмж өгч, аялалынхаа туршид биендээ байршуулж, буцаж гарахдаа үлдээн явахыг хүссэн байна.

Дараа нь GPS-ийн төхөөрөмжүүдээс мэдээллүүдийг хуулбарлан авч дүн шинжилгээ хийсэн ба нийтдээ 112 аялагчдад төхөөрөмж өгсөнөөс бүгд буцааж хүлээлгэн өгсөн байдаг. GPS дэх мэдээллийн өгөгдөл нь аялагчдын төрөлтэй нягт холбогдсон асуулт дээр суурилсан судалгаатай холбогдсон бөгөөд хамгийн их хүн очдог газар, дуртай маршрут, тухайн цэг тус бүрт зарцуулсан хугацаа, туулсан зай, аялалын хурд зэрэг мэдээллүүдийг цуглуулжээ. GPS-ийн мэдээллийг Прухоник ТХГН-ийн явган аялалын жим, үзэсгэлэнт газрууд, байгууламжууд бүхий газарзүйн мэдээллийн системд оруулжээ. Ингэснээр аялагчдын хүсэмжит маршрут, сонирхол, зан төлөвт тааруулсан боломжит аялалыг зохион байгуулах боломжийг олгожээ.


Цогцолборт газрын хамгийн их ашиглагддаг газар нь нэвтрэх хаалганы ойр орчимд байсан бөгөөд бүхий л төрлийн аялагчид 1-2 цаг өнгөрөөхдөө дунджаар 4.2 км явган аялаад гардаг ажээ. Аялагчид хамгийн олноор зочилсон газар нь эртний үеийн цамхаг, цөөрөм болон ботаникийн цэцэрлэгт хүрээлэн бүхий соёл, байгалийн өвийн газрууд байв. Ийнхүү хүмүүс хамгийн ихээр төвлөрч, хэт ачаалал бий болгож, байгальд хүний үйл ажиллагаанаас сөрөг нөлөө учирч болох газруудыг таниж мэдсэний дүнд, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломж олгожээ.

Эх сурвалж: Průhonice Park, 2017

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Ямар үнэ цэнийг хамгаалж буйгаа ойлгосны үндсэн дээр үйл ажиллагаагаа тодорхойлж, менежментийн тохирох арга зүй, практик туршлагуудыг хэрэглэдэг байх.

График 4.2. IUCN-ийн веб хуудас дээрхи Дэлхийн өвийн газрууд програмын хэрэглэгчийн хэсэг



Эх сурвалж: <http://www.worldheritageoutlook.iucn.org/>

нэгтгэх маягаар гаргаж болдог. Дунд болон өндөр өртөг бүхий мониторингийн хөтөлбөрүүдэд байршил тогтоогч (GPS), халууныг мэдрэгч камер, уртын хэмжүүр, хөрсний дээж авагч, ургамлын нягтшил хэмжигч зэрэг хээрийн судалгааны багаж, тоног төхөөрөмж шаардлагатай болдог.

Мөн амралт, зугаалгын газруудад зориулсан гарын авлага, баримтлах үйл ажиллагааны заавруудыг боловсруулж өгчээ (Cole, 1989) (албан ба албан бус) (Marion and Wimpey, 2011).

Экологийн үр дүнтэй хяналт нь өртөг харьцангуй өндөртэй байдаг. Жишээлбэл цэвэрлэсэн бохир усыг экологийн хувьд чухал ач холбогдолтой голын урсацруу орхдох гарах үр нөлөөг нь тогтоохын тулд бүтэн жилийн турш мониторинг шинжилгээ хийх хэрэгтэй болдог. Үүнд булингартал, азот, фосфор гэх мэт эрдэсийн бүтэц, савханцар, паразит гэх мэт микробиологийн бүтэц, ховор загас, хавч хэлбэртэн зэрэг амьтдын тоо толгойг тоолох зэрэг орно. Эдгээр үзүүлэлтүүдийг тодорхой төлөвлөсөн хяналтын цэгүүд ба цутгал хэсэг зэрэг тодорхой талбайд хэмждэг. Энэ ажлыг гүйцэтгэх нэг арга нь мэргэжилтнүүдтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлэх явдал юм. Тухайлбал Жангжижие Байгалийн Цогцолборт Газарт (БНХАУ) ТХГН дахь голын эх, адаг дагуу байгуулах аялагчдын ариун цэврийн байгууламжуудад дээрхи бүх үзүүлэлтүүдээр мониторинг хийхийн тулд чанарын мониторингийн лаборатори байгуулж, ажиллуулахаар ойролцоох их сургуультай гэрээ байгуулсан байдаг.

Тархалтын нөлөөний мониторинг хийх нь нэлээд хүндрэлтэй байна. Тухайлбал ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагааны санамсаргүй нөлөөллөөр тархсан биологийн шинэ зүйлүүдэд мониторинг хийхийн тулд амьтан, ургамлын төрөл зүйлийн талаар сайн мэдлэгтэй хээрийн судлаачид ажиллаж, унаган бус амьтан,

ургамлын төрөл, зүйл бий эсэхэд нууц шатанд нь байхад нь ч болтугай нарийн ажиглалт хийж, таниж тодорхойлох шаардлагатай болдог. Дор дурьдсан дөрвөн жишээ энэхүү ажлын хэр хүнд хэцүүг ойлгоход дэм өгнө. Үүнд: (1) зэрлэгшсэн муур, нохой, үнэгийг зөвхөн алсан амьтдынх нь сэг, эсвэл бааснаас нь таниж мэддэг; (2) зэрлэгшсэн харх, хулгана байгаа эсэхийг зөвхөн байнгын хавх тавих аргаар судалсанаар хяналтаас хэтэрсэн тоо толгойд хүрсэн эсэхийг тогтоодог; (3) харь зүйлийн ургамлыг цэцэглэж, үрээ тараах хүртэл нь илрүүлэх боломжгүй байдаг; (4) өвчин үүсгэгч жижиг организмуудыг олон зүйлийн унаган ургамал, амьтнуудад өргөн тархсан хойно л олж тогтоох магадлал өндөртэй байдаг гэх мэт. Хүний боловсруулаагүй өтгөн шингэн байнга хаягдаж байдаг далай, тэнгисийн тусгай хамгаалалттай газарт дээрхи шинж тэмдгүүдэд хяналт тавьж илрүүлхэд бүр ч түвэгтэй байдаг.

Нутгийн иргэдэд гарч буй нийгмийн нөлөөллийг хянах нь аялагчдын нөлөөллийн мониторингийн чухал хэсэг юм. Аялал жуулчлалын нөлөөллийн талаархи санал сэтгэгдэлийн хэмжүүр нь иргэдээс аялал жуулчлалд гаргадаг олон төрлийн хувьрал, зан төлөвийг хэмждэг шалгуур үзүүлэлтээс тогтдог. Үүнд: оршин амьдарч буй газар, эдийн засгийн аялал жуулчлалын хамаарал, иргэдийн оршин буй газраас орших эдийн засгийн төвийн алслагдмал байдал, аялал жуулчлалын шийдвэр гаргалтанд иргэдийн оролцоох байдал, төрсөн газар, мэдлэгийн түвшин, жуулчидтай холбоо харилцаа тогтоох түвшин, хүн ам зүйн шинж чанарууд, аялал жуулчлалын хөгжлийн түвшин, амрах, зугаалах үйл ажиллагаанаас орон нутагт орох үр нөлөөний талаархи төсөөлөл болон нутгийн иргэдийн хөгжил зэрэг орно (Lankford and Howard, 1994).

Аялагчдын ашиглалт болон нөлөөлөлтэй холбоотой шалгуур үзүүлэлт тус бүрийг хэрхэн хэмжих, ямар арга зүй ашиглах талаар ТХГН-н менежерүүд зориулсан хэд, хэдэн гарын авлагууд бий. Үүнд: Аялагчдын Ашиглалтын

Шигтгээ 4.7

Төлөвлөлтийн явцын жишээ: Пон На Ки Бан БЦГ (Вьетнам улс)



Фонг На Ха Хи Банг БЦГ-ын зүүн талаас нэвтрэх хэсгийн дэлгэмэл зураг (Зүүн гар талд). © Li Migura. Олон талын оролцоот төлөвлөлтийн уулзалтын хурал (Баруун гар талд). © Maximilian Roth

Фонг На Хе Банг БЦГ нь Вьетнам улсын төв хэсэг Кунг Бин мужийн нутагт оршдог. 2003 онд тус БЦГ-ын геологи, геоморфологийн дахин давтагдашгүй шинж чанар, үнэт шохойн чулуу, агуйн системийн ач холбогдлыг үнэлэн ЮНЕСКО-ийн Дэлхийн өвд бүртгэжээ. Дэлхийн өвд бүртгэгдсэнээр Кунг Бин мужийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тусалсан төдийгүй 1999 онд 80,000 аялагчидтай байсан бол 2012 онд 400,000 аялагч болж өсчээ.

Маш хурдацтай хөгжиж байгаа аялал жуулчлалын өсөлт нь тухайн бүс нутгийн экосистем болон байгалийн нөөцөд түшиглэн ТХГН-ийн орчны бүсэд амьдарч буй нутгийн иргэдэд ирэх дарамтыг нэмж иржээ. 2007 онд Вьетнам улсын Засгийн газар, Холбооны бүгд найрамдах Германы улсын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамтай (BMZ) хамтран БЦГ болон онгон бүсийн 13 нөхөрлөлийн 157 өрхөд чиглэсэн төслийг хэрэгжүүлж эхэлжээ. Төслөөр ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, биологийн олон янз байдал болон экосистем, нутгийн иргэдийн амьжиргааг тогтвортой дэмжих, бүс нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг зорьсон байна.

Эрх эзэмшигчид болон оролцогч талуудын тусламжтайгаар оролцооны аргаар Тогтвортой Аялал Жуулчлал 2010-2020 төлөвлөгөөг боловсруулж гаргасан нь орон нутаг болон мужийн түвшинд төлөвлөгөө боловсруулах гол хэрэгсэл болж байна. Үүний цаана төрийн захиргааны байгууллагууд, БЦГ-ын менежерүүд болон нутгийн иргэдийн хооронд нягт хамтран ажилласан нь ийнхүү нэгдсэн төлөвлөгөөн дээр санал нэгдэж гаргах боломжийг бүрдүүлсэн ажээ.

Эх сурвалж: GIZ, 2014; Hübner, et al., 2014; GIZ, 2015a; GIZ, 2015b

Менежментийн Зөвлөлийн Шалгуур, Босго Үзүүлэлт, Мониторингийн Агентлаг хоорондын гарын авлага (<https://visitorusemanagement.nps.gov/VUM/Framework>), АНУ-ын ТХГН-ийн үйлчилгээний шалгуур үзүүлэлт, стандартуудын мэдээллийн сан (<https://usercapacity.nps.gov/search.aspx>) зэрэг орно. Шигтгээ 4.4-т АНУ-ын Есөметигийн Байгалийн Цогцолборт Газар-т хэрэгжүүлж буй аялагчдын ашиглалт ба нөлөөллийн мониторингийн жишээг үзүүлэв. Энэ хөтөлбөр нь БЦГ-ын аялагчдын үйл ажиллагаа-ашиглалт болон нөөцийн хамгаалалтын хамрах хүрээнд боловсруулсан дасан зохицох менежментийн загвар дор хэрэгжүүлдэг аялагчдын ашиглалтын төлөвлөлтийн үйл ажиллагааг дэмжиж өгдөг (АНУ-н ТХГН-н Хамгаалалтын Захиргаа, 1997).

Аялагчдын авах үр өгөөжийн мониторинг

ТХГН дахь тогтвортой аялал жуулчлалын нэгэн чухал шалгуур үзүүлэлт бол аялагчийн авах үр өгөөж билээ (McCool, 2006). Аялагчдын санал хүсэлт, аялагчдын бүртгэл, сошиал медиа дээр өгсөн аялагчдын албан бус мэдээлэл нь тэдний олж авдаг үр өгөөжийн талаар зарим мэдээллийг өгдөг боловч хэт нэг талыг барих магадлалтай байдаг.

Мониторингийг илүү системтэй хийхийн тулд газар дээр нь, ихэвчлэн мэдээллийн төвүүд, аялагчдын төвлөрдөг гол газруудад судалгаа бөглүүлэх явдал юм. Мөн гэртээ харьсаных нь дараа шуудан захидлаар, электрон шуудан эсвэл интернэтээр судалгаа авах боломжууд нээлттэй байдаг. Шигтгээ 4.5 болон 4.6-д Канад, Чех улсуудын аялагчдын авсан үр өгөөжийн талаар чанарын мониторинг хийсэн жишээг үзүүлэв.

Хүснэгт 4.2. ТХГН-ийн Аялал жуулчлалын менежмент дэхь нутгийн иргэдийн оролцооны хэлбэрүүд

Төрөл	Хэлбэрүүд
Удирдлагын түвшний оролцоо	Дүр эсгэсэн хэлбэр: Шийдвэр гаргах боломжгүй хүмүүс.
Идэвхгүй оролцоо	Хүмүүс аль хэдийнэ шийдчихсэн эсвэл тохиолдсон зүйлс.
Зөвлөхийн оролцоо	Хүмүүс зөвлөгөө авах эсвэл асуултанд хариулах хэлбэрээр оролцох. Үйл явц нь ямар нэг дундын шийдвэр гаргахыг зөвшөөрдөггүй. Хүмүүсийн үзэл бодлыг тусгахын тулд мэргэжлийн хүний шаардлага байхгүй.
Эд материалын сонирхолтой оролцоо	Хүмүүс ямар нэгэн нөөцийг дэмжлэг хэлбэрээр өгч буцаагаад нөхөн төлбөр, хоол хүнс, бэлэн мөнгө болон бусад эд материал авах оролцоо. Хүмүүс ямар нэгэн урамшуулал дуусахад дахин оролцох сонирхолгүй байх.
Үйл ажиллагааны оролцоо	Төслийн зорилгод хүрэхийн тулд ямар нэгэн гадны дэмжлэг, оролцоо хэрэгтэй; жишээлбэл хамтарсан шийдвэр гаргах, гэхдээ гадны байгууллагуудын томоохон шийдвэр гарсан тохиолдолд.
Идэвхтэй оролцоо	Хүмүүс хамтарсан төлөвлөгөө гаргах, дүн шинжилгээ хийхэд оролцдог. Оролцоонд харилцах суралцах үйл явцыг оролцуулах.
Өөрийгөө дайчилж оролцох оролцоо	Хүмүүс гадна байгууллагаас гаргасан санаачилгыг бие даасан хэлбэрээр дэмжих. Тэд нөөцийн ашиглалт, гарах шийдвэрт хяналт тавьдаг.

Эх сурвалж: Pretty, 2005

Шигтгээ 4.8

Казакстан дахь нутгийн иргэдийн дунд ТХГН-ийн тухай ойлголтыг өөрчлөхөд Алматы БНГ-ын гүйцэтгэж буй үүрэг

Алматын Байгалийн нөөц газар нь 71,700 га газрыг хамарсан, Алатау уулын хойд хэсэг, Тань Шаны нуруунд оршдог. БНГ-т 1,100 зүйлийн дээд ургамал, үүнээс 50 орчим зүйлийн ургамал нь ховорт тооцогдох ба 26 нь Казакстан улсын улаан номонд орсон нэн ховор зүйл юм.

1931 онд байгуулагдсанаасаа хойш БНГ нь нутгийн иргэдэд хаалттай, зөвхөн судалгаа шинжилгээ хийх зорилготой судлаачид, сургуулийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд ирсэн зочдыг хүлээн авдаг байжээ. Зөвхөн хадгалж, хамгаална гэсэн арга барил нутгийн иргэдийн дунд сөрөг байр суурийг бий болгосон байжээ. Учир нь үүний урьд нутгийн иргэд тус газраас байгалийн нөөц болох жимс, жимсгэн, мөөг зэргийг түүж хэрэглэдэг, амжиргаанд нь ихээхэн нэмэртэй байв.

Нутгийн иргэдийн хандлагыг сайжруулахын тулд нөөц газрын ажилчид байгаль хамгаалал, боловсрол болон олон нийтийн харилцааг нэмэгдүүлэх стратеги боловсруулжээ.

Байгаль хамгаалах стратеги нь Трансил Алатау уулын экосистем, түүний амьтан, ургамлын төрөл зүйлийг хамгаалахад чиглэгджээ. Боловсролын стратегийн хүрээнд Талгар дахь орон нутгийн сургуулиудтай нягт хамтран ажиллаж эхэлсэн байна. Олон нийтийн харилцааны стратегийн хүрээнд “Паркын төлөөх марш” , олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамрах, нийтэд зориулсан тараах материал, танилцуулга, брошут хэвлэх зэрэг санал санаачилгуудыг гаргажээ.

10 гаруй жилийн үйл ажиллгааны үр дүнд нутгийн иргэдийн 50 орчим хувь нь тухайн нөөц газрын талаар эерэг хандлагатай болж, Алматын Байгалийн нөөц газрыг сайнаар ярьдаг болсон байв. Цаашдын төлөвлөгөөнд хариуцлагатай эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, боловсролын хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, дэлхийн ТХГН-ийн хамгаалалтын захиргаанууд болон дээд боловсролын байгууллагуудтай түншлэлийн харилцаа тогтоох зорилтууд тавин ажиллаж байна.

Эх үүсвэр: Dzhanyspayev, 2006



Байгалийн нөөц газрын сургагч багш хүүхдүүдэд ховор ургамлын зүйлийг Байгалийн Түүхийн музейд танилцуулж байгаа нь © Alexandra Vishnevskaya

Менежментийн үр ашигт байдлын мониторинг

ТХГН дахь менежментийн үйл ажиллагаа үр дүнтэй байгаа эсэхийг үнэлж цэгнэх нь ач холбогдолтой болохыг сүүлийн үед улам их хүлээн зөвшөөрч иржээ. Олон улсын байгаль хамгаалах холбоо (IUCN)-ийн WCPA-ийн зүгээс зургаан элементээс бүрдсэн үнэлгээний аргачлалыг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх нарийвчилсан гарын авлагын хамт гаргасан бөгөөд аялал жуулчлал, аялагчдын талаархи үзүүлэлтүүд нь чухал шалгуур болж болох юм (Hockings, et al., 2006). Эдгээр шалгуур үзүүлэлтүүдэд

аялал жуулчлалтай холбоотой хууль эрхзүй, бодлогын орчин, засаглал, дэд бүтэц, аялагчдын менежментэд дэм болох нөөц, менежментийн үйл ажиллагааны үр өгөөж зэрэг зүйлс багтна. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлгээг давтан хийх нь ТХГН болон түүний системийн түвшинд аялал жуулчлал болон аялагчдын менежментийн гүйцэтгэлд мониторинг хийх арга хэрэгсэл болдог байна.

Дээрхийн мөн адил IUCN-ны Дэлхийн өвийн хөтөлбөрийн хүрээнд гаргасан Байгаль Хамгааллын Хэтийн Төлөв-ийн дагуу Дэлхийн өвд орсон газруудын одоогийн байдал, хамгаалалт, менежментийнх нь үр дүнтэй байдал,

Шигтгээ 4.9

БНХАУ-ын Жиужайгоу Цогцолборт Газрын мэдээллийн технологийн ашиглалт



Жиужайгоу хөндийн ТХГН-т байдаг хүрхрээ, БНХАУ. © Chengzhao Wu

Жиужайгоу хөндий (Хятад хэлэнд “Есөн тосгоны хөндий” хэмээх) нь БНХАУ-ын Сычуань мужид оршдог. Энэхүү хөндий нь 720 км² талбайд сунаж тогтсон бөгөөд орчны бүс нь 598 км² талбайг эзэлнэ. Жиужайгоу хөндийн үзэсгэлэнт нутаг нь нарийхан конус хэлбэртэй газрын хэв маяг, цэнхэр, ногоон өнгөтэй галт уулын гаралтай нуурууд болон гайхалтай хүрхрээгээрээ алдартай юм. Энд мөн нэн ховордсон ургамал, амьтны зүйлийн амьдрах орчин бөгөөд Хятад дахь Аварга панда (*Ailuropoda melanoleuca*) -ны хамгаалагдсан арван гурван газрын нэг юм. 1992 онд Жиужайгу хөндийн байгалийн цогцолборт газар (IUCN-ны 5-р категори) нь ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн дурсгалт газарт бүртгэгджээ. Өдгөө Хятад дахь жуулчид хамгийн ихээр очдог Дэлхийн өвийн дурсгалт газар бөгөөд аялал жуулчлалын менежментийг хэрхэн зөв авч явах тал дээр багагүй асуудлууд гаргаж буй газар ажээ.

БЦГ-ын менежмент ба аялал жуулчлалыг дэмжихийн тулд орчин үеийн мэдээлэл технологийг ашиглаж эхэлсэн байна. GIS (Газарзүйн мэдээллийн систем), RS (Зайнаас тандан судлал), GPS/GNSS (Байршил тогтоогч хиймэл дагуулуудын систем), RFID (Радио үелэл тогтоогч), EB (Электрон Бизнес/Арилжаа) болон VR (Виртуал реалити) зэрэг хэд, хэдэн байршил тогтоох, харилцаа холбооны дэвшилтэт техник, арга хэрэгслүүдийг хамтатган ашиглах байдлаар мэдээлэл цуглуулж, ашиглах, бодлого тодорхойлох сувгуудыг бий болгожээ. Энэхүү сувгийг ашиглан бизнес үйл ажиллагаа, олон нийтийн харилцааг сайжруулах, жишээ нь жуулчдын улирлын ид ачааллын үед хэт бөөгнөрөл бий болохоос сэргийлэх зэрэгт ашиглаж байна. Мөн дээр нь нөөц газар дахь экосистемийн өөрчлөлтөнд цаг алдалгүй мониторинг хийснээр болзошгүй байгалийн гамшгийн талаархи мэдээллийг түргэн шуурхай тарааж, яаралтай арга хэмжээг илүү үр дүнтэй төлөвлөх болжээ.

Эх үүсвэр: IUCN, 2017e

болзошгүй аюул занал зэрэгт мониторинг хийдэг (IUCN, 2014). Тухайн газар нутгийн ангилал болон үйл ажиллагааны тайланг Дэлхийн Өвийн Хэтийн Төлөв цахим хуудаснаас авч ашиглах боломжтой (тахирмаг 4.2). Уг тайлангуудыг Дэлхийн өвд бүртгүүлсэн байхын ач холбогдол, байгаль хамгааллын талаар холбогдох эрх эзэмшигчид болон хамаарагч талууд ухуулан таниулахад мөн ашигладаг (IUCN, 2012a; IUCN, 2014; IUCN, 2017b).

4.2 Наймдугаар зарчим: Шийдвэр гаргахдаа техникийн шинж чанартай болон үнэт зүйлсийн шинж чанартайг ялгаж салгадаг байх

Энэхүү зарчим нь бид аялал жуулчлалын менежментийг хэрхэн зөв төсөөлж, ойлгодогийг харуулж өгнө. Бидний гаргадаг дийлэнх шийдвэрүүд нь техникийн асуудал

Шигтгээ 4.10

Аялагчдад Дэлхийн өвийг сурталчилан таниулах нь: Гунунг Мулу Байгалийн Цогцолборт Газар, Малайз улс



Дэлхийн Өвийн логог байршуулсан байдал (зүүн талд) ҮЦГ-ын хамгаалалтын захиргааны байрны гадна байршуулсан байдал (баруун талд). © Lisa M. King

2000 онд байгуулагдсан Гунунг Мулу үндэсний БЦГ нь Малайзын Борнео дахь Саравак мужын хойд хэсэгт оршдог, нийт 52,864 га талбай бүхий Дэлхийн Өвд бүртгэгдсэн нутаг юм. Гунунг Мулугийн цогцолборт газарт нь олон төрлийн карстын тогтоцтой шохойн чулуун цамхагуудтай, уужим зай бүхий агуйтай. Тэр нь 295 км гаруй урт судлагдсан агуйн цооногуудтай ажээ. Энэхүү БЦГ-ын ургамалжилтын 17 бүсэд нь 3,500 зүйлийн ургамал ургадаг бөгөөд “Нарны” гэх ховор баавгай (*Helarctos malayanus*), “Толбот” ирвэс (*Neofelis diardi*), Панголин (*Manis javanica*) болон Эвэр хошуут шувуу (олон зүйлийн) зэрэг ан амьтад, шувуудын биологийн төрөл зүйлүүдтэй.

Дэлхийн өвийн хаягжилттай байгаль хамгааллын үйл ажиллагаа нь Малайз улсын хувьд харьцангуй шинэ зүйл юм. Хамгийн анхны хоёр газар нь Дэлхийн өвд 2000 онд бүртгэгдэж байжээ. Ихэнх Малайзчууд Дэлхийн өв гэж юу болох, юуг илэрхийлдэг талаар мэдлэггүй байдаг. Гунунг Мулугийн менежментийн зүгээс энэ талаар “брэндинг”-ээ сайн хийж, харилцаа холбооны цогц стратеги боловсруулах ажлууд хийж байна. Жишээлбэл орох хаалга болон цогцолборт газрын энд тэндгүй байрлах тайлбарлан мэдээлэх самбарууд дээр Дэлхийн өвийн таних тэмдэгийг тод, томруунаар байрлуулжээ. Дэлхийн өвийн лого нь тус улсын ТХГН-ийн логонд багтдаг бөгөөд жуулчдыг хүлээн авах байрны хажууд тод томруунаар тавигдсан байдаг. Дэлхийн өвийн логог ажилтнуудын хувцас дээр хадаж, гарын авлагын материалуудад тогтмол оруулжээ. Мэдээлэн тайлбарлах самбарууд дээр Дэлхийн өв ба Цогцолборт газрын бүх нийтийн эрхэм үнэ цэнийн талаархи мэдээллийг тавьж, хэд хэдэн газарт тараан байрлуулсанаар аялагчдад хүрч, мэдээлэл, ойлголт өгөх боломжийг нэмэгдүүлдэг ажээ.

Гунунг Мулугийн БЦГ нь мөн бодит байдал дээр аялагчдын сэтгэлийг хөндөх, Цогцолборт Газрын Бүх Нийтийн Эрхэм Үнэ Цэнийг мэдрүүлж ойлгуулахад чиглэсэн дэлхийд хүлээн зөвшөөрөдөг загвар шийдэл бүхий барилга, байгууламжуудыг суурилуулсан байдаг. Мулугийн Дүүжин Гүүрнүүд нь ЦГ-ын зүгээс аялагчдад шинэ үр өгөөж өгөх, ойлголт төрүүлэх зорилгоор хийсэн ажлын нэг юм. Жуулчдын ухамсар, Дэлхийн Өвийн талаархи мэдлэгийг дээшлүүлж, хийж буй ажлынхаа талаар эерэг сэтгэгдэл төрүүлэх нь ТХГН-ийн тогтвортой хөгжлийг хангахад чухал хувь нэмэр оруулах аялагчдын зөв хандлагыг төлөвшүүлдэг байна.

Эх сурвалж: King, et al., 2012; King, 2013; UNESCO, 2017a; UNESCO, 2017b

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Аялагчдад дэлхий дахинд болж буй ижил төстэй асуудал бэрхшээлүүд, боломжтой үед байгаль хамгаалалд тулгарч буй асуудлуудыг ойлгуулан тайлбарлах замаар асуудлын өргөн тал, хүрээг ойлгуулж байх.

шийдэх шинж чанартай байдаг. Жишээлбэл жимээ хаагуур гаргах, газрын зураг дээр хэрхэн тэмдэглэх вэ гэх мэт. Өнгөцхөн харахад энэ нь техникийн чанартай шийдвэр мэт харагдавч бид дотроо баримталдаг үнэ цэн дээр түшиглэж байгаа юм. Жишээлбэл жим хийх газар сонгохдоо ховор ургамалыг хүний хөлд өртөөхгүйн тулд өөр газраар төлөвлөх шийдвэр гаргаж болно. Аливаа

техникийн шинж чанартай шийдвэр болгоны цаана үнэт зүйлсийн шинж чанар агуулагдаж байдаг байна. Хүний үнэт зүйлс нь шийдвэр гаргалтын цаана байдаг гол зүйлс бөгөөд хамгаалалттай газрын менежерүүдэд ч энэ нь хамаатай. Менежерүүдийн хувьд дагаж, биелүүлэх ёстой үнэт зүйлсийг хууль эрхзүй, дүрэм журам, бодлогод тусгаж өгсөн байдаг. Дээрхи үнэт зүйлсийг хэрэгжүүлэх

Шигтгээ 4.11

Перу улсын ТХГН-ийн Үндэсний Сүлжээн дэхь мэдээлэн тайлбарлах төвүүд



Мэдээлэн таниулах төвийн танин мэдэхүйн самбар
© Jorge Chávez

болгох зэрэг орно

Мэдээлэн тайлбарлах төвүүдийг зочдод мэдээллийн технологи болон бусад үндсэн эх үүсвэрүүдийг ашиглан мэдлэг, мэдээллийг энгийн, уян хатан, үзүүлэн таниулах арга замаар таниулах зорилгоор байгуулжээ. Жишээлбэл Паракасын БНГ -ын өмнөд эрэг дээр орших мэдээлэн тайлбарлах төв нь 335,000 га талбайтай нөөц газрын түүх, геологи, палеонтологи, далай тэнгис, биологи, нийгэм эдийн засгийн ач холбогдолыг харуулсан мэдээллийн дэлгэцүүд байрлуулсан. Мэдээлэн тайлбарлах үйл ажиллагаанд видео өрөө, далайн амьтдыг бодит хэмжээгээр дүрсэлсэн чихмэлүүд, зурагт хуудас, фото зургууд, тухайн газар үе, үе болдог паракас хэмээр хуй салхины чимээг гаргадаг гайхамшигтэй салхин түннел, одоо байгаа биологийн төрөл зүйл, тэдгээрийн нутгийн иргэдтэй хэрхэн харилцаанд орж буй тухай видео дүрс, дуу бичлэгүүдийг ашигладаг. Энэхүү мэдээллийн төвийн боссон өртөг нь \$800,000 бөгөөд үүнийг Испани улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгтэйгээр барьжээ. Энэ бол байгаль орчны ач холбогдлыг мэдээлэн тайлбарласан Перу улсын шилдэг жишээ юм.



Паракас дахь Үндэсний мэдээллийн төв. © Jorge Chávez

Перу улсын ТХГН-ийн сүлжээ нь 22 сая гаруй га буюу улсынхаа газар нутгийн бараг 17 хувийг хамарсан байгалийн өвийн чухал хэсэг юм. ТХГН-ийн гол зорилго нь байгалийн олон янз байдлын төлөөлөл болсон амьтад, ургамлыг хадгаж, хамгаалах явдал юм.

ТХГН-ийн сүлжээний зорилго нь тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ сөрөг үр нөлөөг нь хамгийн бага түвшинд барих явдал юм. Хамгаалалттай газрын захиргааны зорилттой уялдуулсаны үндсэн дээр аялал жуулчлалыг олон нийтийг ТХГН-т аялахад нь дэмжлэг үзүүлэх арга хэрэгсэл гэж үздэг. Энэ үүднээс аялал жуулчлал эрхэлхэд гаргасан удирдамж дотор олон чухал заалт орсон бөгөөд жишээ нь үйлчилгээний чанар, өрсөлдөх байдлыг хангахдаа нийгэм, байгаль орчны талаархи наад захын стандартуудыг дагаж баримтлах; байгаль орчны талаарх мэдлэгийг хөгжүүлэх замаар байгаль, соёлын нөөцийн талаархи мэдлэгт хувь нэмэр оруулах; ТХГН-уудад орлого бий

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА:

Байгаль орчны боловсрол олгох, мэдээлэн тайлбарлах хөтөлбөрүүдэд ТХГН-ийн ямар үнэт зүйлсийг сонгохоо стратегийн төвшинд төлөвлөж, тэдгээрийг ТХГН, түүний харьяалагдах системийн ерөнхий зорилго, зорилтуудтай нийцүүлэх.

менежерүүдийн үйл ажиллагаанд техник тоон үзүүлэлт, мэдээллийн бааз нь чухал үүрэгтэй байна. Гаргаж буй шийдвэрүүдийн техникийн чанартай тал, үнэт зүйлсийн холбогдолтой агуулгуудыг тодорхой ялгаж салгаж байх нь гаргаж буй шийдвэрүүдийн зорилго, ач холбогдлыг илүү тодорхой болгож өгч байгаа хэрэг юм.

4.3 Есдүгээр зарчим: Хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэгдсэн байр суурь ба түншлэл шаардлагатай учир хамааралтай талуудын оролцоог хангах

ТХГН дахь тогтвортой аялал жуулчлалд түншлэлийн харилцаа чухал байр суурь эзэлдэг. Түншлэлийн харилцааг амжилттай хөтлөхийн тулд менежерүүд дараах зүйлсийг хийж хэрэгжүүлэх ёстой. Үүнд:

1. Бүх түншүүд үүрэг, хариуцлагаа шийдэж, ойлгож, хүлээн зөвшөөрч, бичгээр баримтжуулсан байх;
2. Бүх оролцогчид үүрэг, амлалтаа адилхан биелүүлдэг байх;
3. Түншлэл нь харилцан ашигтай байх;
4. Түншлэлийн амжилт, ач тусыг үнэлэх механизмтай байх;
5. Нээлттэй, шударга харилцаа нь нэн тэргүүний зорилт байх.

ТХГН-ийн хамгаалалтын захиргаанууд, төрийн бус байгууллагууд, уугуул оршин суугчид, нутгийн иргэд болон хувийн хэвшил хоорондын түншлэл нь тун үр өгөөжтэй байж болох боловч мөн бүлэг тус бүр өөр, өөрийн зорилготой, түүндээ хүрэх өөр, өөр арга замтай тул амаргүй зүйлс тулгардаг. Менежментийн төлөвлөгөө, үйл ажиллагааг боловсруулахдаа оролцоог хангаснаар оролцогч талууд болон нутгийн иргэдийн хооронд үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгож болдог.

Аялал жуулчлалын түншлэлийн талаархи тусгай удирдамжууд байдаг. Жишээлбэл Канадын Аялал Жуулчлалын Коммиссоос тусгай хамгаалалттай газар нутгууд, тур операторуудын түншлэлийн шилдэг арга туршлагын талаар удирдамж гаргасан нь дэлхийн бусад орнуудад ижил төстэй баримт бичиг гаргах сайн жишээ болж байна (Pam Wight ба Associates, 2001).

Хамтын оролцоотой төлөвлөлт ба нутгийн иргэдийн оролцоо

Тогтвортой аялал жуулчлал болон аялагчдын менежментийн төлөвлөлт нь олон тооны үе шатуудтай байдаг бөгөөд уугуул овог аймгийнхан, нутгийн иргэд зэрэг олон тооны эрх эзэмшигчид, оролцогч талуудын оролцоог хангах шаардлагатай болдог (Шигтгээ 4.7). Шилдэг туршлагауудын талаархи нэмэлт жишээнүүдийг Melenhorst, et al. (2013)-ийн бүтээл болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс авч үзэж болно (GIZ, 2014).

Хамтын оролцоотой төлөвлөлт хийх нь иргэдийн хооронд ойлголцлыг бэхжүүлж, аялал жуулчлалаас гарах эерэг, сөрөг үр дагаварт хариу арга хэмжээ авах, менежмент хийхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ аялал жуулчлалын менежментийн чиглэлээр нутгийн

иргэдтэй бодитоор, ханасан хэмжээнд хамтран ажиллах нь хамтын оролцоотой менежментээр хүрэх олон үр дүнгийн зөвхөн нэг нь гэдгийг ойлгох нь зүйтэй. Нутгийн иргэдийг “шууд” бус хэлбэрээр, эсвэл бүр зориуд арга, мэх хэрэглэн оролцуулж ч болдог. Төлөвлөлтийг хамтран хийж, гүйцэтгэхэд жинхэнэ бодит хамтын ажиллагааны бүтээлч, олон талт харилцааг шаарддаг (Хүснэгт 4.2).

4.4 Аравдугаар зарчим: Тогтвортой хөгжлийн талаархи мэдээлэл түгээж, дэмжлэг авахад харилцаа холбоо онцгой чухал

Тогтвортой аялал жуулчлалыг дэмжиж ажиллахад ТХГН-ийн менежерүүдэд мэдээлэл харилцааны тодорхой стратегитай байх хэрэгтэй болдог. Зорилтот бүлгээ тодорхойлж, юуны талаар ойлголцож, харилцах гэж байгаа тэр сэдэв, хэлэх санаа, үг яриагаа бэлтгэх хэрэгтэй байдаг. Эргэх холбоо нь санал сэтгэгдлийг ойлгож, хүлээн авсаныг баримтжуулан үзүүлдэг учир харилцаа холбоонд чухал ач холбогдолтой байдаг. Хамтрагч талуудын уулзалт, биечилсэн уулзалт зөвлөгөөнүүд, сошиал медиа болон онлайн груп хэлэлцүүлэг зэрэг нь харилцаа холбооны чухал хэсгүүд юм. ТХГН-ийн мэдээллийн самбарууд, цахим хуудас, тогтмол хэвлэл, брошур зэрэгт энгийн, тодорхой үг хэллэгээр мэдээлэл оруулах нь бичгэн харилцаа холбоонд чухал ач холбогдолтой байдаг. Шууд бус харилцаа холбоо гэдэг нь ТХГН-ийн ажилтнуудын биеэ авч яваа байдал, гадаад төрх, дэд бүтцийнх нь тордолт зэргээр илэрхийлэгдэнэ. Хэрэв сайн гүйцэтгэж чадвал харилцаа холбоо нь ТХГН-ийн байгаль хамаалал болон менежментийн үйл ажиллагаанд олон нийтийн дэмжлэгийг авч ирдэг (Шигтгээ 4.8 үзнэ үү).

Мэдээллийн технологийг ашиглах

Байгаль хамгаалагчдыг хууль сахиулахад нь сансрын утас, GPS төхөөрөмж суурилсан ухаалаг гар утас, сансрын бусад төхөөрөмжүүд нь тус болдогийн дээр аялагчдад ТХГН-ийн алслагдсан бүсэд аюулгүй аялах боломжийг олгодог. Жишээлбэл Европод ашиглагддаг ВэбПарк хэмээх тусгайлан гаргасан аппликэйшн бий. Үүнийг аялагчид гар утсан дээрээ суурьлуулж тухайн ТХГН-ийн талаар, тухайлбал аялалын жим, цасны нурангын талаархи сэрэмжлүүлэг зэрэг мэдээллийг авч, шаарлагатай үед яаралтай түргэн тусламж авах боломжоор хангагддаг (Krug, et al., 2003). Хэдий ийм үйлчилгээ нь онгон байгальд аялах эрсдэл, аюулыг багасгадаг ч, аялагчид сонор сэргэмжээ алдаж, өөрсдийгөө эрсдэлтэй байдалд оруулах магадлалтайг судалгаагаар харуулжээ.

Цаашилбал, отоглох цэг, мэдээллийн төвүүдэд гар утас, интернетийн сүлжээ бий болгох нь ашигтай ч мөн сул тал бий нь харагдаж байна. Нэг талаас залуу хүмүүс интернет, сошиал медиа ашиглах боломжтой газар аав, ээжтэй хамт аялах магадлал өндөртэй байдаг. Гэвч гадаад ертөнцтэй байнга холбоотой байх нь нөгөө талаар байгалиас эрч хүч, нөхөн сэргэлт авах, хүмүүсийн өөр хоорондоо нийгэмших боломжийг үгүй хийх, биеийн хөдөлгөөн хөгжүүлсэн аялалд оролцох магадлалыг багасгаж орхидог байна.

ТХГН-уудад аялал жуулчлалын зохион байгуулалтанд ашигладаг технологи ч хөгжин дэвшиж байна (Шигтгээ 4.9), Тухайлбал Газарзүйн Мэдээллийн Системийн Аялагчид интернетийн тусламжтайгаар өөрсдийн дуртай

ТХГН-уудын тухай онлайн блогуудад оролцож, аялал зохион байгуулдаг вэбинаруудаар дамжуулан байгаль хамгааллын үйл ажиллагааг ажиглаж, сонгосон аялалаа хийх газраа 360 хэмийн харагдацтайгаар бодит цаг хугацаанд танилцаж, урьдчилан захиалга өгөх боломжтой болжээ.

ТХГН-ийн хамгаалалтын захиргаад олон нийтийн мэдээллийн сүлжээ болох Фэйсбүүк болон твиттерээр гал түймрийн дэгдэлт зэрэг яаралтай мэдээллийг шуурхай дамжуулж, ТХГН-ийг дэмжигчдийн нийтлэг сонирхолтой иргэдийн бүлгүүдийг үүсгэдэг болсон байна.

Боловсрол ба “мэдээлэн тайлбарлах” үйл ажиллагаа

Боловсрол болон мэдээлэн тайлбарлах үйл ажиллагаа нь ихэнх ТХГН-уудын гол зорилтууд болно. ТХГН-ууд нь байгаль, соёлын өвийн талаар мэдлэг олгож, байгаль хамгааллын талаар эерэг хандлагыг бий болгоход өндөр ач холбогдолтой байдаг. Үүнийг гүйцэтгэхэд боловсрол ба мэдээлэн тайлбарлах хөтөлбөрүүд нь гол үүрэгтэй бөгөөд мөн аялагчдын зан төлөв, түүний нөлөөллийг төлөвшүүлэх, хандлагыг сайжруулхад чухал холбогдолтой арга хэрэгслүүд юм. Шигтгээ 4.10-т аялагчдын Дэлхийн өвийн үнэт зүйлсийн талаархи мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн харилцаа холбооны болон боловсролын хөтөлбөрүүдийн жишээг оруулав.

Мэдээлэн тайлбарлах гэдэг нь үзэгчид хийгээд тэдний харж буй нөөц сурвалжийн утга агуулгыг ойлгуулж, сэтгэл хөдлөл, оюун санааны холбоос бий болгох харилцааны үйл явцыг хэлнэ (NAI, 2018). Хөтөчтэй аялалууд, мэдээллийн төвүүд, ном товхимолууд зэрэгээр дамжуулан сайтар гүйцэтгэж чадваас ихээхэн үр дүнд хүргэх ач холбогдолтой (Шигтгээ 4.11). Үүнтэй харьцуулхад боловсрол олгох үйл явц нь хувь хүний соёл, мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, ёс суртахуун, нийгмийн зан чанарыг нь хөгжүүлж буй үйл ажиллагаа юм.

Мэдээлэн тайлбарлах үйл ажиллагаа нь хувь хүний хувьд өмнө нь авсан байсан ойлголт, зан чанар, магадгүй сэтгэлийн гүнд нь орших утсыг нь хөндсөнөөр тухайн сэдэвтэй гүн, гүнзгий авцалдуулан холбож буй үйл явц юм. Ер нь ойлголтын төрлүүдийг ялгаж салгадаг байх нь ач холбогдолтой. Жишээ нь дараах төрлүүд байна. Үүнд:

- **Функционал** буюу “үндсэн утгыг нь мэдэх” – Үүнд “төрөл, зүйл”, “зэрлэг амьтад”, “биологийн олон янз байдал” зэрэг нэр томъёо юу гэсэн үг болохыг агуулгаар нь мэднэ гэсэн үг.
- **Соёлын** - Тухайн нөөцөд агуулагдаж буй соёлын утга учиртай агуулгыг мэдэж байна гэсэн үг (Шигтгээ 4.12);
- **Гүн утга агуулгын** – Тухайн субьектод агуулагдах гүн гүнзгий утга агуулгыг мэдэж байхыг хэлнэ.

Маркетинг үйл ажиллагаа

Харилцаа холбоо, маркетингийн төрөлжсөн хэлбэрүүд нь хэрэглэгч, үйлчлүүлэгч (аялагчид) болон олон түмэнд үнэ цэнтэй мессеж бий болгож, хүргэхэд чиглэдэг бөгөөд уламжлалт дөрвөн П дээр төвлөрч иржээ. Эдгээр нь бүтээгдэхүүнүүд (санал болгох), үнэлгээ тогтоох, сурталчилгаа болон түгээлт (Halpenny, 2007) зэрэг юм. ТХГН-ийн аялал жуулчлал хариуцсан менежерүүдийн хувьд аялагчдын хэрэгцээ, онцлог шинж чанар, зан байдлыг ойлгох үүднээс зах зээлийн судалгаанд анхаарч байж болох юм. Гэхдээ маркетинг сурталчилгааг мөн эрх эзэмшигчид,

сонирхогч талууд, ажилчид гэх мэт олон субьектуудад зориулж болдог (Wearing, 2007). Маркетинг сурталчилгаа хийхийг зорьсон ТХГН-уудын дийлэнх нь шаардагдах хүний нөөц байхгүй нь үнэн юм. Иймд гадны байгууллагатай гэрээ хийж гүйцэтгүүлэх шаардлагатай болдог.

ТХГН-ийн хамгаалалтын захиргаад таван төрлийн маркетинг сурталчилгаа хийж болдог ажээ. Үүнд:

1. **Нийгмийн сурталчилгаа:** Нийгэм, хувь хүмүүст ашиг тустай байх үр дүнг эрхэмлэдэг. Жишээлбэл Викториа ТХГН-ийн захиргаа өөрийн Эрүүл Цогцолборт Газар, Эрүүл хүмүүс гэсэн аянаа сурталчилахын тулд эрүүл мэндийн байгууллагуудтай түншлэн ажилладаг (Шигтгээ 2.9). Энэхүү аяны хүрээнд эмч нар өвчтнүүдээ цогцолборт газарт аялах эмийн жор бичиж өгч, ингэснээр өвчтөнүүдийн эрүүл мэндэд нь сайнаар нөлөөлдөг.
2. **Харилцааны сурталчилгаа:** Энэ нь ТХГН-ийн агентлагууд, эрх эзэмшигч болон оролцогч талуудын хоорондын урт хугацааны, харилцан ашигтай харилцааны үр дүнд түшиглэдэг (Borrie, бусад., 2002). Үүнд мөн ТХГН-ийн байгууллага дотор хийгээд түншүүдтэйгээ эерэг, харилцан нэгнээ дэмжсэн харилцааг бий болгох харилцаа багтана. Сайн дурын ажилтнуудыг жил тутам хүлээн авч, сайшаан магтах арга хэмжээ зохиох нь эерэг харилцааг хөгжүүлдэг бас нэг арга юм. Сэтгүүлчдийг ТХГН-т зохион байгуулалттай аялуулах нь бас нэг арга болно (Wearing, et al., 2007).
3. **Демаркетинг буюу буцаах сурталчилгаа:** ТХГН-ийн менежерүүдийн зүгээс байгаль орчны нөлөөллийг бууруулах, эсвэл аялагчдын авах үр өгөөжийг муутгахуйн тулд тодорхой байршилд очих эсвэл үйлчилгээ эрэлхийлэх явдлыг зориудаар багасгах шаардлагатай үед хэрэглэдэг стратеги юм. Буцаах маркетингийн аргууд нь үнийг өсгөх, дараалал хүлээх систем бий болгох, сурталчилгаагаа багасгах, мөн зөвхөн тодорхой сонгосон зорилтод бүлэгрүү анхаарал хандуулах зэрэг орно. Мөн түүнчилэн эрэлт хэрэгцээг хангах өөр ижил төстэй хувилбар санал болгох, эсвэл ашиглалт хэт их болсноос хүрээлэн буй орчинд доройтол учруулж буйг онцлон гаргаж ирэх зэрэг нь буцаах маркетингийн өөр бусад хэлбэрүүд болно (Armstrong and Kern, 2011).
4. **Хамтын сурталчилгаа:** ТХГН-ийн агентлаг нь тодорхой түнш байгууллагатай хамтран сурталчилгаа хийж, хоюул түүнээс харилцан ашигтай ажиллахыг хэлдэг. Энэ нь түншүүдийн харилцаа холбоогоо өргөжүүлж, санхүүгийн хувьд хэмнэлт гаргах арга юм. Ялангуяа интернетийн орчинд өргөн цар хүрээтэй ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтрах нь үр дүнтэй арга юм. Жишээлбэл Нэйшнэл Жеографик Травэлэр сэтгүүл АНУ-ын ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаатай хамтран Дэлхийн өвд бүртгэгдсэн Уотертоны Мөнх Цаст Олон Улсын Энх Тайвны Цогцолборт Газарт болон түүний эргэн тойрон дахь нутгийн иргэдийн дунд аялал жуулчлал хөгжүүлэхэд хамтран ажилласан байдаг. Энэ ажлын үеэр “Манай Тивийн Титэм” гэсэн санаачилга гарган хэрэгжүүлсэн нь бүс нутаг дахь аялал жуулчлал, байгаль орчин хамгааллын талаархи мэдлэгийг нэмэгдүүлсэн байдаг ажээ.

5. Үр өгөөжийн сурталчилгаа: ТХГН-зүгээс аялагчдад өгч чадах үр өгөөжийг бий болгож, тэдэнд хүргэх, ингэснээс мартагдашгүй, эерэг үр нөлөө үзүүлж, байгаль хамгааллыг дэмждэг, ойлгодог сэтгэлтэй болгоход чиглэсэн үйл ажиллагаа юм (Шигтгээ 4.13). ТХГН-уудын зүгээс үр өгөөж авах нөхцлийг бүрдүүлэх, хүний бүх мэдрэхүйн утсыг хөндөхөд анхаарах, хүн бүрт хүртээлтэй, тусгай сонирхолын бүлгүүдэд өгөөжтэй, мөн хөгжилтэй, дараа нь санан дурсах зүйлстэй байлгахад онцгой анхаарах ёстой байдаг (O'Sullivan and Spangler, 1998; Pine and Gillmore, 1999; Ellis and Rossman, 2008).

4.5 Гэрчилгээжүүлэх

Аялал жуулчлалын гэрчилгээ олгох нь тогтвортой хөгжлийн тодорхой зорилтууд багтаасан стандартуудыг аялал жуулчлалын байгууллага хангаж байгаа эсэхийг гуравдагч байгууллага сайн дурын үндсэн дээр үнэлж байгаа үйл явцыг хэлдэг. Аялал жуулчлалын бизнес эрхлэгчид өөрт олгогдсон гэрчилгээ бүхий шошго тэмдгээ үйл ажиллагааныхаа хариуцлагатай, тогтвортой байдлыг харуулах замаар жуулчдыг татах, урамшуулах зорилгоор маркетингийн хэрэгсэл болгон ашиглаж болдог. Гэвч

Шигтгээ 4.12

Оролцооны хэлбэрээр түүхийг мэдэж суралцах нь: Мэдлэг, Аялагчдын мэдлэг болон ур чадварт суурилсан танин мэдүүлэх аргаар жуулчидтай харилцах нь (Канад улс)

Самуэл Де Чамплайн болон Маттава гол нь Канад улсын Онтариод оршдог 330 ТХГН-уудын хоёр нь юм. Эдгээр ТХГН-ууд нь Маттава голын сав болох Канадын гол, мөрний өвд бүртгэгдсэн газрууд бөгөөд 200 орчим отоглох цэг, дэлгүүр 20 км явган аялалын жимтэй, каное завины маршрут болон мэдээллийн төвтэй юм. Зуны улиралд барилга байгууламжуудад нь 15-20 хүн ажилладаг. 6 мэдээлэн тайлбарлагч нь хөтөчтэй явган аялал, хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр болон үдшийн хөтөлбөр зэрэг уламжлалт мэдээлэн тайлбарлах хөтөлбөрөөр үнэ төлбөргүй үйлчилдэг. Аялагчид бага хэмжээний төлбөр төлснөөр Вояжер адал явдалт аялалын хөтөлбөрт оролцох боломжтой. Ийнхүү газар дээр нь шууд суралцсанаар аялагчид Канад улсын түүхийн талаар ойлголттой болж, Маттава голын талаар сэтгэлдээ гүн ойлголттой болдог байна.

Вояжер адал явдалт аялалд 10 оролцогч оролцож, 11м урт завиар 1.5 цаг Маттава голоор аялна. Аялал эхлэхийн өмнө хөтчүүд аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгнө. Гол дээр гарсан хойноо вояжер завьний дуурайж хийсэн загвар, түүний сэлүүрүүд, хуучин цагийн аялагчдын хувцас зэрэг үзүүлэнг ашиглан бодит байдал дээр нь мэдээлэн тайлбарлах ажлыг гүйцэтгэнэ. Хуучны хувцас өмссөн вояжерүүд буюу

анхны судлан нээгчдийн дууг дуурайлган дуулж, бодит юм шиг, тэр үед очсон мэт сэтгэгдлийг зочдод төрүүлнэ. Эрт цагийн аялагчдын талаарх дурсамжийг сэргээн сануулах бөгөөд хэсэг хугацааны дараа намжих цаг дор аялагчдад сэлүүрдэх, завийг залах гэх мэт ур чадварт суралцуулдаг. Үүний дараагаар мэдээлэн тайлбарлагч хөтчүүд үүх түүх ярьж өгөх, эрт цагийн аялагчдын дуу зэргийг зааж өгнө. Мөн дэргэдүүр нь өнгөрөх газартай холбоотой түүх сөхөн ярьж, өөрт тохиолдсон бодит түүх, тохиолдлуудаас хуваалцах нь өнөө цагийн аялагчдад сэтгэгдэл үлдээдэг байна.

Вояжер адал явдалт аялалын онцлог нь тодорхой, хүн бүрт хүртээмжтэй, бодит байгаль дээр явагддаг оршино. Оролцоонд суурилсан байдлаар мэдээлэл өгөх арга нь оролцогчдод өндөр ач холбогдолтой бөгөөд тэд мэдлэг чадвараа ашиглах бололцоотой болсноор хэт их мэдээлэлд булуулахгүй байх боломжтой болно. Аялагчид нэг талдаа завийг сэлүүрдэж бие мах бодироо оролцохын хажуугаар нөгөө талаар харилцан ярилцах, асуулт асуух, хөгжилдөх гэх мэт оролцоотойгоор аялдаг байна.



ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА:

Байгаль орчны боловсрол, мэдээлэн таниулах үйл ажиллагаандаа зөвхөн мэдээлэл өгдөг байдлаас гарч, аялагчдыг сэтгэл зүйн хувьд татаж, тухайн газрыг хамгаалж буй үнэт зүйлстэй холбосон хөтөлбөр рүү шилжих.

Жуулчид Маттава мөрний эрэг дээрх хуулбарын завиар хичээллэх туршилтанд хамрагдаж байна. © Jake Paleczny

гэрчилгээний олон шошгоны утга учирьг жуулчид төдий л мэддэггүй тул гэрчилгээжүүлэлт нь хүмүүсийг аялалаа төлөвлөхөд нь дорвитой нөлөөлж чаддаг эсэх талаар одоо болтол сайн тодорхой болоогүй хэвээр байна (Font, et al., 2007; Haaland & Aas, 2010; Esparon 2013).

ТХГН-ийн агентлагууд нь тогтвортой аялал жуулчлалын хөгжлийг хангахад чиглэсэн Ногоон Бөмбөрцөг, Ногоон Түлхүүр, Тогтвортой Аялал Жуулчлалын Эко Гэрчилгээ (STEP) зэрэг эсвэл Косто Рикагийн Тогтвортой аялал жуулчлалын хөтөлбөр зэрэг бүс нутгийн хөтөлбөрт хамрагдаж гэрчилгээ авсан компаниудад давуу эрх олгож болдог. Энэ тохиолдолд тус гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа нь аяллын компанийн үйл ажиллагааг үнэн бодитоор үнэлж, тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг

нь дэмжиж чадаж буй эсэхэд ТХГН-ын захиргаа итгэлтэй байх ёстой. Дээрхи гэрчилгээжүүлэлтийн хөтөлбөрүүдийн чанар чансаа нь өнөөг хэр бүрэн тодорхой болоогүй л байна (Spenceley and Bien, 2013).

Гэрчилгээжүүлэлт аялал жуулчлалын байгууллагад хамаатайгаас гадна ТХГН нь өөрөө эко аялал жуулчлалын менежментийн гэрчилгээтэй болж болно. Эдгээрийн жишээ нь барилга, байгууламжид олгодог гэрчилгээжүүлэлт (Эрчим Хүч, Байгаль Орчны Манлай Шийдэл буюу LEED), өдөр тутмын үйл ажиллагаа, процесст олгодог стандарт (ОУ-н Стандартчилалын Байгууллагын гаргасан Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO 14001) зэрэг юм.

Шигтгээ 4.13

Канадын ТХГН-ийн Хамгаалалтын Захиргааны зах зээлийн судалгаа ашиглалт ба үр өгөөжийн сурталчилгаа

Канадын холбооны агентлаг болох ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаа нь өөрийн улсын ТХГН-уудыг (мөн бусад байгаль, соёлын өвийн тусгай хамгаалагдсан газар нутаг) хариуцдаг бөгөөд байгаль хамгаалалд улс төрөөс ирэх дэмжлэгийг бэхжүүлэх үүднээс үйлчлүүлэгч, аялагчдаа таньж мэдэх, тэдэнд санамж, дурсамж өгсөн, үзэл бодолд нь нөлөөлсөн, нас онцлогт нь тааруулсан үр өгөөж өгөхөд ихээхэн анхаардаг байна.

Хамгаалалтын захиргаа өөрийн менежментэд байгаа ТХГН-уудын ашиглалт болон аялагчдын хандлагад хийх соеологийн судалгаанд хөрөнгө оруулалт хийдэг. Үүнд жишээ нь тодорхой нэгэн сэдвээр (тухайлбал хүн - зэрлэг ан амьтдын хоорондын зөрчилдөөн эсвэл хамгаалалтын ажиллагааны үр нөлөө гэх мэт) сар бүр жуулчдаас санал асуулга, судалгаа авдаг. Мөн улс орон даяар утсаар иргэдээсээ судалгаа авч ТХГН-т аялдаггүй бол яагаад гэдгийг тодруулах төлбөртэй судалгааг хийлгэдэг байна. Ингэснээр Канадчуудын ТХГН-ийн талаархи ойлголт, аялах, эс аялах шийдвэр гаргахад нөлөөлдөг нийгэм, эдийн засаг, соёлын чиг хандлагууд юу байдаг талаар мэдэж авах зорилт тавьдаг ажээ.

Хамгаалалтын захиргаа нь Канадын Аялал Жуулчлалын Комисс, Канадын Энвироникс судалгааны компанитай хамтран Канадын ТХГН-т зорьж буй аялагчдын сонирхдог үр өгөөжийн есөн төрлийг тодорхойлжээ. Үүний үр үр дүнг ашиглан Explorer Quotient (EQ) хэмээх программийг бүтээсэн бөгөөд энэ нь хүмүүс яагаад аялдаг,

ямар үр өгөөж авахыг хүсэмжилдэгийг сэтгэлзүйд тулгуурласан графیکیн судалгааг ашиглан тодорхойлдог байна. Аялагчдад өгөх тодорхой үр өгөөжийг EQ-аар тодорхойлсоны дагуу аялагч бүрт нийцүүлэн хүргэхээр хамгаалалтын захиргаа нь ТХГН-таа хэрэгжүүлдэг. Аялагчид түүнчилэн EQ програмийн санал асуулгыг бөглөж болох бөгөөд үүний үндсэн дээр өөрт нь таарч тохирсон аялалын талаархи мэдээллийг авч болдог ажээ. Дараах холбоосоор орж илүү олон жишээг харж болно: http://www.pc.gc.ca/voyage-travel/qe-eq/qe-eq_e.asp

СоциологийнхоёрдахьчухалмэдээллийнөгөгдөлньЭнвирониксАналитикийн дэд систем болох PRIZM C2 хэмээх программ юм. Үүгээр Канадын иргэдийн оршин суугаа газрыг сэтгэл судлал болон хүн ам зүйн мэдээлэл дээр үндэслэн 66 онцлог амьдралын хэв шинжид ангилжээ. Энэ ангилалын мэдээллийг EQ программын өгөгдөлтэй холбон нэгтгэх замаар нийт хүн амын тодорхой бүлэг рүү чиглэсэн Канад улсын ТХГН-ийн сурталчилгааг үр ашигтай явуулах боломж бүрддэг аж. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.destinationcanada.com/en/tools> харж болно. Канад дахь Жишээг дараах сайтнаас авч болно: <http://www.environicsanalytics.ca/blog-details/ea-blog/2014/07/11/summer-s-here-but-some-are-not>.

Эх үүсвэр: Jager & Halpenny, 2012



Санал асуулга (EQ) Канадын ТХГН-ийн талаарх товч асуулгууд; вебсайт (<http://www.pc.gc.ca/en/voyage-travel/>)

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА:

Маркетинг, сурталчилгааны стратеги гаргахаасаа өмнө судалгаа, анализаар дамжуулан оршин суугчдын талаар гүн ойлголттой болох.

ТХГН-уудын хамгаалалтын захиргаа өөрөө тогтвортой хөгжлийн зорилтуудаа оруулсан гэрчилгээжүүлэлтийн систем бий болгож, түүнийгээ ТХГН-уудаа даган мөрддөг болгож болно. Үүний нэг жишээ нь Европын Тогтвортой Аялал Жуулчлалын Дүрэм (ECST)-ийг шигтгээ 4.14-т тайлбарлан харуулав. Энэ дүрэмд ТХГН-т тогтвортой аялал жуулчлалын гэрчилгээ олгоход шаардлагатай шалгуур үзүүлэлт, хамгийн наад захын хангасан байх ёстой шаардлагууд болон хяналтын шалгалт буюу мониторингийн шалгуур үзүүлэлт зэргийг тодорхойлсон байна.

IUCN-ийн Тусгай Хамгаалалттай Газар Нутгуудын Ногоон Жагсаалт

Олон улсын хэмжээнд Дэлхийн Тогтвортой GSTC Аялал Жуулчлалын Зөвлөл нь ТХГН-т зориулсан гэрчилгээжүүлэлт, магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүд боловсруулсан (Шигтгээ 4.15) бөгөөд үүгээр дамжуулан гэрчилгээ, магадлан итгэмжлэлд ашиглах шаардлагуудыг гаргаж ирсэн байдаг. ОУ-н Стандартчилалын Байгууллагаас (ISO) ТХГН-ийн агентлагуудын зүгээс зочлох үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлсон ISO 18065: 2015 гэсэн сайн дураар дагаж мөрдөх стандартыг гаргасан байдаг. (ISO, 2015).

Сүүлийн үед ТХГН-уудын ач холбогдолыг дэлхийн хэмжээнд үнэлж цэгнэх чиглэлээр гарсан ажлын нэг нь өндөр үр бүтээмжтэй хамгаалалттай газруудын олон улсын системчилсэн бүртгэл (Ногоон жагсаалт гэх) болох IUCN-ийн Тусгай Хамаалалттай газар нутгуудын ногоон жагсаалт юм. Сонгон шалгаруулалтыг хийхдээ олон талт үр ашгийг ТХГН-ийн менежментийн зүгээс хэрхэн тогтвортой хадгалж чадаж буйгаар нь дүгнэдэг (IUCN, 2017d). Мөн аялал жуулчлалын ачаалал ихтэй ТХГН-дахь аялал жуулчлалын стандартыг нь үнэлэх орно. Ногоон Жагсаалтын анхны туршин хэрэгжүүлсэн газруудын нэг нь байгаль хамгаалах стратегийн салшгүй хэсэг аялал жуулчлал болсон Араквалын Цогцолборт Газар (Австрали улс, Bushell & Bricker, 2017) байжээ. ТХГН-ийн гүйцэтгэлийг үнэлэхэд ашигладаг шалгуур үзүүлэлтүүд дотор аялал жуулчлалын менежментэд хамааралтай олон зүйлс багтаажээ. Өмнө дурьдагдсан ТХГН дахь аялал жуулчлалын чанарын шалгуур үзүүлэлтүүд нь Ногоон Жагсаалтын ашиглан хийх үнэлгээ хийх нөхцлийг хангаж өгдөг. IUCN-ийн Ногоон Жагсаалтад багтсан ТХГН нь ойр орчимдоо хийж буй аялал жуулчлалын үйл ажиллагаагаа, нөөц боломжоороо бусдын анхаарлыг татдаг.

Шигтгээ 4.14

Европын Тогтвортой Аялал Жуулчлалын Дүрмийн хүрээнд түншлэлийг хөгжүүлэх нь

1995 онд батлагдсан засаглалын загвар болох Европын ТХГН-ийн Тогтвортой Аялал Жуулчлалын Дүрмийг тусгай хамгаалалттай газар нутгууд авч хэрэгжүүлснээр Тогтвортой Зорих Газар Нутаг (EUROPARC Federation, 2010) хэмээн албан ёсоор зөвшөөрөгдөх үндэслэл болдог. Энэхүү батламжийг авахын тулд ТХГН нь байгаль хамгаалах үйлсийг урьтал болгохын зэрэгцээ нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор аялал жуулчлалын менежментээ байнга сайжруулж байх хэрэгтэй байна (EUROPARC Federation, 2012).

ТХГН-ийн урт хугацааны менежментийг хэрэгжүүлэхэд орон нутгийн түншүүдийн дэмжлэг шаардлагатай болохыг энэхүү дүрэмд хүлээн зөвшөөрсөн байдаг. Үүнийг хангах хамгийн сайн аргуудын нэг бол нутгийн иргэд болон аж ахуйн нэгжүүдэд байгаль орчны зорилго, зорилтуудад нийцсэн эдийн засгийн үйл ажиллагаа явуулах боломжууд бий болгож өгөх явдал юм (EUROPARC Federation, 2010; EUROPARC Federation, 2012). Энэхүү дүрмийн биелэлтийг хангасан Европын Холбооны ТХГН-уудын сүлжээнд байх гишүүн 36 улсын ТХГН газар нутгийн хэмжээ болон төрлөөс үл хамааран, дээрхи загварыг ач ашиглах боломжтой байдаг.

Европын Дүрмийн шаардлагыг биелүүлэхийн тулд ТХГН-ууд доорхи таван зүйлийг бүрдүүлсэн байх шаардлагатай байдаг (EUROPARC Federation, 2010; EUROPARC Federation, 2018). Үүнд:

1. ТХГН-ийн болон орон нутгийн захиргаа, байгаль хамгааллын болон олон нийтийн байгууллагууд, аялал жуулчлал эрхлэгчдийн төлөөллүүд өөр хоорондоо харилцах боломжтой Тогтвортой Аялал Жуулчлалын Форумтай болсон байх.
2. Эрх эзэмшигчид, оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ, стратегийн чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг багтаасан Стратеги, Үйл ажиллагааны Төлөвлөгөөтэй байх.
3. Дүрмийн Үнэлгээний Хороо хянасан, газар дээр нь баталгаажуулах үйл ажиллагааг багтаасан Үнэлгээний аргачилалтай байх.
4. Гүйцэтгэлийн хэмжүүр үзүүлэлтүүдийг багтаасан Мониторинг болон Хяналт магадлагааны протоколтой (тогтолцоотой) байх.
5. ТХГН-ийн удирдлагуудтай түншлэл байгуулах шалгуурыг хангасан аялал жуулчлалын бизнес эрхлэгчдэд Дүрмийн Түншлэгч цол олгодог Түншлэл болон Харилцаа Холбооны Хөтөлбөртэй байх.

ТХГН-ийн сайн менежментийг тогтвортой аялал жуулчлал хэрэгжүүлэх эрмэлзэлтэй бизнес эрхлэгчидтэй холбон өгөх замаар Европын Дүрэм нь ТХГН-ийн байгаль болон соёлын өвийг хадгалж, хамгаалах үр өгөөжтэй, сайн арга хэрэгслийг бий болгож буй бөгөөд аялал жуулчлалын даац хэтэрсэн, зохимжгүй үйл ажиллагаа явуулахаас сэргийлж өгдөг байна (салгах) (EUROPARC Federation, 2010; EUROPARC Federation, 2012; EUROPARC Federation, 2018).

Эх сурвалж: EUROPARC Federation, 2010, 2012, 2018

Шигтгээ 4.15

Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын Зөвлөлөөс гаргасан шалгуур үзүүлэлтүүд

Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын Зөвлөл (GSTC) нь НҮБ-ын UNWTO, НҮБ-ийн Байгаль Орчны Хөтөлбөр, НҮБ-ийн Сангийн дэмжлэгтэйгээр олон улсын тогтвортой аялал жуулчлалын 130 стандарт, удирдамжийг нэгтгэн, тус бүрийн өөрийн өвөрмөц шинж төрөхийг нь алдагдуулахгүйгээр улс орон бүрт тогтвортой аялал жуулчлалын наад захын шаардлагыг хангуулахаар зорьж байна. GSTC нь олон улсын төрийн бус байгууллагын хувьд бүх тивээс аялал жуулчлалын салбарын оролцогч талуудыг төлөөлсөн 200 гаруй гишүүдтэй.

GSTC нь аялал жуулчлалын салбарынхан болон тогтвортой аялал жуулчлалын мэргэжилтнүүдтэй хамтран 60 гаруй гэрчилгээ, сайн дурын үндсэн дээр хангаж ажиллах шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж, 2000 гаруй хүний санал сэтгэгдэлийг цуглуулжээ. Энэ үйл явцаар дамжуулан GSTC нь сайн дурын үндсэн дээр хангаж ажиллах стандартын хоёр багцыг боловсруулжээ. Эдгээр нь: GSTC-ийн Зорин Очих Газарт Тавигдах Шалгуур Үзүүлэлт болон GSTC-ийн Аж Үйлдвэрт Тавигдах Шалгуур Үзүүлэлт (зочид буудал, тур операторын хувьд) зэрэг юм.

Шалгуур үзүүлэлтүүд нь тухайн газрыг ямар үзүүлэлтээр тогтвортой аялал жуулчлалын зорин очих газар гэж үзэх, мөн түүнчилэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхээр чармайж буй аялал жуулчлалын компани менежментийн хувьд хамгийн багадаа ямар арга хэмжээ авсан байх ёстой зэрэгт нэгдсэн ойлголт бий болгох гэсэн оролдлого юм. Эдгээр нь аялал жуулчлалын үйл ажиллагааг хянах үүрэг хүлээсэн ТХГН-ийн аливаа менежерүүдийн хувьд хэрэгцээтэй эхлэлийн цэг болдог. Тогтвортой аялал жуулчлалд бүрэн нийцэхийн тулд тухайн газар өөрийн зорин очих газрын, мөн жуулчид, нутгийн иргэдийн нийгэм, байгаль орчин, эдийн засгийн үр ашгийг хамгийн дээд цэгт хүргэж, сөрөг үр нөлөөг хамгийн бага байлгахад чиглэсэн салбар хоорондын уялдаа холбоо, нэгдмэл, харилцан хамааралтай арга барил баримтлах шаардлагатай болдог. Шаардлагууд нь бүхий л төрлийн зорин очих газруудад хамааралтай байхад чиглэгдсэн.

Шалгуур үзүүлэлт, хэмжүүрүүд нь өмнө нь ашиглагдаж байсан төслүүд дээр үндэслэсэн бөгөөд дэлхийн өнцөг булан бүрт орших өөр соёл, геополитиктэй газруудын шинж чанарыг тусгасан гэрчилгээжүүлэлтийн стандартууд, үзүүлэлтүүд, шилдэг туршлагаудыг тусгасан юм. Боломжтой санагдсан үзүүлэлтүүдүүдийг ач холбогдол, практикт ашиглагдах байдал, мөн олон янзын зорин очих газруудад ашиглах боломжит байдал зэргээр нь шүүн тунгаахээ.

GSTC-ийн Зорин Очих Газарт Тавигдах Шалгуур үзүүлэлтүүд нь нь дөрвөн үндсэн хэсэгт хуваагдсан 41 шалгуур болон ТХГН-ийн менежерүүд өөрсдийн орчин нөхцөлд буулгаж хэрэглэж болох гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээс бүрднэ.

GSTC-ийн Аж Үйлдвэрт Тавигдах Шалгуур үзүүлэлтүүдийг 2016 онд зөвлөх уулзалдаанаар хэлэлцэж, хянан нягталсан бөгөөд зочид буудал, тур операторуудад зориулсан гүйцэтгэлийн тусдаа шалгуур үзүүлэлтүүдтэй аж. 2017 оны 2-р сарын байдлаар зочид буудал, тур операторуудад хамаарах 28 гэрчилгээжүүлэлтийн стандарт, зорин очих газарт хамаарах 5 хүлээн зөвшөөрөгдсөн стандарттай болжээ.

GSTC-ийн Бүхэл Чанарын Хөтөлбөр нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, батламжлагдан, магадлан итгэмжлэгдэх боломжийг бүрдүүлдэг. Энэхүү хөтөлбөрийн авж хэрэгжүүлж чадсан үйлчилгээний байгууллага, хөтөлбөрүүдийн нэр хүнд нь өсдөг. Улмаар аялагчид, компаниудад итгэл төрүүлж, ач холбогдолыг нь өндөр болгож, бусад арай нэг талыг барьсан, үр өгөөж муутай стандартын хөтөлбөрүүдээс эрс өөр харагдуулж чаддаг.

GSTC-ийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг засгийн газрын агентлагууд, байгаль хамгаалах байгууллагууд ТХГН болон онгон байгаль түшиглэсэн аялал жуулчлалын хөтөлбөрүүдэд гэрчилгээ олгохдоо авч хэрэгжүүлэх явдал өсөн нэмэгдэж байна. GSTC-ийн Зорин Очих Газарт Тавигдах Шалгуурыг Сьерра Горда Биосферийн Нөөц Газар (Мексик), Куско-Ариун Хөндий Мачу Пичу (Перу), Окаванго дельта (Ботсвана) зэрэг ТХГН-ууд авч хэрэгжүүлжээ. Эдгээр зорин очих газрууд холбогдох шалгууруудыг ашиглан тогтвортой байдлын суурь үнэлгээ хийлгүүлж, сайжруулах зүйлс дээр зөвлөмжүүд авсан байна. Их Шүрэн Арлын Далайн Цогцболборт Газар (Австрали) Өндөр Стандарттай Тур Оператор хэмээх хөтөлбөрийг олон жилийн турш хэрэгжүүлж ирсэн учир өдгөө тус цогцолборт газарт ирж буй зочид гэрчилгээтэй тур оператор компаниар л үйлчлүүлж байна. Түүнчлэн Австралийн ТХГН-ийн менежерүүд нь тур оператор компаниудад урт хугацааны лиценз өгөх, онцгой газруудад аялах тусгай зөвшөөрөл олгох, урамшууллын хөтөлбөрүүд санал болгох замаар гэрчилгээжүүлэлт олгож, сурталчилж байна. Эдгээр өртөг багатай арга ажиллагаанууд нь тур оператор байгууллагуудад тогтвортой ажиллаж, бие даан гэрчилгээжилтэд хамрагдвал бизнест нь ач тустай гэсэн ойлголтыг төрүүлдэг ажээ (R. Hillman, Австрийн Экотуризмын гүйцэтгэх захирал, хэвлэлийн хурал, 11 Дөрөвдүгээр сар 2016).

Эх үүсвэр: GSTC, 2017a; GTSC, 2017b; НҮБ-ийн сан, 2017

<http://www.gbrmpa.gov.au/our-partners/tourism-industry/high-standard-tourism>; <https://www.gstcouncil.org/topics/news/early-adopters/>



Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын Зөвлөлийн лого. © GSTC

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА:

Аялал жуулчлал, түүний нөлөөллийн бодлого, төлөвлөлт, менежментийн, мониторингийн хүрээг багтаасан аялал жуулчлал, биологийн төрөл зүйлийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн удирдамжуудыг дагах

Ногоон Жагсаалттай холбоотой нэмэлт мэдээллийг : [//www.iucn.org/theme/protected-areas/our-work/iucn-green-list](http://www.iucn.org/theme/protected-areas/our-work/iucn-green-list) -ээс авах боломжтой.

4.6 Аялал жуулчлалын менежментийн гурван талт тогтолцооны хүрээ

Энэхүү номны гуравдугаар бүлэгт аялал жуулчлалын менежментийн дөрвөн хүрээг авч хэлэлцсэн билээ. Эдгээр нь: (1) Амралт Зугаалгын Боломжийн Хүрээ (АЗБХ), (2) Даац, (3) Тэвчиж болох өөрчлөлтийн дээд хязгаар (LAC) болон (4) чанарын үзүүлэлт болон стандарт зэрэг болно.

Сүүлийн үед ТХГН болон хөдөө орон нутагт түшиглэсэн амралт, зугаалга нь зөвхөн нөөцөд анхаарал хандуулсан шинжтэй байгаа болиод илүү цогц арга барил руу шилжсэн нь тухайлбал өмнө дурдсан менежментийн

дөрвөн хамрах хүрээ, 10 зарчим зэргийг нэгтгэсэн аялал жуулчлалын менежментийн гурван талт тогтолцооны хүрээ юм.

Аялал жуулчлалын менежментийн гурван талт тогтолцооны хүрээ нь тасралтгүй сайжруулах менежментийн дараах тойргоор хэрэгждэг. Үүнд:

1. Аялал жуулчлалын менежментийн зорилтууд, шаардлага, стандартуудыг ТХГН-ийг бүхэлд нь эсвэл түүний доторхи тодорхой хэсэгт зориулан боловсруулдаг.
2. Стандартыг хангаж байгаа эсэхийг хянахын тулд аялал жуулчлалын чанарын үзүүлэлтүүдэд мониторинг хийдэг.
3. Хэрэв аялал жуулчлалын чанарын стандарт хангагдахгүй эсвэл хангагдахгүй байх эрсдэлд орсон бол сэргийлэх арга хэмжээг авдаг.



АНУ-ын Гранд Канион Цогцолборт газар дахь аялагчдад зориулсан хүн зэрлэг амьтны хоорондын харилцааг харуулсан танин мэдэхүйн самбар. © US National Park Service



LEAVE NO TRACE

International Outdoor Ethics

ТӨЛӨВЛӨЛТ БА БЭЛТГЭЛ

- Аялалд гарах болгондоо тухайн газрын тухай мэдээлэлтэй танилцаж холбогдох хууль дүрэм, зан заншилтай урьдчилан танилцаж бэлтгэл хангах
- Цаг агаарын таагүй нөхцөл, аюул гамшигт бэлэн байх
- Аль болох цөөхүүлээ аялах. Олуулаа тохиолдолд хуваагдах.
- Өөрийн боломж чадвартаа тохирсон аялал сонгох
- Төлөвлөгөөндөө байгальд ул мөргүй аялах ёс зүйг тусгасан байх

УРТ ХУГАЦААГААР ХЭЭРЛЭХ, АЯЛАХ

- Урт хугацаагаар хээрлэн цас мөс, хад чулуун дундуур явахдаа хээрийн зам, жим гаргаж түүнийгээ дагах
- Отоглох газрыг бий болгох биш харин өмнө отоглож байсан найдвартай газрыг олох
- Гол, горхи, нуур зэрэг нойтон газраас хамгийн багадаа 70 м хол зайд отоглох
- Отоглож хоносон газраа өмнө байсан шиг нь үлдээх эсвэл засаж янзлах
- Түгээмэл очдог газарт
- Байгуулсан зам, харгуй, жимээр явах
- Хэдий тэр зам, харгуй, жим дундаа устай, шавар намагтай байсан ч дагах
- Танигдаагүй мэдэхгүй газарт
- Дураараа зам, харгуй, жим гаргахгүй байх
- Эвдэрсэн, нурсан газраар явахгүй байх

ХОГ ХАЯГДЛАА ЦЭВЭРЛЭХ

- Хог хаягдлаа уутанд хийж авч явах эсвэл зориулалтын саванд нь хийх
- Хогоо булах тохиолдолд гол, нуур ус, зам харгуй, жимээс хамгийн багадаа 70 м хол зайд 15-20 см нүх ухаж булах
- Ариун цэврийн цаас, хэрэглэлээ тусгай уутанд хийж авч явах
- Сав суулга, аяга тавгаа угаахдаа гол, нуур ус, зам харгуй, жимээс хамгийн багадаа 70 м хол зайд, биоаюулгүй угаалгын бодис хэрэглэж угаах

ҮЗСЭН, ТААРАЛДСАН ЗҮЙЛИЙГ БҮҮ ОРОЛД

- Түүх соёлын дурсгалт эд зүйлсэд гар хүрэхгүй байх.
- Өвөрмөц чулуу, ургамал таарвал авч явж болохгүй
- Хувийн болон нийтийн эд хөрөнгийг хайрлах, хүндэтгэлтэй хандах
- Амьтан, ургамлыг өөртөө авч явах, тээвэрлэхээс зайлсхийх
- Хад чулуу бусад зүйлсээр янз бүрийн овоо, дүрс бусад зүйл хийхгүй байх

ГАЛЫН АЮУЛ ГАРАХААС СЭРГИЙЛЭХ

- Задгай гал нь ой хээрийн түймрийн аюул гаргах боломжтой тул бол аль болох хээрийн зуух хэрэглэх
- Гал түлэх зөвшөөрөлтэй газарт гал гаргахдаа тэнд байгаа тулга болон тусгай зориулалтын төхөөрөмжийг хэрэглэх
- Гал түлсэн ч бага түлэх. Гар хөлөө түлэхээс сэргийлж галын хайч, шилээвэр хэрэглэх. Нойтон мод, бургас бүү түл.
- Галын нурмыг үнс болтол нь хүлээж, үнсийг шалгасны дараа норгох


ЗЭРЛЭГ БОЛОН ҮРЖҮҮЛГИЙН АМЬТАДТАЙ ЗӨВ ХАРЬЦАХ

- Зэрлэг амьтан, шувуу ажиглахдаа зай барих. Үүр, ноохой, үр төл рүү ойртохгүй байх
- Эрүүл мэндэд нь сөрөгөөр нөлөөлөхөөс сэргийлж Амьтны үр төлд өөрийн идэж буй зүйлээс өгөхгүй байх
- Хоол хүнс, шингэн зүйлийг зэрлэг амьтнаас хамгаалж хадгалах
- Тэжээвэр амьтдад анхаарал хандуулж байх, буцахдаа дагуулж явахгүй байх
- Зэрлэг болон фермийн амьтад нь тэжээвэр амьтдаас ялгаатай тул тэднээс хол байх, шууд харьцахгүй байх

БУСАД ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНДАХ

- Бусад аялагчдыг хүндэтгэх
- Санаанд оромгүй, гэнэтийн үйл явдалд бэлэн байх
- Эелдэг даруу байх
- Орон нутгийн иргэдийг хүндлэх, зан заншлыг дагах
- Тухайн орон нутаг, орчныг судалж хүндэтгэлтэй хандах
- Чимээ шуугиан гаргахаас зайлхийж байгалийн дуу хоолойг сонс.

For more information on Leave No Trace, visit **WWW.LNT.ORG**
© Leave No Trace Center For Outdoor Ethics



Байгальд ул мөргүй аялах ёс зүйн 7 зарчмыг харуулсан шошго (www.LNT.org). ©

Менежментийн гурван талт тогтолцооны хүрээ нөхцөл байдлаас шалтгаалж бага зэрэг өөр, өөр байна. Жишээлбэл АНУ-ын Ойн Газар нь LAC-ын хүрээг ашигладаг (Stankey, et al., 1985) бол АНУ-н ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаа нь Аялагчдын Үр Өгөөж ба Нөөцийн Хамгаалалт (VERP) хэмээх хүрээг ашигладаг (USNPS, 1997). Канад улсын ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаа Аялагчдын Үйл Ажиллагааны Менежментийн Дараалал (VAMP) хэмээх хүрээг ашигладаг (Nilsen and Tayler, 1997) бол Австрали улсад Аялал Жуулчлалын Тохируулах Менежментийн Загвар хэмээх хүрээг хөгжүүлэн ашиглаж байна (ТОММ) (Manidis Roberts зөвлөхүүд, 1996). Өмнөд Африкийн ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаа Түгшүүрийн Босго Хязгаар гэдэг хүрээг аялал жуулчлал болон байгальд гарч буй өөрчлөлтүүдэд менежмент хийхдээ ашиглаж байна. Авч хэрэгжүүлдэг үйл ажиллагааны нэр томъёо, үе шат, дарааллууд ялгаатай байж болох боловч дурдсан хүрээнүүд нь өмнө нэрлэгдсэн гурван үндсэн алхамуудад тулгуурлан үндэслэсэн юм (Manning, 2004). Менежментийн гурван талт тогтолцооны ерөнхий хүрээ нь чанарын шалгуур үзүүлэлтүүдийг хянах, чанарын стандартыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх, мөн хяналтын мэдээлэлд үндэслэн практик тохируулга хийхийг тус тус шаарддаг. Нөхцөл байдал өөрчлөгдөх эсвэл менежментийн төлөвлөгөөг өөрчлөх шаардлага үүсвэл чанарын зорилтууд, холбогдох шаардлагууд болон стандартуудыг эргэн харж болдог.

Менежментийн зорилтууд, холбогдох үзүүлэлт, чанарын стандартыг ТХГН дахь аялал жуулчлал, амралт зугаалгын бүхий л гурван бүрэлдэхүүн хэсэгт авч үзэж болох бөгөөд тэгэх ч ёстой юм. Тэдгээр нь нөөц, үр өгөөж болон менежмент билээ. Менежментийг зардал, үр ашгийг тэгш хувиарласан (жишээ нь нутгийн иргэдийг ажлын байраар хангах замаар), эдийн засгийн үр өгөөжийн нэлээдгүй хувийг ТХГН-т байгаль хамгаалах ажилд зарцуулах байдлаар зохион байгуулж болно.

Нэгэн чигтэй удирдамж гаргаж авахын тулд аялагчдын менежментийн өөр, өөр хүрээг нийлүүлэн ашиглах шаардлагатай юм байна гэдгийг дундаа нийтийн эзэмшлийн 2.7 сая газар нутгийг харъяалдаг АНУ-д холбооны зургаан агентлаг өөр дээрээ харуулжээ. Эдгээр агентлагууд нь бүгдэд хүртээмжтэй, харилцаа холбоо, сургалтын стратегиудаар дэмжигдсэн, уялдаа холбоотой, шинжлэх ухаанд суурилсан менежментийн хүрээлэлтэй болохын тулд Аялагчдын Ашиглалтын Менежментийн Дундын Зөвлөл гэдгийг байгуулсан байдаг (IVUMC, 2017).

2016 онд тус зөвлөлөөс өөрийн Аялагчдын Ашиглалтын Менежментийн Хүрээний талаар хамгийн анхны гарын авлагаа боловсруулж гаргасан байдаг (<https://visitoruse-management.nps.gov/VUM/Framework>).

Өнөөдрийг хүртэл аялагчдын менежментийн хүрээг Хойд Америкт голчлон хэрэглэж байгаа боловч аялагчдын

ашиглалтанд зориулсан дасан зохицох менежментийг дэмжих зорилгоор дэлхийн бусад улс орнуудын ТХГН-ийн сүлжээнд хэрэглэх нь нэмэгдсээр байна (Brown, et al., 2006; McCool, et al., 2007; Roman, et al., 2007; Reck, et al., 2015).

ЮНЕСКО-гоос Дэлхийн өвийн Тогтвортой аялал жуулчлалын цахим гарын авлагыг боловсруулсан бөгөөд үүнд стратеги төлөвлөлт, засаглал, оролцоо, харилцаа холбоо, дэд бүтэц, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжил, аялагчдын зан төлөв, санхүүжилт болон хяналт мониторинг зэрэг сэдвээр олон удирдамжийг агуулсан байдаг. (<http://whc.unesco.org/sustainabletourismtoolkit/>). Эдгээр удирдамжуудыг Малоти-Даркенсбургийн Дэлхийн Өвийн Цогцолборт Газар (Лесото болон Өмнөд Африк), Серенгетийн Дэлхийн Өвийн БЦГ (Танзани улс) зэрэг газарт авч хэрэглэсэн байна. Эцэст нь тэмдэглэхэд UNWTO-ын Тогтвортой Аялал Жуулчлалын Хүрээ хэмээх аялагчдын менежментийн бас нэг хүрээг Перу улсын Мачу Пичу Дэлхийн Өвийн газарт хэрэгжүүлэхээр өргөн баригдаад байна (Larson and Poudyal, 2012).

4.7 Шилдэг туршлагауд

- Судлаач иргэн болон бусад хөтөлбөрөөр дамжуулан сайн дурын ажилтнуудын ур чадвар, урам зоригийг менежментийн үйл ажиллагаанд ашиглах. Ингэхдээ зохих хяналт, чанарын шаардлагыг мөрдөж ажиллуулах.
- Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн мониторингийг



Нутгийн уугуул иргэдийг цогцолборт газрын бүх хэсэгт ажилуулсанаар менежментийн үр өгөөжийн нэмэгдүүлдэг байна. Дайнтрийгийн Цогцолборт Газар, Квинслэнд, Австрали улс. © Glen Hvenegaard



Ханхүү Албертийн Байгалийн Цогцолборт Газар дахь мэдээлэн таниулах үйл ажиллагаа, Канад улс. © Glen Hvenegaard.

шаардлагатай техник технологи, санхүүгийн хангалттай үүсвэртэй уялдуулан холбох.

- Ямар үнэ цэнийг хамгаалж буйгаа ойлгож мэдсэний үндсэн дээр үйл ажиллагаагаа тодорхойлж, менежментийн тохирох арга зам, практик туршлагаудыг хэрэглэдэг байх.
- Байгаль орчны боловсрол олгох, мэдээлэн тайлбарлах хөтөлбөрүүдэд ТХГН-ийн аль үнэт зүйлсийг сонгохдоо стратегийн төвшинд төлөвлөж, тэдгээрийг ТХГН, түүний харъяалагдах системийн ерөнхий зорилго, зорилтуудтай нийцүүлэх.
- Байгаль орчны боловсрол, мэдээлэн таниулах үйл ажиллагаандаа зөвхөн мэдээлэл өгдөг байдлаас гарч, аялагчдыг сэтгэл зүйн хувьд татаж, тухайн газрыг хамгаалж буй үнэт зүйлстэй холбосон хөтөлбөр рүү шилжих.
- Аялагчдад дэлхий дахинд болж буй ижил төстэй асуудал бэрхшээлүүд, боломжтой үед байгаль хамгаалалд тулгарч буй асуудлуудыг ойлгуулан тайлбарлах замаар асуудлын өргөн тал, хүрээг ойлгуулж байх.
- Маркетинг, сурталчилгааны стратеги гаргахаасаа өмнө судалгаа, анализаар дамжуулан оршин суугчдын талаар гүн гүнзгий ойлголттой болох.
- Аялал жуулчлал, биологийн олон янз байдлын талаар олон улсын чанартай удирдамж авч ажиллахдаа аялал жуулчлал, түүний үр нөлөөний талаар бодлого, төлөвлөлт, менежмент болон мониторингийн хүрээтэй удирдамжийг дагах.

Тогтвортой аялал жуулчлалын менежментийн чадавхийг бэхжүүлэх нь

5



5.1 Чадавхийг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсгүүд

ТХГН-ийн аялал жуулчлалын үндсэн зарчим бол тухайн аялагчид үр өгөөж өгдөг, хүрээлэн буй орчиныг хамгаалах явдал билээ (Eagles et al., 2002, Eagles & МкКлоу, 2002). Иймд байгаль дэлхийг хамгаалахын зэрэгцээ тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чадварлаг зохион байгуулалттай менежмент зайлшгүй хэрэгтэй болдог. Менежментийн зүгээс аялал жуулчлалын үр нөлөөг тэвчиж болох хэмжээнд барьж, ТХГН-ийн зорилго, зорилтууд, байгаль хамгаалах үйлсэд нийцсэн аялалын үр өгөөж бий болгоход анхаарах ёстой билээ (Cole, 2004, Jager, et al., 2006; Worboys, et al., 2015). Мэргэжлийн чадавхыг бий болгох нь шийдвэр гаргах үйл явц болон хэрэгжилтийг үр дүнтэй болгох арга замуудын нэг юм (McCool, et al., 2012; Appleton, 2016).

Дээрх чухал сэдвийн талаар дэлгэрэнгүй өгүүлэх энэ бүлэгт аялал жуулчлалын менежментийн чадавхийг бэхжүүлэх сэдвээр хэлэлцэхдээ ТХГН-ийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтуудыг авч үзнэ (IUCN, 2017a). “Чадавхи бэхжүүлэх” гэдэг нь тавьсан зорилгуудыг биелүүлэх, эсвэл тодорхой төслийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах арга замыг (чадавхийг) олж эзэмших үйл явц юм. Чадавхи бэхжүүлэх нь энгийн сургалтаас хамаагүй өргөн ойлголтыг илэрхийлнэ. Чадавхи бэхжүүлэх үйл явцад хүмүүст шаардлагатай тодорхой мэдлэг, чадварыг өгөхийн тулд тусгай сургалт өгөх, эсвэл бүр өргөн хэмжээний боловсрол эзэмшүүлэх, эсвэл бүтээлч оюун бодлыг хөгжүүлж, төлөвшүүлэх зэрэг арга хэрэглэхийг хэлнэ (Шигтгээ 5.1, х.66).

Чадавхи сайжруулах үйл явц нь мөн биет хэлбэрээр хэрэгждэг. Хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхийн тулд барилга байгууламж, тоног төхөөрөмж болон байгалийн нөөц баялагууд хэрэг болдог. Мэргэжлийн шаардлагатай мэдлэг, туршлага бий болгохын тулд мөн нийгэм, соёлын болон хууль эрх зүй / зохицуулалтын бүрэлдэхүүнтэй байх хэрэгтэй болдог. Үүнд ТХГ-т аялал жуулчлалын зохистой,



Окаванго голын сувгаар “Мокоро” хэмээх уламжлалт аргаар матаж хийсэн модон завиар аялж буй нь. Кветани Камп, Окаванго Дельта, Ботсвана. © Wilderness Safaris, Dana Allen

тогтвортой байдлыг хангахад шаардлагатай олон нийтийн дэмжлэг, хууль эрх зүй, улс төрийн хүчин, засаглалыг хөгжүүлэх гэх мэт орно. Энэ бүлэгт чадавхи бэхжүүлэхтэй холбоотой үндсэн ойлголтуудыг тайлбарлаж, амжилттай хэрэгжүүлсэн олон улсын жишээнээс дурьдах болно.

ТХГН-ийн аялал жуулчлалд гүйцэтгэх үүрэг бүрт өөрийн онцлог чадвахи шаардагддаг

ТХГН-т аялал жуулчлалыг удирдан зохион байгуулахад оролцдог дараахь хүмүүсийн чадавхиудыг (зайлшгүй эзэмшвэл зохих ур чадварууд) хөгжүүлэх шаардлагатай байдаг. Үүнд:

- ТХГН-ийн байгалийн өв, соёлын үнэт зүйлсийг хамгаалж, аялал жуулчлалын зохистой төлөвлөлт зохиож, хариуцах менежерүүд;
- Барилга, байгууламжийн зураг төслийг боловсруулж, засвар үйлчилгээ хийдэг төлөвлөгч, архитектор, инженер, барилгын ажилчид (жишээлбэл зам, жим, жуулчны мэдээллийн төв, бие засах газар, өндөрлөг харах цэгүүд гэх мэт);
- Шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг орон нутгийн бизнес эрхлэгчид (жишээ нь: хүнс, тээвэр, байр, мэдээлэн тайлбарлагчид);
- Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг арилжааны тур операторууд;
- Хамгаалалттай газар нутгийг сурталчилах нөхөрлөлийн болон аялал жуулчлалын маркетингийн байгууллагуудын ажилтнууд;
- Аялал жуулчлалын үр нөлөө, тухайн нутагт зочлох аялагчдын авах үр өгөөжийн талаар судалдаг судлаачид;
- Нутгийн иргэд, оршин суугчдад нийгмийн үзүүлэх үр нөлөөлөл, дасан зохицож түүнээс, шинэ боломжуудыг гаргаж авахад туслах хүмүүс;
- Хүрээлэн буй орчин, соёл, боловсролын материал хөгжүүлдэг харилцаа холбооны мэргэжилтнүүд.

Аялагчдын сэтгэлд нийцсэн, чанартай үйлчилгээ үзүүлэх нь дээрхи оролцогч тал бүрийн нэгдсэн үйл ажиллагааг шаарддаг. Тиймээс хүн бүр хариуцлагатай, үр дүнтэй ажиллахын тулд тодорхой ур чадварууд эзэмшсэн байх шаардагатай байдаг байна (Competible Working Group, 2002; McCool, et al., 2012; Appleton, 2016).

Чадавхийн төрлүүд

Чадавхи бэхжүүлэх үйл явц нь биет хэрэгцээ шаардлагыг хэрэгжүүлэх (жишээ нь хууль сахиулах, мэдээлэн тайлбарлах, жим тавих гэх мэт), стратегийн хэрэгцээ шаардлага, үзэл баримтлал, шүүмжлэлт сэтгэлгээний ур чадвар (алдаанаас сурах, уян хатан байх шаардлага, зорилго тодорхойлох, өөр хувилбарууд үүсгэх, шинэ асуудлуудыг үнэлж цэгнэх) зэргийг дамжуулан хүргэх үйл явц юм (McCool, et al., 2012; Appleton, 2016). Төгсгөл хэсэгт дурдагдсан чадавхиуд нь илүү биет бус хэлбэрээр илэрдэг (Wigboldus et al., 2010). Үүнд:

- Суралцаж, төвлөрч, стратеги боловсруулах;
- Тогтворгүй, байнга өөрчлөгдөж буй агуулгыг урьдчилан харж, тохирсон хариу арга хэмжээ авах;
- Ажилтнуудад урам өгч, дэмжих;
- Тухайн орон нутаг болоод орон нутгийн бус хүмүүсийн аль алинтай нийцтэй харилцах;
- Гүйцэтгэлийг сайжруулах үүднээс алдаанаасаа суралцаж, суралцсан зүйлсээ эргээд ашиглах.



Нидерландын Де Хоге Вуреевын байгалийн цогцолборт газрын хөтөчтэй дугуйн аялал. © Yu-Fai Leung

Аялал жуулчлалтай холбоотой дараах гурван төрлийн чадавхийг ТХГН-ийн менежерүүд эзэмшсэн байх шаардлагатайг McCool (2012) зэрэг судлаачид тэмдэглэжээ. Үүнд:

- **Стратегийн чадавхи:** ТХГН-ийн гүйцэтгэх үүргийг урт удаан хугацаанд үргэлжлэх орон зайд тооцоолж, орон нутаг, бүс нутаг, улс үндэстний, тэр бүү хэл олон улсын хүсэн хүлээж буй хүлээлттэй хэр уялдаж буйг тооцоолох.
- **Төлөвлөх чадавхи:** Аялал жуулчлал болон ТХГН-ийн менежментийн зорилтуудыг хооронд нь нэгтгэж, ТХГН-нь орон нутгийн эдийн засагт хэрхэн дэм өгч чадахыг тооцоолох.
- **Үйл ажиллагааны чадавхи:** Аялал жуулчлалыг удирдан, зохион байгуулахтай холбоотой өдөр тутмын хэрэгцээ шаардлагыг хангах.



Вилдернэс Сафарис компанийн хөтөч, тайлбарлагчдын сургалт. © Wilderness Safaris, Dana Allan

IUCN-ийн WCPA-ийн Тусгай хамгаалалттай газар нутгийн мэргэжилтнүүдийн чадавхийн дэлхийн бүртгэл (Appleton 2016: 116-123)-д ТХГН-т аялал жуулчлал, амралт зугаалга, олон нийтийн хэрэглээг удирдан, зохион байгуулахад шаардлагатай чадавхиудыг нэгтгэжээ. Чадавхиудыг үндсэн дөрвөн чиглэл, тодорхой хорин таван чадавхийн төрлүүдэд хуваажээ. Дөрвөн үндсэн чиглэлийн чадавхиудад дараах орно. Үүнд:

1. Байгаль орчин, эдийн засагт тогтвортой аялал жуулчлал, амралт зугаалгын үйл ажиллагаа хөгжүүлэх боломжийг нийт системийн хэмжээнд бий болгох;
2. ТХГН-т нийцсэн тогтвортой аялал жуулчлал, амралт зугаалгыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
3. ТХГН-т зорин ирэх аялагчдад зориулсан хөтөлбөр,



Намиби улсын Торри Байгалийн Нөөц газар дахь чадавхийг бэхжүүлэх, мэдлэг олгох уулзалтууд. © Wilderness Safaris, Mike Myers



Номхон Далайн Эргийн Цогцолборт нөөцийн газарт далайн түрлэгийг судалж буй нь, Бритиш Колумб муж, Канад улс. © Glen Hvenegaard

үйл ажиллагаа, үйлчилгээг төлөвлөж, удирдаж, хянах;

4. ТХГН-т зорин ирэх аялагчдыг хөтөлж, тусалж мөн хяналт тавих.

Дүгнэж хэлвэл аялал жуулчлалын удирдан зохион байгуулах мэргэжлийн чадавхиуд нь ТХГН-т болж буй эрчт хүчтэй, байнга өөрчлөгдөх нарийн төвөгтэй үйл явцыг танин мэдэх, шинэ тутам гарах бэрхшээл, боломжуудыг үнэлж цэгнэх, алдаанаасаа суралцах, ажилтнуудыг байгууллагын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд нь уян хатан, үр чадвартай болгох зэрэгт менежментийн багт дэмжлэг болдог (Appleton, 2016).

5.2 Менежерүүдийн чадавхийг бэхжүүлэх нь

ТХГН болон байгаль хамгааллын албадад аялал жуулчлалын төлөвлөлт, менежментэд мэргэшсэн ажилтнууд заавал байх ёстой. Хэрэв ажилтнууд сургалтанд хамрагдаагүй атлаа аялал жуулчлал, зочдын

Шигтгээ 5.1

ТХГН-ийн Байгаль Хамгаалах Хөтөлбөрийн Нутгийн Иргэдийн Менежмент (COMPACT)

ТХГН-ийн Байгаль Хамгаалах Хөтөлбөрийн Нутгийн Иргэдийн Хөтөлбөр нь (COMPACT) нь 2000 оноос НҮБ-ын ЮНЕСКО-гийн Дэлхийн Өвийн дурсгалт газрыг хамгаалах, удирдах ажилд орон нутгийн иргэдийг оролцуулах үйл явцыг судалж иржээ. Энэхүү хөтөлбөр нь НҮБХХ/Даян Дэлхийн Байгаль хамгаалах сангийн Жижиг буцалтгүй тусламжийн хөтөлбөр, НҮБ-ын Сан (UNF) хоорондын хамтын ажиллагаа юм. Нутгийн иргэдэд суурилсан байгаль хамгааллын төслийн кластеруудыг дэмжих зорилгоор COMPACT нь 50,000 ам.доллар хүртэлх бага хэмжээний буцалтгүй тусламжийг ашигладаг.

COMPACT-ийн үнэлгээ, төлөвлөлтийн үйл явцын үр дүнд аялал жуулчлал нь ихэвчлэн орон нутгийн эдийн засгийн гол бүрэлдэхүүн хэсэг болохын дээр хэрэв зохицуулалтгүй орхивол ТХГН-т аюул заналхийлэл болж хувирдгийг тодорхойлдог байна. Мөн чанараараа өндөр оролцооны шинж чанартай COMPACT-ийн арга зүй нь суурь үнэлгээ, үзэл баримтлалт суурилсан загвар, байршлын стратеги гэсэн гурван бүрэлдэхүүн хэсэгтэй. Энэ арга нь ирээдүйн аялал жуулчлалын хөгжүүлэлт, гарах үр нөлөөнд хяналт, үнэлгээ хийх үндэс суурийг тавьдаг.

COMPACT-ийн эхний хоёр үе шат нь Дэлхийн Өвийн дурсгалт газарт бүртгэгдсэн, эсвэл урьдчилсан жагсаалтад багтсан, дэлхийн есөн улсыг хамарсан найман төсөлд чиглэгджээ. Үүнд:

- Белизийн Шүрэн Арлын Нөөц Газар (Белиз)
- Морне Триос Питонсийн Цогцолборт Газар (Доминикан)
- Кенийн Уулын Байгалийн Цогцолборт Газар (Кени)
- Сиан Каан Биосферийн Нөөц Газар (Мексик)
- Пуэрто Принцесагийн Газар Доорх Голын Үндэсний Цогцолборт Газар (Филиппин)
- Килиманжаро Уулын Байгалийн Цогцолборт Газар (Танзани Нэгдсэн Улс)
- Джоудж - Джавалингын Хил Дамнасан Биосферийн Нөөц Газар болон Дэлхийн Өв (Сенегал, Мавритан)
- Мадагаскарын баруун өмнөдөд орших таван хэсэг ТХГН-ууд

Белизийн хувьд жишээ татахад COMPACT-ийн суурь үнэлгээ нь Белизийн Шүрэн Арлын Нөөц Газрын Систем ба Дэлхийн өвийн бүртгэлтэй тус газарт учруулж дээр загас агнуур, аялал жуулчлалыг тогтворгүй үйл ажиллагааны аюул, эрсдэлээс сэргийлэхэд ашиглагддаг. Үүнтэй зэрэгцэн аялал жуулчлал болон загасчлал нь нутгийн амьжиргаанд хамгийн чухал үйл ажиллагаа гэдгийг олон нийт өөрсдийн үнэлгээгээрээ тодорхойлжээ. Иймд байгаль хамгаалал болон эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг хооронд нь уялдуулахын тулд COMPACT –ийн хүрээнд хөтөч, усанд шумбалтын зааварлагч, спорт загасчлалын мэргэжилтэн зэрэг сургалтаар дамжуулан далайчдыг аялал жуулчлалын ажилтнууд болгожээ. Энэхүү шилжилт нь улмаар далайн нөөцийг хамгаалах үйл хэргийг эхлүүлсэн нь эдүгээ байгаль хамгаалах үйл ажиллагаа болон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд гол түшиг тулгуур болох болжээ.

COMPACT-ийн боловсруулсан арга, туршлагаас хуримтлуулсан мэдлэг нь цаашид Дэлхийн өвийн конвенцийн хүрээнд шинэ санал, санаачилгуудыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл хэмээн тооцогдож байна.

Эх сурвалж: UNDP/GEF Small Grants Program, 2012; Brown & Hay-Edie, 2013

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

ТХГН дахь бүх төлөвлөлтийг дараах дөрвөн үндсэн үе шатаар дамжуулах. Үүнд: (1) байгаль орчин, нийгмийн үнэт зүйлсийн суурь үнэлгээ хийлгэх (2) байгаль орчин, нийтийн үнэт зүйлсэд нийцсэн загвар гаргах (3) газрынхаа төлөвлөлтийг хийх (4) байршлын менежментийн шаардлагатай тохируулгыг хянадаг хяналт, үнэлгээний систем бий болгох.

менежментийн ажилд томилогдсон байвал тэдэнд мэргэжлийн ур чадвар олж эзэмших боломж олгох нь чухал ач холбогдолтой байна.

Чадавхи бэхжүүлэхэд төрөл бүрийн арга хэрэглэж болно. Үүнд богино хугацааны сургалт, семинар зохиох, ТХГН-ийн хооронд эгч дүүсийн харилцаа бий болгох, ажилчдыг солилцох, хурал, симпозиум хийх, зөвлөгөө өгөх, менторинг авах, өөрийгөө хөгжүүлэх, сургуульд сурахаар чөлөө авах гэх мэт орно (McCool, et al, 2012). Албан ёсны боловсрол, сургалтанд хамрагдсанаар ТХГН-ийн захиргаа, аялал жуулчлалын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн зэрэг, диплом, гэрчилгээ, аялал жуулчлалын бусад гэрчилгээнүүд авах боломжтой байна. Чадавхийг саланги тусад нь авч үзэхээс илүү хөтөлбөрт суулгаж өгсөн нь дээр байдаг (Ackoff, 1996) (McCool et al., 2012). Жишээлбэл, Африкийн өмнөд хэсэгт IUCN-ийн WCPA-ийн гишүүдээр ахлуулсан баг ТХГН-ийн менежерүүдэд аялал жуулчлалын концессийн чиглэлээр чадавхи бэхжүүлэх, хэлхээ холбоо сайжруулах үе шаттай үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлсэн байна (Spenceley et al., 2010, Spenceley et al. 2017b).

5.3 Нутгийн иргэдийн чадавхийг бэхжүүлэх нь

Нутгийн иргэдийг ТХГН дахь аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцуулж, ашиг тусыг нь хүртээж, орон нутгийн чадавхийг буй болгохын тулд нутгийн иргэдийн талаар гүнзгий ойлголттой байх хэрэгтэй болдог. Тухайлбал хэн нь уугуул оршин суугчид болох, тэдэнд хүлээн зөршөөрөгдсөн сонирхогч талууд нь хэн болох, нутгийн иргэдийн амьдралд нөлөөлдөг өдөр тутмын үйл ажиллагаа, мөн хамтран ажиллахад саад болж магадгүй хүчин зүйлсүүд нь юу байгаа зэргийг мэдсэн байх шаардлагатай болдог (Шигтгээ 5.1). Нутгийн иргэдтэй мэдээлэл хуваалцаж, аялал жуулчлалын болзошгүй эерэг, сөрөг нөлөөллүүдийг таниулж, тэдний аялал жуулчлалын



АНУ-ын Хавайн Галт Уулын БЦГ-ын Мауна Лоа жимээр явган аялж буй нь. © Yu-Fai Leung

хөгжлийн талаархи төсөөллийг тусгах нь маш чухал юм. Суралцах, харилцан ойлголцох нь ажил үйлст тууштай хандах, орон нутгийн эрх эзэмшигч болон сонирхогч талуудын зүгээс нөөц, хүчин чадлаараа хөрөнгө оруулах алхам хийхэд нөлөөлдөг талтай.

ТХГН-ийн аялал жуулчлалын менежментэд иргэдийн оролцоог хангахад саад болох хүчин зүйлсэд дараах зүйлс орно. Үүнд: олон нийтийн оролцоог хязгаарласан эрх зүйн хязгаарлалтууд, олон ургальч үзэл тусгах боломжгүй болох, сонирхлын бүлгүүдийн ашиг сонирхол буурах (төрөл бүрийн шалтгаанаар) гэх мэт. Мөн хамтын оролцооны хэлбэрээр төлөвлөх арга барилын шийдвэр гаргах үйл явц нь өөрөө урт удаан хугацаа шаарддаг, иргэдийн оролцоог хангах нь санхүүжилтийн нэмэлт эх үүсвэр шаарддаг гэх мэт

Хүснэгт 5.1. Чадамжийг хөгжүүлэхэд олон нийтийн оролцоог үнэлэх шалгуурууд

Шалгуур	Үзүүлэлтүүдийн тодорхойлолт
Оролцооны зорилтууд	<ul style="list-style-type: none">Зорилго нь ... ардчилсан байдлыг хангах уу? Төслийг хүлээн зөвшөөрүүлэх явдал уу? Үр ашгийг тэгш хуваарьлах явдал уу?
Нөлөөлөлд автсан нутгийн иргэд хэн бэ?	<ul style="list-style-type: none">Аялал жуулчлалын мэдлэг, ухамсар ямар түвшинд байна вэ?Орон нутгийн байгууллагуудын чадавхи хэр вэ?Олон нийтийн манлайллын үүргийг тодорхойлсон уу?Оролцогчид чадавхыг бэхжүүлэх хүчин чармайлт гаргах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч байна уу?Оролцоо сайн дурынх уу?
Аялал жуулчлалын эрх эзэмшигчид болон оролцогч талууд хэн бэ?	<ul style="list-style-type: none">Нөлөөлөлд орсон эрх эзэмшигч болон оролцогч талуудыг тодорхойлсон уу?Эрх эзэмшигчдийг зохих ёсоор оролцуулсан уу?Оролцогч талуудын төлөөллийг сонгосон уу?
Олон нийтийн оролцоог үр дүнтэй байлгахад ямар арга ашиглах ёстой вэ?	<ul style="list-style-type: none">Урам зориг өгч, иргэдийн эвлэлдэн нэгдэхийг дэмжихОролцогч талуудыг цаг хугацаанд нь сургалтанд хамруулж, санхүүжүүлж, мэдээллээр хангаж чадсан уу?Уулзалт, яриа хэлэлцээрийн товыг хангалттай хугацааны өмнө өгч чадсан уу?Аялал жуулчлалтай холбоотой аж ахуйн нэгжүүд оролцооны үйл явцад идэвхтэй оролцохоор байна уу?Оролцогчдын эсвэл төлөөлөгчдийн тоо удирдан зохион байгуулалтад оруулахад тохиромжтой юу?Цаг хугацааг тодорхой тогтоож чадсан уу?Шууд санхүүжүүлэх, бодит гар бие оролцох, ложистикийн тусламж үйлчилгээнүүд байна уу?

Эх сурвалж: Wisansing, 2008

Шигтгээ 5.2

Орчны бүсийн нутгийн иргэдийн чадавхийг бэхжүүлэх нь

ТХГН-ийн орчны бүс дахь аялал жуулчлалын жижиг дунд аж ахуйн нэгжүүд санхүүгийн хувьд тэр бүр ашигтай байж чаддаггүй. Шалтгаан нь бүтээгдэхүүн үйлчилгээ нь зах зээлийн бодит эрэлт хэрэгцээг хангаж чаддаггүй, нэгнээсээ ялгарах зүйл багатай, ижил төрлийнх байдгаас болж хоорондоо хүчтэй өрсөлдөж, ашиг шим муутай хоцордог зэргээс үүдэлтэй юм.

Никарагуагын Ометепе арал дахь нутгийн иргэдэд суурилсан (42,000 оршин суугч) аялал жуулчлалын байгууламжийн асуудлыг авч үзье. 2012 оны байдлаар Ометепед донорууд дэмжсэн, тус бүр нь 11-60 өрхийг хамарсан, жуулчдыг гэртээ хонуулдаг 6 төсөл хоорондоо өрсөлдөж байв. Гэвч ихэнх тур оператор компаниуд зочид буудлууд ашиглаж, аялагчиддаа өдрийн цагаар галт уул руу аялах, шөнийн цагаар ресторанд хооллох зэрэг түгээмэл маршрут санал болгож байжээ.

Нутгийн иргэдэд зах зээл, аялагчдын бодит эрэлт хэрэгцээний талаар мэдээлэл, үнэлэх арга хэрэгсэл өгөөгүй байна.

Эко аялал жуулчлалын Жи Адвентурс компанитай холбоотой Планетера сан нь илүү үр ашиг өгсөн, зорих газрын зах зээлд суурилсан аж ахуйн нэгжүүд байгуулах зорилтын хүрээнд айлаар хоноглох төслүүдийг судалжээ. Үүгээр ихэнх айл өрхөд жуулчдыг гэртээ хонуулахад хамгийн наад захын шаардлагатай зүйлс болох угаалгын өрөө, цахилгаан, карантны усгүй болохыг тогтоожээ. Цаашилбал эдгээр өрх айлуудад дээрхи ахуйн хэрэглээний

зүйлс байсан ч гэлээ бизнесийн хувьд явган аялал, хоолны үйлчилгээ үзүүлбэл илүү зохимжтойг тогтоожээ. Иймд Планетера сангийн зүгээс нийлүүлэлтийн сүлжээнд бичил аж ахуйн нэгж байгуулах төлөвлөгөө боловсруулж, Улмаар бизнесийн шинэ чиглэлийг дэмжих зорилгоор тус бүр 1,000 ам.доллараас ихгүй дүнтэй хэд хэдэн буцалтгүй тусламжийг өгсөн байна. Үүнд органик бордоо үйлдвэрлэх гурван өрх айл, зочид буудал, жуулчин хонуулдаг айлуудад даршилсан жимс борлуулах эмэгтэйчүүдийн нэг бүлэгт, жуулчдад үзүүлбэр үзүүлэх хувцас, бүжиг дэглэлтэд зориулж нутгийн уугуул иргэд зэрэгт олгожээ. Хуванцар савны хэрэглээг багасгах зорилгоор хөтөч, тайлбарлагч нарыг зэвэрдэггүй ган саваар хангажээ. Мөн бизнесийн үндсэн ур чадвар өгөх сургалтад санхүүжилт олгосон байдаг. Энэхүү хөтөлбөрөөр олсон амжилтаа эдүгээ Жи Адвентур компани дэлхий даяар сурталчилан ашиглаж буй бөгөөд олон нийтийн хэрэгцээг дэмжсэн 50 ижил төстэй төслийг цаашид хэрэгжүүлэхэд ашиглахаар зэхэж байна.

Эх сурвалж: Galaski, 2015; Planeterra Foundation, 2015



ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Нутгийн иргэдийн аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх чадавхийг үнэлж, хөрөнгө оруулалт хийхийн өмнө бизнесийн зохистой загварчлал хийгдсэн эсэхийг баталгаажуулах.

Жи Адвентурс болон Планетсагийн сангийн баг нутгийн иргэдийн ажиллуулдаг хоолны газарт, Ометепе (Никарагуа). © Megan Epler Wo

хүчин зүйлс байна (Pretty, 2005). Бусад саад болох зүйлсэд оролцогч талуудын дунд нийтлэг зорилго дутмаг байх; аялал жуулчлалын орон нутгийн хариуцагч өмчийн эзнийг тогтооход гарах бэрхшээл, оролцогч талуудын боловсрол, чадавхи, хэлний ур чадварын түвшин; аялал жуулчлалын үйл ажиллагааны талаарх мэдлэг хязгаарлагдмал байх гэх мэт орно.

Хүснэгт 5.1-д орон нутгийн иргэдтэй аялал жуулчлалын санаачилгатай холбоотой чадавхийг бэхжүүлэх талаар холбогдоход анхаарах шалгууруудын багцыг үзүүлэв.

Орон нутгийн иргэдийн чадавхи бэхжүүлэх хөтөлбөрийн жишээнд зэрлэг амьтад ажиглах аялал хийдэг тур операторын дэмжиж хэрэгжүүлсэн "Вилдернес Сафаригийн Хүүхдүүд"-ийг нэрлэж (Wilderness Safaris, 2017) болно. Африкийн хөдөөгийн хүүхдүүдэд манлайллыг хөгжүүлэх замаар ирээдүйн байгаль хамгаалагчдыг бэлтгэхэд чиглэсэн амьдрах ухаан заадаг хөтөлбөр

болно. Хөтөлбөр нь Вилдернес Сафаригийн зусланд жил бүр цөөхөн хэдэн хоног явагддаг ба хөдөөгийн сургууль, нутгийн иргэдийн дундаас 10-аас 17 хүртэлх насны 16-30 залуусыг сонгон байршуулдаг. 2001 оноос хойш 4,500 хүүхэд Вилдернес Сафаригийн (Wilderness Safaris, 2017) бааз байрладаг 7 улсад сургалтад хамтрагджээ. Хөтөлбөр маш амжилттай хэрэгждэг учир ивээн тэтгэгчдийг татаж, дэмжлэг авдаг болжээ. Никарагуа улсын Ометеп хотын нутгийн иргэд, засгийн газар, Планетера сан болон олон улсын аялал жуулчлалын тур операторын түншлэлийн үр дүнд бий болсон нутгийн иргэдийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр гарсан өөр нэгэн бүтээлч хөтөлбөрийг Шигтгээ 5.2-т үзүүлэв.

Шигтгээ 5.3 -т нь Энэтхэг улсын нутгийн иргэдийг түшиглэсэн хамгаалалттай газрын аялал жуулчлалын чадавхийг бэхжүүлэх өөр нэг жишээг харуулав.

Шигтгээ 5.3

Тенбанг Бапу-гийн Нутгийн Иргэдэд Түшиглэсэн Хамгаалалтай Газрын аялал жуулчлал ба байгаль хамгаалал (Энэтхэг улс)



Нутгийн иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр (Зүүн талд). Дэлхийн Байгаль Хамгаалах Сангийн багийн гишүүдтэй Тэмбанг тосгоны иргэд (Баруун талд). © WWF India

Дэлхий дахинаа хэдэн зуун мянган уугуул иргэдээс бүрдсэн Уугуул болон Нутгийн Иргэдэд Түшиглэсэн

Хамгаалалттай Газар Нутаг нь (ICCAs) дэлхийн гадаргуугийн томоохон хэсгийг хамардаг. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр ICCAs нь байгаль хамгаалах үйлсийг дэмжихийн хажуугаар нутгийн иргэдийн амьжиргаанд дориун хувь нэмэр оруулж чаддаг байна. Энэ үр ашгуудыг хараахан системтэйгээр бүртгэж авч амжаагүй ажээ.

Энэтхэгийн Зүүн Гималайд оршдог Аруначал Прадеш мужид Нутгийн Иргэдэд Түшиглэсэн Хамгаалалттай Газар (CCAs) хэд хэд байдаг. Эдгээр нь CCAs нь нутгийн иргэдийн уламжлан хамгаалж, зан заншлын хуулиар зохицуулагдаж ирсэн Мужийн Ангилалгүй Ой (MAO) бүсэд байрладаг.

Энэтхэг улс Дэлхийн Байгаль Хамгаалах Сан (WWF)-тай хамтран Аруначал Прадешийн баруун хэсэгт байрлах Монпа нутгийн иргэдтэй хамтран олон нийтийн харъяалалд орших ойг хамгаалж, байгаль хамгааллыг сайжруулах зорилгоор иргэдийн амьжиргааг сайжруулах чиглэлээр хамтарч ажилладаг. Энэтхэгийн WWF-ийн зүгээс Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (CBT) -ын төлөвлөгөө боловсруулахад тусалж, түүнийг хэрэгжүүлэхэд нь нутгийн иргэдийг сургасан байна. Монпас нь 50,000 хүн амтай Аруначал Прадеш мужийн Таванг болон Баруун Каменг дүүргүүдийн анхдагч овог аймгуудын нэг юм. 2005 онд Баруун Каменг дүүргийн Тэмбанг тосгоны Монпас нь тэдний хяналтад байсан 18 км² ойд Тэмбанг Бапугийн Нутгийн Игэдэд Түшиглэсэн Хамгаалалттай Газар (TBCCA)-ыг байгуулсан. Энэ нутаг одоо 635 км² талбайг хамарч, өтгөн ой, цаст уулс нь Улаан панда (*Ailurus fulgens*), цоохор ирвэс (*Uncia uncia*), Гантиг муур (*Pardofelis mar- morata*), Гималайн хар баавгай (*Ursus thibetanus*) зэрэг ховор ургамал, нэн ховордсон хөхтөн амьтдын амьдрах орчныг бүрдүүлдэг.

Тенбангийн CBT нь айлаар хоноглох дөрвөн гэр буудал (хамгийн ихдээ 10 жуулчин авах), гэр хоолны газар, Монпа урлаг, соёлыг үзүүлэх соёлын хамтлаг, НИТХГ-аар дамжин өнгөрөх явган аялал зохион байгуулж, бэлтгэгдсэн үйлчилгээ эрхлэгчдийг (хөтөч, тогооч, ачаа үүрэгч гэх мэт) хамруулдаг. Хөтөлбөр нь үр өгөөжийг аль болох өргөн олон түмэнд хүртээхийн тулд олон аймгийг хамардаг. Тенбангийн CBT нь хэрэгжиж эхэлснээсээ хойш орлогоо дөрөв дахин нэмэгдүүлж, 2013 онд 15,000 ам.доллар болгосон байна.

Аруначал Прадешийн Засгийн газар айлаар хоноглох гэр буудлын удирдамж боловсруулахдаа Энэтхэгийн WWF-ээс тусламж авсан байна.

Нутгийн иргэд (TBCCA)-ийн гуравны нэгийг Зэрлэг амьтдыг хамгаалах тухай 1972 оны хуулийн дагуу Нутгийн Иргэдэд Түшиглэсэн Нөөц Газар болгуулахаар хүсэлтээ ирүүлээд буй ажээ. Нутгийн иргэдийн хүсэлт нь цаашид орон нутгийн ой хамгааллыг бэхжүүлэх үндэс нь болно.

Эх сурвалж: Mishra, et al., 2006; Kothari, 2008

5.4 Түншлэлийн замаар чадавхийг бэхжүүлэх нь

Хүчин чадлыг бий болгох түншлэл нь жуулчдад өндөр үр өгөөж өгөх, тусгай хамгаалалттай газар нутгийн

байгалийн нөөцийг хадгалах зэрэгт тусалдаг (Шигтгээ 5.5). Вегнер болон бусад судлаачдын үзэж буйгаар хамтарсан түншлэл нь тулгарсан асуудлыг нэгдмэл, цогц байдлаар шийдвэрлэх боломж олгох замаар ТХГН-ийн агентлагуудын чадварыг нэмэгдүүлэх боломжтой болохыг онцолсон байдаг.

Шигтгээ 5.4

Нийнлий Жикийн ТХГН-ийн (загас агнуурын салбар) хамтын төлөвлөлт ба менежмент (Юкон, Канад Улс)

Нийнлий Жик (Загас агнуурын салбар) нь Канадын Юконы умард нутгийн 6,500 км² газар нутаг бүхий талбайг эзэлдэг, төр, нутгийн уугуул иргэдийн хамтын удирдлага бүхий газар юм. Энэ нутгийн 5,400 км²-г онгон нөөц газар, 170 км² -г экологийн нөөц газар эзэлдэг бөгөөд Юконы байгалийн Цогцолборт Газар, Нутгийн Хуулийн эрх зүйд хамрагддаг. 900 км² нь зэрлэг амьтдыг хамгаалах газар нутаг бөгөөд Юкон улсын Зэрлэг Амьтан, Ургамлын Хуулиар зохицуулагддаг. 140 км² газар нь Вунтут Гвитчиний уугуул индианчуудын эзэмшилд тус тус байдаг. Тус газар нутгийг анх 1995 онд Вунтут Гвитчиний Газрын гэрээгээр соёлын болон байгалийн өвийн үнэт зүйлсийг нь хамгаалахаар хамгаалалтад авсан байдаг. Жишээ нь энд Яргай загас, Хүрэн баавгай (*Ursus arctos*) зэрэг амьтдын ховор, чухал цугларалт болдог.

Гэрээ болон менежментийн төлөвлөгөө нь төрийн байгууллага, эрдэм шинжилгээ болон хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг бий болгож, тэдний тэргүүлэх үүрэг, шийдвэр гаргах эрх мэдлийг тодорхой заасан байна. Ялангуяа, Юконы нутгийн удирдлага өөрийн барилга байгууламжуудыг хамтарсан түншүүддээ түрээслүүлснээр, тэдгээрийн нуруун дээрээс хөрөнгө оруулалт хийх ачааг хөнгөлж, үүний зэрэгцээгээр өөрийн оролцооны эрх мэдлээ ч хангаад авдаг байна.

Түншүүд дараах үндсэн үйл ажиллагаануудаар ажлаа явуулж байна.



Канадын Нийнлий Жик ТХГН-т Хүрэн баавгайн зураг авч байна. © Frank Mueller Visuals

- **Менежментийн төлөвлөлт:** Тухайн газрыг хамтран удирдаж төлөвлөх үүрэгтэй Удирдан Зохион Байгуулах Агентлагуудын Хороог байгуулсан. Ингэснээр хувийн хэвшлийн бэлтгэгдсэн хөтөчтэй, барилга байгууламжийг хамгийн бага түвшинд байлгасан, судалгаа шинжилгээ, хяналт шалгалтыг хангах боломжтой болсон.
- **Эрсдэлийн менежментийн төлөвлөлт:** Түншүүд баавгай болон хүн хоорондын зөрчилдөөнийг багасгахын тулд менежментийн төлөвлөгөө боловсруулсан. Үүнд баавгай, яргай загасны тоо толгойд аялал жуулчлалаас үзүүлэх үр нөлөөг хамгийн бага байлгах үйл ажиллагаа, аюлгүй байдлын журам ямар байх, аялагчид баавгайтай тулгарах аюулыг багасгах, тулгарсан тохиолдолд яах вэ зэрэг асуудлуудыг хөнджээ. Хувийн хэвшлээс баавгай судлаач, хөтчүүд оролцож, эко аялал жуулчлал эрхэлдэг аж ахуйн нэгж баавгай хүний хооронд мөргөлдөөн үүсгэхгүйгээр зэрлэг амьтдыг үзэх бүтээгдэхүүний төлөвлөгөө боловсруулж тусалжээ.
- **Судалгаа ба хяналт:** Саймон Фрейзерын Их сургууль нь Баавгай, яргай загасны популяци, түүнчлэн баавгайн зан үйлийн үндсэн хэв шинжийг баримтжуулах судалгаа хийж, мөн мониторинги хийх протокол гаргажээ. Энэхүү ажил нь менежментийн үр дүнг үнэлэх үзүүлэлтүүдийг бий болгожээ.
- **Барилга, байгууламжийн хөгжүүлэлт, үйл ажиллагаа:** Вунтут Гвитчин Хөгжлийн Корпораци болон баавгай харах аялал зохион байгуулж байсан туршлага бүхий эко адал явдалт компани нар хоорондоо арилжааны хамтарсан компани байгуулсан. “Хөгшин Элээ” омгийн индианчууд тухайн газрын онгон байгальд тохирсон байгууламж барих ажилд оролцсон байдаг. Бага нөлөөлөл бүхий аялал (жишээлбэл, намрын улиралд нэг удаа очиход дөрвөн зочин, нэг хөтчөөс илүүгүй байх) - аар дамжуулан болзошгүй үр нөлөө, эрсдлийг багасгах зорилготой. Ангийн аялалыг зөвшөөрдөггүй бөгөөд амьжиргааны зориулалтаар агнах эрх бүхий уугуул иргэд өөрсдийн санал санаачилгаар эл нутагт ан хийхээ зогсоожээ

Эх сурвалж: <http://www.yukonparks.ca/>

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг холбогдох бүх талуудтай, тухайлбал уугуул иргэд, нутгийн иргэд, аялал жуулчлалын хувийн хэвшлийнхэнтэй хамтран боловсруулж байх.

Хэрэв орон нутагт байгаа хүмүүсийн хэрэгжүүлэх чадавхи нь сул байвал ТХГН-ийн аялал жуулчлалын хөтөлбөр нь амжилтад хүрэх магадлал бага билээ. Чадавхи бэхжүүлэх хүчтэй түншлэл нь харилцан ашигтай байх нөхцлийг бүрлүүлдэг: Төрийн байгууллагууд зорилгоо хэрэгжүүлэхийн тулд гаднаас дэмжлэг авдаг. Хувийн хэвшил нь орон нутаг, хамгаалагдсан бүсийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэхэд тусалж, ТББ-ууд нь эдгээр хүчтэй, тууштай түншлэлийг дэмжиж чаддаг. Гэвч түншлэлээр дамжуулан аялал жуулчлалын чадавхийг бэхжүүлэхэд бэрхшээлүүд гардаг билээ (Шигтгээ 5.6).

5.5 Шилдэг туршлагууд

- ТХГН дахь бүх төлөвлөлтийг дараах дөрвөн үндсэн үе шатаар дамжуулах. Үүнд: (1) байгаль орчин, нийгмийн үнэт зүйлсийн суурь үнэлгээ хийлгэх (2)

байгаль орчин, нийтийн үнэт зүйлсэд нийцсэн загвар гаргах (3) газрынхаа төлөвлөлтийг хийх (4) байршлын менежментийн шаардлагатай тохируулгыг хянадаг хяналт, үнэлгээний систем бий болгох.

- Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг холбогдох бүх талуудтай, тухайлбал уугуул иргэд, орон нутгийн иргэд, аялал жуулчлалын хувийн хэвшлийнхэнтэй хамтран боловсруулах
- Нутгийн иргэдийн аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх чадавхийг үнэлж, хөрөнгө оруулалт хийхийн өмнө бизнесийн зохистой загварчлал хийгдсэн эсэхийг баталгаажуулах.
- Түншлэлээр гүйцэтгэсэн бүх ажил үйлсийг, тухайлбал түншүүдийг элсүүлэх, тэдэнтэй харилцаагаа хадгалахад зарцуулсан цаг хугацаа зэргийг бүртгэж, талууд хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгах.

Шигтгээ 5.5

Түншлэлээр дамжуулж чадавхи бий болгосон “Африкийн Нөөц” (Africa’s Recourse)-ийн туршлага



Иргэд ба Цогцолборт Газрын гарын авлага. (Зүүн). Гарын авлагыг нутгийн иргэд ашиглаж байна (Баруун). © Dani Ndebele

Түншлэлийн замаар чадавхийг бэхжүүлэх маш сайн жишээ бол GIZ (Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг) санхүүжүүлдэг Өмнөд Африкт төвтэй Африкийн Нөөц юм. Африкийн Нөөц нь байгалийн аялал жуулчлалын эх үүсвэрийг бүрдүүлдэг нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг (CBNRM) хэрэгжүүлэх шилдэг туршлагын удирдамжийг боловсруулсан байна.

2003 онд IUCN-ийн WCPA дараагаас Өмнөд Африкийн Байгаль орчны асуудал эрхэлсэн газар (DEA) нь хамгаалагдсан бүс нутгийн байгалийн нөөцийн менежментэд иргэдийн оролцоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилтууд тавьжээ. DEA-ийн Хүн ба Парк хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд байгаль орчныг хамгаалах, түүний дотор тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх чадавхийг бий болгох шаардлага үүссэн байдаг.

DEA ба Африкийн Нөөц нь Үндэсний Сугалаа Түгээх Итгэмжлэх Зөвлөлөөс санхүүжилт авсан байдаг. Энэхүү түншлэл нь Африкийн Нөөц ТББ-д чадавхи нэмэгдүүлэх гурван талт аргыг хэрэгжүүлэх боломжийг олгосон юм. Үүнд: (1) Хүн ба Паркийн аялагчдад зориулсан гарын авлагын иж бүрдлийг шинээр хөгжүүлэх; (2) “Театраар Хүрэх Хөтөлбөр”-ийн жүжиглэх урлагийг ашиглан CBNRM-ийг сурталчлах ашиглах; (3) орон нутгийн бизнес эрхлэгчдийг хамгаалагдсан бүсийн эдийн засагт оролцоход саад болж буй сургалтын цоорхойг тодорхойлох ур чадварын эрчимжүүлсэн аудит. Гурван жилийн хугацаатай энэ төслийн үед улсын хэмжээнд хамгаалалттай 30 газар нутагт ажиллаж, 1,400 гаруй хүнийг хамруулсан байдаг. Энэ нь засгийн газрын зүгээс өөрийн орны нөөцийн менежментийн юунд анхаарвал зохихыг тодорхойлж өгсөний үндсэн дээр ижил төстэй үзэлтэй хандивлагчийн санал санаачилгаар орон нутагт боловсрол, танин мэдэхүйн сургалт хийх туршагатай төрийн бус байгууллагаар дамжуулан хэрэгжүүлж буй түншлэлийн хамтын ажиллагааны сайн жишээ юм. Сургалтын энэхүү өвөрмөц арга зүй нь одоо бүтэц, зохион байгуулалтанд орж, Өмнөд Африкийн Зэрлэг Амьтдын Коллеж нь суралцагчдад итгэмжлэгдсэн CBNRM сургалтыг явуулдаг байна.

Эх сурвалж: <http://www.resourceafrica.org/directory/background.html>

Шигтгээ 5.6

Аялал жуулчлалын менежментийн түншлэл: АНУ-ын Ойн алба (USFS)-ны жишээ



ШИЛДЭГ ТУРШЛАГА

Түншлэлээр гүйцэтгэсэн бүх ажил үйлсийг, тухайлбал түншүүдийг элсүүлэх, тэдэнтэй харилцаагаа хадгалахад зарцуулсан цаг хугацаа зэргийг бүртгэж, талууд хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгах.

Марбел Крийкийн Отоглох Цэгийн Найзууд гэдэг нь 2006 онд хамгаалалтаас гаргахаар эзхэж байсан Марк Твайн Үндэсний Ойн Хүрээлэнгийн отоглох цэгүүлийг засаж, сэлбэх зорилготой байгуулагдсан сайн дурынхны байгууллага юм. © Erin Seekamp

АНУ-ын Ойн Алба (USFS) нь АНУ-ын нийтийн газар нутгийн хамгийн том хэсгийг (155 улсын ой, 20 бэлчээр нутаг) удирдан зохион байгуулдаг. USFS-ны зарим хэсгийг ТХГН-ийн хэмжээнд удирддаг ба биологийн олон янз байдал, амралт зугаалга, үзэсгэлэнт газрууд гэх мэт олон талын үр өгөөж өгдөг учир аялал жуулчлалаараа ихээхэн алдартай. Сүүлийн жилүүдэд төсөв, боловсон хүчний хомсдол гарах болсон мөн ойн менежментэд олон нийтийн оролцоог өргөжүүлэх эрмэлзэл бий болсон зэрэг нь түншлэлийн харилцааг улам ач холбогдолтой болгож ирсэн байна. Өмнө нь хоёрдагч чанарын зүйлс дээр хамтран ажилдаг байсан бол илүү гол чиг хандлагатай зүйлс дээр хамтран ажиллах болжээ. USFS нь бүх түвшиндээ түншлэлийн зохицуулагч, сайн дурын ажилтнуудыг хөлсөлж, 2003 онд түншлэлийн удирдамж, арга хэрэгсэл, техник, бодлогын мэдээллийг түгээх зорилгоор Үндэсний Түншлэлийн Албыг байгуулсан байдаг.

Ойн албаны түншлэлийн талаархи соёл, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын ажлууд хийсэн хэдий ч саяхан хийгдсэн судалгаагаар үндэсний ойн газрууд, тэдгээрийн дүүргүүдэд түншлэлийн үйл ажиллагаа явуулхад засаг захиргааны зүгээс үзүүлэх дэмжлэг харилцан адилгүй байгаа нь харагджээ. Түншлэлийн харилцааны цар хүрээ голдуу хувь ажилтны санал санаачилга дээр тогтоож байв. Судалгаагаар түншүүдтэй ажиллах сэдлүүд нь дараах зүйлсийг хамарч байжээ. Үүнд: байгаль хамгааллыг дэмжих, байгууллагынхаа итгэлийг олж авах, газар нутаг удирдан зохион байгуулж буй төрийн байгууллагын үүрэг гэж үзэх, хувь хүний хувьд хөгжил дэвшил гэж харах гэх мэт оржээ. Үүнээс хархад дээрхи мэт үзэл бодолтой, итгэл үнэмшилтэй хүмүүсийг стратегийн хувьд ажилд авах нь ач холбогдолтой гэдэг нь харагдсан байна.

Хөрш зэргэлдээх орон нутгийн иргэдийн хандлага, сэдэл ямар байхаас шалтгаалж Ойн албанаас түншлэлийн талаар өөр өөр хандлагыг авч ашигласан байдаг. Сайн дурын идэвхтэн ихтэй газруудын ойролцоох зарим ойн дүүргүүд (үүнд аялал жуулчлал өндөр хөгжсөн, иргэд хоёр дахь орон сууцаа өмчилдөг хот суурин газар, аялал жуулчлалын зорин очдог газрууд багтна) сайн дурын ажилчдыг сургаж, хэрэгцээт төсөлд нь олж өгдөг “шүхэр” байгууллагатай түншлэн ажилладаг. Аялал жуулчлал багатай, амралт, зугаалгын зорилгоор хоёр дахь орон сууц өмчлөх түвшин багатай хөдөө орон нутагт байрладаг ойн дүүргүүдийн хувьд албаныхаа хүчин чармайлт, түншлэлийн үр нөлөөг дээшлүүлэх үүднээс өндөр зохион байгуулалттай бүлгүүдтэй түншлэн харилцах стратегийн шийдвэр гаргасан байдаг.

Хязгаарлагдмал нөөцтөйн улмаас түншлэл хөгжүүлэхийг зорьж буй засгийн газрын агентлагууд болон хувийн хэвшлийн аялал жуулчлалын менежерүүдэд хүргэх гол захиас бол түншлэлтэй холбоотой хийж буй ажил бүрийг сайтар бүртгэж, тэмдэглэж байх явдал юм. Үүнд түншүүтэй хийсэн сургалт, зарцуулсан цаг, ажилтанг авах, түүнтэй харилцах зэргийг бүртгэж, ажил үүргийн хуваарьт тусгаж, урамшууллаар шагнаж, хүлээн зөвшөөрөгдсөн байх учиртай. Иймэрхүү ажилд ажилтнууд нэлээдгүй цаг зав, хүчин чармайлт гаргадаг тул хийсэн ажил бүрээ баримтжуулж, урамшуулж байх нь ажилд тустай байдаг байна.

Эх сурвалж: Seekamp & Ceverny 2010; Seekamp, et al., 2011; McCreary, et al., 2012.; Seekamp, et al., 2013

Аялал жуулчлалын
орлого, зарлагыг удирдан
зохицуулах замаар
байгаль хамгааллыг үр
дүнд хүргэх нь


6



6.1 Биологийн олон янз байдлыг хамгаалахад учирдаг санхүүгийн хомсдол

ТХГН-ийн үндсэн зорилго нь биологийн болон янз байдлыг хамгаалахад оршдог. Аялал жуулчлал хөгжих тохиромжтой газарт түүнийг зөв хөгжүүлвээс ТХГН-ийн үйл ажиллагааг санхүүжүүлхэд тус дэм болох боломжтой. Энэхүү бүлэгт ТХГН-уудын хувьд санхүүжилтийн уламжлалт эх үүсвэрээс өөр эх сурвалж олох шаардлага улам өсөн нэмэгдэж буй талаар, мөн түүнийг аялал жуулчлалаас хэрхэн олж болох тухай дурьдана. Орлогын олон төрлийн эх сурвалжууд, тэдгээрийг хэрхэн ашиглаж буйг, мөн дэлхий дахинд тэдгээрийг хэрхэн хэрэглэж буй талаар зарим хэрэгжүүлэгч байгууллагуудын зөвлөгөөг танилцуулна. Аялал жуулчлал нь ТХГН-ийн удирдлагуудын хувьд санхүүгийн эх үүсвэрүүдийн нэгд ордогийг цохон тэмдэглэж, аялал жуулчлалаас олох орлого, түүнийг зарцуулахтай холбоотой хэд хэдэн асуудлуудыг энэ бүлэгт мөн хөндөнө. Дараагийн ээлжинд ТХГН-ийн тодорхой байршлын түвшинд аялал жуулчлалаас шууд орлого олох боломжуудад дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ зардлыг хэмнэх замаар ТХГН-ийн үр нөлөө, үр ашгийг дээшлүүлж, санхүүжилтийн хэрэгцээг хэрхэн багасгаж болох талаар авч үзнэ. Бүлгийн эцэст аялал жуулчлалын эдийн засгийн ерөнхий үр өгөөжийн талаар хэлэлцсэнээр өндөрлөнө.

Биологийн олон янз байдлыг хамгаалах, ТХГН-ийн менежментийг хэрэгжүүлэхэд санхүүжилт дутмаг байх нь түгээмэл тохиолддог (UNEP-WCMC & IUCN, 2016).



Эх сурвалж: Adapted from Huwyler, et al., 2014

Хамгаалалтын захиргаадууд байгаль орчны менежмент явуулах санхүүжилтээр улам бүр дутагдсаар байгаа бөгөөд ТХГН-ийн санхүүжилтийг бүрэн шийддэг улс орнууд цөөхөн байна (Buckley, 2003b; Eagles, et al., 2012; Mitchell, et al., 2013; Weaver & Lawton, 2017). Ихэнх ТХГН-ууд нь төрийн санхүүжилтээс хамааралтай байгаа бөгөөд (Bovarnick, et al., 2010), хөгжингүй орнуудад ч гэсэн төр нь төсвийн тэнцвэржүүлэлтээ хангахын тулд ТХГН-ийн төсвийг танах явдал тохиолдсоор байна (Parks Forum, 2012). Үүний улмаас ТХГН-ийн хамгаалалтын захиргаадын хувьд хувийн хэвшлээс орлогоо бүрдүүлэх, нэмэлт эх үүсвэр олох дамрамт шахалтанд орж буй билээ (Watson, et al., 2014). График 6.1-д байгаль хамгааллын санхүүжилтэд гардаг хомсдолыг харуулав. Байгаль хамгаалах үйл ажиллагааны санхүүжилтийг төр болон уламжлалт тусламж, хандивын эх сурвалжууд бүрдүүлсэн хэвээр байгаа боловч хэмжээг нь ядаж хоёр дахин нэмэгдүүлэхийн зэрэгцээ хувийн салбараас орж ирэх хөрөнгө оруулалтыг 20-30 дахин нэмэгдүүлж байж байгаль хамгаалах үйл ажиллагааг санасан хэмжээд гүйцэтгэх дүр зураг харагдаж байна.

Санхүүжилтийн цоорхойг нөхөх энэхүү шаардлага нь зөвхөн аялал жуулчлал төдийгүй бусад орлогоо нэмэгдүүлэх боломжит хувилбаруудын жагсаалтыг гаргахад хүргэжээ. Хүснэгт 6.1-д ТХГН-ийн санхүүжилтийг бий болгох боломжит хэлбэр, механизмуудыг товчлон үзүүлэв.

Аялал жуулчлал нь зах зээлд суурилсан орлого олох арга хэлбэрүүдийн зөвхөн нэг нь бөгөөд байгаль хамгаалахад шууд үр ашигаа өгнө гэж байдаггүй (Шигтгээ 6.1). Орлогын төрлийг солонгоруулах нь хямралд өртөх, жуулчдын нэвтрэх хураамжийн хэмжээ буурах зэргээс шалтгаалж орлого тасалдах явдлаас ТХГН-уудад сэргийлдэг ач холбогдолтой юм.

6.2 Аялал жуулчлалын төлбөрөөс орлого бүрдүүлэх нь

Аялал жуулчлалын ашиглалтын хураамж гэх мэт зах зээлд суурилсан санхүүжилтийн аргууд нь ТХГН-ийн үйл ажиллагааг илүү үр ашигтай, тэнцвэртэй, байгаль орчинд тогтвортой болгож, ТХГН-ийг санхүүжүүлэхэд хувь нэмэр оруулж байдаг (Хүснэгт 6.2). Олон улс оронд (жишээлбэл Канад, Өмнөд Африк) жуулчид, тур оператор, хөрөнгө оруулагчдаас үйлчилгээний, барилга байгууламж ашигласны хураамж авах гэх мэт арга замаар ТХГН-ийнхаа санхүүжилтийн эх үүсвэрийн тоо, төрлийг нэмэгдүүлжээ (van Sickle & Eagles, 1998; Spenceley, 2004). Энэ нь төрийн төсвийн санхүүжилт хийгдэх тэргүүлэх чиглэлүүд өөрчлөгдсөнтэй уялдан гарч байгаа юм (Spenceley, et al., 2017a). Өмнө нь зөвхөн хувийн байгууллагад төвлөрдөг байсан аялал жуулчлалын үр ашгаас ТХГН хүртээх боломжийг ашиглалтын хураамж олгодог. Түүнийг хамгийн их ачаалалтай газарт зарцуулах, доройтсон газрыг нөхөн сэргээх (Kibira, 2014), мөн менежментийн ерөнхий үйл ажиллагаанд зарцуулж болдог. Гэвч ихэнх ТХГН-уудад санхүүжилтийн олон эх үүсвэр хэрэг болох ба аялал жуулчлалаас олох орлого нь төрийн санхүүжилтийг орлох биш харин хавсран дэмжсэн байх зорилготой юм.

Хүснэгт 6.1. Хамгаалалттай газар нутгуудыг санхүүжүүлэх арга хэлбэрүүд

1. Гадаад урсгал	2. Зах зээлийн механизм	3. Зардал хэмнэх арга хэлбэрүүд
<ul style="list-style-type: none">Засгийн газрын төсөвХандивлагч, хоёр болон олон талт хамтын ажиллагааны тэтгэлэгүүдБайгаль орчны итгэлцэлийн сангуудБиологийн олон янз байдал болон нийтэд туслах санБайгаль орчинд зориулагдсан татвар ба татаасуудБайгаль орчны зөрчлийн торгуульСалбар хоорондын төсвийн орлогын шилжүүлэгХандивын татварын хөнгөлөлтХувь хүний хандивХувийн хэвшлийн хандивБайгальд зориулсан өрийн солилцоо	2а. Аялал жуулчлалын орлого	<ul style="list-style-type: none">Хувийн салбар, төрийн бус байгууллагууд болон нутгийн иргэдийн хамтын менежментийн хэлбэрүүдТөр хувийн хэвшлийн хамтын ажиллагааҮйл ажиллагаанд суурилсан хамтын ажиллагааСайн дурынхан ба дадлагажигчид
	<ul style="list-style-type: none">Нэвтрэх хураамжГэрээний (концесс) хураамжҮйл ажиллагааны хураамжАялал жуулчлалын татварОрны (зочид буудлын) шимтгэлЗогсоол, газрын шимтгэл	
	2б. Нөөц ашигласаны төлбөр	
	<ul style="list-style-type: none">Мод, модон бүтээгдэхүүнийБиологийн нөөц ашигласныЗагас агнуурынБиоаюулгүй байдлынАнгийн төлбөрХөдөө аж ахуйн	
	2в. Экосистемийн үйлчилгээний төлбөр	
	<ul style="list-style-type: none">НүүрстөрөгчийнУсны чанарУрсац зохицуулалт	
	2г. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх нь	
	<ul style="list-style-type: none">Далайн амьтан ургамалГазрын тос/хийДэд бүтэц	

Эх сурвалж: Rylance & Barois, 2016

Шигтгээ 6.1

Аялал жуулчлалын зарлагыг байгаль хамгааллын үр дүнтэй холбох нь

Ялангуяа төрийн харъяалалтай хамгаалалтын захиргаадад тулгардаг түгээмэл бэрхшээл бол аялал жуулчлалаас орж буй орлого нь тухайн ТХГН-ийн менежментийн үйл ажиллагаанд эргэж ордоггүй явдал юм. Зарим тохиолдолд төсвөөс хамааралтай байгууллагын олсон орлого нь төсвийн нэгдсэн данс руу шууд ордог. Өөр бусад тохиолдолд олсон орлогын багахан хувь нь эргээд хамгаалалтын захиргаанд хуваарьлагдах эсвэл төрийн санхүү, төсвийн хувиарлалтын үйл ажиллагааны дунд алгуурлагдаж, менежментийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг. ТХГН-т аялал жуулчлал хөгжүүлэхийн өмнө үнэ тогтоох, төлбөр хураамж авах, тайлагнах, ашиг орлогоос өөртөө хувиарлах талаархи төрийн хууль, эрхзүйн зохицуулалт тодорхой байгаа эсэхэд анхаараарай. Аялагчид, аялал жуулчлалын бизнес эрхлэгчид нь төлөх төлбөр нь биологийн төрөл зүйлийг хамгаалахад шууд хувь нэмэр оруулах тохиолдолд төлбөр, төлөөс төлөхдөө огтхон ч цааргалдаггүй.

Түүнчлэн, аялал жуулчлалаас эдийн засаг, нийгэмд сайн үр нөлөө бодитойгоор үзүүлж буй тохиолдолд нутгийн иргэд аялал жуулчлалыг илүү талархан хүлээж авдаг.



Нэвтрэх хураамж нь Алдабра дахь Дэлхийн Өвийн байгаль хамгаалалд хэрхэн тус нэмэр болдогийг Вале дэ Майгийн Дэлхийн өв газарт байгаа мэдээллийн самбарууд дээр тайлбарлан үзүүлжээ. © Andrew Rylance

Аялал жуулчлалаас олох орлого нь бусад орлогуудтай хавсран нийлсэнээр, дараах үйл ажиллагаануудад зарцуулагдаж болно. Үүнд:

- Сэргээн засварлалт, дэд бүтцийн бүтээн байгуулалт (жишээлбэл авто зам, явган хүний жимүүд, усан онгоцны зогсоол, бие засах газар, таних тэмдэгүүд гэх мэт);

- Нутгийн иргэдэд үр ашгийг хуваарилах (жишээлбэл олон нийтийн дэд бүтэц, боловсрол, усан хангамж);
- Байгаль хамгааллын менежмент хийгээд аялал жуулчлал явагдаж байгаа нутаг орон, амьтан ургамлын амьдрах орчинг тэтгэх шаардлагатай газар
- Зорих газар нутгийн маркетинг, сурталчилгаа

Шигтгээ 6.3

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үйл ажиллагааг дэмжихэд аялал жуулчлалыг ашиглах нь: Хустайн Байгалийн Цогцолборт Газар (Монгол)



Хустай Байгалийн Цогцолборт газар дахь Тахь буюу Прежевальскийн зэрлэг адуу (Зүүн гар талд). Жуулчны бааз ба нарны цахилгаан үүсгүүрээр ажилладаг зарим барилга байгууламжууд (Баруун гар талд). © Цэрэндэлэгийн Дашпүрэв

Улаанбаатар хотоос 95 км-т орших Хустайн Байгалийн Цогцолборт газар (БЦГ) нь Монгол улсад байх 99 ТХГН-уудын нэг бөгөөд ЮНЕСКО-ийн Шим мандлын нөөц газрын нэг юм. Хустай нурууг Монгол улсын Засгийн газраас тус газарт Прежевальскийн адуу (*Equus przewalskii*) буюу Тахийг анх сэргээн нутагшуулахтай холбогдуулан 1993 онд тусгай хамгаалалтанд авчээ. Прежевальскийн адуу нь дэлхий дээр үлдсэн цор ганц зэрлэг адуу бөгөөд 1960-д онд байгальдаа устаж алга болсонд тооцогдож байв. Хусайн БЦГ нь дэлхий дээрх хамгийн том популяц буюу 340 гаруй тахь адуу чөлөөтэй идээшлэн амьдарч буй нутаг юм.

Байгаль хамгаалах ТББ болох “Хустайн траст” нь Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу 2003 оноос БЦГ-ын хамгаалалтын менежментийг хэрэгжүүлж буй Монголын цорын ганц ТББ юм. Хустайн БЦГ нь Засгийн газрын санхүүжилт авдаггүй бөгөөд нийт орлогын 80 гаруй хувийг аялал жуулчлалын орлогоос бүрдүүлдэг. Энэхүү орлогыг нэвтрэх хураамж, жуулчны баазад хоноглосны төлбөр, морь унуулах үйлчилгээ хөлс болон бэлэг дурсгалын зүйл борлуулсны орлого зэргээс бүрдүүлдэг байна. Үлдсэн 20 хувийг сайн дурын ажилтан, дадлагажигч оюутны төлбөр зэрэг судалгааны үйл ажиллагаа, хандив, хөнгөлөлттэй зээлийн хүү зэргээс бүрдүүлдэг. Хөнгөлөлттэй зээлийг БЦГ-ын орчны бүсэд амьдарч буй малчдад мал аж ахуйгаас өөр төрлийн орлого олох үйл ажиллагааг дэмжихэд, тухайлбал нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, хүнсний ногоо тариалах болон эсгий хийх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж олгодог байна.

Энэхүү загвар нь Хустайн БЦГ-ын цэвэр ашгийг нэмэгдүүлж, ТХГН-ийн байгаль хамгааллын үйл хэрэгт дам байдлаар ашиг тусаа өгчээ. Тухайлбал хууль бус агнуурыг бууруулж, Тахийг амжилттай сэргээн нутагшуулснаар БЦГ-ын голлох амьтдын төрөл зүйлийн тоо толгой өсөн нэмэгдсэнийг нь зэрлэг амьтдын мониторингийн үр дүн харуулж байна. Зэрлэг амьтдын тоо толгой өссөнөөр жуулчдад ирэх үр өгөөж ч өсөн нэмэгджээ. Аялал жуулчлалын дэд бүтэц, цогцолборт газрын захиргаа болон судалгааны төвүүдэд технологийн өөр шийдлүүдийг ашигласнаар (жишээ нь нарны зайн энергийг ашиглан шүршүүрийн усыг халаах гэх мэт) зардал хэмнэх боломжтой болсон.

Аялал жуулчлалын байгууламж барих, тоног төхөөрөмж зэргийн анх суурьлуулахад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байсныг Нидерландын Засгийн газар, Голландын ТББ болон Прежевальскийн Адууг Хамгаалах Сан зэрэг байгууллагуудаас гаргажээ. Гэсэн ч тогтвортой, санхүүжилтийн үр өгөөжтэй загвар хэрэгжүүлж чадсанаар хамгаалалтын захиргааны зүгээс аялал жуулчлалын хүчин чадал, чанарыг нэмэгдүүлж, хүртээмжийг бий болгохын зэрэгцээгээр байгаль орчинд ээлтэй материал ашиглан аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах боломжтой болжээ. Энэхүү жишээ нь ТББ ТХГН-ийн аялал жуулчлалыг хэрхэн амжилттай хөгжүүлж, орлого олж, төсвийн асуудлаа шийдэж болдогыг харуулж байгаа юм.

Эх сурвалж: Ц.Дашпүрэв, 2013; Хустайн Байгалийн Цогцолборт Газар, 2017



Хятадын Вулингуан Дэлхийн Өвийн Сайт Зангжианжэй Үндэсний Ойн цогцолборт газрын нэвтрэх хаалга болон зочдод үйлчлэх газрууд
© Yu-Fai Leung



АНУ-н Есемэти Үндэсний Паркийн Нэвтрэх Хураамжийн самбар
© Yu-Fai Leung

Өмнөд Африкийн хил дамнасан хамгаалагдсан газар нутагт жил бүр адал явдалт уралдаануудыг (Цөлийн Хаадууд, Тур дэ Тули, Тур дэ Пафури гэх мэт) орлого олохоос илүүтэйгээр зорих газруудыг сурталчилах зорилгоор зохион байгуулдаг (Шигтгээ 6.2).

Хил дамнасан аялал жуулчлалын талаарх нэмэлт мэдээллийг IUCN-ийн шилдэг туршлагуудын гарын авлагаас харж болно (Vasilijević, et al., 2015).

Аялал жуулчлалын хураамжийг байгаль хамгаалахад хэрхэн үр дүнтэй ашиглаж байгаа Монгол улсын жишээг шигтгээ 6.3-д харуулав. Энэ бүлгийн төсгөлд аялал жуулчлалын байршуулах хэрэгслээс олсон орлогоор нутгийн иргэдийн хөгжлийн санал санаачилгуудыг дэмжсэн ашиг хуваалцах үр дүнтэй механизмийг Намиби улсад хэрхэн бий болгосон талаар харуулах болно.

Нэвтрэх хураамж

Нэвтрэх хураамж нь жуулчдаас тухайн ТХГН-т нэвтрэхэд хураадаг хураамж юм. Энэхүү хураамжийг тогтмол эсвэл харъяалал (жишээлбэл: гадаад иргэд илүү мөнгө төлөх), орлого болон бусад олон хүчин зүйлийг харгалзан ялгавартай тогтоодог. Нэвтрэх хураамж нь байгаль хамгаалах шимтгэл (хамгаалалтын захиргааны үйл ажиллагааг шууд дэмжих нэмэлт хураамж), эсвэл жуулчдын дахин ирэхийг дэмжиж олон удаа нэвтрэх эрхийн хураамжаас бүрдэж болно. Санхүүжилтийн энэхүү механизмыг шийдлийг ашиглахдаа тухайн улсын онцлог, нийгэм, улс төрийн хүчин зүйлээс шалтгаалан хураамжийн хэмжээг харилцан адилгүйгээр тогтоодог.

Хүснэгт 6.3. ТХГН-ийн нэвтрэх хураамжуудын харьцуулсан үзүүлэлт

Улс	Тусгай хамгаалалттай газар	Нэвтрэх хураамж (том хүн)
Эквадор	Галапагос Байгалийн Цогцолборт Газар	<ul style="list-style-type: none">Нас болон үндэстнээс хамаарчГадаадын иргэд, ихэвчлэн \$100 ам. долларДотоодын иргэд: \$6 ам. доллар
Индонез	Комодо Байгалийн Цогцолборт Газар	<ul style="list-style-type: none">Гадаадын иргэд: өдрийн IDR 150,000 (Даваа–Бямба) (\$11 ам. доллар)Гадаадын иргэд: өдрийн IDR 225,000 (Ням болон бүх нийтийн амралтын өдөр) (\$16 ам. Доллар)
Өмнөд Африк	Кругер Байгалийн Цогцолборт Газар	<ul style="list-style-type: none">Гадаадын иргэд: өдрийн ZAR328 (\$23 ам. доллар)Бүсийн (SADC) иргэд: өдрийн ZAR164 (\$11.5 ам. доллар)Дотоодын иргэд/оршин суугчид: өдрийн ZAR82 (\$5.8 ам. доллар)
Их Британи	Лэйк Дистрикт Байгалийн Цогцолборт Газар	<ul style="list-style-type: none">Үнэгүй
Америкийн Нэгдсэн Улс (АНУ)	Ээверглэйдэс Байгалийн Цогцолборт Газар	<ul style="list-style-type: none">Машинтай зорчигч: \$25 ам. доллар (7 хоног хүчинтэй)Мотоциклтэй зорчигч: \$20 ам. доллар (7 хоног хүчинтэй)Явган/дугуйтай зорчигч: \$8 ам. Доллар (7 хоног хүчинтэй)
Зимбабве	Виктория Хүрхэрээ, Дэлхийн байгалийн өв	<ul style="list-style-type: none">Гадаадын иргэд: \$30 ам. долларБүсийн (SADC) иргэд: \$20 ам.долларНутгийн оршин суугч: \$7 ам. доллар

Эх сурвалжууд:
• Эквадор: <https://www.galapagosislands.com/travel/transportation/entry-fees.html>. Accessed on 9 November 2017.
• Индонез: <http://uberscubakomodo.com/komodo-national-park-fee/>. Accessed on 5 November 2017.
• Өмнөд Африк: <https://www.sanparks.org/parks/kruger/tourism/tariffs.php>. Accessed on 5 November 2017.
• АНУ: <https://www.nps.gov/ever/planyourvisit/fees.htm>. Accessed on 5 November 2017.
• Зимбабве: <https://victoriafalls24.com/blog/2017/01/23/2015-zimbabwe-national-parks-fees/>. Accessed on 5 November 2017.

Хүснэгт 6.3-д зарим улсад даган мөрдөж буй ТХГН-ийн нэвтрэх хураамжийн харьцуулсан үзүүлэлтийг харуулав. Нэвтрэх хураамжийн хэмжээ болон түүнийг хэрхэн бүрдүүлэх нь харилцан адилгүй (жишээлбэл бүх хүн тогтсон ижил нэг үнэ төлөх, эсвэл оршин суугчийн харъяалал, ямар тээврийн хэрэгсэл ашигласнаас хамааран ялгавартай байх гэх мэт) байдаг. Нэвтрэх хураамжийн хэмжээг тогтоохдоо эрэлтэд суурилсан (жишээлбэл тодорхой бүтээгдэхүүн, үйлчилгээг авахын тулд төлбөр төлөх эсэхэд бэлэн талаархи судалгааны дүнд үндэслэн) эсвэл тодорхой менежментийн зорилгоор, тухайлбал ороо үржлийн эмзэг үед зочдын тоог хязгаарлах, эсвэл орон нутгийн иргэдийг илүү дэмжих зорилгоор ялгавартай тогтоож болох талтай. Зарим оронд хамгаалалтын захиргаа нь нэвтрэх хураамж болон бусад ашиглалтын хураамжийг бие даан тогтоодог бол зарим улсад, жишээлбэл Мозамбикт, засгийн газрын баталсан дүрэм журмаар тогтоодог байна. Зарим улс оронд нэвтрэх хураамжийг улирлаар олон удаагийн тохиолдолд хямдруулах улмаар уг нэвтрэх эрхээрээ тухайн улсын бусад ТХГ-уудад орох давхар эрхийг олгодог (Өмнөд Африкийн Байгалийн Цогцолборт Газруудад хүчинтэй “Байнгын нэвтрэх үнэмлэх”). Зарчмын хувьд үнэ тогтоох арга нь хэдий чинээ түвэгтэй байна төлбөрийг хураах, түүнийг тайлагнах нь төдий чинээ төвөгтэй, цаг хугацаа шаарддаг нь гарцаагүй юм.



АНУ-ын Калифорни мужийн Есөмэти Байгалийн цогцолборт газрын жуулчдын мэдээллийн төвөөс хамгийн сүүлийн үеийн мэдээлэлд үндэслэн зочид хэрхэн аялах талаараа шийдвэр гаргаж байна. © Yu-Fai Leung

Шигтгээ 6.4

Танзани улсын ялгавартай тогтоосон нэвтрэх хураамжийн тухай

Танзани улсад ТХГН-ийг хариуцсан Танзанийн Зэрлэг амьтны хэлтэс/ Зэрлэг амьтны менежментийн захиргаа, Танзанийн Үндэсний Парк, Нгоронгорын галт уулын тогооны Хамгааллын захиргаа гэсэн гурван байгууллага ажилладаг. Энэ гурав үнийн хувьд эрс өөр хураамжууд тогтоосон байдаг. Хэдийгээр байгаль, соёлын үзвэр, зочдод үйлчлэх үйлчилгээний чанарын хувьд ялгаатай (төлбөр, хураамжийн хэмжээгээ ялгагддаг) боловч дээрх гурван байгууллага нь нэг ёсондоо хураамжийнхээ төлбөрийн хэмжээгээр өрсөлдсөн нь араасаа маргаан дагуулсан юм. Үнээр өрсөлдөхийн оронд үнийн бодлого дээрээ хамтран ажиллаж, аялал жуулчлалаас олох орлогоо нэмэгдүүлсэний дүнд улс орныхоо ТХГН-уудын байгаль хамгааллыг сайжруулсан дээр гэж шүүмжлэгчид дүгнэдэг.

ШИЛДЭГ
ТУРШЛАГЫН
ГОЛ САНАА

Нэвтрэх хураамжийг тогтоохын өмнө тухайн ТХГН-т (эсвэл ТХГН-ийн сүлжээнд) санхүүгийн үнэлгээг системтэйгээр хийх хэрэгтэй. Одоогийн нөхцөл байдал, орлого, зарлагад дүн шинжилгээ хийж, хураамжийн үнэд нөлөөлж болох байршил, байгуулагдсан он, олон нийтэд алдартай байдал зэрэг мэдээллийг ашиглан боломжит хувилбарыг сонгох хэрэгтэй.

Ангилал	Зэрлэг амьтны захиргаа									
	Ангийн нөөц		ЗАМЗ	Байгалийн цогцолборт газрууд						ГР
	С, И, Г,	Бусад нөөц газрууд	Бүгд	Сэр	Кил	Ар, Та, Мэн	Кат	Гомб	Мах	
Гадаад, том хүн	50	30	10	50	70	45	30	100	80	60
Гадаад, хүүхэд	30	15	5	30	20	15	10	20	20	20
Дотоод, том хүн	2.5	1	1	30	35	22.5	15	50	40	7
Дотоод, хүүхэд	1.5	0.5	0	10	10	7.5	5	10	10	

Төлбөр нь АНУ\$-р. Товчлол: ЗАМЗ = Зэрлэг Амьтны Менежментийн Захиргааны газрууд, ГР = Горонго Галт уулын газар; С = Селойс; И = Икошоро; Г = Грумети; М = Масва; Сэр = Сэрэнгейти; Кил = Киламанжаро; Ар = Аруша; Та = Таражейр; Мэн = Маниура Нуур; Кат = Катави, Микуми, Руава, Рубондо, Саадани, Китуло, Мкомази, ба Удзунва; Гомб = Гомбе; Мах = Махале.
Эх сурвалж: Spenceley, et al., 2017b

Шигтгээ 6.5

Галт уулын БЦГ-т Горилла харах үйл ажиллагааны хураамж (Руанда)

Руанда улсын Галт уулын Байгалийн Цогцолборт Газар дахь уулын Гориллаг харахаар ирдэг жуулчдаас олдог орлого нь тухайн улсын гадаадын валютаар олдог хамгийн том орлогын нэг бөгөөд жилд 200 сая ам. долларт хүрч, БЦГ-ын эргэн тойронд амьдардаг иргэдэд ажлын байр бий болгож байдаг. Шигтгээ 2.1 (Бүлэг 2) -т уулын гориллын аялал жуулчлалаас олж буй олон үр ашгийн талаар товч тайлбарласан. Энэ шигтгээнд жуулчдын нэвтрэх зөвшөөрлийн хураамж болон жуулчдын үйл ажиллагаатай холбоотой хураамжийн тухайд онцлох болно.

Жуулчдын хувьд гориллаг харах, богино хугацаанд ч тэдэнтэй хамт байх нь маш өвөрмөц мэдрэмжийг төрүүлдэг болохоор үүний төлөө 1,500 ам.доллар төлөхөд бэлэн байдаг. Учир нь дэлхийд зөвхөн 700 гаруй уулын зэрлэг горилла үлдсэн бөгөөд жилд 20 мянган жуулчдад л үзэх зөвшөөрөл олгогддог. Иймд жуулчлалаас олох орлого, нийт үнэ тогтоохдоо дараах бодлогыг баримталдаг:

- Хамгаалалтын захиргааны хамгааллын үйл ажиллагааны шаардлагатай санхүүжилтийг олгох;
- Жуулчдын тоог зохицуулах, жуулчдын сэтгэл ханамжийн баталгааг хангахын зэрэгцээ зэрлэг амьтдыг үргээж цочоохгүй байх
- Нутгийн иргэдэд байгалийн нөөцөө ашиглахад бус түүний үнэ цэнийг хамгаалах, алдагдуулахгүй байхад урамшуулал олгох (жишээлбэл; Руандагийн Вирунга Галт Уулын бүсэд байсан хулгайн анчид жуулчны хөтчөөр ажиллаж эхэлсэн).

Эх сурвалж: Spenceley, et al., 2010; Nielsen & Spenceley, 2011; Maekawa, et al., 2013; Spenceley, 2014a

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Аялал жуулчлалын байгууллага, жуулчид хэдий хэмжээний хураамж төлөхөд бэлэн байдлын судлагаа хийх, ижил төрлийн сонирхолтой жуулчдыг татахаар өрсөлддөг бүсийн болон орон нутгийн ТХГН-ийн хураамжийг жишиг үнэ болгох

Нэвтрэх хураамж өндөр байх, хямд байх, эсвэл огт байхгүй байх нь тухайн ТХГН-ийн зорилго, нөхцөл байдлаас хамаардаг (Шигтгээ 6.4). Шийдвэр гаргахад дараах хүчин зүйлүүд нөлөөлж болдог. Үүнд:

- **Нөхөн сэргэх зардал:** Өөрийн тодорхой үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлыг нөхөх зорилгоор. Жишээ нь явган аяллын жим тохижуулах гэх мэт.
- **Ашиг олох:** Давуулан биелүүлсэн орлогыг байгаль хамгаалах нэмэлт үйл ажиллагааг санхүүжүүлэх буюу эсвэл нөөцийн санд авч, санхүүгийн хямрал (жишээлбэл жуулчдын тоо багасах), эсвэл экологийн гэнэтийн сөрөг нөлөөллөөс (жишээлбэл шүрэн арал амьгүй болох) гарсан хор уршгийг багасгахад ашиглаж болно.
- **Байгаль хамгаалах уламжлалт үйл ажиллагааг санхүүжүүлэх нь:** Хуваарилагдсан төсөв өдөр тутмын байгаль хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй байх, эсвэл өөр ТХГН-ийг санхүүжилтийн дутууг нөхөхөд ашиглах.
- **Орон нутгийн бизнесийг дэмжих:** төлбөр, хураамжийг бага тогтоосноор жуулчдыг татах, ингэснээр нутгийн иргэдэд ирэх ашиг орлогыг нэмэгдүүлэх
- **Танин мэдэхүйг дэмжих нь:** Аялал жуулчлалаар дамжуулж, байгаль хамгаалах ач холбогдлыг сурталчилах
- **Аялагчдын тоо, ачааллыг тэнцвэржүүлэх:** Нэвтрэх хураамжийг өндөр тогтоох замаар ачаалал, экологийн хохиролыг багасгаж, хүмүүсийн хандлагыг өөрчлөх (Lindberg, 2001).

Энэхүү ялгаатай хэрэгцээг тэнцвэржүүлэхийн тулд ТХГН-ийн менежментийг хэрэгжүүлэхэд нэвтрэх хураамж нь ямар үүрэгтэй байдгийг ойлгох нь чухал юм. Тухайлбал,

хамгаалалтын захиргааны зүгээс үйл ажиллагаанаас нь гардаг үр нөлөөнөөс болж тодорхой төрлийн жуулчдыг хязгаарлаж болох юм. Энэ тохиолдолд эрэлтийг хязгаарлах үүднээс нэвтрэх хураамжийг өндөр тогтоох үндэслэл бүрднэ. Эсрэгээрээ орон нутгийн хүүхдүүдийг эцэг эхтэйгээ байгаль орчинд аль болох хамт цагийг өнгөрөөдөг болгоё гэвэл нэвтрэх хураамжийг бага тогтоох үндэслэл бүрднэ.

Жуулчдын үйл ажиллагааны хураамж

Жуулчдын амралт зугаалгын үйл ажиллагаатай шууд холбоотой төлбөр, хураамжид үйлчилгээний төлбөр (хөтөчтэй явган аялал), зөвшөөрлийн хураамж (явган аялал, ууланд авирах), амьжиргааны өртөг (хоол хүнс, орон байр) зэрэг төлбөр, хураамж багтдаг. Эдгээр төлбөрийг нэвтрэх хураамжаас гадна нэмж шууд авч болдог. Зарим тохиолдолд жуулчдаас олон удаа, олон жижиг төлбөр авахаар нэхэмжилж байснаас нэг удаа нэгдсэн төлбөр авах нь зардлын хувьд илүү үр ашигтай байж болно.

Энэ хэлбэрийн хураамжаас олдог орлогыг жуулчдын сонирхолыг татах, ТХГН-ийн менежментийг сайжруулах зорилгоор зарцуулж болох юм. (Шигтгээ 6.5).

Хэдийгээр нэвтрэх хураамжийн хэмжээ нь олон хүчин зүйлсээс шалтгаалдаг боловч хураамжийн хэмжээг Төлөхөд бэлэн байдлын (ТББ) судалгааны үр дүнд суурилан тогтоодог болохыг сүүлийн үеийн судалгааны тойм харуулж байна. ТББ-ын судалгаагаар аялагчид 1) ТХГН-т аялахдаа тодорхой хэмжээний төлбөр төлөхөд бэлэн, 2) түүнчлэн тогтоосон хэмжээнээс ч илүү мөнгийг төлөхөд бэлэн байдаг нь тухайлбал ТББ-ын үнэлгээгээр дараах хандлагыг тогтоожээ. Үүнд (Spenceley, et al., 2017a-с авч өөрчлөв):

Хүснэгт 6.4. Шинэ Зеландад концессийг хэрхэн ангилж, түүнийг хэрхэн хэрэгжүүлж буй жишээ

Концесс	Тодорхойлолт	Үйл явц	Жишээ
Зөвшөөрөл	10 хүртэлх жил, үйл ажиллагаанд суурилсан	Урьдчилан зарлахгүй, энгийн хүсэлтийг 5-45 ажлын өдөрт багтаан (төвөгтэй хүсэлтийг 65 ажлын өдөрт багтаан) шийдвэрлэнэ	Хөтөч хийх (явган аялал, ууланд авирах, ан агнуур, загасчлал, дугуйн аялал, завины аялал г.м)
Тусгай зөвшөөрөл	10 хүртэлх жил урьдчилан мэдээлэхгүйгээр, 30 хүртэлх жилээр урьдчилан мэдээлсэн тохиолдолд*	Урьдчилан мэдээлэх (доор тайлбарласнаар) болон урьдчлан мэдээлэхгүй байхыг хослуулан хэрэглэнэ	Төрийн эзэмшлийн барилга түрээслэх, амралт, сувилалын төхөөрөмжийг ашиглах
Лийзинг буюу түрээс	30 хүртэлх жилээр; хүүгийн төлбөр тогтоох эсвэл газрыг давуу эрхтэйгээр ашиглуулах асуудал хөндөгдөнө	Урьдчлан мэдээлэх, 85 ажлын өдөрт, хүсэлт ирүүлээгүй тохиолдолд (140 хүртэлх ажлын өдөрт, хугацаандаа хүсэлт ирүүлсэн ч нийтийн сонсгол хийгдээгүй, эсвэл 160 ажлын өдрийн дотор хүсэлт ирүүлсэн бөгөөд сонсгол хийгдсэн тохиолдолд) шийдвэрлэнэ	Үл хөдлөх барилга байгууламж тухайлбал зочид буудал, нисэх онгоцны буудал, кафе, банжи үсрэлтийн тавцан, харилцаа холбооны байгууламж гэх мэт
Хөнгөлөлт	30 хүртэлх жил, үйлчилгээ эсвэл шугаман дэд бүтэц	Урьдчлан мэдээлэх болон мэдээлэхгүйгээр	Зам, дамжуулах шугам хоолой, усны хоолой, харилцаа холбооны шугам

* Шинэ Зеланд улсад “урьдчилан мэдээлэх” гэдэг нь концесс олгох эрх бүхий байгаль хамгаалах төрийн байгууллагаас концесс олгох тухайгаа орон нутгийн болон үндэсний хэмжээний сонин хэвлэлд зарлан нийтлэх үүрэг хүлээхийг хэлэх бөгөөд иргэд хүсэлт гаргаж, хүсэлтийн талаар нээлттэй сонсголын үед үг хэлэх эрхтэй байна.



Транк Бэй, Ст Жон, Виржин Айланд Байгалийн цогцолборт Газрын Усан доор шумбах газрын эхлэлийн цэг. © Yu-Fai Leung



АНУ-н Эвергрийн Байгалийн цогцолборт газрын Фламинго Мэдээллийн Төвийн дэргэдэх завинд суух давцангууд © Yu-Fai Leung

- Аннапурнагийн Хамгаалалттай Газарт (Непал) аялагчид одоогийн төлж буй 27 ам.долларын оронд 69 ам.доллар төлөхөд бэлэн байгаагаа мэдээлжээ (Baral, et al., 2008).
- Комодо Үндэсний Цогцолборт Газарт (Индонез) жуулчид одоогийн нэвтрэх хураамжаас 10 дахин илүүг ч төлөхөд бэлэн байжээ (Walpole, et al., 2001).
- Кагалгади Транспортер Парк-д (Ботсван, Өмнөд Африк) хийгдсэн судалгаагаар байгаль хамгааллын шимтгэлийг 115хувиар өсгөж болохыг тогтоожээ (Dikgang and Muchapondwa, 2017).
- Бонайрын Далайн Үндэсний Паркад (Нидерландын Антиллис) хийгдсэн ТББ-ын судалгаагаар жилийн

нэвтрэх хураамжийн дундаж үнэ 61-134 ам.доллар байх боломжтой гэж үзсэн бол одоо авч буй бодит хураамж нь дөнгөж 10 ам.доллар байв. Иймд одоогийн авч буй хураамжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэхэд аялагчдын тоонд нөлөөлөхгүй гэж үзсэн байна (Thur, 2010).

Төлсөн хураамж нь байгаль хамгаалахад чухам ямар эерэг нөлөө үзүүлж буйг мэдсэн тохиолдолд аялагчид хураамж төлбөр төлөхдөө цааргалаад байдаггүй. ТХГН-ийн менежерүүдийн хувьд нэвтрэх цэг, цахим хуудсаараа дамжуулан нэвтрэх хураамжийг юунд зарцуулдагыг танилцуулах нь өөрсдөд нь ихээхэн ач холбогдолтой юм. Галапагосийн Байгалийн Цогцолборт Газар (Эквадор) цахим хуудастаа энэ талаар маш дэлгэрэнгүй мэдээлсэн

байдаг (<https://www.galapagosislands.com/travel/transportation/entry-fees.html>).

Дүгнэж хэлэхэд хураамж тогтоох талаар шийдвэр гаргахад хэдэн хүчин зүйл нөлөөлдөг байна. Үүнд:

- ТХГН-ийн Биологийн олон янз байдлыг хамгаалахад дутагдаж буй санхүүжилтын хэмжээ болон биологийн олон төрөл зүйлийг хамгаалах хэрэгцээ шаардлага.
- Менежментийн гол зорилтуудыг хангахад хураамж нь нийцэж, шаардлага хангаж буй эсэх.

- Тухайн газар нь байршил, олон нийтийг татах чадварын түвшингөөс шалтгаалж хураамжийн хэмжээ нь зах зээлийн эрэлтэд нийцэж буй эсэх
- Улс төр, нийгэм, олон нийтийн байдлаас хамаарч хураамжийн хамгийн боломжит механизм болон хэмжээг тогтоох.
- Тухайн газрын хөгжлийн одоогийн байдал, төлөв нь шинэ санал санаачилгуудыг хөгжүүлж, хэрэгжүүлж, мониторинг хийх чадвартай эсэх.

Шигтгээ 6.6

Өмнөд Африкийн ТХГН-ийн Захиргааны концессийн гэрээнүүд

Өмнөд Африкт Байгалийн цогцолборт газруудтай аялал жуулчлал эрхэлдэг компаниуд концессийн гэрээ хийж аялал жуулчлалын барилга, байгууламжийг ТХГН-т барьж байгуулдаг. Концесс эзэмшигчид тодорхой газар нутаг, тэнд байгаа барилга байгууламжийг ашиглахдаа хураамж төлнө (голдуу 20 жилийн хугацаатайгаар). Гэрээ хийхээс өмнө тухайн газарт ямар нэг барилга, байгууламж байгаа тохиолдолд концесс эзэмшигч хариуцан ашиглах, сайжруулах, мөн шаардлагатай бол шинээр барьж болдог. Тухайн барилга, байгууламжийг ашиг олох зорилгоор эзэмших, ашиглах эрхийн зэрэгцээ концесс эзэмшигч нь санхүүгийн, байгаль орчний, нийгмийн, чадавхижуулах зэрэг багц үүрэг хүлээдэг. Эдгээр үүргээ биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгэлтэй холбогдсон торгууль, цаашлаад гэрээг цуцлах, эд хөрөнгийг ӨА-ын ТХГН-ийн захиргаанд шилжүүлэх хүртэл арга хэмжээ авдаг (төрийн өмчийн давуу эрхийн дагуу).

Концессийн нэг жилийн төлбөрийг дараахь хоёр тохиолдлын аль өндөрөөр тогтоодог. Эдгээр нь: (1) тухайн концессийн гэрээт жилд тогтоосон заавал төлөх ёстой түрээсийн доод хэмжээ. (2) тухайн концессийн гэрээт жилд олохоор төлөвлөсөн орлого дээр үндэслэн хувьчлан тогтоосон концессийн хураамжийн хэмжээ зэрэг болно. Концессийн гэрээ дуусгавар болоход концесс эзэмшигч нь газар нутгийг чөлөөлж, бүх биет хөрөнгө болон бусад бүх эрхээ Өмнөд Африкийн ТХГН-ийн Захиргаанд үнэ төлбөргүй шилжүүлдэг.

Концессийн гэрээ нь Өмнөд Африкийн ТХГН-ийн Захиргааны хувьд хөрөнгө үүсгэх, хувийн салбарын бизнес ур чадварыг ашиглах, бизнесээс авч болох эрсдлийг хувийн хэвшилд үүрүүлэх, ажлын байр бий болгох зэрэг ач холбогдолтой байдаг. Мөн байгалийн баялагаа олон түмэнд зөв зохистой ашиглуулсанаар тухайн байгууллагын нэр хүндийг олон түмний дунд өргөж өгдөг. Заримдаа туршлага багатай байгууллага тендерт орж хэт өндөр төлөвлөгөө үзүүлэх хандлага гардаг боловч орлогын төлөвлөгөөг нь гэрээний заалтаар албажуулах хэлбэрээр эрсдлээс сэргийлж болдог. Гүйцэтгэлийн техникийн ур чадварын шаардлагаа өндөр түвшинд тавьж өгөх нь тохиромж муутай байгууллагуудыг сонгохгүй байх нэг арга болдог билээ.

Эх сурвалж: Varghese, 2008; SANParks, 2012



АНУ-ын Виржин Айландын Виржин Айланд Байгалийн Цогцолборт Газрын жуулчдын мэдээлийн төвийн ажилтан үйлчилгээ үзүүлж байна. © Yu-Fai Leung

Хүснэгт 6.5. Концессийн үйл ажиллагааны цар, хэмжээг 5 улсын жишээгээр

Үзүүлэлтүүд	Улс/Хариуцагч байгууллага				
	АНУ-ын ТХГН-ийн захиргаа	Канадын ТХГН-ийн захиргаа	Шинэ Зеландын Байгаль хамгаалах газар	Намиби	Далайн шүрэн арлын цогцолборт газар (Австрали)
Концессийн гэрээний тоо	600 гэрээ нэмэх нь 6,000 бизнес эрхлэх зөвшөөрөл	2,752 түрээс, тусгай зөвшөөрөл, бизнесийн тусгай зөвшөөрөл	3,700, үүнээс 43% нь бизнесийн үйл ажиллагаатай холбоотой	45	Ойролцоогоор, аялал жуулчлалын зөвшөөрөл
Концессоос орох орлого	60 сая ам.доллар	8.2 сая канад доллар (6.7 ам.доллар)	14.3 сая шинэ зеланд доллар (10.5 сая ам.доллар) (аялал жуулчлал болон бусад концессоос)	419 сая Намби доллар (31.5 сая ам.доллар)	Ойролцоогоор 8 сая австрали доллар (6.4 сая ам.доллар) Байгал, орчны менежментийн хураамжаар
Концессийн үйл ажиллагааг эрхлэн явуулахад оролцож буй ажиллагсадын тоо (бүтэн цагаар)	200 (40 төв оффист)	30	25	3	22
Бага хэмжээний концессийн гэрээ байгуулахад боловрсуулах хугацаа	2 жил (төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг тооцохгүйгээр)	3–6 сар	65 өдөр (2 сар)	3–12 сар	8–10 долоо хоног: оролцох санал хүлээн авах хугацаа 4 сар
Том хэмжээний концессийн гэрээ байгуулахад	2 жил (төлөвлөлтөнд орсон өөрчлөлтийг тооцохгүйгээр)	60 өдөр (тасралтгүй бус)	160 ажлын өдөр (5 сар)	12–24 сар	Хөвөгч завь гэх мэт томоохон төслийн хувьд их хугацаа шаардагдана
Хариуцах бүтэц (төвлөрсөн ба төвлөрсөн бус)	3 сая ам.доллар дээр төвлөрсөн	Тендер	Бүс нутаг дахь концесс хариуцсан салбар	Төвлөрсөн	Хэн түрүүлж хандана, тэр давуу эрхтэй зарчим; гэвч давуу саналыг сонгох боломжтой
Оновчтой хуваарьлах арга ажиллагаа	Тендер	Том хэмжээтэйг төв байгууллагын түвшинд бага хэмжээтэй мөн гэрээний талуудын харилцаа, хяналтын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд	Хувийн хэвшлийн хүсэлт гаргагчийн төлбөрийн баримтийг үндэслэн	Нутгийн иргэдийн байгууллагад шууд; бусад хүсэлт гаргагчдад тендер, дуудлага худалдаа болон шууд	Гэрээ байгуулах, гэрээний менежмент төвлөрсөн; орон нутгийн захиргааны ажилтнууд гүйцэтгэлд хяналт тавина

Эх сурвалж: Thompson, 2009; Thompson, 2014–с авч ашиглав.

6.3 Концессоос олох аялал жуулчлалын орлого

Төр, хувийн хэвшлийн түншлэл ба концесс

Төр, хувийн хэвшлийн түншлэл нь ТХГН-ийг хариуцсан төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулсан албан ёсны гэрээ юм. Гэрээний дагуу хувийн хэвшлийн түншлэгч нь аялал жуулчлалын тодорхой бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг бий болгосноор ТХГН-ийн менежерүүд үндсэн үйл ажиллагаандаа илүүтэй анхаарах боломжийг олгодог.

Хувийн хэвшил гэдэгт ашгийн байгууллага, ТББ эсвэл нутгийн иргэдийн байгууллага багтдаг. Концесс нь төр хувийн хэвшлийн түншлэлийн нэг хэлбэр бөгөөд байгаль хамгаалахад хувийн хэвшлийн сонирхолыг татах чухал арга юм (Thompson, et al., 2014). ТХГН-т бизнесийн үйл ажиллагаа явуулах концессийн гэрээг төр хувийн хэвшлийн түншлэл, түрээс, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл эсвэл хөнгөлөлт эдлүүлэх зэрэг хэлбэрээр байгуулж болно (Хүснэгт 6.4).

Энэхүү гэрээнд үндсэн нөхцөл, шаардлага тухайлбал хугацаа, үйл ажиллагааны хэлбэр, хүрээлэн буй орчны нөхцөл, коцессийн хураамжийн хэмжээг тусгадаг (Spenceley, et al., 2017b). Концессийн хураамж нь ТХГН-ийг ашигласны хураамжийн нэг хэлбэр бөгөөд концесс эзэмшигч нь ТХГН-ийг ашиглан өөрийн бизнесээ хийх давуу эрх эдэлж байгаагийн төлөө хийж буй төлбөр юм. Концессд хоноглох, отоглох байр, хоол хүнс, амралт зугаалгын үйл ажиллагаанууд, танин мэдэхүйн болон боловсролын хөтөлбөр, жижиглэн худалдаа хийх зэрэг үйлчилгээний төрлүүд орж болно (Eagles, et al., 2009).

Концесс эзэмшигчид нь хамгаалалтын захиргаанд тохиромжтой аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль хамгаалах зорилгоо хэрэгжүүлэхэд туслах замаар олон тооны боломжийг бий болгодог. Концессийн хураамж, түрээсийн төлбөр нь ТХГН-ийн санхүүжилтэд тус дэм болдог бол сайн хэрэгжиж буй концесс нь өндөр үр өгөөжтэй аялал жуулчлал хөгжүүлэх замаар эерэг үр дүнг авч ирдэг. Хөгжиж буй орны хувьд концессийн сайн үйл ажиллагаа нь нутгийн иргэд, хөдөөгийн хөгжил, байгаль хамгаалах асуудлыг хооронд холбож өгдөг. Хөгжингүй орны хувьд концессоос олж буй орлого нь ТХГН-т хөрөнгө оруулах үндэслэл болж өгдөг (USNPS, 2017a).

Хамгаалалтын захиргаанаас аялал, жуулчлалын үйл ажиллагааг эрсдэлээ даах чадвартай, үндсэн үйл ажиллагаа нь аялал жуулчлал байдаг байгууллагад олгох нь илүү үр дүнтэй байж болдог. Учир нь аялал жуулчлалын компаниудад дараах давуу талууд байна. Үүнд:

- Зах зээлийн эрэлт, нөхцөл байдлын өөрчлөлттэй хялбархан дасан зохицох чадвартай;
- Ажилтнуудтайгаа илүү уян хатан гэрээ хийх боломжтой;
- Шинэ санаачилга гаргах эрх чөлөө, хэрэгжүүлэх хурдаар илүү хангагдсан;
- Дэд бүтэц хөгжүүлэхэд бусад санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө татах илүү олон боломжтой;
- Үнэ тогтоохдоо илүү уян хатан;
- Албаны хүнд суртлын бэрхшээл бага (Eagles, et al., 2009; Buckley, 2010a) гэх мэт.

ТХГН-т аялал жуулчлалын концессийг хэрэгжүүлэх гурван гол гарын авлагыг боловсруулсан байдаг ба концессийг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ТХГН-т чухал лавлах материалууд болдог. Эдгээр нь: НҮБХХ-ийн ТХГН дахь аялал жуулчлалын концесс (Thompson, et al., 2014); Дэлхийн Банкны гурппын Аялал жуулчлалын концессийн танилцуулга: Амжилттай хөтөлбөрийн 14 шинж чанар (Spenceley, et al., 2016), ба Аялал жуулчлалын хамтын ажиллагаа ба хамгаалалттай бүс нутгуудад концесс хийгчдэд зориулсан Биологийн олон янз байдлын конвенцийн гарын авлага (Spenceley, et al., 2017b) зэрэг болно.

Концесс эзэмшигчдээс ашиглалтын, үйл ажиллагааны бонд, засвар үйлчилгээний, элэгдэл, хорогдлын гэх мэт олон төрлийн хураамжууд авч болохоос ашиглалтын төлбөрөөр үндсэн орлогоо бүрдүүлэх явдал түгээмэл байна. Ашиглалтын төлбөрийн хэмжээг тогтмол нэг түвшингээр тогтоож болдог. Концесс эзэмшигчдээс хураамж авахад энэхүү арга нь хялбар байж болох юм. Учир нь өөр хураамжууд авч буй тохиолдолд ирж буй жуулчдын тоо, тэднээс орох орлогыг хянах, тооцох зэрэг хүндрэлтэй ажил удсан процесс үүсэх гээд байдаг. Концесс эзэмшигчдийн хувьд тогтмол ашиглалтын хураамж төлөх болсоноороо орлого олсон, олоогүйгээс үл шалтгаалж тогтмол төлбөр төлөх шаардлагатай болж байгаад эрсдэл нь оршиж байгаа юм.

Нөгөө талаас, концесс эзэмшигчийн орлого тогтмол өсөж байхад жилийн хураамж тогтмол байгаад байх нь хамгаалалтын захиргаанд ашиггүй байдаг. Концесс эзэмшигчид нь их хэмжээний ашигтай ажиллаж байхад хамгаалалтын захиргаа маш бага төлбөр хураамж авсаар байгаа тохиолдлууд тийм ховор биш билээ. Концесс эзэмшигчид өөрсдийн цэвэр орлогоосоо тодорхой хэмжээгээр хоёр талд тохиолдож болох эрсдлийг бууруулах зорилгоор нэмэлт байдлаар төлж болдог тохиолдлууд байна (Wyman, et al., 2011).

Шигтгээ 6.6-д Өмнөд Африкийн ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаанд концессийн гэрээг хэрхэн зохицуулж байгаа жишээг харууллаа.

ТХГН-ийн концессийн гол зарчим нь цэвэр бизнесийн үйл ажиллагаанд тулгуурлах боловч орлогын хуваарьлалт, орон нутгийн бизнесүүдийг оролцуулах, ажлын байр бий болгох зэрэг орон нутгийн эдийн засагт нэмэлт үр нөлөө үзүүлдэг. Жишээлбэл:

- Нутгийн иргэдэд орлого хуваарьлах: Менежментийн төлөвлөгөө, концессийн гэрээгээр концесс эзэмшигч, нутгийн иргэдийн хооронд орлогыг хэрхэн хуваарьлах талаар зохицуулах боломжтой байдаг (Spenceley, 2014a).
- Орон нутгийн бизнесийн оролцоо: Концессийн гэрээ байгуулах явцад орон нутгийн компаниудыг “давуу эрхтэй”-гээр оролцуулж болно. Мөн концесс эзэмшигч нь орон нутгийн бизнесийг дэмжих, нутгийн бэлтгэн нийлүүлэлт, өртгийн сүлжээг бэхжүүлэх боломжтой (Spenceley, 2014a).
- Орон нутгийн иргэдийн ажил эрхлэлт: Хамгаалалтын захиргаа нь концесс эзэмшигчдэд хандаж нутгийн иргэдийг ажилд авах, эсвэл ажилчдыг зөвхөн нутгийн иргэдээр бүрдүүлэх шаардлага тавьж болно (Wyman, et al., 2011).

График 6.2. Шийдвэр гаргахад хэрэглэдэг гадны болон дотоодын 3 гол асуулт.

Асуулт 1: Аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгоход хамгаалалтын захиргаанд хангалттай хэмжээний хөрөнгө мөнгө, хүн хүч бий юу?	Тийм → Дотоод нөөц бололцоо: Хамгаалалтын захиргаа өөрсдөө дэд бүтцээ хөгжүүлнэ.
Үгүй → Гаднаас: Хамгаалалтын захиргаа Дэд бүтэц хөгжүүлэх хамтрагч хайх	Концесс: Хөрөнгө оруулалт хийх, байгуулах, ажиллуулах хамтрагч хайх.
Асуулт 2: Хамгаалалтын захиргаа нь одоогийн байдлаар дэд бүтэцтэй, түүний үйл ажиллагааг эрхлэн явуулах эрх зүйн болоод туршлага, хүн хүчний бололцоотой эсэх?	Тийм → Дотоод нөөц бололцоо: Хамгаалалтын захиргаа аялал жуулчлалын үйлчилгээг өөрсдөө эрхлэн явуулна.
Үгүй → Гаднаас: Хамгаалалтын захиргаа менежментийн хамтрагч хайна.	Лизинг: Гаднын байгууллагад менежментийн хамтрагч хайна. байгууламж ба газраа тодорхой хугацаанд ашиглуулна.
Асуулт 3: Хамгаалалтын захиргаа аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхийг хүсч байгаа болон түүнийг эрхлэх хангалттай туршлага, эрх болоод хүн хүч бий юу?	Тийм → Дотоод нөөц бололцоо: Хамгаалалтын захиргаа өөрсдөө аялалын үйлчилгээг санал болгоно
Үгүй: → Гаднаас: Хамгаалалтын захиргаа аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх тал дээр хамтрагч хайна	<div> <div>→</div> <div>→</div> </div> Лиценз Онцлог үед түр гадны операторт барилга байгууламж ашиглуулах Зөвшөөрөл: Богино хугацааны зөвшөөрөл

Концессийн гэрээ байгуулах, хэрэгжүүлэх асуудлыг аялал жуулчлалын талаар тодорхой мэдлэгтэй ТХГН-ийн менежментээр мэргэшсэн цөөн тооны мэргэжилтэн, хамгаалалтын захиргааны мэргэжилтнүүд болон шийдвэр гаргагчидтай хамтран хариуцдаг. Концессийн гэрээг байгуулах, түүнийг хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний хүн/цаг шаардлагатай. Хүснэгт 6.5-д Концессийн гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны цар хэмжээг түүнээс олж буй орлоготой харьцуулан хэд хэдэн ТХГН-ийн жишээн дээр харуулав.

6.4 Аялал жуулчлалын орлогыг хандив, тусламжаас бүрдүүлэх нь

Хувь хүний болон бизнесийн хандивууд

ТХГН-т аялагсад нь байгаль хамгаалах үйлсэд хандив тусламж өгөх магадлалтай хүмүүсийн томоохон эх сурвалж болдог. ТХГН-ийн зүгээс хандив тусламжийг тодорхой төсөлд (жишээлбэл байгаль хамгааллын зорилготой аль нэг төсөл), тодорхой амьтан хамгаалхад чиглүүлэн авч болдог. Аль ч тохиолдолд өгсөн хөрөнгөөр нь ямар үр дүнд хүрсэн, ямар өөрчлөлт гарсан талаар хандивлагчдад эргээд мэдэгддэг. 2003 онд Малдивын засгийн газар 1,200 км² бүхий Ваа Атолыг ЮНЕСКО-гийн Шим Мандлын Нөөц газарт бүртгүүлэхийн тулд "Атолын Экосистем Хамгаалал (АЕС)" төслийг (НҮБХХ болон Даян Дэлхийн Байгаль Орчны Сангийн тусламжтай) эхлүүлсэн. АЕС төслийн хүрээнд шим мандлын нөөц газрын менежментийг дэмжих санг байгуулсан байна. Ваа Атолд үйл ажиллагаагаа явуулж буй дийлэнх аялалын байгууллагууд байгаль орчны хамгаалал болон тогтвортой амьжиргааны төслүүдийг дэмжихэд жил бүр ажлын байр бий болгох замаар дэмжих амлалт өгсөн байна. Үүнээс гадна Ваа Атолын экосистемийн үйлчилгээнээс хамааралтай үйл ажиллагаа, тухайлбал усанд шумбах аялал, нэвтрэх зөвшөөрөл, бэлэг дурсгалын

зүйл борлуулалтаас олсон орлогын тодорхой хувийг эргээд Атолын байгаль хамгааллын үйл ажиллагаанд хандивладаг (Ferretti, 2012; MEE-ROm, 2012; VCTS, 2017). Энэ бол сайн зохион байгуулалттай хандивын хөтөлбөрийн нэг жишээ бөгөөд хэрэв хандивын үйл ажиллагааг зөв сайн зохион байгуулахгүй бол төсөл амжилтгүй болох, авлигад өртөх, ил тод бус, итгэл эвдэх болон нутгийн иргэдийг хагаралдуулах гэх мэт үр дүнд хүргэж болдог (Goodwin, et al., 2009; Honey, 2011).

Зарим улс орнуудад бизнесийн байгууллагын өгсөн сайн санааны хандивыг татвараас чөлөөлж тооцдог бөгөөд үүнээс ТХГН-ууд ашиг тус хүртэгч буюу хандивыг хүртэгч болдог (жишээлбэл Goodwin, et al., 2009). Сэеичэл дэх Сэеичэлийн Байгалийн Цогцолборт Газар аялал жуулчлалын компаниудтай хамтын ажиллагааг хөгжүүлж, зарим байгаль хамгаалах үйл ажиллагааг, тухайлбал судлаачдыг санхүүжүүлэх, биологийн мониторингийн мэдээлэл цуглуулах, тоног төхөөрөмж худалдан авах (жишээлбэл гүнзгий уснаас болгоомжлох тэмдэг, жорлон, тэмдэг тэмдэглэгээ) (Spenceley, 2017) зэрэг ажлыг санхүүжүүлдэг. Бизнесийн байгууллагууд нь татвар төлөх орлогынхоо 0.25 хувийг нийгмийн хариуцлагын хүрээнд бүртгэлтэй байгаль хамгаалах байгууллагуудад хандивлах боломжтой.

Цаашилбал жуулчид нь ТХГН-т аялал жуулчлалын бизнесийн байгууллагаар дамжуулан хандив өгөх боломжтой. Тухайлбал олон улсын зочид буудлын сүлжээ "Марриот интернэйшнэл" компани 2008 онд Бразилд Амазон мөрний сав газрын улс орнуудтай хамтран Жумагийн нөөц газарт орших 1.4 сая га халуун орны ойг хамгаалах гэрээ байгуулсан байна. Энэ санаачилгын хүрээнд уг нөөц газарт амьдарч байгаа 2,000 уугуул иргэдийн боловсрол, эрүүл мэнд болон ажил эрхлэлтийг дэмжих, нутгийн уугуул иргэд үүний хариуд хууль бус мод бэлтгэл, хөдөө аж ахуй эрхлэхээс хамгаалахад туслах үүрэг хүлээсэн байна. "Марриот" компани үйлчлүүлэгчиддээ хандан энэ санаачлагыг дэмжин зочид буудлуудаар болон цахим хуудсаар хандив өргөхийг уриалдаг байна (Goodwin, et al., 2009).

Өөр нэг жишээ нь өмнөд Африкийн эко аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч “Вайлдлайф Сафари” компанийн үүсгэн байгуулсан “Онгон Байгаль Сан” (WWF) юм. Сафари аялалд оролцогчдын өлбөрийн тодорхой хувийг энэхүү итгэлцлийн санд хуримтлуулж түүнийг 100 хувь итгэлийн сангийн баталсан төслүүдийн үйл ажиллагаанд зарцуулагддаг байна. 2009 онд Ботсванад ложистик тусламж, хүнс, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ үзүүлэх зорилгоор жуулчны гурван баазийн орчимд судалгааны нэгжийг байгуулсан байна. Ботсванад 2013-2014 оны хооронд биологийн олон янз байдлыг хамгаалах, мониторингийн үйл ажиллагаанд 411 мянган ам.доллар зарцуулжээ (Wilderness Holdings, 2014)). Мөн Окаванга голын ай савыг хамгаалах үйл ажиллагаанд тус нэмэр болох зорилгоор судалгааныхаа үр дүнг засгийн газрын байгаль хамгаалах албатай хуваалцсан байдаг (Spenceley & Snyman, 2017).

6.5 Зардлыг хэмнэх, үр ашигтай байх санаачилгууд

Энэ бүлэгт ТХГН-ийн зардлыг багасгах, эсвэл менежментийн үр дүнг сайжруулахад аялал жуулчлал хэрхэн дэмжлэг үзүүлж болох талаар онцлон үзэх болно.

Аялал жуулчлалын менежментийг гэрээлэх

ТХГН бүр аялал жуулчлалын үйл ажиллагааг өөрсдөө хэрэгжүүлэх, эсвэл чадах албагүй билээ. Үнэндээ зарим тохиолдолд хамгаалалтын захиргаа нь өөрийн нөөцөө ашиглахаас илүүтэйгээр аялал жуулчлалын концесс, тусгай зөвшөөрөл эсвэл зөвшөөрөл олгох зэргээр гадны нөөцийг ашиглах нь илүү үр дүн, ашигтай байж болох юм (Spenceley, et al., 2017b). Зарим тохиолдолд, тодорхой нөхцөл байдлуудаас болж хамгаалалтын захиргаа нь хуулийн хязгаарлалтаас өөр бусад шалтгаанаар аялал жуулчлалын үйл ажиллагааг өөр байгууллагад шилжүүлж өгөхөөс аргагүй байдалд хүрдэг. Ийм нөхцөлд үйл ажиллагааг гүйцэтгүүлхээр аутсорсинг хийх буюу гадны гүйцэтгэгчийг сонгон гэрээлэх шаардлагатай болдог.

Ажил, үүргийг ашгийн төлөө компани, нутгийн иргэдийн нөхөрлөл болон ТББ-уудаар гэрээлэн гүйцэтгүүлэх нь тэдгээрийг хамгаалалтын захиргаа өөрсдөө хариуцаж хийсэнтэй мөн адил давуу болон сул талтай байдаг (Spenceley, et al., 2017b). Өөрийн дотоод нөөц бололцоогоор хийвэл хамгаалалтын захиргааны ажилчид нь түүнийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх зэрэг үйлчилгээг үзүүлэх үүрийг хүлээдэг бөгөөд амжилттай ажиллахын тулд хамгаалалтын захиргаа нь бизнесийн зарчмаар ажиллах шаардлагатай болдог. ТХГН-ийн байр, байгууламжаар дамжуулан ажилчид нь зочдод үйлчилгээ үзүүлж, хамгаалалтын захиргаа нь олон нийтийн үйлчилгээний байгууллага болдог (Spenceley, et al., 2017b). Гадны гүйцэтгэгчээр үйлчилгээ үзүүлэх болсон тохиолдолд хамгаалалтын захиргаа гүйцэтгэгчтэй гэрээ хийнэ. Үйлчилгээний туршлага багатай, шаардлагатай санхүүгийн нөөц эсвэл эрхзүйн боломж байхгүй хамгаалалтын захиргааны хувьд энэ нь зөв шийдвэр байж болдог. Өөрийн газар дээр үйлчилгээ үзүүлэх эрхийг гэрээт гүйцэтгэгчид олгосноор төрийн байгууллага төсөв, нөөц чадавхи, мэргэжилтнүүдийн цаг завьыг хэмнэж, хөнгөвчилж байгаа хэрэг болно (Eagles, 2002).

Зураг 6.2-т харуулсан бүдүүвч нь аялал жуулчлалын үйл ажиллагааг өөрийн нөөцөөр хийх үү эсвэл гадны гэрээт гүйцэтгэгчээр хийлгэх үү гэдэг шийдвэр гаргахад ТХГН-ийн удирдлагуудад туслах юм.

Гадны байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх тохиолдолд ТХГН-ийн удирдлага нь чадвартай, сайн бэлтгэгдсэн ажилтнуудтай байж концесстэй холбоотой олон үйл ажиллагааг зохицуулан удирдах шаардлагатай болно (Spenceley, et al., 2017b). Бэлтгэл шатанд шаардлагатай судалгааг хуулийн, хөрөнгө оруулалтын зуучлагч гэх мэт гадны мэргэжилтнүүдийн тусламжтайгаар хийж болдог. Тэд мөн холбогдох гэрээт байгууллагуудтай гэрээ хийсэн байх шаардлагатай байна. Перу улсад амжилттай хийсэн гэрээний жишээг шигтгээ 6.7-д харуулав.

Гэрээнд дараахь элементүүд орно (Spenceley, et al., 2017b). Үүнд:

- Концессийн эрхийн үндэслэл, хамрах хүрээ (жишээлбэл газар нутаг, гүйцэтгэх ажил, үйлчилгээнүүд, хамаарахгүй асуудлууд)
- Гэрээ хүчин төгөлдөр болохоос өмнөх нөхцөл байдал
- Гэрээний үргэлжлэх хугацаа
- Концессийн гэрээнд тусгасан хөрөнгийн өмчлөлийн талаарх талуудын ашиг сонирхолууд (жишээлбэл газар нутаг, эсвэл дэд бүтцийг ашиглах эрх)
- Концессийн гэрээнд тусгасан хөрөнгийн засвар үйлчилгээ (жишээлбэл замын арчилгаа)
- Төлбөр, хураамжийн хэмжээ (эргэж харах, өөрчлөлт оруулах үйл явц)
- Гүйцэтгэлийн чанарын баталгаа (жишээлбэл үйлчилгээний түвшин, ажил эрхлэлт)
- Гүйцэтгэлийг шалгах гол шалгуур үзүүлэлтүүд, гэрээний биелэлтийг дүгнэх шалгуур асуултууд агуулсан загвар хуудас бүхий хяналт үнэлгээ.
- Даатгалын бодлогууд
- Хариуцлагын хязгаар, хамгаалалтын захиргааны хохирлыг барагдуулах
- Давагдашгүй хүчин зүйл (жишээлбэл хоёр талын хяналтаас давсан эвдрэл, гэмтэл гарах)
- Барилга байгууламж барих, ашиглах, үйл ажиллагаа явуулах үед байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл
- Концессийн эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх эрх
- Концессийг шилжүүлэхэд тавигдах хязгаарлалт/нөхцөлүүд
- Холбогдох талуудын төлбөр тооцоотой холбоотой хязгаарлалт/нөхцөлүүд
- Нийгэм эдийн засагт оруулах хувь нэмэр (жишээлбэл: орон нутгийн хөрөнгө, ажил эрхлэлт, худалдан авалт, нийгмийн төслүүд)
- Хуульд өөрчлөлт орох
- Гэрээг зөрчих, цуцлах
- Маргаан шийдвэрлэх
- Хамгаалалтын захиргаа ба гуравдагч этгээд үйл ажиллагааг хүлээн авч үргэжлүүлэх нөхцөлүүд
- Татвар төлөлт болон бусад санхүүгийн асуудлууд

Гадны гүйцэтгэгчээр аялал жуулчлалын үйл ажиллагааг эхлүүлэхээс өмнө давуу болон сул талуудыг маш сайн харгалзан үзэх шаардлагатай. Засгийн газрын хувьд эдийн засгийн эрх ашгийг байгаль хамгааллын эрх ашгаас илүүд үзэх хандлагатай байдаг тул концесс эзэмшигчид хамгаалалтын захиргааг алгасч, барилга байгууламжаа өргөтгөх, үйл ажиллагаагаа ТХГН-ийн бусад хэсэгт тэлэх дэд бүтцийн зөвшөөрөл авахын тулд дээд шатны албан ташуултнуудад шууд хандах явдал гардаг. Иймэрхүү дарамт, шахалтууд нь ТХГН-ийн төсөв болон хамгаалалтын зорилгуудыг гажуудуулахад хүргэдэг.

Аялал жуулчлал эрхлэгчидтэй хамтарсан үйлчилгээ үзүүлэх нь

ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлал эрхлэгчид ТХГН-ийн менежментийн санхүүжилтийг үр ашигтай байлгах сонирхолтой байдаг. Учир нь тэдэнд хамгаалалтын захиргаанд гардагтай адил төстөй урсгал зардлууд байдаг тул нөөц, эсвэл зардлаа хувааж, байгууллагынхаа нэгжийн зардлыг бууруулах боломжтой болдог байна. ТХГН-т хэрэгжүүлж буй зарим жишээнүүдээс дурдвал:

- Машин техник, завь засварын газрыг хамтран ашиглах замаар гараж, засварын үйлчилгээтэй холбоотой тогтмол зардлын хэмжээг бууруулах;
- Хамгаалалтын захиргаа, хувиараа бизнес эрхлэгчид гэрээт байгууллагаас адилхан авдаг үйлчилгээнийхээ цагийн хуваарийг тааруулсанаар зардал хэмнэх;
- Аялал жуулчлал болон хууль сахиулах зэрэг сэдвүүдээр сургалт зохиохдоо хоёр байгууллагын ажилчдад дунд нь зохион байгуулах;
- Худалдан авалтаа нэтгэн хийснээр сайн хямдрал авах. Энэ арга нь ялангуяа алслагдсан байршилтай ТХГН-т илүү үр ашигтай байдаг;
- Ажилчид унаа тэргээ хамтарч ашигласнаар түлш шатахууны зардлаа багасгаж, улмаар байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх.

Үйл ажиллагаанд суурилсан хамтын ажиллагаа

Байгаль хамгааллыг илүү үр дүнтэй болгохын тулд аялал жуулчлалын оператор компани хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах сонирхолтой хэд, хэдэн үйл ажиллагаа байж болох юм. Эдгээрт ТХГН-ийн захиргааны менежментийн гүйцэтгэлийг дэмнэж, ингэснээрээ аялал жуулчлалын бүтээгдхүүний чанарыг сайжруулж, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагын бизнест амжилт авчрах үйл ажиллагаанууд багтаж болно. Өдгөө хэрэгжиж буй үйл ажиллагаануудаас дурьдвал:

- Аялал жуулчлал эрхлэгчид нь хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд ТХГН-т хууль бус үйл ажиллагааг мэдээлэх;
- Спортын гэх мэт тусгай хэлбэрийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтран дэмжлэг үзүүлэх;
- ТХГН-ийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд оруулж буй хувь нэмрийг хамтран сурталчилах, таниулах, байгаль хамгаалах үйл ажиллагаанд хүүхдүүдийн оролцоог хамтран дэмжих.

Сайн дурынхны аялал жуулчлал

Сонгосон ТХГН-таа очиж өөрийн хувь нэмрийг оруулах хүсэлтэй сайн дурынхны аялал жуулчлал буюу жуулчдын тоо сүүлийн үед нэмэгдэх хандлагатай байна. Үүний үр дүнд энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг нэлээд олон ашгийн болон ашгийн бус байгууллагууд төрөн гарч байна. ТХГН-ууд төлбөртэй эсвэл төлбөргүйгээр сайн дурынхныг ажиллах боломжоор ханган, байгаль хамгаалах тодорхой үйл ажиллагааг өөрийн ажилтнуудтай хамтран нэмэлт хүч маягаар гүйцэтгүүлж болох юм (Бүлэг 2-оос дэлгэрэнгүй мэдээллийг харна уу).

6.6 Эдийн засгийн өргөн үр өгөөжийг байгаль хамгаалах үйлстэй холбох нь

Аялал жуулчлалыг зөвхөн ТХГН-ийн орлого нэмэгдүүлэх эсвэл зардал хэмнэх талаасаа харах бус, түүний эдийн засагт оруулж буй үр өгөөжийг өргөн утгаараа ТХГН-аас бий болж байгаа гэдэг талаас нь харуулбал - байгаль хамгаалахад олон нийтийн дэмжлэг авахад том түлхэц болно. Эдийн засгийн хөгжлийн хязгаарлагдмал боломжтой бүс нутагт аялал жуулчлалын зөв менежмент хэрэгжүүлсэнээр ажилгүйдлээс үүсэх дарамтыг бууруулах боломжтой. Эдийн засгийн үр ашгийг дээд зэргээр хүртээх хоёр арга замд дараах багтна. Үүнд: 1) Аялал жуулчлалаас орж буй орлогын боломжит хамгийн дээд хувийг тухайн орон нутгийн эдийн засагт үлдэж байх; 2) Аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбогдолтой эдийн засгийн боломжийг нутгийн иргэдэд боломжит дээд хэмжээгээр ашиглуулж байх зэрэг болно.

Ялангуяа Африкийн өмнөд хэсэгт ТХГН-ийн тогтвортой үйл ажиллагаа явуулах урьдчилсан нөхцөл нь тухайн орон нутгийн иргэдэд чиглэсэн орлогын эх үүсвэрийг бий болгох явдал байдаг (Hoon, 2004; Musumali, et al., 2007). Олон судалгааны дүнгээс авч үзэхэд орон нутгийн иргэд аялал жуулчлал буюу/эсвэл ТХГН-аас тодорхой өгөөж хүртэж л байвал тэрхүү ТХГН-т хандах хандлага эерэг байдгийг олж тогтоосон байна (Infield, 1988; Gillingham & Lee, 1999; Alexander, 2000; Mehta & Heinen, 2001; Sekhar, 2003; Bauer, 2003; Lepp, 2007; Chandralal, 2010; Snyman, 2014) (Шигтгээ 6.8).


Хамгаалалтын захиргаанууд болон тухайн ТХГН-ийн хамгаалалтын санхүүжилт нь аялал жуулчлалын үйл ажиллагаанаас хэр хэмжээнд хамааралтай байх нь чухал асуудлын нэг юм. Үүнд тохирох хариулт нь дэд бүтэц, байр байршил, зах зээлийн хүчин зүйлс, баримтлах бодлогоос ихээхэн хамаарч янз бүр байдаг (Шигтгээ 6.9). Тухайлбал, буурай хөгжилтэй орны хамгаалалтын захиргаадын хувьд ихэнх жуулчид нь хөгжингүй орны иргэд байдаг. Нэвтрэх хураамж болон үйл ажиллагааны төлбөрийг авах нь хэрэгжих боломжтой хялбар арга ажиллагаанууд бөгөөд эдгээр орлогоор хамгааллын менежментийн зарим зардлыг санхүүжүүлэх нь шударга бөгөөд үр дүнтэй арга хэмжээ юм. Гэхдээ нийт зардлын дийлэнх хэсгийг энэхүү орлогоор барагдуулах боломжгүй. Тухайн ТХГН болон үндэсний хэмжээнд аялал жуулчлалын бус аргаар санхүүжилт бүрдүүлэх олон боломжит хувилбарууд бий бөгөөд тэдгээрээс алийг сонгох нь тухайн ТХГН-ийн хэлбэр, тэнд явагдах зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас хамаардаг (1-р бүлгийг үзнэ үү).

Шигтгээ 6.7

Аялал жуулчлалын үйл ажиллагааг гэрээгээр амжилттайгаар гүйцэтгүүлэх: Тамботагийн Судалгааны Төв болон Байгалийн Нөөц Газар (Перу)

Тур оператор компани болох "Халуун Орны Ойн Экспедиц (ХООЭ)", Тамботагийн Судалгааны Төв (ТСТ) болон Перу Улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн (УТХГН) удирдлагын түншлэл нь нь төр хувийн хэвшлийн түншлэл хэрхэн байгаль хамгаалал, аялал жуулчлалыг амжилттай дэмжиж болдогыг харуулсан нэг жишээ юм. Перугийн зүүн өмнөд хэсэг Амазоны ширэнгэн ойд байрлах Тамботагийн Байгалийн Нөөц Газрын багахан хэсэгт эко аялал жуулчлалыг хэрэгжүүлэх концессийн гэрээг 2006 онд Халуун Орны Ойн Экспедиц, УТХГН-ийн удирдлагын газрын хооронд байгуулсан байна. Гэрээг 20 жил тутамд шинэчлэгдэж байхаар хийжээ.

1989 онд Эдуардо Никандер ба Курт Холле нар судалгааны жуулчдыг хүлээн авах, Макавийн зүйлийн судалгаа хийх зорилгоор ТСТ-ийг байгуулж, 1992 онд ТСТ-ийн байрыг түшиглэн эко аялал жуулчлал эрхлэх ашгийн төлөө Халуун Орны Ойн Экспедиц компанийг байгуулжээ. ТСТ нь тэдний анхны бааз байв. Одоо тус компанийн 2 жуулчны баазын нэгийг нь орон нутгийн иргэд ажиллуулж байна.



Тамботагийн Судалгааны Төвийн Байр. © Rainforest Expeditions

Анх Макавийн олон төрлийн зүйлийн шүтэн амьдардаг шавран цохионуудыг хамгаалах, жуулчид, судлаачдыг байрлуулах зорилгоор баригдсан ТСТ-ийн байр нь 18 унтлагын өрөөтэй. Энэ байр нь олон төрлийн амьтдыг тухайлбал Бүдэг толгойт титис (*Callicebus moloch*), хэрэм (олон зүйлийн), Бор капучинс (*Cebus apella*), Улаан ховлер (*Alouatta seniculus*), Хар аалз сармагчингууд (*Ateles paniscus*), Капибарас (*Hydrochoerus capybara*), Кайманс (олон зүйлийн), Алтла туулай (*Dasyprocta punctata*), Цагаан хэлт зэрлэг гахай (*Tayassu pecari*) зэргийн нэг дор харах боломжтой газар байршдаг. Цомхон дэд бүтэц, үйл ажиллагаанаас гадна байнга судлаачид, байгалийн хөтөч нар ажилладаг нь Амазонкийн зэрлэг амьтдыг судлахад маш тохиромжтой газрын нэг юм.

Перугийн Засгийн газар болон Халуун Орны Ойн Экспедицийн хооронд байгуулсан гэрээнд дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

- Шинжлэх ухааны судалгаа, бүтээл хэвлүүлэлтийг хөгжүүлэх: ХООЭ нь анхнаасаа Тамбота Макави төслийн судалгааны сайн дурынханд тэтгэлэг олгох замаар судалгааны ажлыг ялангуяа
- Пистачиде хэмээх тоть шувууны судалгааны ажлыг дэмжиж ирсэн.
- Шууд ба шууд бус ажлын байр бий болгох, сургалт явуулах: ХООЭ нь зэргэлдээ орших Мадре дэ Диос нутгийн уугуул иргэдийг ажлын байраар хангахад нэн тэргүүнд зорих. ХООЭ нь цэвэрлэгч, хоолны газрын үйлчилэгч, тогооч, хөтөчийн мэрэгшүүлэх сургалтыг жил тутам явуулна.
- Байгаль орчиндоо ээлтэй байх: ХООЭ нь Байгалийн Нөөц Газрын дүрэм журмыг хүндэтгэж, хамгааллын менежментийг дэмжиж ажиллана.
- Байгалийн Нөөц Газрын сурталчилгаа: Экотуризмийг хэвлэл мэдээллээр сурталчилах замаар ХООЭ нь Мадре дэ Диосын, ялангуяа Тамбота Нөөц Газрын биологийн болон соёлын үнэт зүйлийг таниулж мэдээлнэ.

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Жуулчны үйл ажиллагаа эрхлэгчидтэй байгуулах гэрээнд хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалал, тогтвортой үйл ажиллагааг дэмжих нөхцөл боломжийн талаар оруулж өгөх.

ӨАБНУ-д Засгийн газраас ТХГН-ийн удирдлагын газарт шаардлагатай төсвийн дийлэнхийг улсын төсвөөс бус, аялал жуулчлалаас олохыг шаарддаг. Энэ нь зөв үү, буруу юу? (Хүснэгт 6.6). Аялал жуулчлалаас олох орлогод хэт найдах нь олон улсын аялал жуулчлал буурахтай холбоотойгоор ТХГН-ийг эрсдэлд хүргэх тул орлогыг солонгоруулах нь маш чухал. Түүнээс гадна нэвтрэх хураамжийн орлогоос хэт хамааралтай ТХГН-ийн удирдлага нь хязгаарлагдмал төсөвөө хүн ихээр очдог, гол орлогоо олдог цөөхөн ТХГН-ийн өндөр өртөгтэй дэд бүтцэд зарцуулснаар бусад ТХГН-ийн менежментэнд зарцуулах хөрөнгийн хомсдолд орж болзошгүй. Нэг улсын хэмжээнд ТХГН-ууд нь аялал жуулчлалаас олох орлогын хэмжээгээрээ эрс ялгаатай байдаг. Ихэнх улс орнуудад төрийн мэдлийн ТХГН-ийн олсон орлого нь тухайн ТХГН-т эсвэл ТХГН-ийн сүлжээнд үлдэж түүнийг үйл ажиллагаа, тоног төхөөрөмжөө сайжруулахад зарцуулахгүй, харин ч улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлдэг. Гэвч Засгийн газраас өгч буй менежментийн санхүүжилт нь хангалтгүй тохиолдолд аялал жуулчлалаас олох орлого нь төсвийн суурь санхүүжилтийг нэмэх гол арга байж болох юм.

6.7 Шилдэг туршлагууд

- Нэвтрэх хураамжийг тогтоохын өмнө тухайн ТХГН-т (эсвэл ТХГН-ийн сүлжээнд) санхүүгийн үнэлгээг системтэйгээр хийх хэрэгтэй. Одоогийн нөхцөл байдал, орлого, зарлагад дүн шинжилгээ хийж хураамжийн үнэд нөлөөлж болох байршил, байгуулагдсан он, олон нийтэд танигдсан байдал зэрэг мэдээллийг ашиглан боломжит хувилбарыг сонгох
- Аялал жуулчлалын байгууллага, жуулчдын хэдий хэмжээний хураамжийг төлөхөд бэлэн байдлын судалгааг хийх, ижил төрлийн сонирхолтой жуулчдыг татахаар өрсөлддөг бүсийн болон орон нутгийн ТХГН-ийн хураамжийг жишиг үнэ болгох
- Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчидтэй байгуулах гэрээнд хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалал, тогтвортой үйл ажиллагааг дэмжих нөхцөл боломжийн талаар оруулж өгөх.
- Концессийн гэрээнд нийт ажилчдын тодорхой хувийг орон нутгаас бүрдүүлэх, боломжтой тохиолдолд орлогыг орон нутагт зарцуулах, үйлчлэгээний гэрээг орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлэх тухай тусгах.

Шигтгээ 6.8

Эдийн засгийн үр өгөөжийг орон нутгийн иргэд хүртэх нь: Дамараланд Бааз болон Торрагийн Нутгийн Иргэдэд Түшиглэсэн Байгаль Хамгаалах Газар (Намиби)



Намибийн Дамараланд Баазийн зургууд. © Wilderness Safaris and Dana Allen



Аялал жуулчлалаас олсон орлогыг нутгийн иргэдтэй хуваах нь тэднээс дэмжлэг авахад том түлхэц болдог. Африкийн өмнөд хэсэгт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн аялал жуулчлалын “Вилдернес Сафари” компани нь өөрийн үйл ажиллагаандаа орон нутгийн иргэдтэй үр ашгийг хуваах түншлэлийн арга ажиллагааг нэвтрүүлсэн байна. Үүний нэг жишээ бол Намибийн Торрагийн нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалах газар болон “Вилдернес Сафари”-ийн “Дарамаланд” жуулчны бааз хоорондын хамтарсан компани юм.

2005-2011 оны хооронд “Дарамаланд” жуулчны бааз нь байгаль хамгаалах үйл ажиллагаанд 320,000 гаруй ам.доллар зарцуулжээ. Зөвхөн 2013 гэхэд 70,000 гаруй ам.долларыг лизингийн төлбөр, угаалгын үйлчилгээ болон замын арчилгаанд зориулж нөхөрлөлд төлсөн байна. “Дамараланд” жуулчны баазад 30 хүн ажилладаг бөгөөд үүний 77 хувь нь Торрагийн нөхөрлөлийн гишүүд байна. Нөхөрлөлийн 7 гишүүнийг захиргаа, менежментийн хэлтэст байнгын орон тоогоор ажиллуулдаг бөгөөд ангийн улиралд ангийн отогт түр ажилтнаар ажиллуулдаг. Ажилчид цалингаа орон нутагтаа гэр бүл, өөрийн хамааралтай хүмүүстээ зарцуулдаг нь эргээд орон нутгийн эдийн засгаа бэлэн мөнгөөр тэтгэж байна гэсэн үг юм.

Эх сурвалж: Rylance & Spenceley, 2014

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Концессийн гэрээнд нийт ажилчдын тодорхой хувийг орон нутгаас бүрдүүлэх боломжтой тохиолдолд гэрээг орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр хийж орлогыг орон нутагт нь үлдээх

Хүснэгт 6.6. ӨАБНУ-ын Байгалийн Цогцолборт Газруудын паркын орлогын эх үүсвэр, 2016

Орлогын төрөл	Үндэсний валют (мян.)	Ам.доллар (мян.)	Эзлэх хувь
Төлбөрийн орлого			
Аялал жуулчлал, жижиглэн худалдаа, концесс болон бусад	1,497,892	95,044	51.6%
Борлуулалт: амьтан, ургамал	48,791	3,096	1.7%
Бусад үйл ажиллагааны орлого	37,134	2,356	1.3%
Хүү болон нөөцийн төлбөр	37,189	2,360	1.3%
Нийт	1,621,006	102,856	55.8%
Төлбөрийн бус орлого			
Шилжүүлгийн орлого			
Засгийн газрын төсөв болон бусад санхүүжилт	1,265,772	80,315	43.6%
Хандив	16,936	1,075	0.6%
Төлбөрийн бус нийт орлого	1,282,708	81,390	44.2%
Нийт орлого	2,903,714	184,246	100.0%
Валютын ханш: US\$:ZAR, as of 1 June 2016: 15.76			

Эх сурвалж: South African National Parks, 2016

Шигтгээ 6.9

Корбеттийн Байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын менежментийг санхүүжүүлэх нь (Энэтхэг)

1936 онд байгуулагдсан Корбетийн Байгалийн Цогцолборт Газар нь (CNP) нь өмнөд Азидаа хамгийн анхдагчдын нэгд тооцогддог байна. Энэтхэгийн нэн ховор зэрлэг амьтны төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөрийн хүрээнд 1973 онд эхлүүлсэн “Бар” төслийн хүрээнд тус БЦГ нь хамгийн анхны бар хамгаалах нөөц газар болж байжээ. Гималайн нурууны өвөр бэлд орших БЦГ-ын барын (*Panthera tigris tigris*) нягтаршил, шувуудын төрөл зүйлээр нэн баялаг, байгалийн үзэмж төгс бүрдсэн нутаг гэдгээрээ танигдсан газар юм.

Корбетт БЦГ-ын дотор Рамганга голын эрэгт орших олонд танигдсан 33 өрөө бүхий Дикала аялал жуулчлалын баазаас гадна Гайрал, Сардпули зэрэг хэд, хэдэн жижиг хэмжээний жуулчны баазууд бий. Аялал жуулчлалын менежментийг санхүүжүүлэх эх үүсвэр байхгүйн улмаас тэдгээр жуулчны баазуудыг ажиллуулахад хүндрэл үүсээд байсан юм. Харин БЦГ-ын хамгаалалтын захиргаанаас 2001 онд өрөө тутмын төлбөр дээр цэвэрлэгээний хөлсийг 2 ам.доллар нэмснээр жилд нийт 20 мянган ам.долларын нэмэлт орлого олох боломжтой болсон байна. Гэсэн ч ийм хэмжээний эх үүсвэрээр зочид буудлын менежментийг явуулахад хүрэлцэхгүй байсан тул 2005 онд уг төлбөрийн хэмжээг 2 дахин өсгөж, өрөөний болон орны тоог нэмэгдүүлснээр жилд 75 мянган ам.долларын орлого олох боломжтой болгожээ. Энэхүү орлогыг аялал жуулчлалыг хөгжүүлэхтэй холбоотой өргөн хэрэглээний бараа, тавилга, гэрэлтүүлэг, шатахуун, эд хэрэгсэл, цалин, яаралтай тусламжинд зарцуулсан байна. Энэхүү арга хэмжээг авснаар 2009 онд Энэтхэгийн Аялал Жуулчлалын Яамнаас Корбетт БЦГ-т “Жуулчдад Ээлтэй Шилдэг БЦГ” хэмээх өргөмжлөлийг гардуулсан байна.

Энэтхэгийн Зэрлэг Амьтан Хамгаалах хуульд оруулсан 1972 оны нэмэлт өөрчлөлт болон Эко Аялал Жуулчлал Хөгжүүлэх Бар Хамгаалах Газрын удирдамжийн дагуу Корбеттийн БЦГ нь Корбеттийн Бар Хамгаалах Сан хэмээх бие даасан бүтцийг бар хамгаалах үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор байгуулжээ. Засгийн газрын зүгээс Корбеттийн БЦГ-ын аялал жуулчлалын жилийн орлогыг тус санд төлөврүүлэхээр шийдвэрлэсэн нь жил бүр 500 мянга орчим ам.долларыг цуглуулна гэсэн хүлээлтэй байна. Энэхүү хөрөнгөөр хамгаалалт, амьдрах орчны менежмент, аялал жуулчлалын менежмент, ажилтнуудын ажиллах нөхцлийг дээшлүүлэх, оршин суугчдын хөгжлийг дэмжихэд зарцуулах юм. Энэтхэг улсын хэмжээнд энэ жишгээр бар хамгаалах санг нийт 44 нөөц газарт байгуулан ажиллуулж байна.

Эх сурвалж: NTCA, 2012; Corbett National Park, 2017



Корбеттийн Байгалийн цогцолборт газрын бар. © Rajiv Bhartari

ТХГН дахь аялал жуулчлалын хэтийн төлөв

7



© Daniela Cajiao

7.1 Байгаль хамгааллын үндсэн зорилтод хүрэхэд аялал жуулчлал дэм болох боломжтой

Аялал жуулчлал нь байгаль орчны салбарын шийдвэр гаргагчид болон ТХГН-ийн менежерүүдэд яагаад чухал асуудал болдог вэ? Зарим тохиолдолд аялал жуулчлал нь ТХГН-т сөрөг нөлөө үзүүлж, байгаль хамгааллын үнэ цэнийг бууруулдаг. Аялал жуулчлалыг зөв менежменттэй хөгжүүлж чадвал байгаль хамгаалах чухал хөшүүрэг болох төдийгүй, ТХГН-уудад улс төрийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломжтой.

Аялагчдын сэтгэл ханамжийн асуудал нь ТХГН-уудын хувьд анхаарах зорилго байж, тогтвортой байдлын стандартыг нэвтрүүлэх замаар экологийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр аялал жуулчлалын чанарыг хангахын зэрэгцээ, орлого олох боломжийг бүрдүүлдэг. Энэхүү зөвлөмжийн эхэнд дурьдсанчлан ТХГН-ийн аялал жуулчлал нь тогтвортой байхын тулд нэн тэргүүнд түүний байгаль хамгаалалд оруулах хувь нэмэр нь урт хугацааных байх ёстой. Тогтвортой аялал жуулчлал нь ТХГН-ийн байгалийн болон түүх соёлын үнэ цэнийг таниулах, сурталчилах боломжийг олгодог.

Энэхүү удирдамжийн зорилго нь ТХГН явагдаж буй аялал жуулчлал нь түүний байгаль хамгаалах үндсэн үүргийг алдагдуулалгүй, харин дэмжих зорилготой гэдэг онолын болон практик ойлголтуудыг нэмэгдүүлэх амаргүй даалгавар буюу тогтвортой байдлын асуудал юм. Удирдамжийн дүгнэлтийн энэ бүлэгт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж буй зарим газрын жишээ,

ирээдүйд гарч болзошгүй сөрөг хандлагууд, үүнд ТХГН-ийн менежерүүд хэрхэн бэлэн байх, гарын авлагад тусгагдсан зөвлөмжүүдийг хэрхэн ойлгох, эсвэл хэрэгжүүлэх талаар дурдана.

7.2 Тогтвортой аялал жуулчлалын эрин үе

Сүүлийн жилүүдэд ТХГН дахь тогтвортой аялал жуулчлалд дэлхий нийтээр анхаарал хандуулж бодлогын түвшинд авч үзэх нь нэмэгдэж байна (Spencely et al., 2017). Тухайлбал 2014 онд хуралдсан НҮБ-ийн Ерөнхий Чуулганаар тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар ядуурлыг бууруулах, нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах тухай тогтоолыг (A/RES/69/233 тогтоол) баталсан билээ. Мөн тухайн жил Биологийн Олон Янз Байдлын Конвенциос “Үндэсний болон бүс нутгийн ТХГН-уудын чадавхийг дээшлүүлэх ажлын хүрээнд аялал жуулчлалын салбарт техникийн болон эдийн засгийн туслалцаа үзүүлэх замаар ТХГН-уудыг шинээр байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааг тогтворжуулах тал дээр хамтарч ажиллах”-ыг талуудад уриалсан (CBD 2014) бөгөөд тогтвортой аялал жуулчлал нь НҮБ-ийн Тогтвортой Хөгжлийн хэд хэдэн зорилттой уялдаж байна.

Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагын 10 жилийн хөтөлбөрийн хүрэн дэх анхаарал хандуулах 6 асуудлын нэг нь тогтвортой аялал жуулчлал бөгөөд “Аялал жуулчлалын салбарыг өөрсдийн үйл ажиллагаандаа тогтвортой байдлаар дэмжих чиглэлээр өөрчлөлт оруулах”-ыг уриалсан явдал юм. НҮБ-ээс 2017 оныг



Турк улсын “Немрут уул”-ын Байгалийн цогцолборт газарт нар мандахыг хүлээж буй жуулчид. Зургийг Mei Yee Yan

“Хөгжлийн төлөө Тогтвортой Аялал Жуулчлалын Олон Улсын Жил”-ээр зарласан бөгөөд аялал жуулчлалын салбарын үүргийг 1) эдийн засгийн тогтвортой өсөлт, 2) нийгмийн хүртээмжтэй байдал, хөдөлмөр эрхлэлт, ядуурлыг бууруулах, 3) баялагийн зохистой хэрэглээ, байгаль орчны хамгаалал, уур амьсгалын өөрчлөлт, 4) соёлын үнэ цэн, олон янз байдал, өв, 5) харилцан ойлголцол, энх тайван, аюулгүй байдлыг хангахад чухал оролцоотойг цохон тэмдэглэсэн (UNWTO, 2018). Дээрх сэдвүүд нь бүгд ТХГН дахь аялал жуулчлалын тогтвортой байдалтай холбогдох бөгөөд ТХГН дахь аялал жуулчлалын үүрэг нь тухайн нутгийн биологийн олон янз байдлын хамгааллыг дэмжих гол хөдөлгөгч хүч нь болох ёстой (Spenceley, 2017).

7.3 Хэтийн хандлагууд

Аялал жуулчлалын хөгжлийн ирээдүйг тольдоход учирч болзошгүй хэд хэдэн эрсдэл дагуулах асуудлууд байна. Байгаль хамгаалах байгууллагууд, ТХГН-ийн менежерүүд эдгээр асуудлуудыг урьдчилан харж, болзошгүй нөлөөллийг үнэлэн, тэдгээрийн эсрэг шаардлагатай арга хэмжээнүүдийг авахад бэлэн байх хэрэгтэй.

Хүн ам болон хэрэглээний өсөлт

Дэлхийн хүн ам өсөхийн хирээр ТХГН дахь аялал жуулчлалын эрэлт нэмэгдсээр байна. ТХГН-т аялаж буй хүмүүсийн тоо дэлхийн өнцөг булан бүрд харилцан адилгүй хэлбэлзэж байдаг хэдий ч (тухайлбал Канад, Япон) олон улс оронд энэ тоо тогтвортой өсөж байна (Pergams & Zaradic, 2006; Shultis & More, 2011). Хүн ам ихээр төвлөрсөн хотуудын ойролцоо иргэдийн эрүүл мэндийг нөхөн сэргээх, амрах, зугаалах хэрэгцээ, шаардлага ихсэж байгаа нь “хот”-ын ТХГН шинээр байгуулах шаардлага тулгарч байна (Trzyna, 2014). Жишээлбэл Канад улсын Торонто хотод байгуулагдсан “Rouge” Үндэсний “хот”-ын байгалийн цогцолборт газар нь биологийн олон янз байдлын хамгаалал болон амралт зугаалгыг хотын нөхцөлд тохируулан хослуулсан онцлогтой (Parks Canada, 2013). ТХГН-ийн менежерүүдийн хувьд 2050 он гэхэд дэлхийн хүн ам 9-10 тэрбум болтол өсөх тохиолдолд аялал жуулчлалын ямар хэрэгцээ биднийг хүлээж байгаа, “хүн төрөлхтний эрчим хүч, материаллаг хэрэглээ нь Дэлхийн тэтгэх чадварыг давах шахсан эсвэл аль хэдийн давсан одоо үед аялал жуулчлалыг хүний нөлөөнд бага өртсөн, онгон зэлүүд нутагт байрлах ТХГН-уудад хөгжүүлэхийг дэмжих нь хэр зохистой вэ?” гэдэг ёс зүйн асуултууд хурцаар тавигдах болно.

Хотжилт

Хотжилт ихээр нэмэгдэж буй өнөөгийн нийгэмд хотын иргэд, ялангуяа залуучууд байгалиас улам бүр хөндийрөх болсон нь сэтгэл зовоосон асуудлуудын нэг болоод байна (Trzyna, 2014). Энэхүү “байгаль дутмагшлын өвчин”-ний талаар их бичих болсон хэдий ч өвчний хор уршиг, хамрах цар хүрээ нь хир өргөн болох нь тодорхойгүй байна (Dickinson, 2013). Ямар ч тохиолдолд хотын нутаг дэвсгэрийн хүрээнд хот төлөвлөлтийг хийхдээ ТХГН болон ногоон байгууламж бүхий “байгалийн хот”-ыг бий болгох боломж бий. Жишээ нь Сингапур бол дэлхий дээрх хүн амын нягтшил ихтэй улсын нэг бөгөөд 1960 оноос хойш хотын хөгжлийг байгальтай хослуулахаар чармайж байна. Сингапур улсын “Сингапур: Цэцэрлэг



Байгалийн саад бэрхшээл дунд байгуулсан жуулчдад зориулсан дэд бүтэц, ЮНЕСКО-ийн Дэлхийн Геопарк дархан газар. Зургийг Yu-Fai Leung.

доторх хот” уриа нь ногоон байгууламжийг ашиглан явган хүний, гүйлтийн болон дугуйн замуудыг цогцоор нь шийдэхийн зэрэгцээ ногоон байгууламжийг байшин барилгадаа буюу босоо түвшинд давхар хөгжүүлж байна. Олон тооны өндөр барилгууд дээвэр дээрээ ногоон байгууламж барьж, халалтыг бууруулахын тулд байшин доторх өлгөдөг цэцэрлэгүүдийг суурьлуулж байна. Эдгээр ногоон төлөвлөлтүүд нь байгалийн өнгө төрхийг хотжилтод аль болох ихээр шингээхийг зорьж буйн илрэл юм (<http://biophiliccities.org/>). Хотууд өргөжин тэлэх үйл явц нь ТХГН-ийн удирдлагууд технологийн компаниудтай хамтран ажиллаж хотын иргэдийг байгалийн болон соёлын үнэт зүйлстэй биечлэн болон зайнаас танилцах, таашаал авах боломжтой бүтээгдэхүүн гаргах боломжийг олгож байна.

Хүн ам зүй болон хууль эрхзүйн хөгжил

Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хурдацтай өөрчлөгдөж буй дэлхийн хүн амын нас, хүйсийн бүтцийг тооцох хэрэгтэй. Хүн ам ихтэй Хятад, Энэтхэг зэрэг улсад дундаж давхаргын (түүнчлэн дээд давхарга) хүмүүс эрчимтэй өсөж байгаа нь гадаад жуулчдын тоо хэдэн арван саяаар нэмэгдэх боломжийг бий болгож байна. Жишээ нь 2017 онд Хятад жуулчдаас олох ашиг орлогоос шалтгаалж Азийн аялал жуулчлалын салбарт тэсрэлт болсоноор гадаад аялал жуулчлал огцом нэмэгдсэн. 2025 он гэхэд аялал жуулчлалын салбараас бүс нутгийн эдийн засагт оруулах хэмжээ 6 хувиар өснө гэсэн тооцоо байна (Corben, 2017). Зарим улс орнуудад эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь нэмэгдэхийн сацуу охид,



Антарктидын экосистем уур амьсгалын өөрчлөлтөнд нэрвэгдэж байгааг жуулчид гэрчилж байна. Зургийг Daniela Cajiao.

Шигтгээ 7.1:

Перу улсын ТХГН дахь аялал жуулчлал ба уур амьсгалын өөрчлөлт: нөлөөллийн үнэлгээ, түүнд дасан зохицох зөвлөмжүүд

Байгалийн болон өв соёлын баялаг түүхээрээ алдартай Перу улс нь 2012 онд нийт 2.8 сая жуулчдыг хүлээн авч 3.2 сая долларын орлого олон, нийт 1 сая гаруй ажлын байрыг шинээр бий болгожээ. Газар зүйн гурван мужид хуваагддаг Перугийн нутаг дэвсгэрт дэлхий дээрх уур амьсгалын ялгаатай хэв шинжүүдийн 80 хувь, байгалийн 114 голлох экосистемийн 84 нь тохиолддог. Засгийн газар хоорондын уур амьсгалын хорооноос гаргасан цаг уурын загвар нь ойрын хэдэн арван жилд гол өөрчлөлт агаарын дундаж температур, хур тунадасны хэмжээ болон агаар мандалын хувьсагчид гарна хэмээн таамаглаж байна. Перу улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй эдийн засгийн алдагдал 10 тэрбум ам.долларт хүрч болзошгүй гэж таамагладаг.

Германы засгийн газрын санхүүжилттэй хэрэгжсэн “Төсвийн хөрөнгө оруулалт ба Уур Амьсгалын Өөрчлөлтөнд Дасан Зохицох Төсөл” (IPACC) нь шийдвэр гаргагчдад цаг уурын өөрчлөлтөөс тэргүүлэх салбаруудад үзүүлэх зардал, ашгийг үнэлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд дасан зохицох, эрсдлийг бууруулах арга хэмжээнд зарцуулах төсвийн хөрөнгө оруулалтын шалгуур үзүүлэлтийг боловсруулах боломжийг олгосон юм. Перугийн тэргүүлэх салбаруудын нэг нь тус улсын 77 ТХГН-ийг түшиглэн үйл ажиллагаагаа явуулдаг аялал жуулчлалын салбар юм. ТХГН-т учирч болох гол эрсдлүүдэд амьтан, ургамлын аймгуудад үзүүлэх сөрөг нөлөө (аялал жуулчлалын гол бүтээгдэхүүн), халуун орны хүнд халдварладаг өвчний дэгдэлт нэмэгдэх, аялал жуулчлалын гол маршрут болох өндөр уулсын мөнх цасны багасалт, далайн түвшний өөрчлөлт, түшиц газрын дэд бүтцийн эвдрэл, хүнсний хангамжийн хомсдол зэрэг орно.

Үүний хариу үйлдэл болох далай болон эрэг орчмын хамгаалалттай газар нутагт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг нэмэгдүүлэх, мэдрэмтгий байдлыг бууруулах замаар нийгмийн эерэг үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой төслүүдэд зориулсан төсвийн хөрөнгө оруулалтыг хийхэд зориулсан гарын авлагыг төслийн хүрээнд боловсруулсан байна. Жишээлбэл, аялал жуулчлалын шинэ байгууламжуудыг хүчтэй аадар борооны улмаас хөрсний гулсалт үүсэх магадлалтай газраас хол байгуулах шаардлагатай бөгөөд ингэснээр өртөг өндөртэй засвар үйлчилгээ болон аялагчдын аюулгүй байдалд учирч болох эрсдлийг бууруулна. Түүнчлэн гарын авлагад нь дэд бүтцийг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд тэсвэртэй хөгжлийг төлөвлөхдөө жуулчдын урсгал, нөөцийн менежментийг хэрхэн оновчтой хэрэгжүүлэх стратегийг агуулсан байна. Перу улсын ТХГН-уудад уур амьсгалын өөрчлөлтийн улмаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй зардлыг тодорхойлсноор уур амьсгалтай холбоотой шалгуур үзүүлэлтийг төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд тооцох боломжтой болсноор цаг уурын өөрчлөлттэй холбоотой эрсдлийг бууруулж, биологийн олон янз байдлыг хамгаалах төдийгүй ТХГН-ийн аялал жуулчлалаас хамааралтай орон нутгийн эдийн засгийг давхар хамгаалах боломж бүрдэнэ.

Эх сурвалж: BMUB, 2015; IPACC, 2017

ШИЛДЭГ ТУРШЛАГЫН ГОЛ САНАА

Уур амьсгалын шилдэг загвар, дасан зохицох шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтыг ашиглан шийдвэр гаргагчдад ойлгомжтой зөвлөмжийг боловсруулах замаар өргөн цар хүрээтэй явагдаж буй сөрөг хандлагуудыг, тухайлбал уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг анхаарлын төвд оруулах.

бүсгүйчүүдийн санхүүгийн боломж нь дээшилж байгаа нь боломжит аялагчдын тоог мөн нэмэгдүүлж байна.

Дэлхийн улс орнууд аялал жуулчлалаас хэдий хэмжээний орлого олж байгаа нь өөрөө нарийн төвөгтэй асуудал бөгөөд үүнийг улс болгонд адилтгаж үзэх нь учир дутагдалтай. Гэсэн хэдий ч, сүүлийн үеийн судалгаагаар 2035 он гэхэд дэлхий дээрх орлогын тэгш бус хуваарьлалт буурах төлөв ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь эдийн засаг нь хурдацтай өсөж буй Бразил, Орос, Энэтхэг, Хятад зэрэг орнууд руу чиглэсэн аялал жуулчлалын шинэ зах зээлтэй холбоотой. Үүний үр дүнд “дэлхийн улс орнууд, ялангуяа шинэ тутам хөгжиж буй орнуудын орлого хамгийн ихээр нэмэгдэнэ” гэсэн таамаглал байна (Hellebrandt & Mauro 2015: 1). Хэрэв энэ таамаг үнэн бол дэлхийн хэмжээнд хүмүүсийн орлого нэмэгдэх бөгөөд тэр хирээр аялал жуулчлалд зарцуулах мөнгөний хэмжээ ихсэх нь тодорхой юм.

Сүүлийн жилүүдэд нутгийн уугуул иргэдийн эрхийг хамгаалах асуудал хурцаар тавигдаж байгаа бөгөөд зарим улсад тэд газар эзэмших эрхтэй болж байгаа нь ТХГН төдийгүй тэдгээрт явагдаж буй аялал жуулчлалд нөлөөлнө. Энэхүү удирдамжид Канад улсын Юкон мужийн Нийнлий Жик (Загас агнуурын) ТХГН (Шигтгээ 5.4) болон Энэтхэгийн “Тембанг Бапу” нутгийн иргэдийн ТХГН-ийн жишээнүүд багтсан болно (Шигтгээ 5.3).

Уур амьсгалын өөрчлөлт

Аюул занал учруулж буй эдгээр хандлагууд нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үзүүлж буй нөлөөлөл юм. Олон зүйл тодорхойгүй байгаа боловч уур амьсгалын өөрчлөлт нь аялал жуулчлалын салбарын эрэлт, түүний хөгжлийн хүчин зүйлд нөлөөлөл үзүүлэх нь тодорхой (Buckley & Foushee, 2012). ТХГН дахь аялал жуулчлалын аялагчдыг татдаг гол зүйлст нь цаг хугацаа, чанарын өөрчлөлт (жишээлбэл өвлийн спортыг түшиглэсэн аялал жуулчлалын хугацаа богиносх, экосистемийн унаган төрх өөрчлөгдсөнөөр түүнд амьдрах зэрлэг амьтдыг ажиглах боломж буурах гэх мэт) орж магадгүй гэж таамаглаж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай байгалийн гамшиг (түймэр, үер, хар салхи гэх мэт)-ийн давтамж болон цар хүрээ нэмэгдэхийн хирээр ТХГН-ийн байгалийн болон соёлын нөөц, аялал жуулчлалын дэд бүтцэд ойр ойрхон хохирол учрах болно. Саяхны жишээ бол 2017 онд Карибын тэнгисийн зарим хэсгийг хүчтэй хар салхи дайрсны улмаас аялал жуулчлалын салбарт учирсан гамшиг юм. Аялал жуулчлалын салбар нь, ялангуяа зам тээврээр дамжуулан хүлэмжийн хийн жилийн ялгаруулалтанд онцгой хувь нэмэр оруулдаг тул хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах стратегийн чухал тоглогчийн нэг болдог (Hall нар., 2013). Тиймээс аливаа аялал жуулчлалын үнэлгээг хийхдээ олон улсын болон дотоодын тээврийн нөлөөг хамтад нь тооцох хэрэгтэй. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах аливаа стратеги нь тээврийн хэрэгслээс ялгарах хүлэмжийн хийг бууруулахад чиглэгдэх учраас ТХГН дахь аялал жуулчлалд давхар нөлөөлнө гэдгийг тооцох хэрэгтэй (Шигтгээ 7.1).



АНУ-ын Хойд Каролина мужийн “Cape Lookout” Далайн Эргийн байгалийн өв газарт идээшлэн буй морьдтой селфи хийж байгаа аялагчид. Зургийг Yu-Fai Leung

Хүснэгт 7.1. Энэхүү гарын авлагад багтсан шилдэг туршлагууд

Эх сурвалж	Шилдэг туршлага
Төлөвлөлт ба бодлогын асуудлууд	
Шигтгээ 2.7. ТХГН-ийн аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг бодлогоор дэмжих нь: Ботсвана улсын туршлага	Аялал жуулчлалын үндэсний бодлого “гурвалсан суурь зарчим”-ын дагуу ТХГН дахь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Үүнд 1) аялал жуулчлал нь байгаль хамгаалалд шууд утгаараа хувь нэмэр оруулах, 2) ТХГН болон нутгийн иргэдэд эдийн засгийн үр ашгийг бий болгох, 3) нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцон тэдгээрийг боломжит хэмжээнд бууруулах зэрэг багтана.
Шигтгээ 3.3. Аялагчдад өгч буй сэтгэл ханамжаар дамжуулан байгалийг хайрлан хамгаалах сэтгэл зүйг бий болгох нь: Вади Ел-Хитан—Халим загасны хөндий Дэлхийн соёлын өв газар (Египет)	Газар орны макет хийх, байгууламжийг барих, материалыг сонгохдоо эдэлгээ удаан, дахин ашиглах боломжтой, элбэг олдоцтой, тогтвортой байдлыг харгалзах хэрэгтэй. Байгууламжийн зураг төсөлд орон нутгийн соёл, газар зүй, цаг уурын нөхцөлийг тусгах, орчны тохижилт, шавьжийг зохицуулахад нутгийн (унаган) ургамлыг ашиглах.
Шигтгээ 3.4. Даацийн талаарх товч түүх	ТХГН-ийн үнэт зүйл, менежментийн зорилтууд болон тэдгээртэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд, стандартуудад суурилсан менежментийг нэвтрүүлснээр аялал жуулчлал болон байгаль хамгааллыг тэнцвэртэй хөгжүүлэхэд тулгарч буй асуудлыг шийдэхэд туслах мэдээллийг олж авах.
Шигтгээ 3.5. Гранд Каньон Үндэсний Парк (АНУ)-н төлөвлөлт ба бүсчлэл	Жуулчдад зориулсан менежментийн багаж, арга аргачлалуудыг хослуулан хэрэгжүүлж, илүү үр дүнтэй болгох.
Шигтгээ 4.5. Аялагчдын мониторингод ашигладаг олон аргууд: Вилморинь онгон зэрлэг газар (Канад улс)	Аялал жуулчлалаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тохиромжтой технологийг хангалттай санхүүжилтэй хослуулан уялдуулах замаар хянах.
Шигтгээ 4.6. Прухоник Байгалийн Цогцолборт Газар дахь аялагчдын төрөл дээр хийсэн мониторинг (Чех улс)	Тухайн газрын хамгаалж буй үнэт зүйлс, үйл ажиллагааны нөхцөл зэргийг сайтар мэдсэний үндсэн дээр аялал жуулчлалын менежментийн аргыг сонгох, хэрэгжүүлэх.
Шигтгээ 4.15. Дэлхийн Тогтвортой Аялал Жуулчлалын Зөвлөлөөс гаргасан шалгуур үзүүлэлтүүд	Аялал жуулчлалын бодлого боловсруулах, төлөвлөх, удирдах болон түүнээс гарах үр дагаврыг хянахдаа олон улсын хэмжээнд аялал жуулчлал болон биологийн олон янз байдлын талаар дагаж мөрдөж буй удирдамжийг ашиглах.
Шигтгээ 5.1. ТХГН-ийн Байгаль Хамгаалах Хөтөлбөрийн Нутгийн Иргэдийн Менежмент (COMPACT)	ТХГН-т аялал жуулчлалыг төлөвлөхдөө дараах 4 үндсэн үйл явцыг хэрэгжүүлэхэд анхаарах. Үүнд: (1) байгаль орчин, нийгэм эдийн засгийн суурь судалгааг хийх, (2) судалгаанд үндэслэн төсөөллийн ерөнхий загварыг гаргах (3) газар дээрх төлөвлөлтийг хийх, (4) хяналт-үнэлгээний системийг бий болгосноор шаардлагатай тохиолдолд тухайн газарт менежментийн өөрчлөлтүүдийг хийх боломжтой болох.
Шигтгээ 5.4. Нийнлийн Жикийн ТХГН-ийн (загас агнуурын салбар) хамтын төлөвлөлт ба менежмент (Юкон, Канад Улс)	Аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг холбогдох бүх талуудтай, тухайлбал уугуул болон орон нутгийн иргэд, аялал жуулчлалын чиглэлээр ажилладаг хувийн хэвшлийнхэнтэй хамтран боловсруулна.
Шигтгээ 7.1. Перу улсын ТХГН дахь аялал жуулчлал ба уур амьсгалын өөрчлөлт: нөлөөллийн үнэлгээ, түүнд дасан зохицох зөвлөмжүүд	Уур амьсгалын шилдэг загвар, дасан зохицох шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтыг ашиглан шийдвэр гаргагчдад ойлгомжтой зөвлөмжийг боловсруулах замаар өргөн цар хүрээтэй явагдаж буй сөрөг хандлагуудыг, тухайлбал уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг анхаарлын төвд оруулах.
Олон нийт ба харилцааны асуудал	
Шигтгээ 2.4. Биологийн төрөл зүйлийг иргэдийн амьжиргаатай холбох нь: ТХГН дахь нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой түншлэл	Зах зээлд чиглэсэн нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээг дэмжих. Нутгийн иргэдийн үйлдвэрлэл, хувийн хэвшлийн түншлэл нь арилжаанаас ашиг олох боломжийг нэмэгдүүлдэг гэдгийг ямагт анхаарах.
Шигтгээ 2.9. Эрүүл мэндийн түншлэл: Австралийн Медибанк, Викториагийн ТХГН-ийн Хамгаалалтын Захиргаа, Зүрх Хамгаалах Үндэсний Сангуудын хамтын ажиллагаа	ТХГН дахь амралт, сувилалын үйл ажиллагаа нь иргэдийн хэрэгцээг хангахын зэрэгцээ нийгмийн томоохон асуудал болох эрүүл мэнд, сайн сайхан байдлыг тэтгэдэг гэдгийг бодолцох.
Шигтгээ 4.1. Сайн дурынхан ТХГН-т судлаач-иргэн, хянагчаар ажиллах нь	Судлаач иргэн болон бусад хөтөлбөрийн хүрээнд сайн дурын ажилтнуудыг менежментийн үйл ажиллагаанд татан оролцуулах замаар чадавхижуулах, урам зориг өгөх, тодорхой удирдамжаар хангах, чанарын шаардлага тавих.

Хүснэгт 7.1 үргэлжлэл

Шигтгээ 4.10. Аялагчдад Дэлхийн өвийг сурталчилан таниулах нь: Гунунг Мулу Байгалийн Цогцолборт Газар, Малайз улс	ТХГН-ийн менежментийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг олон улсын жишээн дээр тайлбарлан, өргөн хүрээтэйгээр жуулчдад ойлгуулах.
Шигтгээ 4.11. Перу улсын ТХГН-ийн Үндэсний Сүлжээн дэхь мэдээлэн тайлбарлах төвүүд	Байгаль орчны боловсрол болон мэдээлэн тайлбарлах хөтөлбөрт ТХГН-ийн үнэ цэнийг онцлон ойлгуулах талаар стратегитэй, ухаалаг хандаж, тухайн ТХГН болон ТХГН-ийн сүлжээний ерөнхий зорилго, зорилттой уялдуулах.
Шигтгээ 4.12. Оролцооны хэлбэрээр түүхийг мэдэж суралцах нь: Мэдлэг, Аялагчдын мэдлэг болон ур чадварт суурилсан танин мэдүүлэх аргаар жуулчидтай харилцах нь (Канад улс)	Зөвхөн дан мэдээлэл дээр суурилсан байгаль орчны боловсрол, мэдээлэн тайлбарлах хөтөлбөрөөс гадна болох оролцогчид, хүүхэд залуусын сэтгэл хөдлөлийг татсан хөтөлбөрт шилжих, ингэснээр жуулчид болон залуу үеийнхэн тухайн хамгаалж буй газрын үнэ цэнийг улам ихээр ойлгуулах.
Шигтгээ 5.2. Орчны бүсийн нутгийн иргэдийн чадавхийг бэхжүүлэх нь	Нутгийн иргэдийн аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх чадавхийг үнэлэн, хөрөнгө оруулалт хийхээс өмнө бизнес загварыг нь сайтар боловсруулсан эсэхийг нягтлах нь чухал.
Шигтгээ 5.6. Аялал жуулчлалын менежментийн түншлэл: АНУ-ын Ойн алба (USFS)-ны жишээ	Түншлэлтэй холбоотой бүхий л ажлууд, тухайлбал түншүүдийг элсүүлэх, харилцаа холбоог гүнзгийрүүлэхэд зарцуулсан цаг хугацаа зэргийг албан ёсоор бүртгэж, талуудад хүлээн зөвшөөрөгдсөн байх.
Санхүүгийн асуудлууд	
Шигтгээ 2.5. Түншлэлээр дамжуулан бизнесийн ур чадварыг бүрдүүлэх нь	Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээний бизнесийг хөгжүүлэх, менежментийн чадавхийг олгох сургалтыг нутгийн иргэд, ТББ-ын төлөөлөгчид, ТХГН-ийн менежерүүдэд зохион байгуулах.
Шигтгээ 4.13. Канадын ТХГН-ийн Хамгаалалтын Захиргааны зах зээлийн судалгаа ашиглалт ба үр өгөөжийн сурталчилгааг	Маркетингийн стратегийг хэрэгжүүлэхийн өмнө судалгаа, дүн шинжилгээ хийх замаар ялгаатай бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар гүнзгий ойлголттой болох нь чухал.
Шигтгээ 6.4. Танзани улсын ялгавартай тогтоосон нэвтрэх хураамжийн тухай	Нэвтрэх хураамжийн үнийг тогтоохын өмнө ТХГН-ийн (эсвэл ТХГН-ийн сүлжээнд) санхүүгийн үнэлгээг системтэйгээр хийх хэрэгтэй. Өнөөгийн нөхцөл байдал, орлого, зарлагад дүн шинжилгээ хийж, мэдээллийг ашиглан хураамжийн хэмжээг тогтоох хувилбаруудыг, жишээлбэл оршин суугчдын статус, нас, эсвэл тухайн газрын танигдсан байдал, эсвэл энэ бүгдийн холимог хувилбар хэлбэрийг жигнэн үзэж хураамжийг ялгавартай тогтоох шаардлагатай.
Шигтгээ 6.5. Галт уулын БЦГ-т Горилла харах үйл ажиллагааны хураамж (Руанда)	Нэвтрэх хураамжийг төлөх бэлэн байдлын судалгааг хувилбар бүрээр авч үзэх хэрэгтэй. Ижил төстөй үйлчилгээ явуулж, тухайн зах зээлд өрсөлддөг орон нутгийн болон бүс нутгийн ТХГН-ийн нэвтрэх хураамжийг жишиг үнэ болгож авах.
Шигтгээ 6.7. Аялал жуулчлалын үйл ажиллагааг гэрээгээр амжилттайгаар гүйцэтгүүлэх: Тамботагийн Судалгааны Төв болон Байгалийн Нөөц Газар (Перу)	Аялал жуулчлалын компанитай байгуулах гэрээнд тэргүүн туршлага нэвтрүүлэх, ТХГН-ийн байгаль хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэгийн асуудлыг тусгай заалт болгон оруулах.
Шигтгээ 6.8. Эдийн засгийн үр ашгаас нутгийн иргэд хувь хүртэх: Намиб улсын "Дамараланд" жуулчны бааз болон "Торра" байгаль хамгаалах нөхөрлөл	Ажилчдын тодорхой хувийг нутгийн иргэдээс бүрдүүлэх, олсон орлогыг аль болох орон нутагт нь зарцуулах, ажил үйлчилгээ үзүүлэх гэрээг орон нутгийн компаниудтай байгуулах гэх мэт заалтуудыг концессийн гэрээнд тусгаж өгөх.

Зарим тооцож боломгүй хүчин зүйлс

Дэлхий нийт хувьсан өөрчлөгдөхийн хэрээр зарим зүйлсийг урьдчилан тооцох боломжгүй нөхцөлд хүргэж байна. Тухайлбал терроризм үүнд багтана. Алан хядагчид стратегийн үүднээс гол төлөв жуулчдыг, жуулчдын очих дуртай (хялбар байг) газруудыг онилдог бөгөөд дийлэнх тохиолдолд хохирогчид нь жуулчид байдаг. Хэдийгээр алан хядагчид хэзээ, хаана халдлага зохион байгуулах гэж буйг урьдчилан тооцох боломжгүй ч ТХГН-ууд өөрсдийн аюулгүй ажиллагааны төлөвлөгөөндөө халдлагаас хамгаалах, халдлага гарсан тохиолдолд хэрхэн хариу арга хэмжээ авах тухай тусгах хэрэгтэй (Fagel & Hesterman,

2017). Терроризм нь аялал жуулчлалын хэв маягийг хэрхэн, ямар хэмжээгээр өөрчлөх нь илүү өргөн хүрээтэй асуудал юм. Эдгээр асуултанд хариулах баримт нотолгоо хоорондоо зөрчилдөөнтэй хэдий ч, томоохон террорист халдлага нь хүмүүсийн аяллын сонголт хийхэд урт хугацаанд сөргөөр нөлөөлдөг болох нь тодорхой байна.

Сүүлийн үед хөгжиж буй шинэ хандлага бол "мөрөөдлийн багцад багтсан аяллууд" болон "сүүлчийн боломжит аялал" зэрэг аяллын төрлүүд юм. "Сүүлчийн боломжит" гэдэг нь тодорхой сонирхолын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас ч юм уу тодорхой нэг экосистем эргэлт буцалтгүйгээр өөрчлөгдөх эсвэл ямар нэгэн

зэрлэг амьтдыг устаж үгүй болохоос нь өмнө амжиж үзэх зорилготой аялал жуулчлалын нэг хэлбэрийг хэлж байна (Мюллер, et al 2013). Тээврийн салбараас голлон хамаардаг аялал жуулчлалын хувьд бас нэг тодорхойгүй зүйл бол ирээдүйд уламжлалт шатахууны хэрэглээ дуусгавар болсоны дараах эрин үед хүмүүс ТХГН руу болон ТХГН-т хэрхэн аялах вэ гэдэг асуулт юм.

Ирээдүйд бидний одоогоор төсөөлж чадамгүй технологи бий болох нь тодорхой юм. Эдгээр технологийн тусламжтайгаар жуулчид ТХГН руу аялах аялалаа төлөвлөхөд шаардлагатай мэдээллээ олж авах бүтээлч арга зам бүрдэснээр өөрсдийн аялалаа байгалийн онцгой үзэгдэлтэй (зэрлэг амьтдын нүүдэл, шувуудын үүрлэх хугацаа) давхцуулах, найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ туршлагаа цахимаар хуваалцах, аюулгүй байдлаа сайжруулах боломжийг бүрдэнэ.

ТХГН-ийг амралт, зугаалгын зориулалтаар ашиглах сонирхол ирээдүйд өөрчлөгдөх нь зайлшгүй бөгөөд энэ нь маш олон хүчин зүйлс, тухайлбал хүн амын насжилт, цагаачлал, аялах боломж, мэдээлэл, технологийн хүртээмж зэргээс шалтгаална.

7.4 Дүгнэлт

Аялал жуулчлал нь ТХГН-т тодорхой нөлөөллүүд үзүүлдэг бөгөөд тэдгээрийг байгаль хамгаалах зорилгодоо ашиглахын тулд таних, үнэлэх, удирдан чиглүүлэх шаардлагатай. ТХГН нь ирж буй жуулчдын сонирхолыг өөртөө татсанаар байгаль хамгааллын ажлыг өргөн хүрээнд сурталчилах, улмаар тэдгээрийн дэмжлэгийг авах боломж бүрдэнэ. Ихэнхи тохиолдолд аялал жуулчлал нь ТХГН-ийг шинээр байгуулах, тэдгээрийн менежментийг авч явахад чухал ач холбогдолтой. Энэ бүлэгт багтсан шилдэг туршлагууд (Хүснэгт 7.1) нь ТХГН дахь аялал жуулчлалын талаарх суурь ойлголтуудыг өгүүлэх төдийгүй менежерүүдэд зориулсан зөвлөмж болон хэрэглэгдэхүүний талаар өгүүлсэн болно. Давтан хэлэхэд эдгээр зөвлөмжүүд нь нуршсан жагсаалт биш шилдэг туршлагуудын түүвэр юм. Энэхүү жагсаалт нь биологийн олон янз байдлын хамгаалал, тогтвортой байдлыг хангахад аялал жуулчлалын оролцоо тэдгээрийн шилдэг туршлагыг нэвтрүүлэхэд ач холбогдолтой (e.g., EUROPARC Federation, 2012; CBD, 2007; CBD, 2015).

Зөвлөмжүүдийг хэрхэн ойлгож, хэрэгжүүлэх вэ? Зөвхөн үндэсний хийгээд орон нутгийн байр байдал, нөхцөлд таарсан тохиолдолд хэрэглэнэ. Бодлого боловсруулагчид болон менежерүүд аливаа шийдвэрийг гаргахаасаа өмнө нөлөөлж болох бүхий л хүчин зүйлүүдийг тооцсон нарийвчилсан үнэлгээ хийх хэрэгтэй. Эдгээр зөвлөмжүүдийг олон улсын туршлага дээр үндэслэн гаргасан тул өргөн хүрээтэй ашиглах боломжтой мэт боловч аливаа ТХГН бүр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байдаг. Иймд ТХГН-ийн удирдлага, менежерүүд өөрсдийн нөхцөл байдлыг үнэлэн, ирээдүйд учирч болох өөрчлөлтийг урьдчилан харж, үүнтэй уялдуулан эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх нь чухал юм.

Эцэст нь хэлэхэд менежерүүд нөхцөл байдлыг тогтмол үнэлэн, аливаа өөрчлөлтийг баримтжуулан, шаардлагатай тохиолдолд хэрэгцээтэй өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай. Байгаль хамгааллын үнэ цэн, тухайлбал биологийн олон янз байдлыг хадгалахын хажуугаар аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд богино, дунд, урт хугацааны хэрэгжих боломжит, бодитой зорилтуудыг тавих, зорилтуудаа биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц шийдвэрийг гаргахад өргөн олны сэтгэлийг татах хөшүүрэг хэрэгтэй.

Энэхүү зөвлөмжийн туршид бид тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгарч болох бэрхшээлүүдийн талаар олон удаа дурьдсан билээ. Аялал жуулчлалаас үзүүлж болох сөрөг нөлөөллүүдийг бууруулан, эерэг нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн шилдэг туршлагуудыг гаргаж тавьсан. ТХГН дахь тогтвортой аялал жуулчлал нь зорилго болон үйл явцын нэгдэл бөгөөд менежерүүдийн урт хугацаанд, хүчин чармайлт гарган хэрэгжүүлэх ёстой зүйлс юм.

Гэхдээ энэ нь ТХГН дахь эрх бүхий этгээдүүд, бүхлоролцогч талуудын идэвхитэй харилцаа, хамтын ажиллагаагүйгээр хэрэгжих боломжгүй. Уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийтийн дэмжлэгийг авснаар ТХГН-ийн хамгаалалтын зорилгодоо хүрэх боломжтой. Иймд бид энэхүү удирдамж нь зорилгодоо хүрэхэд гол хурдасгах хүчин зүйл болно гэдэгт итгэж байна.

Үгийн тайлбар

Best practices \ Шилдэг туршлагаууд

Туршлага дээр батлагдсан стратеги, арга зүй, техник нь ТХГН-т хамгийн үр ашигтай байдлаар зохицуулсан арга зам юм. Шилдэг туршлага нь цаг хугацааны явцад өөрчлөгдөн, шинэ мэдлэгийг сайжруулах боломжийг олгож, аялал жуулчлалыг ТХГН-ийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл болгон ашиглаж буй менежерүүд, аялал жуулчлалын бизнес эрхлэгчид, олон нийт, жуулчдын мэдлэг, хандлага, хичээл зүтгэл, үүрэг хариуцлагын илэрхийлэл болдог.

Biodiversity \ Биологийн олон янз байдал

Хуурай газар, далай тэнгисийн болон бусад усан экосистем, тэдгээрийн хамаарах экологийн иж бүрдэлд хамрагдах бүх төрлийн амьд организмын нэгдэл; энэхүү нэгдэлд зүйлийн доторх, зүйлүүд болон экосистемүүд хоорондын олон янз байдал орно.

Biosphere reserve \ Шим мандлын нөөц газар

ЮНЕСКО-гийн олон улсын экосистемийн сүлжээг бүрдүүлдэг, ТХГН-ууд нь биологийн олон янз байдал, тэдгээрийн хадгалан хамгаалалт болон тогтвортой ашиглалтыг дэмжин, нийгмийн болон экосистемийн өөрчлөлт, харилцан үйлчлэлийг ойлгох, зохицуулахад чиглэсэн салбар хоорондын арга зам юм.

Branding \ Брэнджүүлэх

Зураг, сэдэв, дизайн эсвэл таних бусад элементийг (эсвэл тэдгээрийн хослол) аялал жуулчлалыг сурталчлах зорилгоор тусгай хамгаалалттай газар нутгийн бэлэгдэл болгон ашиглах.

Bucket list or Last chance \ Тусгайлсан аялал жуулчлал /багц жагсаал эсвэл сүүлчийн боломж/

Зарим газар нутгийг, түүний дотор тусгай хамгаалалттай газруудыг уур амьсгалын өөрчлөлтийн улмаас унаган төрхөө алдах, зэрлэг амьтдыг устаж үгүй болохоос нь өмнө ажиглах зорилгоор аялах.

Capacity building \ Чадавхи бэхжүүлэх

Хүмүүс тодорхой зорилгоо биелүүлэх эсвэл төслийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай арга замыг (чадавхи) олж авах үйл явц.

Carrying capacity, tourism \ Аялал жуулчлалын даац

Аялах газрын [тухайлан тусгай хамгаалалттай газарт] байгаль орчин, эдийн засаг, нийгэм соёлын орчныг сүйтгэхгүй, жуулчдын сэтгэл ханамжийг бууруулахгүйгээр аялах боломжтой хамгийн их хүний тоо.

Certification \ Гэрчилгээжүүлэлт

ТХГН-т аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийн тогтвортой байдлын тодорхой зорилтуудыг багтаасан стандартуудад нийцүүлэн баталгаажуулах гуравдагч талын сайн дурын үнэлгээ.

Commercialization manual \ Арилжааны гарын авлага

ТХГН-ийн менежерүүд ашгийн төлөө аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчидтэй хэрхэн үе шаттайгаар гэрээ хийх зааварчилгаа.

Community \ Үгүүлбэрт хэрэглэж буй байдлаасаа шалтгаалж “Нутгийн иргэд” болон “Нөхөрлөл”

Гишүүд нь тодорхой газарт амьдардаг, хамтын удирдлагатай, түүхийн болон соёлын нийтлэг өвтэй байж болох нийгмийн хэсэг бүлэг хүмүүсийн нэгдэл. Түүнчлэн ойрын орчиндоо харилцаж, цаг хугацааны хувьд уялдаа холбоо, залгамж чанар сайтай, нийгмийн харилцан үйлчлэл, ойр дотно байдал, ёс суртахууны үүрэг хариуцлага, олон талт харилцаа, харилцан ойлголцол зэрэг шинж чанар бүхий бүлэг хүмүүсийг хамарч болно.

Competencies, operational \ Ур чадвар ба үйл ажиллагаа

ТХГН дахь аялал жуулчлалын өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд удирдан зохион байгуулахад шаардлагатай ур чадвар.

Competencies, Planning \ Ур чадвар ба төлөвлөлт

ТХГН-ийн аялал жуулчлал, зорчих болон бусад зорилтуудыг цогцоор нь шийдэж төлөвлөх, ингэхдээ тусгай хамгаалалттай газар нь орон нутгийн эдийн засгийн хөгжилд хэрхэн дэмжлэг үзүүлэх боломжийг нь давхар тусгах ур чадвар.

Competencies, strategy \ Ур чадвар ба стратеги

ТХГН-ийн үүрэг, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд орон нутаг, бүс нутаг болон улсын хэмжээнд бүр цаашлаад олон улсын эрэлт хэрэгцээ, хүлээлтэд нийцүүлэн урт хугацаанд сэтгэх мэдлэг чадвар.

Concession; concessionaires \ Концесс, концесс гэрээлэгч

ТХГН-т тодорхой үйлчилгээг үзүүлэх онцгой эрхийг аж ахуйн нэгжид (ихэвчлэн ашгийн төлөө компанид) өгдөг тусгай хамгаалалттай газрын удирдах байгууллагаас байгуулсан гэрээний зохицуулалт. Тухайн аж ахуйн нэгжийг концессын гэрээлэгч гэнэ.

Concession fees \ Концессийн төлбөр хураамж

Концессийн гэрээлэгчийн тусгай хамгаалалттай газарт үйлчилгээ үзүүлэх онцгой эрхийн олгосны төлөө өгч буй төлбөр. Энэхүү төлбөр нь шууд мөнгөн хэлбэрээр байхаас гадна гүйцэтгэлийн баталгаа, засвар үйлчилгээний төлбөр, зөрчлийн торгууль хэлбэрээр байж болно.

Conservation ethic \ Байгаль хамгааллын ёс зүй

Байгаль болон соёлын үнэ цэнийг үнэлдэг, хамгаалахыг дэмждэг хүний сэтгэлгээ нь түүний итгэл үнэмшилд оршдог. ТХГН дахь тогтвортой аялал жуулчлалын нэг гол зорилт нь байгаль хамгааллын ёс зүйг дэмжих явдал юм.

Cultural heritage \ Соёлын Өв

Нийгэмд бий болсон амьдралын хэв маягийн илэрхийлэл нь үеэс үе дамжин уламжлагдан ирсэн ёс заншил, зан үйл, газар, объект, уран сайхны илэрхийлэл, үнэт зүйл зэргийг агуулдаг. Энэ нь ихэвчлэн “биет бус” (жишээлбэл ёс заншил, хэл) эсвэл “биет” (жишээлбэл биет үзмэр) (Хөшөө дурсгал, дурсгалт газруудын олон улсын зөвлөл) хэлбэрээр илэрхийлэгддэг. Өв уламжлал нь өнгөрсөн үеийнхнээс өвлөгдөн, одоогийн байдлаар хадгалагдаж, хойч үедээ өвлүүлэх нөхцөлийг онцгойлон авч үздэг.

Co-Marketing \ Хамтарсан маркетинг

Бүх талын ашиг тусыг хүртэх, аялал жуулчлалын боломжийг сурталчлах зорилгоор ТХГН-ийн агентлаг түншүүдтэй хамтран ажилладаг маркетингийн нэг хэлбэр.

Concentration of use; Dispersal of use \ Ашиглалтын төвлөрөл ба хуваарилалт

Эхнийх нь менежерүүд аялагчид ашиглах сөрөг нөлөөллийг ТХГН-ийн харьцангуй бага хэсэгт хязгаарлах замаар оролдох стратеги. Дараагийнх нь эсрэгээр: урамшуулал, зохицуулалтаар ашиглалтыг илүү өргөн хүрээнд тараах замаар сөрөг нөлөөллийг багасгах оролдлого.

Demarketing \ Буцаах сурталчилгаа

ТХГН-гийн менежерүүд хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах эсвэл зочдын туршлагыг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой байршил эсвэл үйлчилгээнд аялал жуулчлалын эрэлтийг зориудаар хориглох стратеги.

Differential pricing \ Ялгаатай үнэ

Шаардлагатай үед эрэлт хэрэгцээг харгалзан үнэ тогтоох, жишээлбэл нуурын эрэг орчимд байрлах төлбөрийг аялал жуулчлалын оргил улиралд үнийг нэмэх зэрэг зохицуулалт хийх систем.

Ecotourism \ Экотуризм (байгалийн аялал жуулчлал)

Байгаль орчноо хамгаалах, нутгийн иргэдийн сайн сайхан байдлыг ханган, танин мэдэх, мэдлэг боловсрол олгох хариуцлагатай аялал.

Entrance fee \ Нэвтрэх хураамж

ТХГН-т нэвтрэн ороход өгөх хураамж.

Environmental impact assessment \ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл эсвэл бүтээн байгуулалтыг тодорхойлох албан ёсны дүн шинжилгээ, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл, түүний ач холбогдол, гарч болзошгүй үр дагаврыг урьдчилан тооцоолж, түүнийг бууруулах арга замыг зөвлөж иргэдээр хэлэлцүүлсэн шийдвэр гаргах, хяналт мониторинг хийх болон төсөл хэрэгжсэний дараах хөндлөнгийн дүгнэлт зэргийг тусгасан албан ёсны баримт бичиг.

Gazetted \ Зарлагдсан, тунхагласан

Төрөөс гаргасан эрхзүйн шийдвэр нь албан ёсоор нийтлэгдсэн байх нөхцөл. Тухайн газар нь тусгай хамгаалалтад авагдсан тухай статусыг албан ёсоор зарлан тунхагласан байхыг хэлнэ.

Global geoparks \ Дэлхийн Геопаркууд

Газар нутаг, ландшафт нь дэлхийн хэмжээний геологийн онцгой ач холбогдол бүхий, байгаль хамгаалал, боловсрол, тогтвортой хөгжлийг нэгэн зэрэг хангах ТХГ-ын олон улсын сүлжээ.

Governance \ Засаглал

ТХГН-ийн зорилтуудыг хангах зорилгоор гаргасан зарчим, хууль бодлого, дүрэм, заавар болон аялал жуулчлалын өдөр тутмын менежментийн чиглэлээр шийдвэр гаргах.

Governance types \ Засаглалын хэлбэрүүд

ТХГН-ийн ангиллаас хамаарч засаглал нь үндсэн 4 хэлбэртэй байдаг. (1) Засгийн газар, (2) Хамтын засаглал, (3) Хувийн хэвшлийн (ТББ-ын удирддаг) (4) Нутгийн уугуул иргэдийн болон нөхөрлөлийн засаглал. Аль ч засаглалд аялал жуулчлалын хариуцлагыг төрийн бусад агентлагт хариуцуулах эсвэл хувийн операторт гэрээгээр хариуцуулах боломжтой.

Green exercise \ Ногоон дасгал

Амралт зугаалгын арга хэмжээ нь байгаль орчинд суурилсан байх эсвэл байгальд амрах.

Hardening \ Чангатгах, хатуурхах

ТХГН-ийн нөөц баялгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх, аялагчийн үзүүлэх шууд нөлөөллийг бууруулахад менежерүүдийн хийх стратеги. Жишээлбэл, аялагчдын үзүүлж буй нөлөөллийг бууруулахын тулд хатуу зам тавих, эсвэл сөрөг нөлөөллийн талаар мэдээлэх замаар нөлөөллийг бууруулах.

Indigenous Peoples \ Уугуул иргэд

Тэдний нутаг дэвсгэрт байсан колоничлолын өмнөх болон колоничлолын нийгэмд түүхэн тасралтгүй байдлаас болж өөрсдийгөө тухайн нутаг дэвсгэрт амьдарч буй нийгмийн бусад салбараас ялгаатай гэж үздэг хүмүүс.

Indicators and quality standards \ Шалгуур үзүүлэлт ба чанарын стандарт

Байгалийн болон нийгмийн орчны хэмжигдэхүйц хэсгийг бага ба түүнээс дээш чанарын хувьд тодорхойлох боломжтой бөгөөд ингэснээр чанарын стандартын өөрчлөлтийг хянах боломжийг олгодог. Чанарын үзүүлэлтүүд нь менежментийн зорилтын тусгал болно; тэдгээрийг менежментийн зорилтын тоон үзүүлэлттэй төлөөлөгчид гэж үзэж болно. Чанарын стандарт нь заагч хувьсагчийн зөвшөөрөгдөх хамгийн бага нөхцөлийг тодорхойлдог.

Infrastructure \ Дэд бүтэц

ТХГН-т аялал жуулчлал эрхлэх, аялагчдад зориулан байгуулсан мэдээллийн төв, зам болон үйлчилгээний цэг зэрэг болон бусад бүтээн байгуулсан зүйлүүд.

Interpretation \ Харилцаа

Байгалийн нөөцөд хамаарах утга болон олон нийтийн хоорондох сэтгэл хөдлөлийн болон оюун бодлын холболтыг бий болгодог харьцааны үйл явц.

Law enforcement, 'soft' and 'hard' \ Хуулийн хэрэгжилт ба “зөөлөн, хатуу” буюу “сануулга” болон “шийтгэл” гэсэн ойлголтууд

ТХГН-т хуулийн хэрэгжилт гэдэг ойлголтын цаана аялагчдыг дагаж мөрдүүлэх “сануулга” болон “шийтгэл” гэсэн 2 янзын менежментийн арга байна. “сануулга” гэдэгт ямар нэгэн албадсан бус арга хэмжээ буюу зөвхөн дохио зангаа, үг хэл зэргээр тайлбарлаж ойлгуулах, “шийтгэл” гэдэгт албадсан арга хэмжээ авах буюу гаргасан зөрчилд нь тохирсон хуулийн заалтын дагуу захиргааны арга хэмжээ авах, торгох, баривчлах зэрэг арга хэмжээнүүд орно.

